



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.04.17 № 3г-1/52
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тухай

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн
төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн
төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их
Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000244001449



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.04.15 № Хэл/740
танай _____-ны № _____-т


**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацаа товлох тухай**

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт^{6/} хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН




**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.03.15 № 1/1223
танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай
хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль
тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8
дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн
мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.


 **Б.ЭНХБАЯР**

151600984
Doc.yam a5.2024



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2024.03.22 № 01/1774
танай 2024.03.15-ны № 01/1222-т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД Б.ЭНХБАЯР ТАНАА**

Танаас ирүүлсэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгохыг хүссэн албан бичигтэй танилцаад, Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасны дагуу Улсын Их хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761000771

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 45 дугаар тэмдэглэлд:

“V.ХЭЛЭЛЦСЭН нь: Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Б.ЭНХБАЯР

**ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дөрөв дэх хэсэгт засаглалын бодлогын талаар заасан бөгөөд 4.2.10-т “Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын тавд засаглалын бодлогын талаар заасан бөгөөд зорилго 5-д “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” гэж зааснаас гадна “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны тав дахь хэсэгт засаглалын талаар зааж, 5.2 дахь хэсэгт “Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна.”, 5.2.13-т “Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах, эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.”, 5.2.14-т “Гэрээгээр гүйцэтгүүлж болох бүх төрийн чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудад шилжүүлэх тогтолцоог нэвтрүүлнэ.” гэж тус тус заасан.

1.2.Практик шаардлага

Улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих, худалдаа үйлдвэрлэлийн орчин үеийн тогтолцоо бий болгох, гишүүдийнхээ болон гадаад дотоодын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим /цаашид “Үндэсний танхим” гэх/-ын үйл ажиллагааны үндсэн чиглэл, тогтолцоо, зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлсон Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль нь 1995 онд батлагдаж 2002, 2011, 2015 онуудад Иргэний хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль тус тус батлагдсантай холбоотойгоор нэмэлт, өөрчлөлтүүд орж байжээ.

Дээрх хууль нь Монгол Улсын хурдацтай өсч буй бизнесийн орчинд Үндэсний танхим зохицон ажиллах, аж ахуй эрхлэгчдийн нийтлэх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төрийн байгууллагад төлөөлөн илэрхийлэх, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох зэрэг чиг үүргүүдийг хэрэгжүүлэхэд багагүй хүндрэл учруулж байгаа, түүнчлэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтэц, тогтолцоо, гишүүнчлэл, санхүүжилт, танхимын зорилт, чиг үүрэг зэрэг нь орчин цагийн эдийн засаг, бизнесийн хөгжилтэй нийцэхгүй байгаа нь тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний үр дүнд харагдаж байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.4-т "тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон." гэж үзэж байгаа бөгөөд дараах зайлшгүй практик шаардлагууд байна.

Тогтолцооны хувьд:

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 5 дугаар зүйлээр танхимын тогтолцоог зохицуулсан бөгөөд 5.2-т "Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим байж болно" гэж заасан. Харин тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Аймаг, нийслэлийн, аймаг дундын танхимыг 50-иас доошгүй аж ахуйн нэгж, байгууллага Иргэний хууль болон Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу үүсгэн байгуулж болно." гэж заасны дагуу бие даасан танхим байгуулах эрхийг аж ахуйн нэгж, байгууллагуудад нээлттэй болгосон байна. Энэхүү зохицуулалтаас үзвэл манай улс 1995 оноос эхлэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг бүс нутгийн зарчмаар хөгжүүлэхийг зорьсон нь харагдаж байна. Тус зохицуулалтын дагуу 2015 онд "Улаанбаатар хотын худалдааны танхим" ГҮТББ байгуулагдсан нь Үндэсний танхимаас гадна бие даан үйл ажиллагаа явуулж буй ганц танхим болж байна.

Түүнчлэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 25 жилийн хугацаанд бие даасан танхим ганцхан байгуулагдсан, энэхүү танхим нь зөвхөн нийслэлд байгуулагдсан байгаа нь тус хуулийн зорилттой уялдаа холбоо муу, орон нутагт 50 аж ахуйн нэгж нэгдэж бие даасан танхим байгуулах боломж хомс, 2021 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй 56,8 мянган аж ахуйн нэгжийн 39,3 мянган аж ахуйн нэгж нь зөвхөн нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа, орон нутагт санхүүжилтээ бие даан шийдэх боломж бага зэрэг шалтгааны улмаас худалдаа, аж үйлдвэрийн танхимыг бүс нутгийн зарчимд суурилж хөгжүүлэх зорилго биелээгүй байна.

Үндэсний танхимын хүчин төгөлдөр үйлчилж буй үндсэн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Аймаг, нийслэл Улаанбаатар хот дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь Үндэсний танхимын үндсэн чиг үүргийг тухайн орон нутагт бүхэлд нь буюу хэсэгчлэн гүйцэтгэх албан ёсны салбар мөн" гэж, 3.2-т "Салбар танхим нь Үндэсний танхимаас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна" гэж, 3.4-т "Салбар танхим нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг улирал бүр гарган Үндэсний танхимд хүргүүлнэ" зэргээр зохицуулсан бөгөөд Үндэсний танхимын зүгээс 1997 онд анхны салбар танхимыг байгуулж, өнөөдрийн байдлаар 21 аймагт салбар танхимтай үйл ажиллагаа явуулж байна. Тухайн салбар танхимууд нь салбарын гэрчилгээтэй, Үндэсний танхимаас оруулсан орлогын хувиар урамшуулал авдаг, зөвхөн гишүүнчлэлийн татвараа өөрсдийн орлого болгон зарцуулж байгаагаас үзвэл орон нутагт бие даасан танхим байгуулах зорилго нь Үндэсний танхимын салбар болсон байна.

Түүнчлэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн зөвлөмж хэсэгт цаашид бүс нутгийн

зарчмаар бус, аж ахуйн нэгжүүдийн явуулж буй үйл ажиллагааны чиглэл, онцлог, салбар зэргийг харгалзан үзэж бизнесийн салбар тус бүрээр нэгдсэн мэргэжлийн худалдаа аж үйлдвэрийн танхим байгуулах замаар худалдаа, аж үйлдвэрийн танхимыг хөгжүүлэх, эдгээр танхимын төлөөлөл нь Үндэсний танхимын Их хурал, Удирдах зөвлөл зэрэг удирдах байгууллагыг бүрдүүлэхийг оновчтой гэж үзжээ.

Иймд худалдаа, аж үйлдвэрийн танхимыг дан ганц бүс нутгийн зарчимд суурилж хөгжүүлэх хуулийн зорилт хэрэгжихгүй байгаа, тухайн нөхцөл байдалд тааруулан Үндэсний танхимын зүгээс орон нутгийн аж ахуй эрхлэгчдэд үйлчилгээгээ хүргэх зорилгоор салбар байгуулсан зэрэг шалтгаанууд нь танхимын тогтолцоог эргэн харах, бүс нутгийн тогтолцоо бус өөр байдлаар хөгжүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

Мөн одоогийн байдлаар “танхим” гэсэн нэр агуулсан, худалдаа аж үйлдвэрийн танхимын зорилгыг илэрхийлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо нийт 69 байгаагаас ТББ-ын хэлбэрээр 65 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр ТББ-аас Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан 50-иас доошгүй аж ахуйн нэгж, байгууллага нийлэн үүсгэн байгуулсан, хуульд заасан шаардлага хангасан цорын ганц бие даасан танхим нь 2015 онд байгуулагдсан “Улаанбаатар хотын худалдаа танхим” ГҮТББ байгаа бөгөөд бусад ТББ-ын тухай зөвхөн Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан нөхцөл шаардлагыг удирдлага болгон “худалдааны танхим”, “танхим” болон “худалдаа, аж үйлдвэрийн танхим” зэрэг нэр томъёог ашигласан байгаа нь “худалдаа, аж үйлдвэрийн танхим”, “худалдааны танхим”, худалдаа аж үйлдвэрийн танхимын зорилгыг илэрхийлж болох бусад нэр томъёог хуулиар хамгаалж, зөвхөн хуульд заасан шаардлага хангасан тохиолдолд ашиглах байдлаар хуульд тусгах шаардлагатай байна.

Чиг үүргийн хувьд:

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулиар Үндэсний танхимд аж ахуй эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, төрийн эрх барих болон гүйцэтгэх байгууллагуудад төлөөлөх, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх зэрэг зорилгоо хэрэгжүүлэхэд нь чиглэсэн бүрэн эрхүүдийг зааж өгсөн. Тухайлбал, тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т “худалдаа үйлдвэрийнхний нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлөн илэрхийлэх, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал оруулах” эрхийг Үндэсний танхим хэрэгжүүлэхээр заасан бөгөөд тус чиг үүргийн хүрээнд 2015-2018 оныг хүртэлх нийт 4 жилийн хугацаанд 25 бодлогын баримт бичиг, хуулийн болон журмын төсөл боловсруулах ажилд оролцон ажилласан байх бөгөөд 35 хэлэлцүүлэг уулзалтуудыг зохион байгуулж, 23 мэдэгдэл, уриалга гаргасан гэсэн тоон үзүүлэлт байна. Оролцон ажилласан бодлогын баримт бичгийг салбар тус бүрээр нь үзвэл эдийн засаг, санхүүгийн чиглэлээр 5, Худалдааны чиглэлээр 6, Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр 2, Органик хүнсний чиглэлээр 7, бусад чиглэлээр 5, нийт 25 бодлогын баримт бичигт санал өгөх байдлаар оролцож ажилласан байна. Мөн 2022 оны байдлаар Үндэсний танхимын зүгээс нийт 17 тооны зөвлөл, хороонд оролцон ажиллаж байгаа бөгөөд хууль тогтоомжийн төсөл боловсруулах болон бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой нийт 45 ажлын хэсэгт хамрагдан ажиллаж байна.

Гэвч гишүүн байгууллагуудын зүгээс Үндэсний танхимыг төр засагтай аж ахуйн нэгжийг холбох, бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд түлхүү анхаарахыг хүссэн, түүнчлэн бизнес эрхлэгчдээс авсан “бизнес итгэлийн индекс” судалгаагаар эдийн засаг, бизнесийн талаар авч хэрэгжүүлж буй төр, засгийн бодлого шийдвэр, түүний

хэрэгжилт, үр дүнд сэтгэл хангалуун биш байгаагийн зэрэгцээ бизнес итгэлийн ерөнхий индекс өсөлт удаан, бизнесийн орчны шийдвэрлэвэл зохих асуудлууд нь “зээлийн хүү, бодлогын тогтворгүй байдал, авилга, хээл хахууль, татварын хувь хэмжээ, төрийн хүнд суртал, хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал, төрийн нүсэр бүтэц” зэрэг тодорхой хэдэн асуудлуудыг онцолж байгаагаас үзвэл Үндэсний танхимын төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход оруулж буй санал, дүгнэлтүүд нь тооцоо судалгаа муу, төр засгийн зүгээс заавал хүлээн авах үүрэг байхгүй зэрэг шалтгааны улмаас цаашид энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллахгүй тохиолдолд аж ахуй эрхлэгчид төр, засгийн бодлогын гадна үлддэг дүр зураг хэвээр байхаар байна.

Иймд тунхагийн шинжтэй, бодит байдалд хэрэгждэггүй, чиг үүргээ хангалттай сайн хэрэгжүүлэх хөшүүрэг байхгүй, аж ахуй эрхлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төрийн байгууллагад хангалттай хэмжээнд төлөөлөн илэрхийлж чадахгүй байгаа зэрэг эдгээр асуудлуудыг засах үүднээс зарим шаардлагатай чиг үүргийг нэмэх, тухайн чиг үүргүүдийг ангилах, чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг заах, төрийн байгууллагын дэргэдэх хамтын удирдлагын байгууллагуудад төлөөллөө оролцуулах, хуульд зааснаар төрийн зарим чиг үүргийг шилжүүлэн авч хэрэгжүүлэх боломжийг хуульд тусгайлан зааж өгөх шаардлага бий болжээ. Ингэснээр аж ахуй эрхлэгчдийн дуу хоолой шийдвэр гаргах түвшинд бодитоор хүрэх, төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлснээр төрийн байгууллагын ачаалал буурах, төрд үүсэх зардал багасах, үйлчилгээний чанар сайжрах зэрэг олон давуу тал бий болохоор байна.

Санхүүжилтийн хувьд:

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д танхимын санхүүжилт нь гишүүний татвар, иргэд байгууллагын хандив болон үйлчилгээний орлогоос бүрдэхээр заасан байна. Тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн дүгнэлт, зөвлөмж хэсэгт зааснаар 2015-2018 оны хооронд Үндэсний танхим нь нийт орлогынхоо 80-90 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого болон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд олсон орлогоор бүрдүүлж байгаа бол 10-20 хувийг гишүүдийн хураамжаас бүрдүүлж байна. Мөн Үндэсний танхимын үндсэн үйл ажиллагааны орлого нь үйл ажиллагааны зардлаа нөхөж чаддаггүй, жил бүр алдагдалтай ажиллаж байгааг цаашид өөрчлөх, гишүүнчлэлийн тогтолцоог өөрчлөх замаар гишүүнчлэлийн хураамжийн Үндэсний танхимын орлогод эзлэх хувийг нэмэгдүүлэх зэргээр олон улсын жишигт нийцүүлэн санхүүжилтийн асуудлыг хуульд шинээр зохицуулах шаардлагатай байна. Тухайлбал, гишүүнчлэлийн хураамжийг тухайн мэргэжлийн танхим болон салбар танхимын үйл ажиллагааны нөхцөл байдал, орлогын хэмжээ зэрэгт тулгуурлан ялгамжтай байдлаар тогтоох, зарим төрлийн гишүүдийг хураамжаас чөлөөлөх эрхийг тухайн мэргэжлийн танхим болон салбар танхимд олгох зэргээр олон улсын туршлагаас өөрийн орны онцлогт тохируулан сайжруулах шаардлага зүй ёсоор бий болжээ.

Санхүүжилтийн асуудлыг шинээр зохицуулснаар Үндэсний танхим төдийгүй мэргэжлийн танхим, салбар танхим нь хуульд заасан бүрэн эрх, чиг үүргээ санхүүгийн хувьд хүндрэл бэрхшээлгүй хэрэгжүүлэх боломж нээгдэх бөгөөд тодорхой хэмжээний төсвийг бизнесийн орчны суурь судалгаа хийх, бие даасан судалгааны институт байгуулах, өөрийн гэсэн бизнесийн орчны мэдээллийн нэгдсэн сантай болох, холбогдох хуулийн төсөлд санал өгөхдөө тусгайлан судалгаа хийлгэж илүү бодитой, аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхлыг хамгаалах зэргээр чиг үүргээ бодитой хэрэгжүүлэх нэг хөшүүрэг болох юм.

Мөн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т "Танхимын үйлчилгээний хөлсний хэмжээг танхимын саналыг үндэслэн Сангийн сайд, Худалдаа үйлдвэрийн сайд хамтран тогтооно" гэж заасан байгаа нь тухайн байгууллагын орлогын гол эх үүсвэрээ бүрдүүлж буй үйл ажиллагаанд төрийн зүгээс оролцож болох зохицуулалт байна. Зах зээл, эдийн засгийн өөрчлөлтөөс хамааран үйлчилгээний хөлс өөрчлөгдөх, шинэ үйлчилгээ бий болсноор түүний үнийг тогтоох, зарим бизнесийг дэмжих зорилгоор үнэ, хөлсийг бууруулах эсхүл чөлөөлөх арга хэмжээ авах шаардлагатай байдаг боловч энэ тохиолдолд бүрт Сангийн сайд болон Худалдаа үйлдвэрийн сайдын хамтарсан шийдвэр гарахыг хүлээх нь танхимын бие даасан, хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх юм. Бусад улс орны хувьд үйлчилгээний хөлсийг худалдаа, аж үйлдвэрийн танхимын Их хурал, эсхүл Удирдах зөвлөл тогтоох жишиг тогтсон бөгөөд худалдаа, аж үйлдвэрийн танхимын зүгээс тодорхой хэмжээний шат дамжлага, хяналт тогтоосон байдаг байна. Иймд Үндэсний танхимын хувьд гадаадын зарим орны туршлагаар үйлчилгээний хөлсийг өөрөө тогтоох болон түүний хяналтын тогтолцоог бий болгох зэрэг өөрчлөлт хийх шаардлагатай байна.

Үндэсний танхимын зарим үйлчилгээний хувьд:

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд Төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагчийн талаарх харилцааг зохицуулсан бөгөөд 8.1-д "Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулж болно" гэж заасан бөгөөд Үндэсний танхимын дэргэд анх 2014 онд эвлэрүүлэн зуучлах төв байгуулагдаж, тухайн үедээ эвлэрүүлэн зуучлалын албаны дарга, нарийн бичиг, 18 эвлэрүүлэн зуучлагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байжээ. Гэвч Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол нөгөө тал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй" гэж заасан нь тухайн эвлэрүүлэн зуучлагчийн шийдвэрийг шүүгч баталгаажуулж, захирамж гаргадгүйгээс заавал биелэгдэх шинжгүй болсон байна. Иймд Үндэсний танхимын дэргэдэх Эвлэрүүлэн зуучлалын төвийн шийдвэрийг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасны нэгэн адил шүүгч баталгаажуулж, захирамж гарган шүүхийн шийдвэрийн нэгэн адил заавал биелэгддэг болох боломжийг хуульд тусгах шаардлагатай байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох, Үндэсний танхимын тогтолцоог эдийн засаг, бизнесийн орчин төдийгүй нутаг дэвсгэр, хүн ам зүйн тархалт зэргийг харгалзан үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуй эрхлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадах бүтэцтэй болгох, аж ахуй эрхлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлд Үндэсний танхимын хэрэгжүүлж болох чиг үүргийг нэмэгдүүлэх, төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх боломжийг бий болгох, үйл ажиллагаагаа бие даасан, хараат бусаар хэрэгжүүлж чадахуйц санхүүгийн чадамжтай болгох зэргээр үйл ажиллагааг нь боловсронгуй болгож чадах Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасныг үндэслэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болгох, шинээр бүлэг, зүйл, заалт оруулах зэргээр хуулийн нийт заалтын тавиас дээш хувьд нь нэмэлт өөрчлөлт орж байгаа тул хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөл нь 8 бүлэгтэй байх бөгөөд дээр дурдсан үндэслэл, шаардлагад тулгууран зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, худалдаа, аж үйлдвэрийн танхимын хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг;

Хоёрдугаар бүлэгт Худалдаа, аж үйлдвэрийн танхимын зорилго, зохион байгуулалт, гишүүнчлэл, танхимын нэр;

Гуравдугаар бүлэгт салбар танхимын зохион байгуулалт, санхүүжилт;

Дөрөвдүгээр бүлэгт мэргэжлийн танхимын зохион байгуулалт, санхүүжилт;

Тавдугаарт бүлэгт Үндэсний танхимын чиг үүрэг, зохион байгуулалт, санхүүжилт;

Зургаадугаар бүлэгт Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас бусад этгээдтэй харилцах харилцаа, төрийн байгууллага, албан тушаалтан болон бусад этгээдтэй харилцах харилцаа, Үндэсний танхим болон мэргэжлийн танхим, салбар танхим хоорондын харилцах журмыг;

Долоодугаар бүлэгт Үндэсний танхимын үзүүлэх зарим үйлчилгээ болох гарал үүслийн гэрчилгээ олгох, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын гэрчилгээ олгох, бараа, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулах баримт бичиг олгох, хөндлөнгийн экспертизийн үйлчилгээ, орон нутагт үйлдвэрлэсэн бараа, материал үйлчилгээний тодорхойлолт олгох үйлчилгээ үзүүлэх нөхцөл, журам, арбитрын үйлчилгээ, эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ болон оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээг;

Наймдугаар бүлэгт Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хараат бус байдал, үйл ажиллагааны тайлан, тус хуулийг зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгана.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Тус хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар доор дурдсан үр дагавар гарна гэж үзэж байна. Үүнд:

1.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтэц, зохион байгуулалт, түүний бүрэн эрх тодорхой болсноор аж ахуй эрхлэгчид эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах, хамтын удирдлагын байгууллагаар дамжуулан дуу хоолойгоо төр болон олон нийтэд хүргэх боломж бололцоо нэмэгдэнэ.

2.Монгол Улсын худалдаа, аж үйлдвэрийн танхимын тогтолцоо нь үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нэг танхим болон эдийн засгийн үйл ажиллагааны салбараар дагнан байгуулагдсан мэргэжлийн танхим болон аймаг, нийслэлд байгуулагдах салбар танхимуудаас бүрдэх тул тодорхой бизнес, эдийн засгийн

салбарын аж ахуй эрхлэгчид нь тус бүрийн салбарын асуудлаа мэргэжлийн танхим дээрээ хэлэлцэн ярилцах, орон нутаг, нийслэлийн аж ахуй эрхлэгчид салбар танхим дээрээ хэлэлцэн, ярилцсаны үндсэн дээр нэг шийдэл, шийдвэрт хүрэх боломжтой болох юм.

3.Хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд “үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим”, “худалдаа, аж үйлдвэрийн танхим” болон худалдаа, аж үйлдвэрийн танхимын зорилгыг илэрхийлэх нэр томьёог хэрэглэх боломжтой болж нэрийн хамгаалалт бий болно.

4.Үндэсний танхимын гишүүнчлэлийг шинээр зохион байгуулснаар тухайн байгууллагаас үйлчилгээ авах аж ахуй эрхлэгчдийн тоо нэмэгдэж, цаг хугацаа, эдийн засгийн хувьд хэмнэлттэй болно.

5.Үндэсний танхим болон мэргэжлийн танхим, салбар танхим нь үйл ажиллагаагаа хараат бус, бие даасан байдлаар явуулах санхүүгийн боломж бий болно. Ингэснээр аж ахуй эрхлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлд ахиц гарах болно.

6.Аж ахуй эрхлэгчдийн хооронд үүссэн маргааныг заавал шүүхээр шийдүүлэх бус эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтай шийдүүлж, тухайн шийдвэр нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэнэ. Үүнтэй холбоотойгоор бизнесийн эрх зүйн холбогдолтой маргааныг дагнан шийдвэрлэх, мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчид бий болох боломжтой юм. Дээрх нөхцөлүүд бүрдсэнээр шүүх дэх иргэний хэрэг маргааны ачаалал буурах эерэг талтай байна.

7.Үндэсний танхимын чиг үүрэг тодорхой болно.

8.Холбогдох төрийн байгууллагаас зөвшилцсөний үндсэн дээр зөвлөл, хороо, комисс зэрэг хамтын удирдлагын бүрэлдэхүүнд төлөөлөл оролцуулах боломж бий болно.

9.Худалдаа, аж үйлдвэрийн танхим үйл ажиллагаагаа улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид явуулах боломж бий болно.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хуулиудад нийцүүлж боловсруулах бөгөөд худалдаа, аж үйлдвэрийн танхимын чиг үүргийг тодорхой болгох зорилгоор 1995 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан Худалдаа, аж үйлдвэрийн танхим хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай зэрэг хуулийн төслүүдийг боловсруулна.

--- 000 ---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Худалдаа, аж үйлдвэрийн
танхимын тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дөрөв дэх хэсэгт засаглалын бодлогын талаар заасан бөгөөд 4.2.10-т “Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.” гэж заасан.

Улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих, худалдаа үйлдвэрлэлийн орчин үеийн тогтолцоо бий болгох, гишүүдийнхээ болон гадаад дотоодын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилго бүхий Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль нь 1995 онд батлагдсан.

Тус хууль нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.4-т “тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон.” гэж, мөн 25.1.2-т заасны дагуу Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн нийт заалтын тавиас дээш хувьд нь нэмэлт өөрчлөлт орсон тул уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь 8 бүлэг 29 зүйлтэй бөгөөд хуулийн төсөлд худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтэц, тогтолцоог сайжруулах, чиг үүргийг шинээр тодорхойлох, санхүүгийн бие даасан байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг тусгасан болно.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтэц, зохион байгуулалт, түүний бүрэн эрх тодорхой болсноор аж ахуй эрхлэгчид эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах, хамтын удирдлагын байгууллагаар дамжуулан дуу хоолойгоо төр болон олон нийтэд хүргэх боломж бололцоо нэмэгдэнэ.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу боловсруулсан бөгөөд хэрэгжилтийн үр дагаврын судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог тус тус хийж, холбогдох саналыг хуулийн төсөлд тусгасан болно.

Түүнчлэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Унгар Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын худалдаа, аж үйлдвэрийн танхимын эрх зүйн байдлыг зохицуулсан хууль тогтоомжийг харьцуулан судалж, олон улсын жишиг зохицуулалтыг харгалзан Монгол Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн бүтэц, зохицуулах асуудлуудын цар хүрээг тодорхойлж, Монгол

Улсын эдийн засаг болон гадаад, дотоод худалдаа, хүн ам зүйн тархалт, аж ахуй эрхлэгчдийн төвлөрөлт, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой холбоодын үйл ажиллагааны үр дүнтэй байдал, аж ахуй эрхлэгчдэд дутмаг байгаа санхүүжилтийн төдийгүй техник, боловсон хүчний нөхцөл байдал зэрэгт тулгуурлан хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд төрийн захиргааны төв байгууллага, холбогдох бусад байгууллагын саналыг авч тусгасан болно.

--- o0o ---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА


Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль 1995 онд батлагдаж, өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.4-т, 25.1.2-т заасныг үндэслэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болгох, шинээр бүлэг, зүйл, заалт оруулах зэргээр нэмэлт өөрчлөлт орсон тул Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагавар, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог тус тус хийлгэж, холбогдох саналыг хуулийн төсөлд тусган 8 бүлэг 29 зүйлтэй боловсруулсан.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль батлагдсан 1995 оноос 2022 он хүртэл нийт үйлдвэрлэл 6.6 их наяд төгрөгөөс 28.5 их наяд төгрөг болж Монгол Улсын эдийн засаг 4.3 дахин тэлсэн. Мөн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн тоо 1998 онд 7.8 мянга байсан бол 2022 оны байдлаар 79.4 мянга болж 10.2 дахин нэмэгдсэн.¹

Түүнчлэн, эдийн засгийн өсөлтөд хувийн хэвшлийн оролцоо улам бүр нэмэгдэж, хувийн хэвшлийн нэгдэл, зохион байгуулалтыг сайжруулан төрийн бодлого, хууль, дүрэм, журам, шийдвэр гаргах явцад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зураг 1. ДНБ-д хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь




Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны мэдээлэл

МҮХАҮТ-аас бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, бодлогын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаанд бизнес эрхлэгчдийн оролцооны түвшин ямар байгаа, бизнесийн эрх ашгийг хамгаалах бизнесийн болон мэргэжлийн холбоодын үйл ажиллагаа нь хүртээмжтэй ажиллаж тухайн салбарын бизнес

¹ Үндэсний статистикийн хорооны тоон мэдээлэл, 2015 оны суурь үнээр


эрхлэгчдийг бүрэн төлөөлж, эрх ашгийг хамгаалж байгаа эсэхийг тодруулах зорилгоор 2022 оны 11 дүгээр сард 1603 аж ахуй нэгжээс судалгаа явуулсан бөгөөд судалгааны үр дүнгээс харвал бизнесийн холбогдолтой бодлого, хууль, дүрэм журам шийдвэр гаргах процесст бизнес эрхлэгчдийн оролцоо ямар түвшинд байна гэж үзэж байгаа тухайд тодруулахад судалгаанд оролцсон аж ахуй эрхлэгчдийн 80 хувь нь дунд болон муу, маш муу байна гэсэн бол 16 хувь нь сайн, маш сайн байна гэжээ.

Зураг 2. Төрийн бодлого, хууль, дүрэм, журам, шийдвэр гаргах процесст аж ахуй эрхлэгчдийн оролцоо ямар түвшинд байна вэ?



Олон улсын Худалдаа аж үйлдвэрийн танхимуудын хувьд голдуу бүс нутгаар хөгжсөн байдаг ба үүний адилаар 1995 оны хуулиар Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг бүс нутгийн зарчмаар хөгжүүлэхийг зорьсон. Гэвч 2023 оны 3-р улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж буй 95,143 хуулийн этгээдээс 82,667 аж ахуйн нэгж байгаа ба үүний 60,523 нь буюу 73.2 хувь нь зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа² ба хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа улам бүр нэмэгдсээр байна. Орон нутагт санхүүжилтээ бие даан шийдэх боломж бага, үүнийг дагаад танхимын хүний нөөц ба чадавх зэрэг шалтгааны улмаас танхимыг бүс нутгийн зарчимд суурилж хөгжүүлэх зорилго биелээгүй учир Монгол Улсын онцлогт тохирсон мэргэжлийн танхимуудыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар бий болгох нь зүйтэй гэж үзсэн.

Зураг 3. МУ-ын зарим тоон үзүүлэлт, нийслэл, орон нутгаар



Эх сурвалж: ҮСХ-ны 2022 оны тоон мэдээлэлд суурилсан болно.

² Үндэсний статистикийн хорооны тоон мэдээлэл

Иймд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Унгар Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын худалдаа, аж үйлдвэрийн танхимын эрх зүйн байдлыг зохицуулсан хууль тогтоомжийг харьцуулан судалж, олон улсын жишиг зохицуулалтыг харгалзан Монгол Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн бүтэц, зохицуулах асуудлуудын цар хүрээг тодорхойлж, Монгол Улсын эдийн засаг болон гадаад, дотоод худалдаа, хүн ам зүйн тархалт, аж ахуй эрхлэгчдийн төвлөрөлт, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой холбоодын үйл ажиллагааны үр дүнтэй байдал, аж ахуй эрхлэгчдэд дутмаг байгаа санхүүжилтийн төдийгүй техник, боловсон хүчний нөхцөл байдал зэрэгт тулгуурлан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн танилцуулгыг бэлтгэлээ.

Хуулийн төслийг дараах байдлаар олон нийтээр хэлэлцүүлж, гарсан саналуудыг тусган бэлтгэсэн.

1. Аймгуудын ХАҮТ-уудтай хийсэн уулзалт хэлэлцүүлэг, 2020.10.22
2. Мэргэжлийн холбоодтой хийсэн уулзалт хэлэлцүүлэг, 2021.11.11
3. Улаанбаатар хотын худалдааны танхимд 2 удаа
 - Ерөнхийлөгч А.Ганхуяг, гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ нарт, 2022.08.10
 - Удирдах зөвлөлийн гишүүд ба удирдлагад, 2022.10.06
4. МҮХАҮТ-ын тэргүүлэгч, УЗ-ын гишүүдэд 2 удаа, 2021.12.12 ба 2022.10.10
5. МҮХАҮТ-ын дэргэдэх Хуулийн бодлогын зөвлөл, МОУА-ын Арбитрчдын зөвлөлд нэгтгэн хийсэн хуулийн төслийн танилцуулга, 2022.09.30

Нэгдүгээр бүлэгт: Хуулийн нийтлэг үндэслэл болох хуулийн зорилтыг тодорхойлж, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгалаа.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын эрх зүйн байдлыг тодорхойлохдоо Монгол Улсад Үндэсний танхим нь нэг байж, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчныг сайжруулах, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх, хамгаалах зорилгыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхээр тусгасан.

Монгол Улс 2015 оноос эхлэн дэлхийн өрсөлдөх чадварын тайланд орсон ба 2023 оны байдлаар нийт 100 онооноос 35.56 оноогоор тайланд орсон 64 улсаас 62 дугаар байрт эрэмблэгдэж байна. 2016-2018 онуудад өрсөлдөх чадварын оноо өссөн ба 2018 оноос хойш тасралтгүй буурсан.

Иймд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, төр болон улс төрийн нам, эвслээс хараат бус, бие даасан байх зэргээр тодорхойлов.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг бүс нутгийн зарчмаар хөгжүүлэх зохицуулалтын дагуу 2015 онд “Улаанбаатар хотын худалдааны танхим” ГҮТББ

байгуулагдан ажиллаж байна. Ийнхүү хууль үйлчлэх 25 жилийн хугацаанд бие даасан танхим ганцхан байгуулагдсан, энэ нь зөвхөн нийслэлд байгаа нь 2021 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй 56,8 мянган аж ахуйн нэгжийн 39,3 мянган аж ахуйн нэгж нь зөвхөн нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

Олон улсын жишигт Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь тодорхой зохион байгуулалт, бүтэцтэй байгууллага бөгөөд улс орны эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулдаг байна.

Иймд цаашид бүс нутгийн зарчмаар бус, аж ахуйн нэгжүүдийн явуулж буй үйл ажиллагааны чиглэл, онцлог, салбар зэргийг харгалзан үзэж эдийн засгийн үйл ажиллагааны салбар бүрд нэг салбарын танхим тухайн аймаг, нийслэлд аймаг, нийслэлийн танхим тус тус байгуулан ажиллахаар тусгаж, чиг үүрэг, уялдаа холбоог тодорхойлсон болно.

Хоёрдугаар бүлэгт: Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчныг сайжруулах, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх, хамгаалах үндсэн зорилгын хүрээнд хэрэгжүүлэх бүрэн эрхийг нарийвчлан тусгасан.

Тухайлбал, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болон эдийн засгийн салбаруудын бодлого боловсруулахад оролцох, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төрийн холбогдох байгууллага, албан тушаалтанд төлөөлөн илэрхийлэх, хамгаалах, тэдгээрийн үйл ажиллагаа, шийдвэрийн үр нөлөөг сайжруулахтай холбоотой санал, зөвлөмж хүргүүлэх болон зөвлөл, хороо, комисс, ажлын хэсэг зэрэг хамтын удирдлагын бүрэлдэхүүнд төлөөлөл оролцуулах замаар аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх, хамгаалахаар тусгалаа.

Түүнчлэн хууль, эсхүл Засгийн газрын шийдвэрээр шилжүүлсэн төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж болохоор хуулийн төсөлд тусгаснаар төрийн байгууллагын ачаалал, зардал тодорхой хэмжээнд багасах эерэг үр дагавартай гэж үзэж байна.

Гуравдугаар бүлэгт: Монголын Үндэсний танхимын удирдлага, зохион байгуулалтын харилцааг тусгасан бөгөөд зарим гадаадын орны туршлагаар Үндэсний танхимын Их хурал, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгч, Хяналтын зөвлөл зэрэг удирдлагын бүрэн эрх, чиг үүрэг, хэрхэн сонгогдох, чөлөөлөгдөх зэрэг харилцааг хуульчилснаар бүтэц, зохион байгуулалт тодорхой, тогтвортой байх боломжийг бий болголоо.

Түүнчлэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтэц, зохион байгуулалтыг ойлгомжтой, тодорхой болгох зорилгоор олон улсын жишигт нийцүүлэх хүрээнд аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дарга нь Монголын Үндэсний танхимын Удирдах зөвлөлийн гишүүн байх зохицуулалтыг тусгалаа.

Дөрөвдүгээр бүлэгт: Аймаг, нийслэлийн болон салбарын танхимыг байгуулах, түүний удирдлага, зохион байгуулалттай холбогдох харилцааг тусгалаа.

Аймаг, нийслэлийн танхимыг тухайн аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 50-аас доошгүй тооны аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулж, үйл ажиллагаагаа бие даан хэрэгжүүлэх бөгөөд аймгийн танхим байгуулагдаагүй хоёр болон түүнээс дээш аймгийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд нэгдэж аймаг дундын танхим, эсхүл хэд хэдэн аймгийн танхим хоорондоо нэгдэж аймаг дундын танхим байгуулж болохоор тусгасан.


Харин салбарын танхимыг эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 50-аас доошгүй тооны аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулж, үйл ажиллагаагаа бие даан хэрэгжүүлэх бөгөөд хэд хэдэн салбарын танхим нэгдэж салбарын дундын танхим байгуулж болохоор тусгалаа.

2021 оны байдлаар Монгол Улсад нийт 3762 бизнес, мэргэжлийн холбоо, эвлэл үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 65 хувь нь 1-2 ажиллагчтай, 86 хувь нь 5 хүртэлх ажиллагчтай байгаа нь эдгээр ТББ, мэргэжлийн холбоодын ихэнх хүний нөөц хангалтгүйг илтгэж байна.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан мэдээллээс үзэхэд зөвхөн барилгын салбарт 24, аялал жуулчлалын салбарт 80, уул уурхайн салбарт 92, хүнсний салбарт 102 ТББ, мэргэжлийн холбоод бүртгэлтэй байгаа ч нийтэд мэдэгдэж үйл ажиллагаа явуулж байгаа нь эдгээр салбар тус бүрээр 4-10 орчим байна. Энэ нь салбарын төлөөлөх чадавх сул, зарим салбарын ТББ, мэргэжлийн холбоод нэгдмэл бус байгааг харуулж байна.

МҮХАҮТ-аас явуулсан бизнесийн холбогдолтой бодлого боловсруулахад бизнес эрхлэгчдийн оролцооны түвшинг тодорхойлох судалгааны үр дүнгээс үзэхэд бизнес эрхлэгчдийн 91% нь Монгол улсад шийдвэр гаргах түвшинд бизнесийн холбогдолтой ТББ-уудын нөлөөлөл дунд ба сул нөлөөтэй гэж хариулжээ.

Зураг 4. Таны бодлоор Монгол улсад шийдвэр гаргах түвшинд бизнесийн холбогдолтой төрийн бус байгууллагуудын нөлөөлөл ямар түвшинд байна гэж үзэж байна вэ?



Иймд салбар бүрийг төлөөлж чадахуйц салбарын танхимын хэрэгцээ, шаардлага байна гэж үзсэн бөгөөд бизнес, эдийн засгийн салбарын аж ахуй эрхлэгчид нь тус бүрийн салбарын асуудлаа салбарын танхим дээрээ хэлэлцэн

ярилцах, орон нутаг, нийслэлийн аж ахуй эрхлэгчид аймаг, нийслэлийн танхим дээрээ хэлэлцэн, ярилцсаны үндсэн дээр нэг шийдэл, шийдвэрт хүрэх боломжтой болох юм.

Мөн Монголын Үндэсний танхим нь шинээр байгуулагдах зарим салбарын танхимын чиг үүргийг тухайн эдийн засгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн олонхын төлөөллийг нэгтгэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ашгийн төлөө бус хуулийн этгээдэд шууд гэрээний үндсэн дээр шилжүүлж болох зохицуулалтыг тусгаснаар гадна аймаг, нийслэлийн болон салбарын бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөл, даргын чиг үүрэг, тэдгээрийн зохион байгуулалтын асуудлыг хуульд тодорхой зааж өгсөн болно.

Түүнчлэн гадаадын орны туршлагад үндэслэн аймаг, нийслэлийн болон салбарын танхимын гишүүн болгоны оролцоог хангах, хяналт тавих боломжийг бий болгох, үйл ажиллагаа эмх цэгцтэй, ил тод явуулах боломжийг бүрдүүлэх хүрээнд хяналтын нэгж буюу хяналтын зөвлөлийг бий болгохоор тусгалаа.

Тавдугаарт бүлэгт: Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүнчлэл, санхүүжилтийн асуудлыг тусгалаа.

Аймаг, нийслэлийн болон салбарын танхимууд нь Монголын Үндэсний танхимын гишүүн байх бөгөөд харин Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарын танхим, эсхүл өөрийн харьяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах аймаг, нийслэлийн танхимд сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэж болохоор тусгалаа.

Тодруулбал, Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь Монголын Үндэсний танхимд гишүүнээр элсэхгүй бөгөөд өөрийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарын танхим, эсхүл аймаг, нийслэлийн өөрийн харьяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах аймаг, нийслэлийн танхимд гишүүнээр сайн дурын үндсэн дээр элссэнээр Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд оролцохоор боловсрууллаа.

Түүнчлэн, Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үйл ажиллагааны салбараас хамааран хэд хэдэн салбарын танхимд гишүүнээр элсэж болохоос гадна аймаг, нийслэлийн танхимаас гадна салбарын танхимд давхар гишүүнчлэлтэй байж болохоор заасан болно.

Зургаадугаар бүлэгт: Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах журмыг тусгасан.

Энэхүү зохицуулалт нь хуулийн төсөлд шинээр тусгасан зохицуулалт бөгөөд Үндэсний танхим нь худалдаа, аж үйлдвэрийн танхимын зорилгод хамаарах аливаа асуудлаар бүх шатны төрийн байгууллага, албан тушаалтантай чөлөөтэй харилцах, мэргэжлийн танхим нь өөрийн хамаарах эдийн засгийн үйл ажиллагааны салбарын асуудлаар төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтантай шууд харилцах, салбар танхим нь өөрийн харьяа засаг захиргаа

нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах төрийн байгууллага, албан тушаалтантай шууд харилцах байдлаар зохицуулсан.

Долдугаар бүлэгт: Монголын Үндэсний танхимын үзүүлэх үйлчилгээний талаар тусгасан гарал үүсэл тодорхойлох, гэрчлэх, баталгаажуулах, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлыг гэрчлэх, бараа, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар нэвтрүүлэх баримт бичиг олгох, Хөндлөнгийн магадлал, үнэлгээ, дүгнэлт гаргах, орон нутагт үйлдвэрлэсэн бараа, материал үйлчилгээний тодорхойлолт олгох, арбитрын үйлчилгээ, эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ болон оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг тодорхой зааж өгсөн.

Мөн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8.1-д заасны дагуу Үндэсний танхимын дэргэд аж ахуй эрхлэгчийн хооронд үүссэн маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлалын төв ажиллах бөгөөд тус төвийн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэй байгуулсан эвлэрлийн гэрээг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу баталгаажуулсан захирамж гарч, шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэх хууль зүйн боломжийг бий болгосон.

Наймдугаар бүлэгт: Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хараат бус байдал, үйл ажиллагааны тайлан, тус хуулийг зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгасан болно.

Энэ бүлэгт зааснаар Үндэсний танхим, мэргэжлийн танхим болон салбар танхим нь улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах бөгөөд үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан олон нийтэд нээлттэй ил тод байх талаар зохицууллаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАНХИМЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь худалдаа, аж үйлдвэрийн танхимын эрх зүйн байдал, үйл ажиллагааны зарчим, бүрэн эрх, удирдлага зохион байгуулалтыг тодорхойлж, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчныг сайжруулах, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх, хамгаалах харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хууль тогтоомж

2.1.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Төрийн бус байгууллагын тухай хууль³, Улсын бүртгэлийн ерөнхий хууль⁴, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль⁵, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим /цаашид "Монголын Үндэсний танхим" гэх/, аймаг, нийслэлийн танхим болон эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нэгдсэн танхим /цаашид "салбарын танхим" гэх/-ын зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаа, гишүүнчлэл, санхүүжилт, төрийн болон бусад байгууллагатай харилцах болон бусад харилцааг зохицуулна.

3.2.Энэ хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан худалдаа, аж үйлдвэрийн танхимаас бусад худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 01 дэх дугаарт хэвлэгдсэн.

² Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 07 дахь дугаарт хэвлэгдсэн.

³ Төрийн бус байгууллагын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1997 оны 03 дугаарт хэвлэгдсэн.

⁴ Улсын бүртгэлийн ерөнхий хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 30 дахь дугаарт хэвлэгдсэн.

⁵ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 30 дахь дугаарт хэвлэгдсэн.

явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.

4 дүгээр зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын эрх зүйн байдал

4.1.Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчныг сайжруулах, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх, хамгаалах зорилгыг хэрэгжүүлэгч ашгийн төлөө бус хуулийн этгээд байна.

4.2.Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь энэ хуулийн 4.1-д заасан зорилгыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэгч Монголын Үндэсний танхим, аймаг, нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэгч аймаг, нийслэлийн танхим, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын хүрээнд хэрэгжүүлэгч салбарын танхим, гадаад улсад хэрэгжүүлэх төлөөлөгчийн газраас бүрдэнэ.

4.3.Монголын Үндэсний танхим нь Монгол Улсын хэмжээнд нэг байх бөгөөд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлана.

4.4.Монголын Үндэсний танхимыг аймаг, нийслэлийн танхим болон салбарын танхимууд энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу байгуулна.

4.5.Аймаг, нийслэлийн танхим нь тухайн аймаг, нийслэлд нэг байна.

4.6.Салбарын танхим нь эдийн засгийн үйл ажиллагааны салбар бүрд нэг байна.

4.7.Монголын Үндэсний танхим нь гадаад улсад худалдаа, аж үйлдвэрийн танхимын зорилгыг хэрэгжүүлэх төлөөлөгчийн газар байгуулж болно.

4.8.Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь энэ хууль болон өөрийн үндсэн дүрэмд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

5 дугаар зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.хууль дээдлэх;

5.1.2.төр болон улс төрийн нам, эвслээс хараат бус, бие даасан байх;

5.1.3. аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

5.1.4.үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН БҮРЭН ЭРХ

6 дугаар зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүрэн эрх

6.1.Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь энэ хуулийн 4.1-д заасан зорилгын хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад оролцох;

6.1.2.аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төрийн холбогдох байгууллага, албан тушаалтанд төлөөлөн илэрхийлэх, хамгаалах;

6.1.3.аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн асуудлаар төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын явуулж байгаа үйл ажиллагаа, шийдвэрийн үр нөлөөг сайжруулахтай холбоотой санал, зөвлөмж хүргүүлэх;

6.1.4.хуульд заасан болон холбогдох төрийн байгууллагатай зөвшилцсөний дагуу зөвлөл, хороо, комисс зэрэг хамтын удирдлагын бүрэлдэхүүнд төлөөлөл оролцуулах;

6.1.5.эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд хуульд заасан журмын дагуу санал өгөх, холбогдох ажлын хэсгийн бүхэлдэхүүнд орж ажиллах;

6.1.6.эдийн засгийн салбаруудын талаар төрийн бодлого боловсруулахад оролцох;

6.1.7.хууль болон дүрэмд заасан бусад.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан бүрэн эрхийг Монголын Үндэсний танхим үндэсний болон гадаад улсын хүрээнд, аймаг, нийслэлийн танхим нь тухайн аймаг, нийслэлийн хүрээнд, салбарын танхим нь тухайн эдийн засгийн салбарын хүрээнд тус тус хэрэгжүүлнэ.

6.3.Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19.1-д заасан холбогдох шийдвэрийн дагуу төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг хэрэгжүүлж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ТАНХИМЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

7 дугаар зүйл.Монголын Үндэсний танхимын Их хурал

7.1.Монголын Үндэсний танхимын эрх барих дээд байгууллага нь Монголын Үндэсний танхимын их хурал /цаашид "Их хурал" гэх/ байна.

7.2.Их хурлын төлөөлөгчдийг аймаг, нийслэлийн танхим болон салбарын танхимын удирдах зөвлөлийн гишүүд бүрдүүлэх бөгөөд нэг төлөөлөгч саналын нэг эрхтэй байна.

7.3.Их хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит хурлыг дөрвөн жилд нэг удаа хуралдуулна.

7.4.Ээлжит бус их хурлыг Монголын Үндэсний танхимын Ерөнхийлөгч, эсхүл удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй гишүүдийн саналаар зарлан хуралдуулна.

7.5.Монголын Үндэсний танхимын Ерөнхийлөгч, Хяналтын зөвлөлийн гишүүнийг сонгох саналыг нууцаар гаргах бөгөөд санал хураалтыг цахимаар зохион байгуулна.

7.6.Их хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

7.7.Их хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.7.1.Монголын Үндэсний танхимын дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

7.7.2.Монголын Үндэсний танхимын Ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх;

7.7.3.Монголын Үндэсний танхимын Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх;

7.7.4.Монголын Үндэсний танхимын Ерөнхийлөгч болон Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тайлан сонсох, дүгнэлт өгөх;

7.7.5.Их хурал хуралдааны дэгээ өөрөө тогтооно;

7.7.6.Их хурлаар хэлэлцэх асуудлын саналыг тоолох үүрэг бүхий тооллогын комиссыг аймаг, нийслэлийн болон салбарын танхимаас тус бүр хоёр, Монголын Үндэсний танхимаас нэг хүнийг буюу нийт долоон хүнийг нууц санал хураалтаар сонгоно;

7.7.7.хуульд заасан бусад.

7.8.Их хурал төлөөлөгчдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.

7.9.Их хурал асуудлыг хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхын саналаар шийдвэрлэж, шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргана.

8 дугаар зүйл.Монголын Үндэсний танхимын Удирдах зөвлөл

8.1.Монголын Үндэсний танхимын Удирдах зөвлөл /цаашид “Удирдах зөвлөл” гэх/ нь Их хурлын чөлөөт цагт Монголын Үндэсний танхимын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий хамтын удирдлагын байгууллага байна.

8.2.Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дарга нь Монголын Үндэсний танхимын Удирдах зөвлөлийн гишүүн байна.

8.3.Монголын Үндэсний танхимын Ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн дарга байна.

8.4.Монголын Үндэсний танхимын Удирдах зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.4.1.Монголын Үндэсний танхимын жилийн ажлын төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөөг хэлэлцэн батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

8.4.2.Монголын Үндэсний танхимын дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих;

8.4.3.Их хурлыг зарлан хуралдуулах, товыг тогтоох;

8.4.4.Монголын Үндэсний танхимын Ерөнхийлөгчийн санал болгосноор Монголын Үндэсний танхимын бүтцийг хэлэлцэн батлах;

8.4.5.Монголын Үндэсний танхимын үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, нөхцөл, журмыг батлах;

8.4.6.энэ хуулийн 4.6-д заасан салбарын танхим байгуулах эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллыг батлах;

8.4.7.аймаг, нийслэлийн болон салбарын танхимуудын жилийн үйл ажиллагааны нэгдсэн тайланг сонсох;

8.4.8.Удирдах зөвлөлийн ажиллах журмыг тогтоох;

8.4.9.Монголын Үндэсний танхимын гишүүнчлэлийн хураамжийн хэмжээ, түүнээс хөнгөлөх нөхцөл, журмыг тогтоох;

8.4.10.Монголын Үндэсний танхимын Ерөнхийлөгчийн санал болгосноор Үндэсний танхимын дэргэдэх арбитрын даргыг томилж, чөлөөлөх;

8.4.11.хууль, Монголын Үндэсний танхимын дүрэмд заасан бусад бүрэн эрх.

8.5.Удирдах зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд нийт гишүүдийн олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

8.6.Удирдах зөвлөлийн ээлжит бус хурлыг Монголын Үндэсний танхимын Ерөнхийлөгчийн, эсхүл Хяналтын зөвлөлийн, эсхүл Удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар зарлан хуралдуулна.

8.7.Удирдах зөвлөл хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд санал тэнцсэн тохиолдолд нэмэлт санал хураалт явуулж санал дахин тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

8.8.Удирдах зөвлөлийн шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

9 дүгээр зүйл.Монголын Үндэсний танхимын Ерөнхийлөгч

9.1.Ерөнхийлөгчөөр Монголын Үндэсний танхимын Удирдах зөвлөлийн гишүүн, улс төрийн намын харъяалалгүй, төрийн албан хаагч бус, 10-аас доошгүй жил аж ахуйн үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай Монгол Улсын иргэнийг Их хурлаас нууц санал хураалтаар нэг удаа дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

9.2.Ерөнхийлөгч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.2.1.Монголын Үндэсний танхимыг гадаад, дотоод харилцаанд төлөөлөх;

9.2.2.Монголын Үндэсний танхимын нэрийн өмнөөс гэрээ, хэлцэл байгуулах,

9.2.3.Их хурал, Удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулах;

9.2.4.Монголын Үндэсний танхимын гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх, гэрээ байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

9.2.5.Монголын Үндэсний танхимын бүтцийг Удирдах зөвлөлөөр батлуулах;

9.2.6.Монголын Үндэсний танхимын чиг үүрэгт бодлогын дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Зөвлөл, Хороо байгуулах;

9.2.7.хууль болон Монголын Үндэсний танхимын дүрэмд заасан бусад бүрэн эрх.

9.3.Ерөнхийлөгч нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд тушаал гаргана.

9.4.Ерөнхийлөгч дараах үндэслэлээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ Удирдах зөвлөлд гаргана:

9.4.1.эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

9.4.2.төрийн албан тушаалд томилогдохоор болсон, улс төрийн намд гишүүнээр элссэн, эсхүл бүх шатны сонгуульд нэр дэвшихээр болсон.

9.5.Энэ хуулийн 9.4-т заасан нөхцөл бий болсон, эсхүл Ерөнхийлөгч энэ хуулийн 9.1-д заасан шалгуурыг хангахгүй болсон, эсхүл гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож, шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон бол Удирдах зөвлөлөөс Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, ээлжит бус Их хурлыг 30 хоногийн дотор зарлан хуралдуулна.

9.6.Энэ хуулийн 9.5-д заасны дагуу Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд Ерөнхийлөгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг Удирдах зөвлөл томилно.

10 дугаар зүйл.Хяналтын зөвлөл

10.1.Хяналтын зөвлөл нь Монголын Үндэсний танхимын дүрэм, журмын хэрэгжилт болон санхүүгийн үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргах хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох чиг үүргийг хэрэгжүүлнэ.

10.2.Хяналтын зөвлөл нь долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүдийг Их хурлаас нууц санал хураалтаар нэг удаа дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

10.3.Дараах шаардлагыг хангасан хүнийг Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгоно:

10.3.1.банк, санхүү, хууль, эдийн засгийн салбарын дээд боловсролтой, тухайн салбарт таваас доошгүй жил ажилласан;

10.3.2.төрийн улс төрийн болон жинхэнэ алба тушаалд ажилладаггүй;

10.3.3.ял шийтгэлгүй.

10.4.Хяналтын зөвлөлийн даргыг Хяналтын зөвлөлийн гишүүдийн дотроос гишүүдийн олонхын саналаар сонгоно.

10.5.Хяналтын зөвлөл үйл ажиллагаагаа Их хурлын өмнө хариуцан тайлагнана.

10.6.Монголын Үндэсний танхимын Удирдах зөвлөлийн гишүүн, Ерөнхийлөгч, санхүүгийн асуудал хариуцсан ажилтан нь Хяналтын зөвлөлийн гишүүн байхыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН БОЛОН САЛБАРЫН ТАНХИМЫГ БАЙГУУЛАХ, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

11 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийн болон салбарын танхимыг байгуулах

11.1.Аймаг, нийслэлийн танхимыг тухайн аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 50-аас доошгүй тооны аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд сайн дурын үндсэн дээр нэгдэн энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу байгуулах бөгөөд үйл ажиллагаагаа бие даан хэрэгжүүлнэ.

11.2.Салбарын танхимыг эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 50-аас доошгүй тооны аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд сайн дурын үндсэн дээр нэгдэн энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу байгуулах бөгөөд үйл ажиллагаагаа бие даан хэрэгжүүлнэ.

11.3.Аймгийн танхим байгуулагдаагүй хоёр болон түүнээс дээш аймгийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд нэгдэж аймаг дундын танхим, эсхүл хэд хэдэн аймгийн танхим хоорондоо нэгдэж аймаг дундын танхим байгуулж болно. Нэгдсэн аймгийн танхимын эрх, үүрэг шинээр бий болсон аймаг дундын танхимд шилжинэ.

11.4.Хэд хэдэн салбарын танхим нэгдэж салбарын дундын танхим байгуулж болно. Нэгдсэн салбарын танхимын эрх, үүрэг шинээр бий болсон салбарын дундын танхимд шилжинэ.

11.5.Тухайн эдийн засгийн үйл ажиллагааны салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдийн тоо энэ хуулийн 11.2-т заасан шаардлагыг хангахгүй тохиолдолд тухайн салбарын хуулийн этгээдийн олонх нэгдэн салбарын танхим байгуулж болно.

11.6.Монголын Үндэсний танхим нь шинээр байгуулагдах зарим салбарын танхимын чиг үүргийг тухайн эдийн засгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж

ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн олонхын төлөөллийг нэгтгэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ашгийн төлөө бус хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр шилжүүлж болно.

12 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын Бүх гишүүдийн хурал

12.1. Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын удирдах дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал /цаашид “Бүх гишүүдийн хурал” гэх/ байна.

12.2. Бүх гишүүдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит хурлыг дөрвөн жилд нэгээс доошгүй удаа хуралдуулна.

12.3. Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дарга эсхүл удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар зарлан хуралдуулна.

12.4. Бүх гишүүдийн хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.4.1. энэ хуульд нийцүүлэн аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

12.4.2. Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх;

12.4.3. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан сонсох, зөвлөмж, чиглэл өгөх;

12.4.4. дүрэмд заасан бусад.

12.5. Бүх гишүүдийн хурал асуудлыг хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхын саналаар шийдвэрлэж, шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргана.

13 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын Удирдах зөвлөл

13.1. Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын Удирдах зөвлөл нь бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт аймаг, нийслэлийн болон салбарын танхимын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий хамтын удирдлагын байгууллага байна.

13.2. Удирдах зөвлөл нь 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

13.3. Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд нэг эцсийн өмчлөгчтэй таваас дээш тооны хуулийн этгээд байхыг хориглоно.

13.4. Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын Удирдах зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.4.1. аймаг, нийслэлийн болон салбарын танхимын үндсэн чиглэл, бодлогыг тодорхойлох;

13.4.2.аймаг, нийслэлийн болон салбарын танхимын даргыг сонгох, чөлөөлөх;

13.4.3.аймаг, нийслэлийн болон салбарын танхимын үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

13.4.4.аймаг, нийслэлийн болон салбарын танхимын бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах;

13.4.5.аймаг, нийслэлийн болон салбарын танхимын даргын санал болгосноор аймаг, нийслэлийн болон салбарын танхимын гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх;

13.4.6.аймаг, нийслэлийн болон салбарын танхимын бүтцийг батлах;

13.4.7.аймаг, нийслэлийн болон салбарын танхимын бүх гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудлыг батлах;

13.4.8.аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дүрэмд заасан бусад.

13.5.Удирдах зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд нийт гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

13.6.Удирдах зөвлөлийн ээлжит бус хурлыг дарга, эсхүл удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар зарлан хуралдуулна.

13.7.Удирдах зөвлөл хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд санал тэнцсэн тохиолдолд нэмэлт санал хураалт явуулж санал дахин тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

14 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дарга

14.1.Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын даргыг Удирдах зөвлөлийн хурлаас нууц санал хураалтаар нэг удаа дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

14.2.Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дарга нь тухайн танхимын удирдах зөвлөлийн дарга байна.

14.3.Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.3.1.аймаг, нийслэлийн болон салбарын танхимыг төлөөлөх;

14.3.2.аймаг, нийслэлийн болон салбарын танхимын нэрийн өмнөөс гэрээ, хэлцэл байгуулах;

14.3.3.аймаг, нийслэлийн болон салбарын танхимын бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулах;

14.3.4.хууль болон аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дүрэмд заасан бусад бүрэн эрх.

14.4.Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дарга нь Удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг тухай бүр Монголын Үндэсний танхимд хүргүүлнэ.

14.5.Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дарга нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд тушаал гаргана.

14.6.Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дарга дараах үндэслэлээр үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ Удирдах зөвлөлд гаргана:

14.6.1.эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

14.6.2.төрийн албан тушаалд томилогдохоор болсон.

14.7.Энэ хуулийн 14.6-д заасан нөхцөл бий болсон эсхүл гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож, шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон бол удирдах зөвлөлөөс даргын бүрэн эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, бүх гишүүдийн ээлжит бус хурлыг 30 хоногийн дотор зарлан хуралдуулна.

14.8.Энэ хуулийн 14.7-д заасны дагуу даргын бүрэн эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг удирдах зөвлөл томилно.

15 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын хяналтын зөвлөл

15.1.Хяналтын зөвлөл нь аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргах хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох чиг үүргийг хэрэгжүүлнэ.

15.2.Хяналтын зөвлөлийн гишүүдийг бүх гишүүдийн хурлаас нууц санал хураалтаар нэг удаа дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

15.3.Хяналтын зөвлөл үйл ажиллагаагаа бүх гишүүдийн хурлын өмнө хариуцан тайлагнана.

15.4.Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын удирдах зөвлөлийн гишүүн, дарга болон санхүүгийн асуудал хариуцсан ажилтан нь хяналтын зөвлөлийн гишүүн, дарга байхыг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ГИШҮҮНЧЛЭЛ, САНХҮҮЖИЛТ

16 дугаар зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүнчлэл

16.1.Аймаг, нийслэлийн болон салбарын танхимууд нь Монголын Үндэсний танхимын гишүүн байна.

16.2.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарын

танхим, эсхүл өөрийн харьяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах аймаг, нийслэлийн танхимд сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэж болно.

16.3.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үйл ажиллагааны салбараас хамааран хэд хэдэн салбарын танхимд гишүүнээр элсэж болно.

16.4.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь аймаг, нийслэлийн танхимаас гадна салбарын танхимд давхар гишүүнчлэлтэй байж болно.

16.5.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь Монголын Үндэсний танхимд гишүүнээр элсэхгүй.

16.6.Төрийн өмчийн 50-аас дээш хувийн оролцоотой хуулийн этгээд нь худалдаа, аж үйлдвэрийн танхимд гишүүнээр элсэхгүй.

16.7.Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь гишүүнчлэлийнхээ бүртгэлийг цахим хэлбэрээр хөтөлнө.

17 дугаар зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын санхүүжилт, зарцуулалт

17.1.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 17.1.1.гишүүнчлэлийн хураамж;
- 17.1.2.хандив, тусламж;
- 17.1.3.үйлчилгээний орлого;
- 17.1.4.хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

17.2.Энэ хуулийн 17.1.1-д заасан гишүүнчлэлийн хураамжийн хэмжээг тухайн танхимын удирдах зөвлөл батална.

17.3.Аймаг, нийслэлийн болон салбарын танхим нь Монголын Үндэсний танхимд, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь аймаг, нийслэлийн болон салбарын танхимд гишүүнчлэлийн хураамж төлнө.

17.4.Монголын Үндэсний танхимд тухайн жилийн гишүүнчлэлийн хураамжаа төлөөгүй аймаг, нийслэлийн болон салбарын танхим нь Монголын Үндэсний танхимын Их хурал, Удирдах зөвлөлд сонгох, сонгогдох эрх эдлэхгүй.

17.5.Аймаг, нийслэлийн болон салбарын танхимд тухайн жилийн гишүүнчлэлийн хураамжаа төлөөгүй хуулийн этгээд нь аймаг, нийслэлийн болон салбарын танхимын бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөлд сонгох, сонгогдох эрх эдлэхгүй.

17.6.Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь гишүүнчлэлийн хураамж болон үйл ажиллагааны орлогоо зөвхөн хууль, дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд зарцуулна.

17.7.Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь жил бүр санхүүгийн тайландаа хөндлөнгийн аудит хийлгэх бөгөөд гишүүд, олон нийтэд нээлттэй байна.

17.8.Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь өөрийн зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэхдээ бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМААС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНТАЙ ХАРИЛЦАХ

18 дугаар зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах

18.1.Монголын Үндэсний танхим нь худалдаа, аж үйлдвэрийн танхимын зорилгод хамаарах аливаа асуудлаар бүх шатны төрийн байгууллага, албан тушаалтантай шууд харилцана.

18.2.Аймаг, нийслэлийн танхим нь үйл ажиллагаа явуулж байгаа аймаг, нийслэлийн төрийн байгууллага, албан тушаалтантай шууд харилцах бөгөөд бусад харилцаанд Монголын Үндэсний танхимаар дамжуулан харилцана.

18.3.Салбарын танхим нь өөрийн хамаарах эдийн засгийн үйл ажиллагааны салбарын асуудлаар холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтантай шууд харилцах бөгөөд бусад харилцаанд Монголын Үндэсний танхимаар дамжуулан харилцана.

18.4.Бүх шатны төрийн байгууллага, албан тушаалтан нь худалдаа, аж үйлдвэрийн танхим энэ хуульд заасан зорилго, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ТАНХИМЫН ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

19 дүгээр зүйл.Гарал үүсэл тодорхойлох, гэрчлэх, баталгаажуулах

19.1.Монголын Үндэсний танхим нь Монгол Улсаас гарал үүсэлтэй экспортын барааны гарал үүслийг тодорхойлох, гэрчлэх үйлчилгээ үзүүлнэ.

19.2.Монголын Үндэсний танхим нь эрх бүхий этгээдийн хүсэлтээр гарал үүслийн гэрчилгээг дахин шалгах буюу баталгаажуулж болно.

19.3.Гарал үүслийн гэрчилгээ нь Монголын Үндэсний танхимаас олгосон үнэт цаас бүхий хууль ёсны баримт бичиг бөгөөд олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд хүчинтэй байна.

19.4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4.3-т заасан бараа, материалын гарал үүсэл, үзүүлж байгаа үйлчилгээг нийслэл, дүүрэг, улсын зэрэглэлтэй хотод хамаарахгүй орон нутагт үйлдвэрлэсэн талаарх тодорхойлолт олгоно.

19.5.Монголын Үндэсний танхим нь бараа, бүтээгдэхүүний гарал үүслийг Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээрт заасан нөхцөл, журмыг баримтлан гэрчилнэ.

20 дугаар зүйл.Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлыг гэрчлэх

20.1.Монголын Үндэсний танхим нь гэрээний талуудын хооронд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад үүссэн гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийг гэрчилнэ.

20.2.Монголын Үндэсний танхим нь гэрээний талуудын хооронд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад үүссэн хүнд нөхцөл байдлыг талуудын гэрээний тохиролцоо болон ханш, инфляцийн өөрчлөлтийг үндэслэн гэрчилнэ.

20.3.Монголын Үндэсний танхимын Удирдах зөвлөл нь энэ хуулийн 20.1-д заасан үйлчилгээний нөхцөл, журмыг олон улсын худалдааны танхимын нийтлэг жишигт нийцүүлэн батална.

21 дүгээр зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар нэвтрүүлэх баримт бичиг олгох

21.1.Монголын Үндэсний танхим нь Монгол Улсын хилээр бараа бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар татваргүй нэвтрүүлэх, гарахад шаардлагатай үндэсний гаалийн мэдүүлгийг орлох баримт бичиг /АТА карней/ олгох, бүрдүүлэлт хийх, хяналт тавих үйлчилгээ үзүүлнэ.

21.2.Монголын Үндэсний танхим нь энэ хуулийн 21.1-д заасан үйлчилгээг үзүүлэхэд Монгол Улсын олон улсын гэрээнд заасан нөхцөл, журмыг баримтлана.

22 дугаар зүйл.Хөндлөнгийн магадлал, үнэлгээ, дүгнэлт гаргах

22.1.Монголын Үндэсний танхим нь хувь хүн, хуулийн этгээдийн хүсэлтээр экспорт, импортын барааны гэрээгээр тохирсон тоо, чанар, иж бүрдлийг хараат бусаар хянан хөндлөнгийн магадлал гаргана.

22.2.Монголын Үндэсний танхим нь хувь хүн, хуулийн этгээдийн хүсэлтээр хөндлөнгийн үнэлгээ болон дүгнэлт гаргах үйлчилгээг үзүүлнэ.

23 дугаар зүйл.Арбитрын үйлчилгээ

23.1.Монголын Үндэсний танхимын дэргэд байнгын, хараат бус, бие даасан арбитрыг Арбитрын тухай хуулийн 7.3-т заасны дагуу байгуулан ажиллуулна.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан арбитрын үйл ажиллагаатай холбоотой харилцааг Арбитрын тухай хуульд заасны дагуу зохицуулна.

24 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ

24.1.Монголын Үндэсний танхимын дэргэд маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх зорилготой эвлэрүүлэн зуучлалын төв ажиллуулж болно.

24.2.Энэ хуулийн 24.1-д заасан эвлэрүүлэн зуучлалын төвийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар зохицуулна.

25 дугаар зүйл.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээ

25.1.Монголын Үндэсний танхим нь Оюуны өмчийн тухай хуулийн 16.2-т заасан оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээ үзүүлж болно.

25.2.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь үйл ажиллагаандаа Оюуны өмчийн тухай хуулийн 16.6-д заасан журмыг баримтална.

25.3.Энэ хуулийн 25.1-д заасан оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг Оюуны өмчийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

26 дугаар зүйл.Монголын Үндэсний танхимын үйлчилгээний эрхийг шилжүүлэх

26.1.Монголын Үндэсний танхим нь зарим үйлчилгээг үзүүлэх эрхээ аймаг, нийслэлийн болон салбарын танхимд гэрээний үндсэн дээр шилжүүлж болно.

26.2.Үйлчилгээний эрх шилжүүлэхтэй холбоотой харилцааг Монголын Үндэсний танхимын дүрэмд зааснаар зохицуулна.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

27 дугаар зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хараат бус байдал

27.1.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаа нь төр болон улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байна.

27.2.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

27.2.1.улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаа, нэр дэвшигчтэй холбоотой аливаа үйл ажиллагаа явуулах;

27.2.2.энэ хууль болон дүрэмд заасан зорилгоос ангид үйл ажиллагаа явуулах.

27.3.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг худалдаа, аж үйлдвэрийн танхимын дүрмээр зохицуулна.

28 дугаар зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагааны тайлан

28.1.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан олон нийтэд нээлттэй, ил тод байна.

28.2.Аймаг, нийслэлийн болон салбарын танхим нь жил бүрийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Монголын Үндэсний танхимд хүргүүлнэ.

29 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

29.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ
ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 1995 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.5¹ дэх хэсэг нэмсүгэй:

“22.5¹.Энэ хуулийн 22.4.2 дахь заалтад заасан бизнесийн тогтсон хэм хэмжээг сахин биелүүлсэн нөхцөл, боломжийг хангасан эсэх асуудлыг нягтлахдаа Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын санал, дүгнэлтийг авна.”

2 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.5.Энэ хуулийн 9.3-т заасан зөвлөлийн бүрэлдэхүүнд Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах төлөөллийг оруулсан байна.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн "бүрдэнэ." гэсний дараа "Орон тооны бус нэг гишүүнийг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын саналыг үндэслэн томилно." гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Статистикийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өрсөлдөөний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн "Монголын" гэсний дараа "Үндэсний" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Худалдаа” гэснийг “Монголын Үндэсний худалдаа” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Чөлөөт бүсийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “хөрөнгө оруулагчдын” гэсний дараа “болон Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийн “Эвлэрүүлэн зуучлалыг” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол эвлэрүүлэн зуучлалыг” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “Энэ” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “мэргэжлийн холбоо,” гэсний дараа “Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим,” гэж, 22 дугаар зүйлийн 22.3.2 дахь заалтын “ажил олгогч,” гэсний дараа “Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74^{1.2} дахь хэсгийн “эвлэрүүлэн зуучлагч” гэсний дараа “, эсхүл талууд хүсэлт гаргасан тохиолдолд Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлагч” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хуульд заасан Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим нь 1995 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим төрийн бус байгууллага байна.

2 дугаар зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн дагуу хуралдах Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын анхдугаар их хурлыг энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан нөхцөл биелснээс хойш 180 хоногийн дотор зарлан хуралдуулах бөгөөд Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим хариуцан зохион байгуулна.

3 дугаар зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аймаг, нийслэлийн танхимын тоо 16, салбарын танхимын тоо 16 ба түүнээс дээш болсноос хойш Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Удирдах зөвлөлөөс энэ хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу Их хурал хуралдах товыг тогтооно.

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан анхдугаар их хурлын төлөөлөгчдийг сонгоход Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасан журмыг баримтална.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсгийн "хараат бус гишүүнээр" гэсний дараа "Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН

**ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ**

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

УДИРТГАЛ

НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

**ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ ХЭСГИЙГ СОНГОСОН БАЙДАЛ,
ҮНДЭСЛЭЛ**

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ

ТАВ.ЗӨВЛӨМЖ

Удиртгал

Монгол Улсын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим /цаашид "Үндэсний танхим" гэх/-ын захиалгаар Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлыг хийж гүйцэтгэж, энэхүү тайланг боловсруулав. Энэхүү үнэлгээний тайланг (1) Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр Тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу, (2) ажлын захиалагч болох Үндэсний танхим болон хуулийн төслийг боловсруулсан багийн гишүүдээс хараат бусаар хийж гүйцэтгэсэн болно.

Ингэхдээ хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөлд тусгасан зорилгод хүрэхэд чиглэгдсэн, тус зорилгод хүрэх боломжтой эсэх болон хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагыг хангах боломжтой эсэх талаар голчлон анхаарч хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлыг хийж гүйцэтгэв.

Энэхүү үнэлгээний тайлан нь хуулийн төслийг бүхэлд нь хамрахгүй бөгөөд гагцхүү тайланд тусгасан үнэлгээ хийсэн шалгуур үзүүлэлт болон хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсгээр хязгаарлагдах юм.

НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал /цаашид "Аргачлал" гэх/-ын 1.4-т заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааны эхний үе шат нь шалгуур үзүүлэлтийг сонгох үе шат юм. Аргачлалын 2.2-т хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх зургаан төрлийн үндсэн шалгуур үзүүлэлтийг тогтоосон нь "зорилгод хүрэх байдал", "практикт хэрэгжих боломж", "ойлгомжтой байдал", "хүлээн зөвшөөрөгдөх байдал", "зардал", "харилцан уялдаа" гэсэн шалгуур үзүүлэлтүүд байна. Энэхүү хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ /цаашид "Үнэлгээ" гэх/-г "зорилгод хүрэх байдал" болон "харилцан уялдаа" гэсэн хоёр үндсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийж гүйцэтгэв. Аргачлалын 2.9-т шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тооцож болох тухай заасан байна. Иймд дээрх хоёр шалгуур үзүүлэлтийг сонгох нь Аргачлалд нийцэх юм.

Аргачлалын 2.8-д "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгахгаар заасан. Иймд тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг олон талаас нь үнэлэх тул Үнэлгээг бүтээлч байлгах үүднээс тус шалгуур үзүүлэлтийг сонгов.

Аргачлалын 2.3-т заасан ёсоор "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлт нь тухайн хуулийн төслөөр тавьж байгаа зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судалдаг шалгуур үзүүлэлт юм. Иймд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь хуулийн төсөл, түүний үзэл баримтлалд тусгагдсан зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэлэх үүднээс тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

ХОЁР: ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ ХЭСГИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Аргачлалын 1.4.2-т заасан ёсоор Үнэлгээний хоёр дахь үе шат нь Хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсгийг сонгох үе шат байна. Энэхүү үе шатанд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсэг буюу тодорхой зохицуулалтуудыг сонгон авах тул Үнэлгээг бодитой хийх үүднээс хуулийн төслийн чухал ач холбогдолтой, гол хэсгийг сонгож авах нь чухал юм. Энэ талаар Аргачлалын 3.2-т “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоохдоо шууд үр дагавар үүсгэж байгаа гол ач холбогдолтой зохицуулалтыг олж тогтоох нь зүйтэй” хэмээн заасан байна. Иймд хуулийн төслийн үзэл баримтлалд голчлон тусгагдсан, хуулийн төслийн гол, чухал ач холбогдолтой зохицуулалт агуулсан зүйл, заалтуудыг сонгон авч үнэлгээ хийхийг чухалчлав.

(1) Хуулийн төслийн үзэл баримтлалд эдийн засгийн үйл ажиллагааны салбар тус бүрээр нэгдсэн мэргэжлийн худалдаа, аж үйлдвэрийн танхимыг хөгжүүлэх, бизнесийн салбар бүрт аж ахуй эрхлэгчийн нэг шийдэл, шийдвэрт хүрэх байдлыг хангах тухай голчлон тусгагдсан байна. Иймд хуулийн төслийн энэ талаарх зохицуулалтууд болох 14.1, 14.2 дахь заалтуудыг хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсэг болгон сонгов.

(2) Хуулийн төслийн үзэл баримтлалд Үндэсний танхим нь бие даасан, хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулах санхүүгийн боломж бий болгох тухай тусгагдсан байна. Иймд хуулийн төслийн энэ талаарх зохицуулалтууд болох 4.1.2, 26.5.13, 26.5.14, 27.2, 27.5 дахь заалтууд болон 40 дүгээр зүйлийг хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсэг болгон сонголоо.

(3) Хуулийн төслийн үзэл баримтлал болон төсөлд Үндэсний танхим нь аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах тухай голчлон тусгагдсан байна. Иймд үүнтэй холбоотой зохицуулалтууд болох төслийн 20 дугаар зүйл, 7.1, 7.4, дахь заалтуудыг хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсэг болгон сонгов.

(4) Хуулийн төсөл болон төслийн үзэл баримтлалд Үндэсний танхимын гишүүн байгууллагууд хооронд үүссэн маргааныг эвлэрүүлэн зуучлалын тусламжтайгаар шийдвэрлэх, бизнесийн эрх зүйн ач холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлэх мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчид бий болгох тухай тусгагдсан байна. Иймд энэ талаарх зохицуулалтууд болох төслийн 33 дугаар зүйлийг бүхэлд нь, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл болон Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсэг болгон сонголоо.

(5) Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төсөлд Үндэсний танхим нь төрийн холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний дагуу зөвлөл, хороо, комисс зэрэг хамтын удирдлагын бүрэлдэхүүнд төлөөлөл оролцуулах тухай тусгагдсан байна. Иймд энэ талаарх зохицуулалтууд болох төслийн 21.1.3 дахь заалт болон хуулийн төсөлтэй цуг нэмэлт, өөрчлөлт орох бусад хуулийн төслүүдийн холбогдох заалтуудыг хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсэг болгон сонгов.

Хуулийн төслийн дээрх таван хэсгийн үр нөлөөг “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх болно. Ингэснээр хуулийн төслийн холбогдох заалтууд нь хуулийн төсөл болон төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилгод хүрч чадахуйц эсэхийг үнэлэх юм. Аргачлалын 4.5.2-т “Хуулийн төсөлд зорилгод чиглэсэн хэд хэдэн зохицуулалт, арга хэмжээг тусгасан бол арга хэмжээ, зохицуулалт бүрт дүн шинжилгээ хийж, тэдгээрийн зорилгод хүрэх боломжийг харьцуулна” гэж заасан байна. Иймд хуулийн төслийн нэг зорилгод чиглэгдсэн хэд хэдэн зохицуулалтыг хамтад нь сонгон авч энэхүү үнэлгээг хийсэн болно.

(6) Аргачлалын 3.3-т “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг шалгах тохиолдолд хуулийн төслийн тодорхой зүйл, заалтыг бус хуулийн төслийг бүхэлд нь шалгах тухай заасан байна. Иймд тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь шалгах болно.

Хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсэг болон үр нөлөөг тооцох шалгуур үзүүлэлтийг хүснэгтэлсэн байдал:

№	Шалгуур үзүүлэлт	Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсэг
1	Зорилгод хүрэх байдал	Төслийн 14.1, 14.2 дахь заалтууд
2		Төслийн 4.1.2, 26.5.13, 26.5.14, 27.2, 27.5 дахь заалтууд болон 33 дугаар зүйл
3		Төслийн 20 дугаар зүйл, 7.1, 7.4 дэх заалтууд
4		33 дугаар зүйлийг бүхэлд нь болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл
5		Төслийн 21.1.3 дахь заалт болон хуулийн төсөлтэй цуг нэмэлт, өөрчлөлт орох бусад хуулийн төслүүдийн холбогдох заалтууд
6	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан бизнесийн салбар тус бүрээр Дагнасан танхимыг хөгжүүлэх, бизнесийн салбар аж ахуй эрхлэгчийн нэг шийдэл, шийдвэрт хүрэх байдлыг хангах зорилгын хүрээнд хуулийн төслийн 7.1, 14.1, 14.2 дахь заалтуудын үр нөлөөг үнэлсэн байдал.

Хуулийн төслийн үзэл баримтлалын “1.2.Практик шаардлага, Тогтолцооны хувьд” хэсэгт “*бизнесийн салбар тус бүрээр нэгдсэн мэргэжлийн Танхим байгуулах замаар Танхимыг хөгжүүлэх, эдгээр дагнасан танхимын төлөөлөл Үндэсний Танхимын удирдах байгууллагыг бүрдүүлэх*” тухай, “Гурав.Хууль батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ” хэсэгт “*Танхимын тогтолцоо нь үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нэг танхим болон эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нэгдсэн мэргэжлийн танхим, аймаг, нийслэлийн салбар танхимуудаас бүрдэх тул тодорхой бизнес, эдийн засгийн салбарын аж ахуй эрхлэгчид нь тус бүрийн салбарын асуудлаа дагнасан танхим дээрээ хэлэлцэн ярилцсаны үндсэн дээр нэг шийдэл, шийдвэрт хүрэх боломжтой болох юм*” хэмээн тусгасан байна. Иймд хуулийн төслөөс дээрх зорилготой холбоотой зохицуулалт бүхий 14.1, 14.2 дахь заалтуудын үр нөлөөг “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх болно.

Хуулийн төслийн 18.2-т “Энэ хуулийн 14.1-д заасан жагсаалтад үндэслэн тодорхой нэг эдийн засгийн үйл ажиллагааны салбарт үйл ажиллагаа явуулдаг 50-аас доошгүй тооны аж ахуй эрхлэгч этгээд нь тухайн салбарын мэргэжлийн танхимыг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу үүсгэн байгуулж болно.” гэж тус тус заасан байна. Ингэснээр аливаа эдийн засгийн үйл ажиллагааны салбар бүрт Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бодлого нэгдмэл байх, бодлого боловсруулагчдад өөрсдийн дуу хоолойг нэгдмэл байдлаар хүргэх боломжтой болохоор байна. Хуулийн төслийн тус зохицуулалтуудын хүрээнд Мэргэжлийн танхимыг аль гишүүн, аж ахуй эрхлэгчид үүсгэн байгуулснаас үл хамааран тухайн салбарын бусад аж ахуй эрхлэгчид ямар нэгэн нэмэлт шаардлага, хураамжгүйгээр мэргэжлийн танхимын гишүүн байх, бусад гишүүдтэй ижил тэгш саналын эрхтэй байхаар байна. Иймд мэргэжлийн танхим нь тухайн салбарын аж ахуй эрхлэгчдийн төлөөлөл, нэгдмэл байр суурийг илэрхийлэгч байж чадахаар байна. Хэрэв мэргэжлийн танхимд гишүүнээр элсэн ороход нэмэлт шаардлага тавигддаг, нэмэлт хураамж, төлбөр төлөгддөг бол үүнээс улбаалан тухайн бизнесийн салбарын зарим аж ахуйн нэгжид мэргэжлийн танхимд гишүүнээр элсэхгүй байх, ингэснээр мэргэжлийн танхим нь тухайн бизнесийн салбарын нэгдмэл дуу хоолой, байр суурийг илэрхийлэгч байж чадахгүйд хүрэх эрсдэлтэй болохоор байна.

Мэргэжлийн танхим нь тодорхой эдийн засгийн үйл ажиллагааны салбараар дагнан байгуулагдаж буй тул тухайн салбар аж ахуй эрхлэгчид нь хоёр буюу түүнээс дээш мэргэжлийн танхим байгуулах нөхцөлд тэдгээрийн шийдвэр, бодлого зөрчилдөх, тодорхой асуудлаар танхимын байр суурь тодорхой бус болох сөрөг үр дагаварт хүргэх юм. Тухайлбал, уул уурхай, ашигт малтмалын чиглэлийн бизнес эрхлэгчид хоёр буюу түүнээс дээш мэргэжлийн танхим байгуулах нөхцөлд тэдгээр нь хоорондоо зөрчилдөх байр суурь баримтлах, шийдвэр гаргах, улмаар аль мэргэжлийн танхимын байр суурийг тухайн салбарын нэгдмэл шийдвэр, байр суурь гэж хүлээж авах эсэх нь тодорхой бус болох юм.

Мэргэжлийн танхим олонхоор шийдвэр гаргасан нөхцөлд цөөнх болж буй гишүүд өөрсдийн байр суурийг бодлого тодорхойлогчид, Үндэсний танхимд хүргэх, илэрхийлэх эрхийг нь хуулийн төслөөр хязгаарлаагүй байна. Мөн мэргэжлийн танхимын цөөнх болсон гишүүд өөрсдийн байр суурь, шийдвэр, түүний үндэслэл, судалгааны талаар мэргэжлийн танхимын бусад гишүүддээ танилцуулах замаар

дэмжлэг авах, олонх болох боломжтой бөгөөд ингэснээр мэргэжлийн танхимын шийдвэр гаргах үйл явц нь мэтгэлцээн, судалгаанд үндэслэсэн, ардчилсан үйл явц байж чадахаар байна.

Түүнчлэн, хуулийн төслийн 7.1-д Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, энэ хуулийн 7.5-д зааснаас бусад аж ахуй эрхлэгч нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй чиглэлээр байгуулагдсан мэргэжлийн танхим эсхүл өөрийн харьяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах аймаг, нийслэлийн танхимд заавал гишүүнчлэлтэй байна.” гэж заасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан “бизнесийн салбар аж ахуй эрхлэгчийн нэг шийдэл, шийдвэрт хүрэх байдлыг хангах” зорилгод хүрэхэд чиглэсэн чухал зохицуулалт болсон байна. Учир нь, ашгийн төлөөх хуулийн этгээд бүр мэргэжлийн танхим, эсхүл салбар танхимын гишүүнчлэлтэй байснаар тухайн аймаг нийслэл, мөн бизнес, эдийн засгийн салбарын аж ахуй эрхлэгчдийн нэгдмэл байр суурийг илэрхийлэгч байж чадахаар байна. Хэрэв гишүүнчлэл нь сайн дурын байх нөхцөлд мэргэжлийн танхим нь тухайн салбарын нийт аж ахуй эрхлэгчдийн төлөөлөл бус зөвхөн мэргэжлийн танхимд бүртгэлтэй, гишүүнчлэлтэй хэсэг бүлэг аж ахуй эрхлэгчдийн төлөөлөл болох эрсдэлтэй байна.

Иймд хуулийн төслийн дээрх зохицуулалтууд нь төслийн үзэл баримтлалд тусгагдсан “тодорхой бизнес, салбарын аж ахуй эрхлэгчид тус салбарын асуудлаа мэргэжлийн танхим дээрээ хэлэлцэн ярилцсаны үндсэн дээр нэг шийдэл, шийдвэрт хүрэх боломжтой болох юм” гэх зорилгод хүрэх боломжтой гэж дүгнэх үндэслэлтэй байна.

Харин хуулийн төслийн 14.2-т тодорхой нэг эдийн засгийн үйл ажиллагааны салбарт үйл ажиллагаа явуулдаг 50-аас доошгүй тооны аж ахуй эрхлэгч этгээд нь тухайн салбарын мэргэжлийн танхимыг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу үүсгэн байгуулахаар заасан байна. Ингэснээр тухайн салбарын 50-иас доошгүй гишүүн хуулийн этгээд мэргэжлийн танхим байгуулах нь зөв гэж шийдсэн нөхцөлд мэргэжлийн танхим байгуулагдахаар байна. Хуулийн төслийн тус зохицуулалт нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 8.2-т *“Аймаг, нийслэлийн, аймаг дундын танхимыг 50-иас доошгүй аж ахуйн нэгж, байгууллага ... үүсгэн байгуулж болно”* гэж заасантай төстэй буюу хуулийн тус заалтаас улбаатай гэж ойлгогдож байна. Хуулийн төслийн тус заалтын дагуу (1) 50-иас төдийлөн ихгүй оролцогч, аж ахуй эрхлэгчтэй эдийн засгийн салбарын хувьд мэргэжлийн танхим үүсгэн байгуулах нь хүндрэлтэй болох, (2) 50-аас цөөн тооны оролцогч бүхий эдийн засгийн тодорхой салбарт мэргэжлийн танхим байгуулагдахгүй байх үр дагаварт хүрэхээр байна. Тухайлбал, Монгол Улсад арилжааны банк болон даатгалын бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг нийт компаниудын тоо нь 50 хүрдэггүй. Иймд нийт оролцогчдын тоо нь 50 хүрэхгүй эдийн засгийн салбарын оролцогч, аж ахуй эрхлэгчид мэргэжлийн танхим байгуулах болон Үндэсний танхимын удирдлагад төлөөлөл оролцуулах боломжгүй болох, улмаар тэдгээр аж ахуй эрхлэгчдийн байр суурь Үндэсний танхимын шийдвэр, бодлогод тусгалаа олохгүй байх эрсдэлтэй байна. Иймд хуулийн төслийн 14.2-т заасан мэргэжлийн танхим байгуулах гишүүдийн “50-аас доошгүй” гэх босго нь эдийн засгийн үйл ажиллагааны салбар тус бүрт мэргэжлийн танхим байгуулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, зорилгыг бүрэн хангаж чадахааргүй байна.

Хуулийн төслийг үзэл баримтлалд тусгагдсан Танхим нь бие даасан, хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулах санхүүгийн боломж бий болгох зорилгын хүрээнд төслийн 4.1.2, 26.5.13, 26.5.14, 27.2, 27.5 дахь заалтууд болон 33 дугаар зүйлийн үр нөлөөг үнэлсэн байдал.

Хуулийн төслийн үзэл баримтлалын “Гурав.Хууль батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч

хэрэгжүүлэх арга хэмжээ” хэсгийн 5-д “Үндэсний танхим, мэргэжлийн танхим болон салбар танхим нь үйл ажиллагаагаа хараат бус, бие даасан байдлаар явуулах санхүүгийн боломж бий болно. Ингэснээр аж ахуй эрхлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлд ахиц гарах болно” гэж, 9-т “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаа улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид явуулах боломж бий болно” гэж, хуулийн төслийн 4.1.2-т Танхимын үйл ажиллагаанд улс төрийн нам, эвслээс хараат бус, бие даасан байх зарчмыг баримтлах тухай тус тус заасан байна. Иймд хуулийн төслийн холбогдох заалтууд тус зорилгод хүрч чадах эсэхийг дүгнэх үүднээс “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэв.

Хуулийн төслийн 4.1.2-т Танхимын үйл ажиллагаа нь улс төрийн нам, эвслээс хараат бус, бие даасан байх тухай, 40.2.1-т Үндэсний танхим, салбар танхим болон мэргэжлийн танхимын үйл ажиллагаанд улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаа, нэр дэвшигчийг дэмжсэн буюу эсэргүүцсэн аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглох тухай тус тус заасан байна. Гэвч Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бие даасан, хараат бус байдлыг хангах нь зөвхөн улс төрийн нам, эвслийн хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалах явдлаар хязгаарлагдахгүй гэж үзэж байна. Худалдаа, аж үйлдвэрийн танхим бие даасан, хараат бус байх үүднээс төрийн байгууллага, түүний албан хаагч, аливаа аж ахуйн нэгж байгууллага, иргэн хэний ч болов хөндлөнгийн нөлөөлөөс хараат бус, бие даасан байх учиртай. Иймд хуулийн төслийн 4.1.2-т зөвхөн улс төрийн нам, эвслээс хараат бус байх тухай заасан нь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бие даасан, хараат бус байдлыг явцуу хүрээнд тодорхойлсон хэрэг байна. Тухайлбал, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4.1-т Төрийн бус байгууллага нь үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 6.1-т шүүх нь шүүх эрх мэдлийг аливаа байгууллага, этгээдээс хараат бусаар хэрэгжүүлэх тухай тус тус заасан байна. Хуулийн тус зохицуулалтууд аливаа өөрийгөө удирдах ёсны байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хамгаалах нь зөвхөн улс төрийн нам, эвсэл зэргээс бие даасан байх ойлголтоор хязгаарлагдахгүйг харуулах юм.

Хуулийн төслийн 40.2.1-т Үндэсний танхим, салбар танхим болон мэргэжлийн танхим улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаа, нэр дэвшигчийг дэмжсэн буюу эсэргүүцсэн аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглох тухай заасан байна. Хуулийн төслийн тус зохицуулалт нь хуулийн төслийн 4.1.2-т заасан зорилгыг хангахад чиглэгдсэн байна. Гэвч хуулийн төслийн тус заалт зөрчигдөх нөхцөлд Үндэсний танхим, салбар танхим болон мэргэжлийн танхимын удирдлагад ямар хариуцлага хүлээлгэх тухай хуулийн төсөлд тусгаагүй байна. Иймд хуулийн төслийн дээрх заалтууд төслийн зорилгод хүрэхэд шаардлагатай зохицуулалтыг бүрэн агуулж чадахгүй байна.

Хуулийн төслийн 27.2-т Үндэсний танхимын Ерөнхийлөгчид төрийн албан хаагч бус байх шаардлага тавьсан байна. Мөн Үндэсний танхимын Ерөнхийлөгч нь тус шаардлагыг хангахгүй болсон буюу төрийн албанд томилогдсон нөхцөлд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлж, ээлжит бус хурлын Их хурлыг зарлан хуралдуулах тухай заасан байна. Хуулийн төслийн тус заалтын агуулга нь Ерөнхийлөгч төрийн албан хаагч болсон нөхцөлд түүнийг албан тушаалаас нь чөлөөлөх агуулгатай гэж ойлгогдож байгаа боловч тус агуулга тодорхой тусгагдаагүй байна. Тодруулбал, хуулийн 27.2-т заасан шаардлагыг хангахгүй болсон нөхцөлд болон бусад үндэслэлээр ч тэр Ерөнхийлөгчийг албан тушаалаас нь огцруулах тухай хуулийн төсөлд тусгагдаагүй байна. Хуулийн төслийн 4.1.2-т Танхимын үйл ажиллагаа нь улс төрийн нам, эвслээс хараат бус, бие даасан байх тухай заасан боловч Ерөнхийлөгчид улс төрийн нам, эвслийн гишүүн бус байх эсвэл намын гишүүнчлэлээс түдгэлзэх шаардлага тавиагүй байна. Иймд хуулийн төслийн зохицуулалтын дагуу аливаа улс төрийн намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог

хүн Үндэсний танхимын Ерөнхийлөгчөөр сонгогдох, эсвэл Ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараа улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, тэдгээрийн гишүүн байх боломжтой байна. Энэ нь Үндэсний танхимын үйл ажиллагаа улс төрийн нам, эвслээс хараат бус, бие даасан байх зарчмыг алдагдуулах эрсдэлтэй юм. Хуулийн төслийн 31.2.1-д аливаа улс төрийн нам, эвслийн үйл ажиллагааг дэмжих буюу эсэргүүцэх үйл ажиллагаа явуулахыг Үндэсний танхим, салбар танхим болон мэргэжлийн танхимд хориглосон ч тус зохицуулалт нь Үндэсний танхимын Ерөнхийлөгч хувь хүнийхээ хувьд улс төрийн нам, эвсэлд гишүүнээр элсэхгүй байх, үйл ажиллагаанд нь оролцохгүй байх агуулгатай биш байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн тус заалт нь Үндэсний танхимын Ерөнхийлөгчид шууд хамааралтай биш байна. Мөн төрийн албан хаагч биш байх, улс төрийн нам, эвслийн гишүүн биш байх шаардлагыг Үндэсний танхимын Гүйцэтгэх захиралд тавиагүй байна.

Хуулийн төслийн 26.5.13, 26.5.14-т гишүүнчлэлийн хураамжийн хэмжээ, түүнээс чөлөөлөх, хөнгөлөх нөхцөл, журмыг болон Үндэсний танхимын үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг Удирдах зөвлөл тогтоох тухай тус тус заасан байна. Хуулийн төслийн 29.1.1, 29.1.3-т тус тус заасны дагуу гишүүний хураамж болон Танхимын үйлчилгээний орлого нь Үндэсний танхимын санхүүжилтийн гол хэсэг байна. Учир нь хуулийн төслийн 29.1-д нэрлэн заасан дөрвөн төрлийн санхүүжилтийн эх үүсвэрээс гишүүний болон бусад этгээдийн хандив, тусламж нь сайн дурын шинжтэй бол төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхэд зориулж хууль тогтоомжийн дагуу олгосон санхүүжилт нь тогтмол төлөгдөх шинжгүй байна. Өөрөөр хэлбэл, төрийн зарим чиг үүргийг Үндэсний танхимд шилжүүлээгүй үед тус санхүүжилт олгогдохгүй юм. Иймд Үндэсний танхимын гол санхүүжилт нь гишүүнчлэлийн хураамж болон үйлчилгээний хөлс байхаар байна. Иймд тэдгээрийн хэмжээг Удирдах зөвлөл тогтоохоор заасан нь Үндэсний танхимын үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангаж байна. Хэрэв Үндэсний танхимын гишүүнчлэлийн хураамж болон үйлчилгээний хөлсний хэмжээг тогтооход төрийн байгууллага, албан тушаалтан оролцохоор бол энэ нь Үндэсний танхимын бие даасан, хараат бус байдлыг алдагдуулах эрсдэлтэй болох юм. Тодруулбал, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 11.3-т Танхимын үйлчилгээний хөлсний хэмжээг Сангийн сайд, Худалдаа үйлдвэрийн сайд хамтран тогтоох тухай заасан нь Үндэсний танхимын бие даасан, хараат бус байдлыг алдагдуулах зохицуулалт болох талаар Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд тусгагдсан байна.

Өөрөө удирдах ёсны байгууллагуудын гишүүнчлэлийн хураамж, үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох туршлагын талаар өөр салбарын туршлагыг авч үзэхэд, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 46.2.7-д зааснаар хуульчдын татварын хэмжээг Хуульчдын их хурал, Өмгөөллийн тухай хуулийн 41.6.8-д зааснаар Өмгөөлөгчдийн холбооны гишүүнчлэлийн хураамжийн хэмжээг Өмгөөлөгчдийн холбооны Их Хурал тогтоох тухай, 8.5-д өмгөөлөгчийн шалгалтын хураамжийн хэмжээг Удирдах зөвлөл тогтоох тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 72.1.1, 73.2-т тус тус зааснаар үнэт цаасны зах зээлийн өөрөө удирдах ёсны байгууллагын гишүүнчлэлийн хураамжийг бүх гишүүдийн хурал тус тус тогтоохоор заасан байна. Өөрөөр хэлбэл дээрх салбарын өөрийгөө удирдах ёсны байгууллагуудын хувьд гишүүнчлэлийн хураамж болон шалгалт, сургалтын төлбөр зэрэг үйлчилгээний хөлсний хэмжээг тухайн байгууллагууд өөрсдөө тогтоож байна.

Түүнчлэн, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд "2015-2018 оны хооронд Танхимын үйл ажиллагааны зардал нь жил бүрийн үйл ажиллагааны орлогоос давж ирсэн" тухай тусгасан байна. Иймд хуулийн төслөөр Үндэсний танхимын үйлчилгээний хөлсний хэмжээг төрөөс тогтоодог одоогийн зохицуулалтаас татгалзаж, Үндэсний танхимын

удирдах зөвлөл тогтоохоор заасан нь Үндэсний танхимын бие даасан байлыг хангах зорилгод хүрэхэд чухал ач холбогдолтой зохицуулалт болсон байна.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон төсөлд тусгагдсан Үндэсний танхим нь аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах зорилгын хүрээнд Төслийн 20 дугаар зүйл, 7.1, 7.4 дэх заалтуудын үр нөлөөг үнэлсэн байдал.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилтыг тодорхойлохдоо "... аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлж төрийн байгууллага, бусад этгээдтэй харилцах харилцааг зохицуулах ..." тухай, 6.1-д "Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь аж ахуй эрхлэгчдийн худалдаа, үйлдвэрлэл эрхлэхтэй холбогдсон нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх, хамгаалах ... зорилго бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээд байна" гэж тус тус заасан байна. Иймд хуулийн төслийн холбогдох заалтууд тус зорилгод хүрч чадах эсэхийг дүгнэх үүднээс "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэв.

Хуулийн төслийн 19.1.1-д аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах нь Үндэсний танхимын нэг чиг үүрэг байхаар заасан байна. Мөн тус чиг үүргийн хүрээнд ямар үйл ажиллагаа явуулах тухай хуулийн төслийн 20.1-д тодорхойлжээ. Үндэсний танхим нь аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэднийг төлөөлөн илэрхийлэгч байхын тулд Үндэсний танхим нь аж ахуй эрхлэгчдийн оролцоог хангасан, тэдний байр суурь, дуу хоолойг сонсдог байх нь чухал юм. Иймд хуулийн төслийн 7.1-д Монгол Улсад үүсгэн байгуулагдсан ашгийн төлөө хуулийн этгээд нь салбар танхим, эсхүл мэргэжлийн танхимд заавал гишүүнчлэлтэй байхаар заасан нь худалдаа, аж үйлдвэрийн танхим аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөгч байхад чухал зохицуулалт байна. Учир нь, худалдаа, аж үйлдвэрийн танхим өөрөө зөвхөн хэсэг, бүлэг аж ахуй эрхлэгчдийн сайн дурын гишүүнчлэлтэй байгаа нөхцөлд аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлж чадах байдал болон нийт аж ахуй эрхлэгчдэд тийм байдлаар хүлээн зөвшөөрөгдөх байдал буурах юм.

Гэвч хуулийн төслийн 7.4-т ашгийн төлөө хуулийн этгээд нь улсын бүртгэлд бүртгэгдсэнээс хойш 90 хоногийн дотор мэргэжлийн танхим, эсхүл салбар танхимд бүртгүүлж, гишүүнээр элсэх тухай заасан нь заавал гишүүнчлэлтэй байх зохицуулалттай зөрчилдөх, хуулийн төслийн зорилгыг хангахад учир дутагдалтай байхаар байна. Учир нь, ашгийн төлөөх хуулийн этгээд нь хуулийн төслийн 7.4-т заасны дагуу гишүүнээр элссэнээр салбар танхим, эсхүл мэргэжлийн танхимын гишүүн болох эсэх, эсвэл улсын бүртгэлд бүртгэгдсэнээр гишүүний эрх эдэлж, үүрэг хүлээх эсэх нь тодорхой бус, хоорондоо зөрчилдөөнтэй байна. Ашгийн төлөөх бүхий л хуулийн этгээдийг мэргэжлийн танхим, эсхүл салбар танхимд гишүүнчлэлтэй байлгах бол хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэнээр гишүүний эрх эдэлж, үүрэг хүлээдэг байх нь зүйтэй юм. Иймд хуулийн төслийн 7.4-т заасны дагуу гишүүнээр бүртгүүлсэнээр гишүүн болох зохицуулалт нь ашгийн төлөөх бүхий л хуулийн этгээдүүд заавал гишүүнчлэлтэй байх хуулийн төслийн зорилгыг хангахад учир дутагдалтай зохицуулалт болохоор байна.

Түүнчлэн, Хуулийн төслийн 7.5-д заасны дагуу (1) гадаад улсын хуулийн этгээд, (2) үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигч, эсхүл тухайн хуулийн этгээд нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд эсхүл мэргэжлийн холбооны заавал гишүүнчлэлтэй байхаар хуульд заасан бол заавал гишүүнчлэлтэй бус, сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэж болох тухай заасан байна. Энэхүү зохицуулалт нь мэргэжлийн холбоодын заавал гишүүнчлэлтэй хуулийн этгээдүүд нь тухайн холбоогоор дамжуулан өөрсдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалуулах боломжтой хэмээн үзсэнтэй холбоотой гэж ойлголоо.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлээр Үндэсний танхим нь аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах үүднээс (1) хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахад санал, дүгнэлт оруулах, (2) аж ахуй эрхлэгчдийн нийтлэг ашиг сонирхолтой холбоотой хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, (3) аж ахуй эрхлэгчдийн нийтлэг ашиг сонирхолтой холбоотой захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөх болон (4) төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэхээр тус тус тусгагдсан байна. Мөн аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг мэдэх, зөв илэрхийлэх үүднээс бизнес эрхлэлтийн орчны талаар судалгаа хийх, аж ахуй эрхлэгчдийн хооронд сонсгол зохион байгуулахаар заасан нь чухал байна. Түүнчлэн, Хуулийн төслийн 22.1.8-д шаардлагатай судалгаа, шинжилгээг хийх чиг үүрэг бүхий судалгааны институтыг Үндэсний танхим дэргэдээ байгуулах тухай, 22.1.2-т үндэсний хэмжээний бизнесийн орчны судалгааг жил бүр хараат бусаар хийж гүйцэтгэж, Засгийн газар, Улсын Их Хурал болон холбогдох төрийн байгууллагад саналын хамт хүргүүлэх тухай тус тус заасан нь хуулийн төслийн 20.1.4-т заасан зорилгыг хангахад чухал ач холбогдолтой зохицуулалт байна. Үндэсний танхим нь дэргэдээ судалгааны байгууллагатай байснаар бизнесийн орчны судалгааг сайн хийж чадах бөгөөд тэр хэмжээгээр аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхол болон тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлж чадах юм. Иймд Үндэсний танхим нь аж ахуй эрхлэгчдийг сонсох, бизнесийн орчны талаар судалгаа хийх зэргээр тэдний нийтлэг эрх, ашиг сонирхлыг олж мэдэх, үүнд үндэслэж бодлогын баримт бичиг, хууль, хэм хэмжээний актын төсөлд санал өгөх болон төрийн эрх барих дээд байгууллагад төлөөлөн илэрхийлэх зэргээр аж ахуй эрхлэгчдийн нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах боломжтой хэмээн дүгнэлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон төсөлд тусгагдсан Үндэсний танхимын дэргэд аж ахуй эрхлэгчдийн хооронд үүссэн маргааныг эвлэрүүлэн зуучлалын тусламжтайгаар шийдвэрлэх, бизнесийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлэх мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчид бий болгох зорилгын хүрээнд хуулийн төслийн 33 дугаар зүйлийг бүхэлд нь болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн үр нөлөөг үнэлсэн байдал.

Хуулийн төслийн үзэл баримтлалын "Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага" хэсэгт (Үндэсний танхимын зарим үйлчилгээний хувьд) *"Үндэсний танхимын дэргэдэх Эвлэрүүлэн зуучлалын төвийн шийдвэрийг эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасны нэгэн адил шүүгч баталгаажуулж, захирамж гарган шүүхийн шийдвэрийн нэгэн адил заавал биелэгддэг болох боломжийг хуульд тусгах шаардлагатай байна"* гэж заасан нь хуулийн төсөлд Эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээний талаар тусгах болсон зорилго байна. Мөн хуулийн төслийн үзэл баримтлалын Гурав дахь хэсгийн 6-д *"бизнесийн эрх зүйн холбогдолтой маргааныг дагнан шийдвэрлэх, мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчид бий болох боломжтой юм. Дээрх нөхцөлүүд бүрдсэнээр шүүх дэх иргэний хэрэг, маргааны ачаалал буурах эерэг талтай байна"* гэж тусгасан байна.

Энэ зорилгыг хангах үүднээс аж ахуй эрхлэгчийн хооронд үүссэн маргаан, эсхүл аж ахуй эрхлэгч болон ажилтны хооронд үүссэн хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх эвлэрүүлэн зуучлалын төв ажиллахаар хуулийн төслийн 33.1-д заасан байна. Хуулийн төслийн тус заалтаас харахад аж ахуй эрхлэгчид хоорондын болон аж ахуй эрхлэгчийн ажилтан хоорондын ганцаарчилсан маргаанд Үндэсний танхимын дэргэдэх Эвлэрүүлэн зуучлалын төв ажиллах боломжтой талаар заасан байна. Эндээс

дүгнэхэд аж ахуй эрхлэгч болон түүний үйлчлүүлэгч иргэн хоорондын маргааны хувьд Үндэсний танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд хандах боломжгүй байна. Энэ нь хуулийн төслийн зорилгод хүрэх байдлыг хязгаарлаж байна.

Хуулийн төслийн дээрх зорилгыг хангах үүднээс Үндэсний танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг шүүгч баталгаажуулах тухай хуулийн төслийн 33.4-т заасан байна. Ингэснээр хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлага болох “Үндэсний танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг шүүх баталгаажуулдаг болох” шаардлага хангагдахаар болсон байна. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27.1-д шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаас бусад буюу төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын тусламжтайгаар байгуулагдсан гэрээг шүүхээр баталгаажуулахгүй байхаар заасан. Хуулийн тус зохицуулалтын дагуу Үндэсний танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтайгаар байгуулагдсан эвлэрлийн гэрээ биелэгдэхгүй бол гэрээний аль нэг тал дахин шүүхэд хандах шаардлагатай байдаг. Иймд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27.1 дэх заалт нь Танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд хамаарахгүй байх агуулгаар Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан байна. Хуулийн тус төсөл батлагдсанаар Үндэсний танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулагдсан гэрээг шүүхээр баталгаажуулах, гэрээний аль нэг тал гэрээний үүргээ биелүүлэхгүй бол дахин шүүхэд нэхэмжлэл гаргахгүйгээр (шүүхийн эвлэрүүлэн зуучлалын нэгэн адил) шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх журмын дагуу гүйцэтгүүлэхээр шүүхээр албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудас гаргуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандах боломжтой болохоор байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74^{1.2}-т шүүхээс шилжүүлсэн маргааны хувьд тухайн шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахаар заасан байна. Энэ нь шүүхэд буй хэрэг, маргааны хувьд Үндэсний танхимын эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх боломжийг хаахаар байна. Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74^{1.2}-т “эвлэрүүлэн зуучлагч” гэсний дараа “эсхүл талууд хүсэлт гаргасан тохиолдолд Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлагч” гэж нэмсэнээр шүүх дэх хэрэг, маргааны хувьд Үндэсний танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалыг хэрэгжүүлэх боломжтой болохоор байна. Ингэснээр хуулийн төслийн “иргэний хэргийн шүүхийн ачааллыг бууруулах, Танхимын эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх” зорилго биелэгдэх боломжтой байна.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон төсөлд тусгагдсан хамтын удирдлага бүхий төрийн байгууллагуудын удирдлагын бүрэлдэхүүнд төлөөлөл оролцуулах зорилгын хүрээнд Төслийн 21.1.3 дахь заалт болон хуулийн төсөлтэй цуг нэмэлт, өөрчлөлт орох бусад хуулийн төслүүдийн холбогдох заалтуудад үнэлгээ хийсэн байдал.

Хуулийн төслийн 21.1.3-т хуульд заасан болон холбогдох төрийн байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр хамтын удирдлагын бүрэлдэхүүнд Үндэсний танхимаас төлөөлөл оролцуулах тухай заасан байна. Гэвч одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудад хамтын удирдлага бүхий төрийн байгууллагын удирдлагад Үндэсний танхимаас төлөөлөл оролцуулахаар зохицуулсан зохицуулалт төдийлөн байхгүй. Гагцхүү Өрсөлдөөний тухай хуулийн 17.2, Эрчим хүчний тухай хуулийн 8.3 дахь заалтуудад Эрчим хүчний зохицуулах хороо болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын орон тооны бус гишүүнийг Үндэсний танхимын санал болгосноор бүрдүүлэхээр заасан байна.

Иймд хуулийн төслийн 21.1.3 дахь заалт нь дангаар хуулийн төслийн үзэл баримтлал болон төслөөр тодорхойлсон дээрх зорилгод хүрч чадахгүй юм. Тус зорилгод хүрэхийн тулд Үндэсний танхимаас төлөөлөл оруулах хамтын удирдлага бүхий төрийн байгууллагуудыг тус тусын хуулиар нэрлэн заах шаардлагатай юм. Энэ хүрээнд хуулийн төсөлтэй цуг Хөрөнгө оруулалтын тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Статистикийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах замаар дараах байгууллагуудад Үндэсний танхимын төлөөлөл орохоор төсөл боловсруулсан байна. Үүнд: Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх асуудлаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл; Харилцаа холбооны зохицуулах хороо; Үндэсний статистикийн хорооны дэргэдэх зөвлөл; Гаалийн тарифийн орон тооны бус зөвлөл; Татварын маргаан таслах зөвлөл; Ерөнхий сайдын дэргэдэх Төсөв, санхүү, эдийн засгийн үндэсний зөвлөл; Ирээдүйн өв сангийн хяналтын зөвлөл; Боловсролын зээлийн сан, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо, хяналтын хороо; Тендерийн үнэлгээний хороо; Чөлөөт бүс дэх Хөрөнгө оруулагчдын зөвлөлд Үндэсний танхимын төлөөлөл орохоор төсөл боловсруулсан байна. Мөн Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.5-д Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн дэх хувийн хэвшлийн төлөөллийг ажил олгогчид болон Үндэсний танхимын хамтран зохион байгуулсан төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын нэгдсэн хурлаас сонгох тухай заасныг Үндэсний танхим дангаар төлөөлөх агуулгаар өөрчлөн найруулах төсөл боловсруулсан байна.

Хамтын удирдлага бүхий дээрх байгууллагуудын удирдлагын бүрэлдэхүүнд Үндэсний танхимын төлөөлөл оруулах агуулга бүхий хуулийн төслүүдийг харвал одоо хүчин төгөлдөр үйлчилж буй зохицуулалтууд нь хувийн хэвшлийн оролцоог хангах агуулга бүхий зохицуулалт байна. Тодруулбал, хөрөнгө оруулагчид, ажил олгогчид, мэргэжлийн холбоод, тухайн салбарын төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулахаар заасан байна. Хуулийн төслийн дагуу ашгийн төлөөх хуулийн этгээдүүд Үндэсний танхимд заавал гишүүнчлэлтэй байхаар байна. Иймд Хуулийн төсөл батлагдах нөхцөлд Үндэсний танхим нь одоогийн хуулиудад тусгагдсан хувийн хэвшил, ажил олгогчид болон хөрөнгө оруулагчид гэх ойлголтыг бүрэн төлөөлж чадах цор ганц байгууллага болохоор байна.

Монгол Улсад одоогоор Эрчим хүчний, Харилцаа холбооны болон Санхүүгийн гэсэн гурван төрлийн зохицуулах хороо байна. Эдгээрээс одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны бүрэлдэхүүнд Үндэсний танхимын төлөөлөл орох боломжтой байна. Харилцаа холбооны зохицуулах хорооны орон тооны бус нэг гишүүнийг Үндэсний танхимын саналаар томилохоор хуулийн төсөл боловсруулсан байна. Харин Санхүүгийн зохицуулах хороог яагаад орхигдуулсан эсэх буюу тус Хорооны бүрэлдэхүүнд Үндэсний танхимын төлөөлөл орох шаардлагагүй гэж үзсэн эсэх нь тодорхой бус байна.

Түүнчлэн, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5.1-д заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Засгийн газар, ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо тогтоодог. Хуулийн төсөлд тусгагдсан ёсоор Үндэсний танхимд нийт ашгийн төлөөх хуулийн этгээдүүд заавал гишүүнчлэлтэй бөгөөд Үндэсний танхим нь аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах үүрэг

бүхий байгууллага байна. Иймд хуулийн төсөл ёсоор Үндэсний танхим нь ажил олгогчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг улсын хэмжээнд, бүрэн бөгөөд хууль ёсоор төлөөлж чадах цор ганц байгууллага байхаар байна. Эндээс дүгнэхэд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны нэг гишүүн нь Үндэсний танхимаас байх бүрэн боломжтой байна. Гэвч энэ талаар нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсрогдоогүй байна. Иймд цаашид энэ талаар судлан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Дээрхээс дүгнэхэд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөлтэй цуг Үндэсний танхимын төлөөллийг хамтын удирдлага бүхий байгууллагуудад оруулах агуулга бүхий нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд нь хуулийн төслийн зорилгыг хангахад чухал ач холбогдолтой байна. Харин Санхүүгийн зохицуулах хороо, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо зэрэг зарим байгууллагуудын талаар авч үзээгүй, орхигдуулсан байна.

Хуулийн төслийн харилцан уялдаатай байдал

Аргачлалын 4.10-т хуулийн төслийн уялдаа холбоог шалгахдаа нийт 16 төрлийн асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог тогтоохоор заасан байна. Иймд тус асуултуудад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог шалгав.

№	Асуулт	Хариулт, түүний үндэслэл, тайлбар
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төслийн зорилтод хамааралгүй зохицуулалт агуулаагүй байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиуд тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Хуулийн төслийн 2.1-д хуулийн төсөл нь Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиудыг нэрлэн заасан байна. Хуулийн төсөлд Үндэсний танхим нь төрийн бус байгууллагын статустай байх тухай заагаагүй байна. Иймд Төрийн бус байгууллагын тухай хууль нь энэхүү харилцаанд хамаарахгүй хууль байна. Хэрэв Үндэсний танхим нь төрийн бус байгууллагын статустайгаар үйл ажиллагаа явуулах бол хуулийн төслийн холбогдох заалт болох 6.1 дэх заалтыг тус агуулгаар тодруулах нь зөв юм.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж буй эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Хуулийн төслийн 7.1 болон 7.4 дэх заалтууд хоорондоо зөрчилдөж байгаа талаар энэхүү үнэлгээний тайланд тусгасан. Тодруулбал, ашгийн төлөөх хуулийн этгээд нь улсын бүртгэлд бүртгэгдсэнээр эсвэл Үндэсний танхимд бүртгэгдэж, гишүүнээр элссэнээр гишүүний эрх эдэлж, үүрэг хүлээх эсэх нь тодорхой бус, зөрчилдөөнтэй байна.

		Хуулийн төслийн 33.1-д аж ахуй эрхлэгчийн хооронд үүссэн маргааныг эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр шийдвэрлүүлэх тухай заасан боловч хуулийн төслийн 33.2-т мэргэжлийн танхим болон салбар танхимын гишүүд хоорондын маргаанд л эвлэрүүлэн зуучлалыг ашиглах агуулгаар заасан байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн 33.2-т маргалдагч талууд бүгд Үндэсний танхимын гишүүд байх нөхцөлд Үндэсний танхимын эвлэрүүлэн зуучлалд хандах боломжтой тухай заасан бол хуулийн төслийн 33.1-д Үндэсний танхимын гишүүн байх шаардлага тавиагүй байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардал байхгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тодорхой тусгагдсан.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Хуулийн төслийн 8.1-д Үндэсний танхимын зорилгыг илэрхийлэх бусад төсөөтэй үг, нэр томьёо хэрэглэх болон хуулийн этгээдийн улсын бүртгэлд нэр баталгаажуулах, бүртгэхгүй байх тухай заасан байна. Гэвч хуулийн төслийн 8.1 дэх заалттай зөрчилдсөн нэр бүхий одоогийн байдлаар бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийг хэрхэн зохицуулах тухай хуулийн төсөлд заагаагүй байна. Үндэсний танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаанд Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль үйлчлэх тухай заагаагүй байна. Хуулийн төсөлд заагаагүй аливаа асуудалд Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль үйлчлэх тухай зааснаар ойлгомжтой, тодорхой болох юм. Хуулийн төслийн 32.2-т арбитраж үйл ажиллагаатай холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулах тухай заасан байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зохицуулалт судалгаагаар тогтоогдоогүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Хуулийн төсөлд төрийн байгууллагуудад бүрэн эрх олгосон зохицуулалт байхгүй байна. Харин төрийн зарим чиг үүргийг Үндэсний танхимд олгож болох тухай хуулийн төсөлд тусгагдсан байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр,	Судалгаагаар энэ төрлийн зөрчил тогтоогдоогүй. Үндэсний танхимын гишүүнчлэлийн хураамж, үйлчилгээний хөлс нь албан татвар, төлбөр,

	хураамж тогтоосон эсэх;	хураамжид хамаарахгүй юм.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт, журам бий болгоогүй.
12	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчил тогтоогдсонгүй.
13	Жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчил тогтоогдсонгүй.
14	Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчил тогтоогдсонгүй. Харин шударга өрсөлдөөнийг дэмжих, өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилсан сэргийлэх нь Үндэсний танхимын үйл ажиллагаанд баримтлах зарчим болох тухай хуулийн төслийн 4.1.4-т заасан байна.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчил тогтоогдсонгүй. Харин хамтын удирдлага бүхий төрийн байгууллагуудын удирдлагад Үндэсний танхимаас төлөөлөл оролцуулах агуулга бүхий хуулийн төслийн заалтууд нь Авлигын эсрэг хуулийн 6.1.3-6.1.5, 6.1.7 дахь заалтуудад заасан авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нийцтэй байна.
16	Хуулийн төсөлд тусгагдсан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх;	Хуулийн төслийн 42.1-д “Энэ хуулийг зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан. Гэвч тус хуулийн төсөлд хариуцлагыг тодорхой тусгаагүй. Мөн хуулийн төсөлтэй цуг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулагдаагүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар тус бүрээр Дагнасан танхимыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэгчдийг нэг шийдэл, шийдвэрт хүрэх байдлыг хангах зорилгын хүрээнд хуулийн төслийн 7.1, 7.4, 14.1, 14.2 дахь заалтуудын үр нөлөөг үнэлж, дараах дүгнэлтэд хүрлээ.

Хуулийн төслөөр ашгийн төлөөх хуулийн этгээдүүд мэргэжлийн танхим, эсхүл салбар танхимд заавал гишүүнчлэлтэй байх, тодорхой бизнесийн салбарт зөвхөн нэг мэргэжлийн танхим байхаар тус тус заасан нь бизнесийн тодорхой салбарын аж ахуй эрхлэгчид, мэргэжлийн танхим нэгдмэл шийдвэрт хүрэх, нэгдмэл байр суурьтай байх зорилгыг хангахад чухал ач холбогдолтой болсон байна.

Хуулийн төслийн 14.1-д 50-аас доошгүй тооны гишүүн хуулийн этгээд нь тухайн салбарын мэргэжлийн танхимыг байгуулж болох тухай заасан нь 50-аас төдийлөн ихгүй оролцогч, аж ахуй эрхлэгчтэй бизнесийн салбарын хувьд мэргэжлийн танхим байгуулах нь хүндрэлтэй болох, 50 хүрэхгүй оролцогч, аж ахуй эрхлэгчтэй бизнесийн салбарын хувьд мэргэжлийн танхим байгуулах боломжгүй байдалд хүрэхээр байна. Энэ нь бизнесийн салбар бүрт нэг мэргэжлийн танхим байгуулах зорилгод нийцэхгүй байна.

Үндэсний танхим нь бие даасан, хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулах санхүүгийн боломж бий болгох зорилгын хүрээнд төслийн 4.1.2, 26.5.13, 26.5.14, 27.2, 27.5 дахь заалтууд болон 33 дугаар зүйлийн үр нөлөөг үнэлж, дараах дүгнэлтэд хүрлээ.

Хуулийн төслийн 4.1.2-т Үндэсний танхимын үйл ажиллагаа улс төрийн нам, эвслээс хараат бус, бие даасан байх тухай заасан нь Үндэсний танхимын бие даасан, хараат бус байдлыг явцуу хүрээнд тодорхойлсон хэрэг байна.

Үндэсний танхим нь улс төрийн нам, эвслээс бие даасан хараат бус байх тухай хуулийн төсөлд заасан боловч Үндэсний танхимын Ерөнхийлөгч нь улс төрийн нам, эвслийн гишүүн биш байх эсвэл гишүүнээс түдгэлзэх, татгалзах шаардлагыг тавиагүй байгаа нь тус зорилгыг бүрэн хангаж чадахгүй байна.

Үндэсний танхимын Ерөнхийлөгч нь төрийн албан хаагч бус байх шаардлагыг тавьсан боловч төрийн албанд томилогдсон нөхцөлд түүнийг огцруулах тухай хуулийн төсөлд тодорхой тусгаагүй нь хуулийн төслийн зорилгыг бүрэн хангаж чадахгүй байна.

Хуулийн төсөлд Үндэсний танхимын Гүйцэтгэх захиралд улс төрийн нам, эвслийн гишүүн, төрийн албан хаагч бус байх шаардлага тавиагүй нь хуулийн төслийн зорилгыг бүрэн хангаж чадахгүй байна.

Үндэсний танхим, салбар танхим болон мэргэжлийн танхим нь аливаа улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн үйл ажиллагааг дэмжих, эсэргүүцэх үйл ажиллагаа явуулахгүй байх тухай заасан нь хуулийн зорилгыг хангахад чухал зохицуулалт боловч түүнийг зөрчсөн нөхцөлд хүлээлгэх хариуцлагын тухай заагаагүй нь хуулийн төслийн зорилгыг алдагдуулж байна. Мөн Үндэсний танхимын Ерөнхийлөгчид тийнхүү үйл ажиллагаа явуулахыг хориглоогүй байна.

Үндэсний танхимын гишүүнчлэлийн хураамж болон үйлчилгээний хөлсний хэмжээг Үндэсний танхимын Удирдах зөвлөл тогтоохоор хуулийн төсөлд тусгасан нь Үндэсний танхимын бие даасан, хараат бус байдлыг санхүүгийн хувьд бүрдүүлсэн, өөрөө удирдах ёсны бусад байгууллагын жишиг зохицуулалтад нийцсэн чухал зохицуулалт болсон байна.

Үндэсний танхим нь аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах зорилгын хүрээнд Төслийн 20 дугаар зүйл, 7.1, 7.4, дэх заалтуудын үр нөлөөг үнэлж, дараах дүгнэлтэд хүрлээ.

Хуулийн төслийн 7.1-д ашгийн төлөөх хуулийн этгээд нь салбар танхим эсхүл мэргэжлийн танхимд заавал гишүүнчлэлтэй байхаар заасан нь худалдаа, аж үйлдвэрийн танхим аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэгч, төлөөлөгч байх, тийнхүү байдлаар хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нэмэгдүүлэх чухал зохицуулалт болсон байна. Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь сайн дурын гишүүнчлэлтэй байгаа нөхцөлд нийт аж ахуй эрхлэгчдийн төлөөлөл болж хүлээн зөвшөөрөгдөхгүй байх сөрөг талтай байна.

Хуулийн төслийн 7.5-д гадаадын хуулийн этгээд болон мэргэжлийн холбоодод заавал гишүүнчлэлтэй ашгийн төлөөх хуулийн этгээдүүд салбар танхим, эсхүл мэргэжлийн танхимд сайн дурын гишүүнчлэлтэй байхаар заасан нь хуулийн төслийн зорилгыг алдагдуулна гэж үзэв.

Үндэсний танхим нь жил бүр бизнесийн орчны судалгааг хийх, дэргэдээ судалгааны байгууллага байгуулах тухай болон Үндэсний танхимын гишүүд дунд сонсгол зохион байгуулах тухай тус тус заасан нь Үндэсний танхим аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхол, бизнес эрхлэхтэй холбоотой хүндрэл бэрхшээлийг тодорхойлох, түүнд үндэслэн аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэх, төлөөлөх, хамгаалахад чухал шаардлагатай зохицуулалт байна.

Үндэсний танхим нь хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль болон хэмжээний актын төсөлд санал, дүгнэлт өгөх, төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэхээр заасан нь хуулийн төслийн зорилгыг хангахад чухал шаардлагатай зохицуулалт болсон байна.

Мэргэжлийн танхим эсхүл салбар танхимын гишүүн байгууллагууд хооронд үүссэн маргааныг эвлэрүүлэн зуучлалын тусламжтайгаар шийдвэрлэх, бизнесийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлэх мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчид бий болгох зорилгын хүрээнд хуулийн төслийн 33 дугаар зүйлийг бүхэлд нь болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн үр нөлөөг үнэлж, дараах дүгнэлтэд хүрлээ.

Хуулийн төслөөр Үндэсний танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг шүүхийн эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэй байгуулсан эвлэрлийн гэрээний нэгэн адил шүүхээр баталгаажуулах, шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Шүүх дэх хэрэг, маргааны хувьд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхээр болсон бол зөвхөн шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд шилжүүлэхээр заасан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг өөрчлөх замаар шүүх дэх хэрэг, маргаанд Үндэсний танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх, ингэснээр иргэний хэргийн шүүхийн ачааллыг бууруулах боломжийг бүрдүүлсэн байна.

Хамтын удирдлага бүхий төрийн байгууллагуудын удирдлагын бүрэлдэхүүнд төлөөлөл оролцуулах зорилгын хүрээнд Төслийн 21.1.3 дахь заалт болон хуулийн төсөлтэй цуг нэмэлт, өөрчлөлт орох бусад хуулийн төслүүдийн холбогдох заалтуудын үр нөлөөг үнэлж, дараах дүгнэлтэд хүрлээ.

Хөрөнгө оруулалтын тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Статистикийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх асуудлаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл; Харилцаа холбооны зохицуулах хороо; Үндэсний статистикийн хорооны дэргэдэх зөвлөл; Гаалийн тарифийн орон тооны бус зөвлөл; Татварын маргаан таслах зөвлөл; Ерөнхий сайдын дэргэдэх Төсөв, санхүү, эдийн засгийн үндэсний зөвлөл; Ирээдүйн өв сангийн хяналтын зөвлөл; Боловсролын зээлийн сан, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо, хяналтын хороо; Тендерийн үнэлгээний хороо; Чөлөөт бүс дэх Хөрөнгө оруулагчдын зөвлөлд Үндэсний танхимын төлөөлөл орохоор төсөл боловсруулсан нь хуулийн төслийн 21.1.3 дахь заалтын зорилгыг хангаж байна.

Дээрх хуулийн төслүүдийг боловсруулахгүйгээр хуулийн төслийн 21.1.3 дахь заалт нь дангаар хуулийн төслийн зорилгыг хангаж чадахгүй гэж дүгнэлээ.

Дээрх хуулийн төслүүдэд хөрөнгө оруулагчдийн төлөөлөл, мэргэжлийн холбоодын төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөлөл, ажил олгогчдийн төлөөллийг оролцуулна гэх зэргээр хувийн хэвшийн төлөөллийг оролцуулах агуулга бүхий заалтууд байх бөгөөд Үндэсний танхим нь тус байгууллагуудыг бүрэн төлөөлж чадна гэж дүгнэлээ. Ялангуяа ашгийн төлөөх хуулийн этгээдүүд Үндэсний танхимд заавал гишүүнчлэлтэй байх хуулийн төсөл батлагдах нөхцөлд Үндэсний танхим нь хөрөнгө оруулагч, ажил олгогчдийг улсын хэмжээнд төлөөлж чадах цор ганц байгууллага гэж хүлээн зөвшөөрөгдөхөөр байна.

Санхүүгийн зохицуулах хороо, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо зэрэг хамтын удирдлага бүхий байгууллагад Үндэсний танхимаас төлөөлөл оролцуулах тухай хуулийн төсөл боловсруулаагүй, энэ талаар авч үзээгүй байна.

Хуулийн төслийн харилцан уялдаатай байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь шалгаж үзээд, дараах дүгнэлтэд хүрлээ.
--

Хуулийн төсөл нь хуулийн төслийн зорилтод хамааралгүй зохицуулалт агуулаагүй. Хуулийн төсөлд Үндэсний танхим нь төрийн бус байгууллагын статустай байх тухай заагаагүй тул Төрийн бус байгууллагын тухай хууль нь энэхүү харилцаанд хамаарахгүй хууль байна. Хуулийн төслийн 33.1-д аж ахуй эрхлэгчийн хооронд үүссэн маргааныг эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр шийдвэрлүүлэх тухай заасан боловч хуулийн төслийн 33.2-т Мэргэжлийн танхим болон салбар танхимын гишүүд хоорондын маргаанд эвлэрүүлэн зуучлалыг ашиглах агуулгаар заасан нь зөрчилдөөнтэй байна.

Хуулийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан. Хуулийн төслийн 8.1-д Үндэсний танхимын зорилгыг илэрхийлэх бусад төсөөтэй үг, нэр томьёо хэрэглэх болон хуулийн этгээдийн улсын бүртгэлд нэр баталгаажуулах, бүртгэхгүй байх тухай заасан боловч хуулийн төслийн 8.1 дэх заалттай зөрчилдсөн нэр бүхий одоогийн байдлаар бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийг хэрхэн зохицуулах тухай хуулийн төсөлд заагаагүй байна. Үндэсний танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаанд Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль үйлчлэх тухай хуулийн төсөлд заагаагүй байна.

Хуулийн төсөл нь төрийн байгууллагын чиг үүргийг давхардуулан заах, шинээр албан татвар, хураамж, төлбөр бий болгох, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой журам, зохицуулалт бий болгох, авлига, хүнд суртлыг бий болгох, хүний эрх, жендерийн эрх тэгш байдлыг зөрчих, шударга бус өрсөлдөөнийг бий болгох зэрэг сөрөг үр дагавар бүхий зохицуулалт агуулаагүй байна. Хуулийн төсөл нь шударга өрсөлдөөнийг дэмжих, авлига, хүнд суртлыг багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх зохицуулалттай нийцтэй зохицуулалтууд агуулсан байна. Хуулийн төсөлд тусгагдсан хориглосон хэм хэмжээг зөрчсөн нөхцөлд хүлээлгэх хариуцлагын тухай тодорхой тусгаж чадаагүй байна.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар тус бүрээр Дагнасан танхимыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэгчдийн нэг шийдэл, шийдвэрт хүрэх байдлыг хангах зорилгын хүрээнд хуулийн төслийн 7.1, 14.1, 14.2 дахь заалтуудтай холбоотой зөвлөмж.

1. Хуулийн төслийн 14.2-т заасан 50-аас доошгүй аж ахуй эрхлэгч нэгдсэн нөхцөлд мэргэжлийн танхим байгуулах тухай босгыг бууруулах эсвэл 50 хүрэхгүй оролцогч, аж ахуй эрхлэгчтэй бизнесийн салбарын хувьд дагнасан танхим байгуулах боломжийг бий болгох зохицуулалтыг хийх нь зүйтэй гэж үзлээ.

Үндэсний танхим нь бие даасан, хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулах санхүүгийн боломж бий болгох зорилгын хүрээнд төслийн 4.1.2, 26.5.13, 26.5.14, 27.2, 27.5 дахь заалтууд болон 31 дүгээр зүйлтэй холбоотой зөвлөмж.

1. Хуулийн төслийн 4.1.2 дахь заалтыг Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь төрийн байгууллага, албан тушаалтан, улс төрийн нам, эвсэл болон бусад этгээдээс бие даасан, хараат бус байх агуулгаар өөрчлөх;
2. Үндэсний танхимын Ерөнхийлөгчид тавигдах шаардлагад улс төрийн нам, эвслийн гишүүн бус байх эсвэл нэр дэвшсэн үеэс эхлэн гишүүнчлэлээс татгалзах тухай нэмж тусгах;
3. Үндэсний танхимын Ерөнхийлөгч нь төрийн албанд томилогдсон, улс төрийн нам, эвслийн гишүүн болсон нөхцөлд түүнийг огцруулах тухай зохицуулалтыг нэмж тусгах;
4. Үндэсний танхимын Гүйцэтгэх захиралд мөн адил Танхимын бие даасан, хараат бус байдлыг хангахтай холбоотой шаардлагыг хуульчлах;
5. Хуулийн төслийн 40.1-д Үндэсний танхимын Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлыг нэмж заах буюу тэдгээрт улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийг дэмжсэн, эсэргүүцсэн аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглох;
6. Хуулийн төслийн 40.1 дэх заалт зөрчигдсөн нөхцөлд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох нь зүйтэй гэж үзлээ.

Үндэсний танхимын гишүүн байгууллагууд хооронд үүссэн маргааныг эвлэрүүлэн зуучлалын тусламжтайгаар шийдвэрлэх, бизнесийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлэх мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчид бий болгох зорилгын хүрээнд хуулийн төслийн 33 дугаар зүйлийг бүхэлд нь болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой зөвлөмж.

1. Хуулийн төслийн 33.1-д аж ахуй эрхлэгч болон түүний хэрэглэгч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх тухай агуулгыг нэмж тусгах;
2. Хуулийн төслийн 33.3-т мэргэжлийн танхим эсхүл салбар танхимын гишүүд маргаанаа эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлүүлэхээр тусгасныг "хуулийн төслийн 33.1-д заасан маргалдагч талууд" болгож өөрчлөх буюу эвлэрүүлэн зуучлалын талуудыг зөвхөн мэргэжлийн танхим, эсхүл салбар танхимын гишүүнээр хязгаарлахгүй байх;
3. "Үндэсний танхимын эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаатай холбоотой энэ хуульд заагаагүй бусад асуудал Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар зохицуулагдах" агуулгаар хуулийн төсөлд заалт нэмэх нь зүйтэй гэж үзлээ.

Хамтын удирдлага бүхий төрийн байгууллагуудын удирдлагын бүрэлдэхүүнд төлөөлөл оролцуулах зорилгын хүрээнд Төслийн 21.1.3 дахь заалт болон хуулийн

төсөлтэй цуг нэмэлт, өөрчлөлт орох бусад хуулийн төслүүдийн холбогдох заалтуудтай холбоотой зөвлөмж.

1. Санхүүгийн зохицуулах хороо болон Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо зэрэг бусад хамтын удирдлага бүхий байгууллагад Үндэсний танхимын төлөөлөл оруулах боломж, зохицуулалтын тухай судлах нь зүйтэй гэж үзлээ.

Хуулийн төслийн харилцан уялдаатай байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь шалгаж үзсэнтэй холбоотой зөвлөмж.

1. Хуулийн төслийн 2.1 дэх заалтаас “Төрийн бус байгууллагын тухай хууль” гэснийг хасах;
2. Хуулийн төслийн 7.1 болон 7.4 дэх заалтууд хоорондын зөрчилтэй байх тул зөрчилгүй болгож өөрчлөх буюу хуулийн төсөлд ашгийн төлөөх хуулийн этгээдүүд нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэнээр мэргэжлийн танхим, эсхүл салбар танхимын гишүүний эрх эдэлж, үүрэг хүлээх тухай тодорхой тусгах;
3. Хуулийн төслийн 8.1 дэх заалтыг зөрчсөн нэр бүхий одоогийн аж ахуйн нэгжүүдийг хэрхэн тухай тодорхой зохицуулалт тусгах;
4. Хуулийн төсөлд тусгагдсан хориглосон хэм хэмжээг зөрчсөн нөхцөлд хүлээлгэх хариуцлагын тухай тодорхой тусгах;

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

**ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ**

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**ХОЁР.ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БАТЛАГДАН ГАРСНААР ХУУЛИЙН
ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

- 2.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.Нэг бүрийн зардлыг тооцох;
- 2.3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 2.5.Хялбарчлах боломжийг шалгах;
- 2.6.Нэмэлт зардлыг тооцох.

**ГУРАВ.ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БАТЛАГДАН ГАРСНААР ҮНДЭСНИЙ
ТАНХИМД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

- 3.1.Үндэсний танхимын шинээр гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 3.2.Хүний нөөцийг тогтоох;
- 3.3.Гарах зардлыг тооцох;
- 3.4.Нийт зардлыг нэгтгэн тооцох;
- 3.5.Хялбарчлах боломжийг шалгах;

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

**/Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл/**

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх болон нэмэгдэх үүргийн улмаас бий болох зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог хийнэ.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах болон бууруулах талаар санал боловсруулах, зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд энэхүү тайлангийн зорилго чиглэгдэх болно.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь танхимын зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, чиг үүрэг, эрх зүйн байдлыг тодорхойлж, танхимаас аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлж төрийн байгууллага бусад этгээдтэй харилцах харилцааг зохицуулах замаар аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг дэмжих, аж ахуй эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг сайжруулах, худалдаа, үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх үндсэн зорилготой юм.

Эндээс үзэхэд хуулийн төслийн онцлог нь аж ахуй эрхлэгчдийн худалдаа, үйлдвэрлэл эрхлэхтэй холбоотой нэгдсэн ашиг сонирхлыг хамгаалах төрийн бус, ашгийн бус байгууллага болох Худалдаа аж үйлдвэрийн танхимын эрх зүйн байдлыг тогтоосон хуулийн төсөл юм.

Иймээс хуулийн төсөл нь иргэн болон төрд аливаа төрлийн зардал үүсгэх зохицуулалт агуулаагүй бөгөөд хуулийн этгээдэд зардал үүсгэх шинэ төрлийн үүргийг бий болгосон байна. Энд эрх ашиг сонирхлоо хамгаалуулахаар нэгдсэн гишүүн хуулийн этгээдүүд болон тэдгээрийн нэгдлийн үр дүнд байгуулагдсан Худалдаа, аж үйлдвэрийн танхим гэсэн хоёр төрлийн хуулийн этгээдийн асуудал яригдах юм.

Иймд хуулийн төслийн дагуу бусад хуулийн этгээд буюу гишүүн хуулийн этгээдэд үүсэх зардал болон Худалдаа, аж үйлдвэрийн танхимд үүсэх зардал гэсэн хоёр бүлгээр зардлыг тооцох юм.

Хуулийн төслийг судалж, дараах зохицуулалт нь гишүүн хуулийн этгээдэд зардал үүсгэхээр байна. Үүнд:

ГИШҮҮН ХУУЛИЙН ЭТГЭЭД:

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн төслийн 7 дугаар зүйл:

“7.1.Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, энэ хуулийн 7.5-д зааснаас бусад аж ахуй эрхлэгч нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй чиглэлээр байгуулагдсан мэргэжлийн танхим эсхүл өөрийн харьяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах аймаг, нийслэлийн танхимд заавал гишүүнчлэлтэй байна.

¹ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

7.4.Энэ хуулийн 7.1-д заасан аж ахуй эрхлэгч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэнээс хойш 90 хоногийн дотор өөрийн үйл ажиллагаа явуулж буй чиглэлээр байгуулагдсан мэргэжлийн танхим эсхүл салбар танхимд бүртгүүлж, гишүүнээр элсэнэ."

ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ:

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн төслийн 23 дугаар зүйл:


"23.1.1.Монгол Улсад зохион байгуулагдах олон улсын болон бүс нутгийн аж ахуй эрхлэгчдийн бараа, ажил, үйлчилгээний болон Монгол Улсын аж ахуй эрхлэгчдийн гадаад улсад оролцох үзэсгэлэн, худалдааны бүртгэлийг хөтөлж, олон нийтэд таниулан сурталчлах;" чиг үүргийг хэрэгжүүлнэ.

ХОЁР.ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэхүү тооцооны аргачлалаар хуулийн этгээд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан заавал гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэхэд тухайн хуулийн этгээдээс гарах мөнгөн зардлыг тооцно.

Өөрөөр хэлбэл хуульд заасан үүргийг хэрэгжүүлэхэд тухайн аж ахуйн нэгж байгууллага нь ямар, ямар үйл ажиллагаа явуулах вэ?, түүнд дунджаар хэдий хэр цаг хугацаа зарцуулах вэ? Үүний цаана ямар хэмжээний мөнгөн зардал гарах вэ? гэдгийг тооцож гаргана.


Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:



Хуулийн этгээдийн нийт зардал = Захиргааны зардал + Нэмэлт зардал

2.1.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ

Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтооход дараах алхамыг гүйцэтгэнэ.



- Үүрэг болгосон эрх зүйн заалт нэг бүрийг тодорхойлох,
- Үүргийн агуулга нэг бүрийг тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэх хуулийн этгээд нэг бүрийг тодорхойлж гаргана.

Тухайн харилцаанд оролцогч хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг гэдэгт холбогдох хуулиар тоо баримт, тайлан, бусад мэдээллийг төрийн байгууллага буюу **гуравдагч этгээдэд** бэлтгэж өгөх, бэлэн байлгах, эсвэл мэдээлэл хүргүүлэхийг **үүрэг** гэдэгт хамааруулан ойлгоно;

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр дээрх хуульд өмнө нь байгаагүй, хуулийн этгээдэд шинээр ногдуулж байгаа болон өмнө нь хуулийн этгээд гүйцэтгэдэг байсан боловч уг үүргийг өргөжүүлсэн, нэмэгдүүлсэн үүргийг олж тогтоон, зардлыг тооцох юм.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгээр ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байгаа нийт хуулийн этгээдийг заавал гишүүнчлэлтэй болгож, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 90 хоногийн дотор Танхимд гишүүнээр элсэж, бүртгүүлэх үүргийг хүлээлгэсэн байна.

Энэ зохицуулалтыг хуулийн төслөөс эшлэвэл:

7.1.Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, энэ хуулийн 7.5-д зааснаас бусад аж ахуй эрхлэгч нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй чиглэлээр байгуулагдсан мэргэжлийн танхим эсхүл өөрийн харьяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах аймаг, нийслэлийн танхимд заавал гишүүнчлэлтэй байна.

7.4.Энэ хуулийн 7.1-д заасан аж ахуй эрхлэгч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэнээс хойш 90 хоногийн дотор өөрийн үйл ажиллагаа явуулж буй чиглэлээр байгуулагдсан мэргэжлийн танхим эсхүл салбар танхимд бүртгүүлж, гишүүнээр элсэнэ.


Үүргийг олж тогтоосон тул дараагийн алхам болох дээрх үүргийн агуулга буюу үүргийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдийн зүгээс бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг тогтоох бөгөөд хуулийн төсөлд энэ талаар шууд нэрлэн зааж тусгаагүй тул Танхимын холбогдох албан хаагчтай ярилцсаны дагуу дараах байдлаар тодорхойлов.

Хүснэгт 1

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Тайлбар
1	7.4.Энэ хуулийн 7.1-д заасан аж ахуй эрхлэгч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэнээс хойш 90 хоногийн дотор өөрийн үйл ажиллагаа явуулж буй чиглэлээр байгуулагдсан мэргэжлийн танхим эсхүл салбар танхимд бүртгүүлж, гишүүнээр элсэнэ.	Байгууллагын товч танилцуулга	Худалдаа, аж үйлдвэрийн танхимын www.mongolchamber.mn цахим хуудаст гишүүнээр элсэхэд бүрдүүлэх баримт бичиг буюу үүргийн агуулгыг зааж өгснөөс эшлэв.
		Байгууллагын лого 800*800 хэмжээтэйь png болон psd /файл/	
		Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	
		Гишүүнчлэлийн татвар төлсөн баримт	
		Гишүүнээр элсэх тухай өргөдөл /анкет/	

2.2.НЭГ БҮРИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Энэ шатанд өмнөх шатанд тодорхойлсон хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд нэг хуулийн этгээдээс зарцуулах мөнгөн зардлыг цаг хугацаагаар дамжуулан тооцоолон гаргана. Ингэхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:



Үүрийг гүйцэтгэхэд зайлшгүй хийгдэх үйлдлийг **стандарт үйл ажиллагаа** гэнэ. Хэдийгээр үүрэг бүр өөр өөрийн онцлогтой, тэдгээртэй холбогдуулан хийх үйлдэл ялгаатай байх боловч нийтлэг хийгддэг ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан аргачлалд засан “Стандарт үйл ажиллагаа”-ны жагсаалтаас ашиглаж болохоор заасныг харгалзах нь зүйтэй.

Иймээс стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтад заасан хугацааг харгалзан үзэхийн хамт Үндэсний танхимын бүртгэл хариуцсан холбогдох ажилтантай уулзалт ярилцлага хийсний дүнд бий болсон үр дүнг ашигласан болно.

Хүснэгт 2

Хуулиар хүлээсэн үүрэг	Үүргийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа
7.4.Энэ хуулийн 7.1-д заасан аж ахуй эрхлэгч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэнээс хойш 90 хоногийн дотор	Байгууллагын товч танилцуулга	Байгууллагын талаар товч мэдээлэл бэлтгэх	15 мин
		Мэдээллийг нягталж, алдааг засах	5 мин

өөрийн үйл ажиллагаа явуулж буй чиглэлээр байгуулагдсан мэргэжлийн танхим эсхүл салбар танхимд бүртгүүлж, гишүүнээр элсэнэ.	Байгууллагын лого 800*800 хэмжээтэй png болон psd /файл/	Байгууллагын логог тавьсан стандартад нийцүүлэн бэлтгэх	5 мин
	Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	Улсын бүртгэлийн гэрчилгээг хуулбарлах	1 мин
	Гишүүнчлэлийн татвар төлсөн баримт	Холбогдох банканд гишүүнчлэлийн татварыг төлөх	5 мин
		Татвар төлсөн баримтыг хавсаргах	1 мин
	Гишүүнээр элсэх өргөдөл /анкет/	Гишүүнээр элсэх анкет бөглөх	10 мин
		Бөглөсөн анкет дахь мэдээллийг нягтлах	2 мин
НИЙТ ЗАРЦУУЛАХ ХУГАЦАА			44 мин

Ажлын хөлсийг тооцож гаргахдаа дундаж ажилтанд олгох сарын үндсэн цалинг Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг ажилтны ажиллах цагийн горимоор тогтоосон хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цаг, минутаар гаргана.

Үндэсний танхимд гишүүнээр элсэх хуулийн этгээд нь эдийн засгийн салбар үл харгалзах бөгөөд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан нийт аж ахуйн нэгжүүд заавал гишүүнчлэлтэй байхаар заасан тул ажлын хөлсийг тооцоолохдоо тодорхой салбарын дундаж цалин хөлсийг бус улсын дунджийг авч үзэх нь зүйтэй байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар² “2019 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт ажиллагчдын хамгийн олонх хувь буюу 30,9 хувь нь 840,000 орчим төгрөг хүртэлх цалинтай, бөгөөд 2019 оны байдлаар дундаж цалин 1,161,178 төгрөг болж өссөн байна.” гэж уг судалгаанд дурдсан байна. Иймд хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэгтэй холбоотой ажлын хөлсийг тооцоолохдоо Үндэсний статистикийн хорооноос гаргасан дээрх судалгааг эх сурвалж болгон ашиглах юм.

Ажиллах хугацааг гаргахдаа Хөдөлмөрийн тухай хуульд³ заасан ажлын цагийг баримтлав.

Хүснэгт 3

Ажлын хөлс = Үндсэн цалин : ажиллах хугацаа
1,161,178 ⁴ : 22 ⁵ өдөр : 8 ⁶ цаг = 6,597 төгрөг /дундажаар ажлын нэг цагт ноогдох хөдөлмөрийн хөлс/
6,597 : 60 минут = 110 төгрөг /нэг минутын хөдөлмөрийн хөлс/

² http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=average_wage_2017.pdf&ln=Mn /Үндэсний статистикийн хорооны албан ёсны веб хуудаст байршуулсан цалин хөлсний талаарх судалгаа

³ Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүлийн 1999 оны №25 дугаарт хэвлэгдсэн.

⁴ Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2019 оны байдлаарх сарын дундаж цалин хөлс

⁵ Хөдөлмөрийн тухай хуульд заасан 7 хоногийн 5 өдөр ажиллах тул сард дундажаар 22 ажлын өдөр байдаг болно.

⁶ Хөдөлмөрийн тухай хуульд заасан 1 ажлын өдөрт ажиллах цаг

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд нэг хуулийн этгээдэд үүсгэж байгаа захиргааны зардлыг Үндэсний танхимд гишүүнээр элсэх үйл ажиллагаанд зарцуулж буй хугацааг ажлын хөлсөөр үржүүлэх замаар тооцоолох юм.

Хүснэгт 4

д/д	Гүйцэтгэх үүрэг	Зарцуулах хугацаа	Ажлын хөлс /минутаар/	Нэг аж ахуйн нэгжийн зардал
1	7.4.Энэ хуулийн 7.1-д заасан аж ахуй эрхлэгч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэнээс хойш 90 хоногийн дотор өөрийн үйл ажиллагаа явуулж буй чиглэлээр байгуулагдсан мэргэжлийн танхим эсхүл салбар танхимд бүртгүүлж, гишүүнээр элсэнэ.	44 минут	110 төгрөг	4,840 төгрөг

2.3.ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тогтоосон үүргийг буюу хуулийн төслийн тухайд Үндэсний танхимд гишүүнээр элсэх үүргийг хэдэн хуулийн этгээд, жилд хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргах юм.

Хуулийн төсөлд зааснаар ашгийн төлөө хуулийн этгээд нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 90 хоногийн дотор салбар танхим, эсхүл мэргэжлийн танхимд бүртгүүлж, гишүүнээр элсэхээр заасан байна. Үндэсний танхимын www.mongolchamber.mn цахим хуудаст мэдээлснээр тус танхим нь 2020 оны 2 дугаар сарын байдлаар 5,000 орчим гишүүнтэй бол Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн www.burtgel.mn цахим хуудаст 2020 оны 2 дугаар сарын байдлаар Монгол Улсад 194,741 хуулийн этгээд бүртгэлтэй бөгөөд эдгээрээс 36,642 нь ашгийн төлөө бус, 158,099 нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд байна. Улсын бүртгэлийн ерөнхий газар нь 2017 онд 15464, 2018 онд 15536, 2019 онд 15465 шинээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэн байна.⁷

Тоон үзүүлэлтийг гаргахын тулд **тохиолдлын тоо**⁸ болон **давтамжийг**⁹ холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр **“тоон үзүүлэлт”** нь илэрхийлэгдэх юм.

ТОХИОЛДЛЫН ТОО x ДАВТАМЖ = ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Дээрх томъёог ашиглан Үндэсний танхимд бүртгүүлж, гишүүнээр элсэх үүргийн тоон үзүүлэлтийг тогтооё.

Хүснэгт 5

д/д	Гүйцэтгэх үүрэг	Тохиолдлын тоо	x	Давтамж	=	Тоон үзүүлэлт
1	7.4.Энэ хуулийн 7.1-д заасан аж ахуй эрхлэгч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэнээс хойш 90 хоногийн дотор өөрийн үйл ажиллагаа	15,465 ¹⁰	x	1 ¹¹	=	15,465

⁷ Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны үйл ажиллагааны тайлангаас

⁸ “Тохиолдлын тоо” гэдэг нь тухайн шинээр бий болж байгаа үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлэх тоог ойлгоно.

⁹ “Давтамж” гэдэг нь тухайн үүргийг биелүүлэх хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж байгууллагауг үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэхийг илэрхийлэх тоо юм.

¹⁰ 2019 онд шинээр үүсгэн байгуулагдан Улсын бүртгэлд бүртгэгдсэн хуулийн этгээдийн тоо

¹¹ Гишүүнээр элсэх үүргийг зөвхөн нэг удаа хэрэгжүүлэх тул давтамжийг 1 байхаар тодорхойлов.

	явуулж буй чиглэлээр байгуулагдсан мэргэжлийн танхим эсхүл салбар танхимд бүртгүүлж, гишүүнээр элсэнэ.				
--	--	--	--	--	--

Нэг хуулийн этгээд Үндэсний танхимд гишүүнээр элсэх үүргийг биелүүлэхтэй холбоотой захиргааны зардал нь өмнөх хэсэгт 4,840 төгрөг байхаар тооцоолсон болно.

2.4.НИЙТ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ДҮНГ ТООЦОЖ ГАРГАХ

Энэ үе шатанд хуулийн төслийн дагуу шинээр хүлээсэн үүргийг хуулийн төслийн үйлчлэлд хамаарах нийт хуулийн этгээдэд ямар хэмжээний захиргааны зардал гарах вэ гэдгийг нэг бүрийн зардлыг “тоон үзүүлэлт”-ээр үржүүлэх замаар тооцоолох юм. Үүнийг томъёогоор илэрхийлвэл:

НЭГ БҮРИЙН ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ x ТООН ҮЗҮҮЛЭЛТ = НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт 6

д/д	Гүйцэтгэх үүрэг	Нэг бүрийн зардал	x	Тоон үзүүлэлт	=	Нийт зардал ¹²
1	7.4.Энэ хуулийн 7.1-д заасан аж ахуй эрхлэгч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэнээс хойш 90 хоногийн дотор өөрийн үйл ажиллагаа явуулж буй чиглэлээр байгуулагдсан мэргэжлийн танхим эсхүл салбар танхимд бүртгүүлж, гишүүнээр элсэнэ.	4,840 ¹³	x	15,465 ¹⁴	=	74,850,600 төг

2.5.ХУВИЛБАРЫГ НЯГТАЛЖ, ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙН ТАЛААР

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн дагуу шинээр байгуулагдах нийт хуулийн этгээдийг мэргэжлийн танхим, эсхүл салбар танхимд заавал гишүүнчлэлтэй байх үүргийг хүлээлгэсэн болно.

Уг үүрэгтэй холбоотойгоор нэг хуулийн этгээдэд болон нийт хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг тооцоолон гаргалаа. Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд сайн дурын гишүүнчлэлтэй байгаа ба 2020 оны 2 дугаар сарын байдлаар 5,000 орчим гишүүнтэй гэсэн статистик гаргасан байна.

Гэтэл 2020 оны байдлаар Монгол Улсад ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг 158,099 хуулийн этгээд байгааг Улсын бүртгэлийн ерөнхий газрын статистик тоо харуулж байна. Хуулийн төсөл батлагдснаар одоо танхимын гишүүн бус 153,000 орчим хуулийн этгээдийг заавал гишүүнчлэлд хамруулах шаардлага бий болохтой холбоотойгоор хуулийн этгээдэд нилээн зардал чирэгдэл үүсэхээр байгаа тул хуулийг

¹² “Нийт зардал” гэдэг нь уг хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн төсөлд тусгагдсан үүргийг биелүүлэх нийт хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал юм.

¹³ Танхимд гишүүнээр элсэхэд нэг хуулийн этгээдээс гарах захиргааны зардал

¹⁴ Тоон үзүүлэлт буюу уг үүргийг нэг жилд хэдэн хуулийн этгээд гүйцэтгэх талаарх үзүүлэлт буюу давтамж, тохиолдлын тооны үржвэр.

дагаж мөрдөх журмын тухай хууль гаргах замаар нэгэнт байгуулагдсан боловч Худалдаа аж үйлдвэрийн танхимын гишүүн бус хуулийн этгээдүүдийн гишүүнчлэлийн асуудлыг хялбаршуулан шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

2.6.НЭМЭЛТ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан хуулийн этгээдийн зүгээс хуульд заасан үүргийг биелүүлэхийн тулд зайлшгүй төлөхөөр хууль тогтоомжоор тогтоосон төлбөр хураамж, шинээр худалдан авах шаардлагатай тоног төхөөрөмж, материал зэрэгтэй холбогдон үүсч, шууд гарах зардлыг **нэмэлт зардал** гэсэн ойлголтод хамруулж ойлгодог болно.

Худалдаа аж үйлдвэрийн танхимын гишүүнээр элсэхийн тулд уг танхимын дүрэмд заасны дагуу гишүүнчлэлийн татвар төлдөг бөгөөд татварын хэмжээний талаар Үндэсний танхимын цахим хуудаст дараах байдлаар тогтоосон байна. Энэ нь гишүүн байгууллагын Үндэсний танхимаас авах үйлчилгээний цар хүрээнээс хамааран ялгамжтай байдлаар тогтоосон байна.

Хүснэгт 7


д/д	Гишүүнчлэлийн ангилал	Сарын хураамж	Жилийн хураамж
1	Standart	10.000	100.000
2	Gold	50.000	500.000
3	Platinum	100.000	1.000.000
4	Diamond	300.000	3.000.000
5	Sponsor	-	10.000.000

Хуулийн этгээдэд үүсэх зардлыг тухай хуулийн этгээд өөрөө санхүүжүүлдэг болохыг тэмдэглэж байна.

ГУРАВ.ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН ҮНДЭСНИЙ ТАНХИМД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО


Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн төслөөр зохицуулах харилцааны онцлогоос хамааран хуулийг хэрэгжүүлэгч буюу хуулиар чиг үүрэг хүлээсэн байгууллага нь төрийн бус, ашгийн төлөө бус хуулийн этгээд болох Үндэсний танхим байгаа болно.

Үндэсний танхим нь хуулийн төслийн дагуу тодорхой шинэ чиг үүргийг одоо хэрэгжүүлж байгаа чиг үүрэг дээр нэмж хэрэгжүүлэхээр байна. Иймд уг чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Үндэсний танхимд ямар хэмжээний зардал үүсэхийг тооцоолон гаргах юм. Ингэхдээ төрийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох аргачлал, үе шатыг ашиглан дараах үе шатын дагуу тооцоолно. Үүнд:



I үе шат. Байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлох

Байгууллагын буюу Үндэсний танхимын шинээр гүйцэтгэх үүргийг тодорхойлохдоо дараах алхамыг хийнэ:



Хуулийн төслийн зохицуулалтын хүрээнд шинээр үүрэг хүлээсэн байгууллагыг тодорхойлох; Манай тохиолдолд үүрэг хүлээсэн байгууллага нь Үндэсний танхим юм.

Шинээр хүлээсэн гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн тодорхойлно.

Гүйцэтгэх чиг үүргийг тогтоох:


Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр дараах чиг үүргийг Үндэсний танхим шинээр нэмж гүйцэтгэхээр заасан байна.

- Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтад “Монгол Улсад зохион байгуулагдах олон улсын болон бүс нутгийн аж ахуй эрхлэгчдийн бараа, ажил, үйлчилгээний болон Монгол Улсын аж ахуй эрхлэгчдийн гадаад улсад оролцох үзэсгэлэн, худалдааны бүртгэлийг хөтөлж, олон нийтэд таниулан сурталчлах;”-аар заасан байна.

3.2.ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ТОДОРХОЙЛОХ

Тухайн чиг үүрэг, түүнд хамаарах ажил үйлчилгээг хэрэгжүүлэх хугацаа болон уг ажил үйлчилгээг нэг жилд хэдэн удаа, /хэдэн иргэн, хуулийн этгээдэд/ гүйцэтгэх тоо /тохиолдлын тоо/, шаардагдах нийт ажлын цаг гэсэн гурван үзүүлэлтээр шинээр нэмэгдэж буй чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тооцоолон гаргана.

Өөрөөр хэлбэл үүрэг буюу ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлохын тулд дараах алхамыг гүйцэтгэнэ.



Тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог /цаашид "тохиолдлын тоо" гэх/, шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо Үндэсний танхимын холбогдох албан хаагчтай уулзаж адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн саналыг авсны үндсэн дээр баримжаалж тогтоов.

Дотоод үзэсгэлэн:

Хүснэгт 8

Танхимын шинээр гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минутаар/
		цагаар		
Монгол Улсад зохион байгуулагдах олон улсын болон бүс нутгийн аж ахуй эрхлэгчдийн бараа, ажил, үйлчилгээний болон Монгол Улсын аж ахуй эрхлэгчдийн гадаад улсад оролцох үзэсгэлэн, худалдааны бүртгэлийг хөтөлж, олон нийтэд таниулан сурталчлах;	Тухайн жилд зохион байгуулах дотоодын үзэсгэлэнгийн төлөвлөгөө боловсруулах, баталгаажуулах.	8	2 ¹⁵	16
	Үзэсгэлэнгийн заалтай үзэсгэлэн зохион байгуулах гэрээг байгуулах хугацааг баталгаажуулах.	8	2	16
	Үзэсгэлэнгийн танилцуулга Монгол, Англи хэл дээр бэлтгэн гадаад, дотоодын байгууллагуудад хүргүүлэх	40	2	80
	Үзэсгэлэнг хамтран зохион байгуулах байгууллагууд болон шалгаруулалтын комиссын гишүүдэд мэдээлэл өгч хамтран ажиллах санал хүргүүлэх.	24	2	48
	Үзэсгэлэн эхлэхээс 1 сарын өмнө Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, олон улсын байгууллагууд, хамтрагч байгууллагуудад урилга бэлтгэн хүргүүлэх.	16	2	32
	Үзэсгэлэн эхлэхээс өмнө нийт оролцогчдоос байгууллага болон бүтээгдэхүүн үйлчилгээний тухай мэдээллүүдийг нэгтгэн авч үзэсгэлэнд зориулан каталог тараах материал бэлтгэх	40	2	80
	Үзэсгэлэнгийн зар сурталчилгаа, ТВ-ийн шторк, баннер зэргийг бэлтгэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зараа түгээж реклам самбаруудад мэдээллээ байршуулах.	40	2	80
	Үзэсгэлэнгийн нээлтийн арга хэмжээ болон үзэсгэлэнгийн хөтөлбөр гаргах.	16	2	32
	Үзэсгэлэнгийн зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хуралдуулах тус үзэсгэлэнд оролцсон шилдэг	16	2	32

¹⁵ Монгол Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдснаар энэ жил дотоодын 2 үзэсгэлэн зохион байгуулахаар төлөвлөсөн тул тохиолдлыг тоог 2 байхаар тогтов.

	бүтээгдэхүүн, үйлчилгээг шалгаруулж үзэсгэлэнгийн нэрэмжит цом өргөмжлөлөөр шагнахаар шийдвэрлэх.			
	Шалгарсан байгууллагуудад олгох цом өргөмжлөлийг захиалан бэлдэх.	8	2	16
	Үзэсгэлэнгийн хаалтын хүлээн авалт зохион байгуулж шалгарсан байгууллагуудад үзэсгэлэнгийн нэрэмжит цом, өргөмжлөлийг гардуулах.	16	2	32
	Үзэсгэлэнгийн тайлан санхүүгийн тооцоог гаргах	24	2	48
НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА				512 цаг

Гадаад үзэсгэлэн:

Хүснэгт 9

Танхимын шинээр гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минутаар/
		цагаар		
Монгол Улсад зохион байгуулагдах олон улсын болон бүс нутгийн аж ахуй эрхлэгчдийн бараа, ажил, үйлчилгээний болон Монгол Улсын аж ахуй эрхлэгчдийн гадаад улсад оролцох үзэсгэлэн, худалдааны бүртгэлийг хөтөлж, олон нийтэд таниулан сурталчлах;	Гадаад үзэсгэлэнгийн урилга хүлээн авах	1	30 ¹⁶	30
	Үзэсгэлэнгийн талаар судалгаа хийж Монголын бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, худалдан борлуулах боломжтой эсэхийг тодорхойлох	24	30	720
	Үзэсгэлэнгийн зар, бүртгэлийн хуудас, зардлын тооцоог гаргаж баталгаажуулах,	8	30	240
	Танхимын вебсайт, ФБ пэйж хуудас, гишүүдийн мэйл хаягаар үзэсгэлэнгийн мэдээллийг түгээх,	4	30	120
	Үзэсгэлэнд оролцогчидтой гэрээ байгуулж төлбөрийг барагдуулах,	32	30	960
	Үзэсгэлэнд оролцох бараа бүтээгдэхүүнийг хил нэвтрүүлэхэд шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх,	24	30	720
	Оролцогчдын бараа бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэх, худалдааны чөлөөт бүсээр нэвтрүүлэх,	16	30	480
	Оролцогчдын онгоц, галт тэрэгний билетийн захиалга хийх,	8	30	240
	Оролцогчдын зочид буудлыг захиалах,	8	30	240
	Үзэсгэлэнгийн талбайн хуваарилалт хийж үзэсгэлэнгийн талбайн тохижилтийн ажил хийх,	16	30	480
	Сэтгэл ханамжийн судалгаа авах /оролцогчдоос, болон үзэгчдээс/	8	30	240
	Борлуулалтын мэдээ авч нэгтгэх,	8	30	240
	Үзэсгэлэнгийн тайлан гаргаж судалгааг нэгтгэн үр ашгийн тооцоо хийж удирдлагуудад тайлагнах,	16	30	480
НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА				4,950 цаг

¹⁶ Монгол Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын 2020 оны төлөвлөгөөнд гадаадад болон 30 үзэсгэлэнд оролцохоор төлөвлөсөн тул тохиолдолын тоог үүгээр авав.

Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд нийт шаардлагатай хугацаа

Хүснэгт 10


д/д	Үзэсгэлэнгийн төрөл	Шаардлагатай хугацаа
1	Дотоод үзэсгэлэн	512 цаг
2	Гадаад үзэсгэлэн	4,950 цаг
3	Нийт	5,462 цаг

Шаардлагатай хүний нөөцийг гаргах нь:

$5,462 \text{ цаг} : 8^{17} \text{ цаг} = 682 \text{ ажлын өдөр} : 200^{18} = 3.4 \text{ албан хаагч шаардлагатай байна.}$

Гарах зардлыг урьдчилан тооцоолох

Хуулиар хүлээсэн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөц нэмэх шаардлагатай болсон тохиолдолд нийт зардлыг тооцохдоо дараах зардлын төрлийг орхигдуулахгүй хамт тооцох юм. Үүнд:



Худалдаа аж үйлдвэрийн танхимд үүсэх нийт зардал:

Хүснэгт 11

д/д	Зардлын төрөл	Хэмжээ
1	Хүний нөөцийн зардал	3.4 албан хаагчийн цалин хөлс
2	Материаллаг зардал	3.4 албан хаагчтай хамааран гарах ажлын байрны зардал, ажиллах хэрэгслийн зардал
3	Бусад зардал	Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой тоног төхөөрөмж зэрэг шууд гарах зардал. Энэ хуулийн төслийн хүрээнд бусад зардал байхгүй болно.

-----oOo-----

¹⁷ Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг өдрийн ажлын цаг

¹⁸ Хуанлийн 365 хоногоос Хөдөлмөрийн тухай хуульд заасан нийтээр амрах баярын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитойгоор ажиллах өдрийг 200 өдөр байхаар тооцохыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан аргачлалд заасан болно.

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдан гарах зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2015 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалыг баримтлан гүйцэтгэв.

Хуулийн төслийн зохицуулах харилцааны онцлогоос хамааран хуулийн төсөл нь төрийн болон иргэнд аливаа төрлийн зардал үүсгэхгүй бөгөөд харин зардал тээгч гуравдагч бүлэг болох хуулийн этгээдэд тодорхой төрлийн зардал үүсгэхээр байна.

Хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдийг хоёр үндсэн бүлэгт хувааж болохоор байна. Үүнд нэг талаас эрх ашиг сонирлоороо нэгдсэн гишүүн хуулийн этгээдүүд, нөгөө талаас тэдгээрийн эрх ашгийн нэгдэл дээр байгуулагдсан Үндэсний танхим гэсэн ашгийн бус хуулийн этгээд байна.

Иймээс хуулийн этгээдэд үүсэх зардлыг дээрх хоёр бүлэгт үүсч байгаа зардлаар хоёр бүлэг болгон тооцсон болно. Хуулийн төслөөр Монгол Улсад үүсгэн байгуулагдсан ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах нийт хуулийн этгээд нь салбар танхим, эсхүл мэргэжлийн танхимын заавал гишүүнлэлтэй байх зохицуулалт туссантай холбоотойгоор гишүүнээр элсэхэд хуулийн этгээдэд үүсэх захиргааны болон нэмэлт зардлыг тооцон гаргасан болно. Хуулийн энэ зохицуулалт нь батлагдвал одоо хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэлтэй, гишүүнээр элсээгүй 153,000 орчим хуулийн этгээдийн гишүүнчлэлийн асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг дагаж мөрдөх журмын зохицуулалтаар тодорхой болгохгүй бол тэдгээр хуулийн этгээдүүдэд зардал, хүндрэл үүсэхээр байгааг анхаарах шаардлагатайг дурдсан болно.

Харин нөгөө талаас Үндэсний танхим нь нийт ашгийн төлөө хуулийн этгээдүүдийн эрх ашгийг хамгаалах зорилготойн хувьд шинэ төрлийн чиг үүрэг нэмж хүлээж байгаа учир Үндэсний танхимд тодорхой зардал үүснэ гэж үзэж Үндэсний танхимд үүсэх зардлыг шинээр нэмэгдэж байгаа чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцөөр дамжуулан гаргасан болно.

Хуулийн төслийг дагалдан гарах зардал нь хуулийн төслийн үр өгөөжтэй харьцуулахад үр өгөөж нь илүү буюу зардал байж болохуйц хэмжээнд байна гэж үзлээ.

-----oOo-----

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛЬ

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

Товчилсон үгсийн жагсаалт

Удиртгал

НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1. 1 Үнэлгээ хийх шалтгаан
1. 2 Үнэлгээ хийх хүрээ
1. 3 Үнэлгээний шалгуур үзүүлэлт
1. 4 Үнэлгээний харьцуулах хэлбэр
1. 5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох
1. 6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3. 1 “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал
3. 2 “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5. 1 Дүгнэлт
5. 2 Зөвлөмж

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХАВСРАЛТ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим
ХАҮТ-Х	Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
УБЕГ	Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
УЗ	Удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн Газар
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНКУ	Бүгд Найрамдах Казахстан Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
УБЕГ	Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага

Удиртгал

Монгол Улсын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын захиалгаар “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль”-ийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

“Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль”-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгаа нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой.

Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатаас бүрдсэн болно.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох,
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох
- Харьцуулах хэлбэрийг сонгох
- Шалгуур үзүүлэлтийг томъёолох
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

1.1 Үнэлгээ хийх шалтгаан

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /цаашид “ХАҮТтХ” гэх/ нь 1995 оны 10 дугаар сарын 24-ний өдөр батлагдаж, 2002, 2011, 2015 онуудад тус бүр нэмэлт өөрчлөлт орж байсан боловч өнөөдрийг хүртэл нэг ч удаа хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээгүй байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр зааагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дөрөв дэх хэсэгт засаглалын бодлогын талаар заасан бөгөөд 4.2.10-т “Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын тавд засаглалын бодлогын талаар заасан бөгөөд зорилго 5-д “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” гэж зааснаас гадна “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны тав дахь хэсэгт засаглалын талаар зааж, 5.2 дахь хэсэгт “Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна.”, 5.2.13-т “Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах, эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.”, 5.2.14-т “Гэрээгээр гүйцэтгүүлж болох бүх төрийн чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудад шилжүүлэх тогтолцоог нэвтрүүлнэ.” гэж тус тус заасан.

Мөн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр Тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал /цаашид “Аргачлал” гэх/-ын 3.2.4-т “нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар түүнийг өөрчлөх, шинэчлэх, эсхүл

хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал гаргасан” бол гэж зааснаар Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим /цаашид “Үндэсний танхим” гэх/-ын зүгээс дээрх аргачлалын 3.2.2-т “хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт бодит байдалд нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, эсхүл нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, эсхүл тэдгээрээс улбаалсан сөрөг үр дагавар бий болсон бол” гэсний дагуу энэхүү нөхцөл байдал үүссэн тухай үндэслэл бүхий зарчмын тодорхой саналууд гаргасан байна.

Иймд дээрх шалтгаануудын үүднээс ХАҮТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай гэж үзэн энэхүү үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

1.2 Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” хэмээн заасан байна. Иймд ХАҮТХ-ийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий заалтуудаар үнэлгээний хүрээг тогтоох шаардлагатай байна.

Иймд дээрх шалгуур үзүүлэлтийг үндэслэн ХАҮТХ-ийн 1 дүгээр зүйлд зааснаар “Энэ хуулийн зорилт нь худалдаа, аж үйлдвэрийн танхим болон худалдааны танхим /цаашид “танхим” гэх/-ын бүрэн эрх, үйл ажиллагааны үндсэн чиглэл, түүний тогтолцоо, зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох, танхим болон төрийн ба бусад байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн хоорондын харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан бөгөөд өнөөдрийн байдлаар Үндэсний танхимд тус зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүрэн эрх хуулиар олгогдсон эсэх, бүтцийн хувьд тус зорилтыг хэрэгжүүлэх боломжтой эсэх, төсөв, санхүүгийн хувьд зорилтоо хэрэгжүүлэх боломж бий эсэх, гишүүнчлэлийн хувьд өнөө цагийн бизнесийн орчинд хэр нийцэж байгаа зэрэг эрх зүйн зохицуулалтуудыг үнэлгээ хийх хүрээнд хамруулах нь зүйтэй гэж үзлээ. Өөрөөр хэлбэл дараах зохицуулалтууд үнэлгээ хийх хүрээнд хамаарна гэсэн үг. Үүнд:

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Зохицуулалтын агуулга
1	5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт	“Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим байж болно.”
2	6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг ¹	1 дэх заалт. “төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах, түүний дотоод, гадаадад тайлбарлан таниулах, хэрэгжилтэд нь тус дэмжлэг үзүүлэх”
3	6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг	2 дахь заалт. “худалдаа, үйлдвэрийнхний нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлөн илэрхийлэх, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал оруулах”
4	6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг	4 дэх заалт. “хуульд зааснаар дэргэдээ гадаад худалдааны арбитр байгуулан ажиллуулах”
5	6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг	6 дахь заалт. “давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх”

¹ Үндэсний танхим нь танхимын нийтлэг зорилт, бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ дараахь тодорхой бүрэн эрхтэй байна.

6	10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	"Үндэсний танхим нь энэ хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5, 6-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх албыг байгуулан ажиллуулна. Түүний ажиллах журмыг зөвлөл тогтооно."
7	11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	"Танхимын санхүүжилт гишүүний татвар, иргэд, байгууллагын хандив, үйлчилгээний орлогоос бүрдэнэ."

1.3 Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4-т Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан бөгөөд энэхүү шалгуур үзүүлэлтүүдээс дараахь 2 шалгуур үзүүлэлтийг сонгож байна. Үүнд:

Аргачлалын 3.4.1-д заасан "зорилгод хүрсэн түвшин". Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.

Аргачлалын 3.4.5-д заасан "практикт нийцэж байгаа байдал". Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

1.4 Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.5.3 дахь хэсэгт заасан дөрвөн төрлийн харьцуулах хэлбэрүүдээс 3.5.3.1. "байх ёстой болон одоо байгаа байдал"², мөн 3.5.3.4. "тохиолдол судлах"³ хэлбэрүүдийг сонголоо. Учир нь, одоо байгаа нөхцөл байдлыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлагатай харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохын тулд "байх ёстой болон одоо байгаа" харьцуулах хэлбэрийг хэрэглэхээр заасан байна. Бид үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн заалтуудын хувьд "зорилгод хүрсэн түвшин" шалгуур үзүүлэлтээр шалгахад тогтоосон тул үүнтэй уялдуулан дээрх харьцуулах хэлбэрийг сонгов.

Мөн үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн заалтууд бусад улс орнуудын хувьд хэрхэн хэрэгждэг талаар судлах үүднээс "тохиолдол судлах" харьцуулах хэлбэрийг сонгосон болно. Учир нь бусад улс орнуудын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль тогтоомжийг харьцуулан судлах нь тус хуулийг сайжруулахад зайлшгүй хийгдэх ёстой судалгаа гэж үзлээ.

1.5 Шалгуур үзүүлэлтийг томьёолох

² Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар (одоо байгаа нөхцөл байдал)-ыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон гаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно.

³ Хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэмж хэмжээ өөр, өөр орчин нөхцөл (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

Дээр тайлбарласан ёсоор бид энэхүү үнэлгээг хийхэд зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал болон хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг сонгож авсан болно. Шалгуур үзүүлэлтийг томъёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараахь асуултуудыг боловсрууллаа.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- ХАҮТХ-ийн 5 дугаар зүйлийн 2 дах хэсэг. Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим байгуулах зорилгодоо хүрсэн эсэх?
- ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 1 дэх заалт. Үндэсний танхим нь төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах, түүний дотоод гадаадад таниулах, хэрэгжилтэд тус дэмжлэг үзүүлэх зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?
- ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 2 дахь заалт. Худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлж, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал оруулах зохицуулалт зорилгодоо хүрсэн үү?
- ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 4 дэх заалт. Үндэсний танхимын дэргэд гадаад худалдааны арбитр байгуулан ажиллуулах зохицуулалт зорилгодоо хүрсэн үү?
- ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6 дахь заалт. Давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?
- ХАҮТХ-ийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Үндэсний танхим нь экспортын барааны гарал үүслийг гэрчлэх, экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах, давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх албыг байгуулах зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?
- ХАҮТХ-ийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. Танхим нь гишүүний татвар, иргэд байгууллагын хандив, үйлчилгээний орлогоор санхүүжилтээ шийдэх зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- ХАҮТХ-ийн 5 дугаар зүйлийн 2 дах хэсэг. Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим байгуулах зохицуулалтыг өнөөдрийг хүртэл практикт хэчнээн удаа хэрэглэсэн бэ? Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын хэчнээн танхим байгуулсан бэ?
- ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 1 дэх заалт. Үндэсний танхим нь төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах, түүний дотоод гадаадад таниулах, хэрэгжилтэд тус дэмжлэг үзүүлэх зохицуулалт практикт хэрэгжиж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байна уу?
- ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 2 дахь заалт. Худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлж, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал оруулах зохицуулалт практикт хэрэгжиж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байна уу?
- ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 4 дэх заалт. Үндэсний танхимын дэргэд гадаад худалдааны арбитр байгуулан ажиллуулах зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?
- ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6 дахь заалт. Давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

- ХАҮТХ-ийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Үндэсний танхим нь экспортын барааны гарал үүслийг гэрчлэх, экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах, давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх албыг байгуулах зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?
- ХАҮТХ-ийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. Танхим нь гишүүний татвар, иргэд байгууллагын хандив, үйлчилгээний орлогоор санхүүжилтээ шийдэх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны ажил уншиж, судлах, харьцуулалт хийх, мэргэжилтнүүдтэй уулзаж, ярилцах, санал солилцох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд мэдээлэл цуглуулах дараахь аргуудыг ашигласан болно. Үүнд:

- Аргачлалын 3.7.3.1-д заасны дагуу Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах: ХАҮТХ-д холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, бусад эрх зүйн баримт бичиг, ном сурах бичиг, нэг сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, статистик мэдээнд дүн шинжилгээ хийсэн;
- Аргачлалын 3.7.3.2-т заасны дагуу Холбогдох субъектээс судалгаа авах: ХАҮТХ-ийн үйлчлэлд хамаарах худалдаа, үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага болон хуульч, судлаачдаас фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргаар судалгаа авсан.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ХАҮТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ бэлэн байгаа мэдээллийг цуглуулах, холбогдох субъектээс судалгаа авах аргаар холбогдох материалыг цуглуулан үнэлгээг хийсэн болно.

- *Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах*

Хууль, эрх зүйн акт

Монгол Улсын Үндсэн хууль, 1992

Монгол Улсын Иргэний хууль, 2002

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль, 1995

Төрийн бус байгууллагын тухай хууль, 1997

Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2016

Статистик мэдээ, судалгааны тайлан, ном, сурах бичиг

Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын 2011-2014 онуудад хийсэн ажлын тайлан, УБ., 2014 он

Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын 2015-2018 онуудад хийсэн үйл ажиллагааны тайлан, УБ., 2018 он

МҮХАҮТ-ын гишүүдийн 2016 оны сэтгэл ханамжийн судалгааны тайлан, УБ., 2017 он

Монгол Улсын бизнесийн орчны суурь судалгаа-эцсийн тайлан, УБ., 2018 он

Монгол орны хувьд баримтлах стратеги, Европын сэргээн босголт хөгжлийн банкны баримт бичиг, УБ., 2013 он

Бизнес итгэлийн индекс, 2016 оны судалгааны тайлан, УБ., 2016 он

Монголын бизнесийн орчны судалгаа, УБ., 2017 он

Монгол Улсын компанийн засаглалын үндэсний тайлан, УБ., 2015 он

Бизнес итгэлийн индекс, 2018 оны судалгааны тайлан, УБ., 2018 он

Бизнес итгэлийн индекс, 2017 оны судалгааны тайлан, УБ., 2017 он

Арбитрын тухай хуулийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, эрх зүйн орчныг сайжруулах арга зам, Хууль зүйн үндэсний хүрээлэн иргэн, эдийн засгийн эрх зүйн сектор, УБ., 2010 он

Монголын бизнесийн орчны талаарх үндэсний хэмжээний судалгааны үр дүн, УБ., 2014 он

МҮХАҮТ-ын 2018 оны бодлого, зорилтууд, УБ., 2018 он

Цахим эх сурвалж

<http://opendata.burtgel.gov.mn/lesinfo/8172676>

<http://opendata.burtgel.gov.mn/les?condition=3&text=%D1%82%D0%B0%D0%BD%D1%85%D0%B8%D0%BC>

<http://2012.parliament.mn/law/project/931/category/1>

<http://www.arbitr.mn/index.php/aboutus>

https://www.ubchamber.mn/uploads/Force_majeure_Hardship.pdf

<https://www.mongolchamber.mn/>

ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн томъёоллын дагуу ХАҮТХ-аас сонгож авсан зохицуулалтуудад дараахь байдлаар үнэлгээ хийлээ.

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

ХАҮТХ-ийн үндсэн зорилтыг “худалдаа, аж үйлдвэрийн танхим болон худалдааны танхим /цаашид “танхим” гэх/-ын бүрэн эрх, үйл ажиллагааны үндсэн чиглэл, түүний тогтолцоо, зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох, танхим болон төрийн ба бусад байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн хоорондын харилцааг зохицуулахад оршино” хэмээн уг хуулийн 1 дүгээр зүйлд заажээ. Энэхүү зорилтыг хуулийн бүхий л зохицуулалт хангаж байх ёстой гэж үзэж байна. Иймд тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалт, 6.2.2 дахь заалт, 6.2.6 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг болон 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн зохицуулалт тус бүрт үнэлгээ хийхээр сонгож авсан болно.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ХАҮТХ-ийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.⁴ Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим байгуулах зорилгодоо хүрсэн эсэх?

ХАҮТХ-ийн 5 дугаар зүйлээр танхимын тогтолцоог зохицуулсан бөгөөд тус зүйлийн 2 дугаар хэсэгт “Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим байж болно.” гэж заасан бөгөөд тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Аймаг, нийслэлийн, аймаг дундын танхимыг 50-иас доошгүй аж ахуйн нэгж, байгууллага Иргэний хууль болон Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу үүсгэн байгуулж болно.” гэж заасны дагуу бие даасан танхим байгуулах эрх нь аж ахуйн нэгж, байгууллагуудад нээлттэй байна. Харин ХАҮТХ-ийн 7 дугаар зүйлийн 1-д зааснаар “Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим тухайн нутаг дэвсгэрт нэг байна.” гэснээр аймаг тус бүр эсхүл нийслэлийн танхим нь тухайн нутаг дэвсгэрт нэг байхаар байна. Өөрөөр хэлбэл тус зохицуулалтын зорилго нь Монгол Улсын 21 аймаг бие даасан танхим байгуулах, эсхүл аймаг дундын танхим байгуулах, нийслэлд танхим байгуулах боломжийг бий болгосон байна.

Өнөөдрийн байдлаар “танхим” гэсэн нэр агуулсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо нийт 69 байгаа бөгөөд үүнээс ТББ-ын хэлбэрээр нийт 65 аж ахуйн нэгж байгууллага байгуулагдсан байна. Үүний нэг нь Улаанбаатар хотын танхим бөгөөд 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр 50 аж ахуйн нэгж нийлэн “Гишүүдээ дэмжих, нийслэлийн эдийн засгийн хөгжлийг дэмжих төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, засаг захиргааны бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сурталчлах, бизнес эрхлэгчдийн санал бодлыг уламжлах”⁵ чиглэлээр үүсгэн байгуулагдсан байна. Өөрөөр хэлбэл ХАҮТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан 50-иас доошгүй аж ахуйн нэгж, байгууллага нийлэн үүсгэн байгуулсан, хуулийн дагуу бие даасан танхим байна.

Харин “танхим” гэсэн нэр агуулсан бусад ТББ-ын (Үндэсний танхимаас бусад) хувьд аваад үзвэл дараах нөхцөл байдалтай байна. Тухайлбал, “Шинжаны Худалдаа, аж үйлдвэрийн танхим” ТББ, “Монгол Оросын худалдааны танхим” ТББ, “Монгол тайваны хамтын ажиллагаа, Худалдаа, аж үйлдвэрийн танхим” ТББ, “Монгол хятадын хөрөнгө оруулалт худалдаа хамтын ажиллагааны танхим” ТББ, “Монгол, Израйлийн хадалдаа, соёл урлаг, боловсролын төв танхим” ТББ, “Хятад

⁴ ХАҮТХ-ийн 5 дугаар зүйлээр Танхимын тогтолцоог зохицуулж өгсөн бөгөөд 2 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим байж болно” гэж заасан байна.

⁵ <http://opendata.burtgel.gov.mn/lesinfo/8172676>

монголын эдийн засаг, худалдааны талын зам танхим” ТББ, “Монгол туургатны худалдааны танхим” ТББ, “Монгол польшийн аж үйлдвэрийн танхим” ТББ, “Бельги ба монголын албан ёсны худалдааны танхим” ТББ, “Монгол европын худалдаа аж үйлдвэр бизнесийн танхим” ТББ, “Монгол Солонгосын гадаад худалдаа, бизнес хөгжлийн хамтын ажиллагааны танхим” ТББ, “Бразил Монголын худалдааны танхим” ТББ, “Монгол францын худалдаа, аж үйлдвэрийн танхим” ТББ, “Монгол хятадын бүтээн байгуулалт, худалдааны танхим” ТББ, Монгол дахь австралийн худалдааны танхим” ТББ, “Канад монголын худалдааны танхим” ТББ⁶ зэрэг хувь хүмүүс нийлэн үүсгэн байгуулсан хоёр орны худалдааны хөгжлийг дэмжих, бизнес эрхлэгчдийн эрх, ашгийг хамгаалах, сургалт семинар зохион байгуулах, ижил төстэй байгууллагатай харилцах, бизнес эрхлэгчдийг холбох зэрэг нийтлэг зорилго чиглэлтэй “танхим” нэрийг агуулсан хоёр орны хамтын үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Харин “Баянхонгор аймгийн гар үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн танхим” ТББ, “Гар үйлдвэрлэлийн танхим” ТББ, “Үндэсний хөдөө аж ахуй, худалдаа үйлдвэрлэлийн танхим” ТББ, “Монголын хайлуур жоншны Худалдаа, аж үйлдвэрийн танхим” ТББ, “Монголын уул уурхайн салбарын Худалдаа, аж үйлдвэрийн танхим” ТББ зэрэг үйлдвэрлэл худалдааны чиглэлээр байгуулагдсан иргэд хоорондоо нийлж үүсгэн байгуулсан ТББ-ууд үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр нь ХАҮТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан 50-иас доошгүй аж ахуйн нэгж, байгууллага нийлэн үүсгэн байгуулсан бие даасан танхим биш бөгөөд зөвхөн “танхим” гэх үгийг ашиглан иргэд хоорондоо нийлж байгуулсан ТББ-ууд байна.

Үндэсний танхим нь өнөөдрийн байдлаар 21 аймагт салбар танхимтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Хөдөө орон нутгийн бизнес эрхлэгчдэд хүрч ажиллах, тэдгээрийг дэмжих зорилгоор 1998 онд анхны салбар танхимыг Дархан-Уул аймагт байгуулснаас хойш 21 аймагт салбар танхимтай болж танхимын үйлчилгээг орон нутгийн бизнес эрхлэгчдэд хүргэж байна. Салбар танхимын ба танхимын чадавхыг бэхжүүлэх зорилгоор МҮХАҮТ-ГХАҮТХ хоорондын хамтын ажиллагааны төсөл, Европын сэргээн босголт хөгжлийн банкны Экспортын зөвлөх үйлчилгээний төслүүдэд хамруулж ажиллаж байгаа бөгөөд орон нутаг дахь салбар танхимуудад 2018 оны байдлаар нийт 2115 гишүүд хамрагдан үйл ажиллагаа явуулж байна. Аймгуудын салбар танхимууд нь бүх гишүүдийн хурлаар танхимын дүрмээ баталж, гишүүдээсээ тэргүүлэгчид болон даргаа сонгон үйл ажиллагаагаа явуулдаг.⁷

Дээрхээс дүгнээд үзвэл зөвхөн ТББ байгуулах шаардлага хангасан тохиолдолд “танхим” гэдэг үг ашиглан ТББ байгуулах боломжтой байгаа нь ХАҮТХ-д заасан шаардлагыг зарим иргэн, аж ахуйн нэгжүүд хялбар байдлаар ашиглаж, хэрэглэх боломж бүрдсэн байгаа нь тухайн зохицуулалтыг эргэн харах зайлшгүй шаардлагатай болсныг илтгэж байна. Аливаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд үзэл санаагаараа нэгдэн ТББ үүсгэн байгуулахад “танхим” гэх үгийг ашиглахыг тодорхой хязгаартай болгох буюу зөвхөн ХАҮТХ-ийн шаардлагыг хангасан тохиолдолд ашиглах эрх олгох, одоо байгаа “танхим” гэсэн үг агуулсан ТББ-ын нэрийг олон нийт андуурахаас сэргийлсэн арга хэмжээг авах буюу нэрийн хамгаалалтыг хуульд тусгах зайлшгүй шаардлагатай байна.

Иймд тухайн зохицуулалт зорилгодоо бүрэн хүрээгүйн дээр “танхим” гэх нэрийг хуульд заасан шаардлага хангаагүй иргэн, аж ахуйн нэгжүүд өөрсдийн үйл

⁶<http://opendata.burtgel.gov.mn/les?condition=3&text=%D1%82%D0%B0%D0%BD%D1%85%D0%B8%D0%BC>

⁷ МҮХАҮТ-ын 2015-2018 оны үйл ажиллагааны тайлан, УБ 2019 он., 49 дэх тал

ажиллагаандаа ашиглаж байгаа зэрэг нь тухайн зохицуулалтыг эргэн харах шаардлагыг илэрхийлж байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. ХАҮТТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 1 дэх заалт. Үндэсний танхим нь төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах, түүний дотоод гадаадад таниулах, хэрэгжилтэд тус дэмжлэг үзүүлэх зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

2015-2018 онуудад Монголын эдийн засагт нүүрлэсэн хямралын улмаас бизнес эрхлэгчдэд ихээхэн хүндрэл бэрхшээл тулгарсан хүндхэн цаг үеийг тууллаа. Бизнес тулгарч буй бэрхшээл, асуудлыг тодорхойлох, шийдлийг олох, энэ чиглэлээр УИХ, ЗГ, яам агентлагуудад асуудал, санал зөвлөмжийг хүргүүлэх зэргээр Үндэсний танхим нь ажиллаж байгаа бөгөөд тодорхой зарим асуудлаар бизнесийн төлөөллүүдтэй хамтран судалгаа хийж шаардлагатай арга хэмжээг авч ажилласан⁸ байна. Мөн тухайн үеийн ерөнхий сайд болон танхимын сайдуудтай Үндэсний танхимын УЗ-ийн гишүүд, тэргүүлэгчид, бусад бизнесийн төлөөллийг оролцуулсан уулзалтуудыг зохион байгуулж, бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа асуудлыг бизнесийн орчныг сайжруулахад авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, бодлогын зөвлөмжийг багцлан танилцуулж ажиллажээ.

Төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг дотоод, гадаадад тайлбарлан таниулах, хэрэгжилтэд тус дэмжлэг үзүүлэх бүрэн эрхийн хүрээнд 2015-2018 оны хооронд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

2015 онд Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбоотой, Хөдөлмөрийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг зэргээр нийт 6 удаагийн хэлэлцүүлэг, 2016 онд зарим хуулийн төслийн хэлэлцүүлгээс гадна бизнес эрхлэгчидтэй бизнесийн орчны асуудлаар нийт 10 удаагийн хэлэлцүүлэг, 2017 онд нийт 12 удаагийн хэлэлцүүлэг, уулзалтууд, 2018 онд татварын багц хуулийн 3 удаагийн хэлэлцүүлэг, Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар 3 удаагийн хэлэлцүүлэг зэрэг нийт 11 уулзалт хэлэлцүүлэг хийсэн байна. Мөн тухайн онуудад бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор бизнесийн үйл ажиллагаанд саад болж буй хүндрэл, бэрхшээл, асуудлуудыг төр засагт хүргэх, тэдгээрийг шийдвэрлэхэд хамтран ажиллах талаар холбогдох байгууллагуудыг уриалсан 23 мэдэгдэл, уриалга гаргаж хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн байна.

Хэдийгээр дээрх арга хэмжээг авч ажилласан хэдий ч Үндэсний танхимаас 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд явуулсан “Танхимын гишүүдийн сэтгэл ханамжийн судалгаа”-д оролцсон нийт 432 гишүүн байгууллагын 15,2 хувь буюу 56 гишүүн нь “мэдээллээр хангах”, 11,7 хувь буюу 43 гишүүн байгууллага нь “сургалт семинар чанартай зохион байгуулах”, 5,4 хувь буюу 20 гишүүн байгууллага нь “арбитр, бизнесийн орны хууль зүйн зөвлөгөө” гэсэн үйлчилгээнүүдийг танхимаас цаашид авах хүсэлтэй байна гэсэн бол 4,9 хувь буюу 18 гишүүн байгууллага нь “төр засагтай аж ахуйн нэгжийг холбох, бизнесийн таатай орчин бүрдүүлэх” гэсэн санал өгсөн байна. Гишүүдийн зүгээс авахыг хүссэн дээрх бүтээгдэхүүн, үйлчилгээ нь ХАҮТТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан бүрэн эрхтэй салшгүй холбоотой үйл ажиллагаанууд байгаа бөгөөд нийт судалгаанд хамрагдсан гишүүдийн 35 орчим хувь эдгээр төрлийн үйлчилгээг сайжруулахыг хүссэн байгаа нь Үндэсний танхим цаашид хуулийн энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй гэж үзэж байна. Өөрөөр

⁸ МҮХАҮТ-ын 2015-2018 оны үйл ажиллагааны тайлан, УБ 2019 он., 20 дахь тал

хэлбэл практикт тодорхой хэмжээнд хэрэгжиж байгаа ч зорилгодоо хүрэх хэмжээнд хангалттай байж чадахгүй байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 2 дахь заалт. Худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлж, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал оруулах зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлж, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал оруулах” бүрэн эрхтэй байхаар зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл “Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдүүлэх, сургалт семинар явуулах” үйл ажиллагааны чиглэлтэй байгууллагын хувьд Засгийн газарт бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар идэвхтэй ажиллаж, санал оруулснаар зорилгодоо хүрсэн гэж дүгнэх боломжтой юм.

Тухайн зохицуулалтын зорилгодоо хүрсэн эсэхийг тогтоохын тулд эхний ээлжинд Үндэсний танхимын зүгээс хийдэг бизнес итгэлийн индекс тулгуурлан тодорхойлох нь зүйтэй гэж үзлээ. Учир нь бизнесийн орчны ерөнхий төлөв байдал, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого, түүний өөрчлөлтийн талаарх хүлээлт, макро эдийн засгийн үндсэн асуудлууд болох ядуурал, ажилгүйдэл, инфляци, хөрөнгө оруулалтын орчин зэргийн талаар бизнес эрхлэгчдийн байр суурь, цаашид яаж өөрчлөгдөх талаар хүлээлт, бизнесийн орчинд таатай, таагүй нөлөө үзүүлж буй төрийн бодлого шийдвэр, бизнесийн орчинг сайжруулах чиглэлд нэн тэргүүнд хэрэгжүүлвэл зохих бодлого, тулгамдаж буй асуудлууд зэрэг эдийн засаг бизнесийн орчны чухал асуудлыг хөнддөг судалгаа юм.

Үндэсний танхим нь дээрх бүрэн эрхийн хүрээнд 2015-2018 оны хооронд нийт 4 жилийн хугацаанд 25 бодлогын баримт бичиг, хуулийн болон журмын төсөл боловсруулах ажилд оролцон ажилласан байх бөгөөд 35 хэлэлцүүлэг уулзалтуудыг зохион байгуулж, 23 мэдэгдэл, уриалга гаргасан⁹ гэсэн тоон үзүүлэлт байна. Оролцон ажилласан бодлогын баримт бичгийг салбар тус бүрээр нь аваад үзвэл эдийн засаг, санхүүгийн чиглэлээр 5, Худалдааны чиглэлээр 6, Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр 2, Органик хүнсний чиглэлээр 7, бусад чиглэлээр 5, нийт 25 бодлогын баримт бичигт санал өгөх байдлаар оролцож ажиллажээ.

2016 оны байдлаар Монгол Улс Дэлхийн банкны бизнес эрхлэлтийн индексээр 2015 онд дэлхийн 189 орноос 56 дугаар байрт орсон байна. Тухайн онд хийсэн судалгааны дагуу бизнесийн итгэлийн индексийн үр дүнг нэгтгэвэл судалгаанд оролцогчдын 42% нь бизнесийн орчин “дунд”, 29,9% нь “муу”, 12,8% нь “маш муу” гэсэн үнэлгээ өгсөн байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан нийт хүний 85% нь Монголд бизнес эрхлэх орчин хангалтгүй буюу сайн бүрдэж чадаагүй гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.¹⁰ Харин 2017 оны гадаад зах зээлийн эерэг нөлөө, дотоод эдийн засагт ажиглагдсан макро болон микро түвшний сэргэлтүүд, засгийн газрын бодлого тогтворжин, төсөв санхүүгийн сахилга бат сайжирсан зэрэгтэй холбогдуулан гадаад, дотоод бизнесийн орчин өмнөх жилүүдээс сайжирч, бизнес эрхлэгчдийн итгэл нэмэгдэн 2017 оны бизнес итгэлийн индекс -0.32 гарсан бөгөөд энэ нь 2016 оноос 0.85 функтээр өссөн байна.¹¹ 2018 оны хувьд бизнес итгэлийн

⁹ МҮХАҮТ-ын 2015-2018 оны үйл ажиллагааны тайлан, УБ 2019 он., 20 дахь тал

¹⁰ МҮХАТ-ын Бизнес итгэлийн индекс 2016 судалгааны тайлан, УБ 2016 он., 7 дахь тал

¹¹ МҮХАТ-ын Бизнес итгэлийн индекс 2016 судалгааны тайлан, УБ 2017 он., 15 дахь тал

ерөнхий индекс 0.47 функт гарсан нь сүүлийн 6 жилийнхээ хугацаанд анх удаа эерэг үр дүн болсон байна. Энэ нь 2017 онтой харьцуулахад 0.79 нэгжээр өссөн байна. Энэ нь бизнес итгэлийн индекс эерэг утгатай байгааг эдийн засгийн өсөлт, ялангуяа түүхий эдийн үнийн өсөлт, томоохон төслүүдийн бүтээн байгуулалттай холбон үздэг байна.¹²

Шигтгээ 1

Судлаачдын зүгээс Үндэсний танхимы гишүүн байгууллагуудад 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 31-ний хооронд явуулсан 30 асуулт бүхий нийт 60 аж ахуйн нэгжийг хамарсан судалгаанд оролцогчдын 38,3 хувь нь "МҮХАҮТ нь худалдаа үйлдвэрийнхний нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлөх чиг үүргээ ямар түвшинд хэрэгжүүлж байгаа вэ" гэсэн асуултанд "Зарим талаар хэрэгжүүлдэг" гэж хариулсан бол 35 хувь нь "хэрэгжүүлдэг", 11,7 хувь нь "хэрэгжүүлж чаддаггүй" гэж хариулсан байна.

Судалгаанд оролцогчид...

Дээрх онуудын бизнес итгэлийн индексийн үр дүнгээс харвал монголд бизнес эрхлэхэд бизнесийн орчин хангалттай сайн бус, төр засгийн зүгээс бизнесийн орчинг сайжруулах чиглэлд нэн тэргүүнд хэрэгжүүлвэл зохих бодлого, тулгамдаж буй асуудлуудын эрэмбэ байхгүй байгаа энэ нөхцөлд Үндэсний танхимын идэвхтэй үйл ажиллагаа чухал байна. Үндэсний танхимын хувьд 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Эдийн засгийн бодлогын зөвлөл, Тогтвортой хөгжлийн үндэсний хороо, Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл зэрэг нийт 46 зөвлөл, хороонд оролцож байгаа бөгөөд хууль, тогтоомжийн төсөл боловсруулах болон бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой нийт 45 ажлын хэсэгт хамрагдан ажиллаж байна. Эдгээр зөвлөл, хороо болоод ажлын хэсгүүдийн холбогдох төрийн байгууллагад ЗГ-ийн яамдууд болон харьяа агентлагууд байгаа нь Үндэсний танхимын зүгээс тухайн ажиллаж буй ажлын хэсгээр дамжуулан ЗГ-т бизнес эрхлэгчдийн эрх, ашгийг төлөөлөн үр ашигтай ажиллах боломж бүрэн байна.

Үндэсний танхимын зүгээс 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд явуулсан "Танхимын гишүүдийн сэтгэл ханамжийн судалгаа"-д оролцсон нийт 432 гишүүн байгууллагын дийлэнх хэсэг нь "хууль эрх зүй, бодлогын чиглэлээр УИХ болон ЗГ агентлагуудад хүчтэй нөлөө үзүүлдэг бүтэц зохион байгуулалтад орох"-ыг цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ болгохыг хүссэн байгаагаас харвал Үндэсний танхимын энэхүү үйл ажиллагааны талаар танхимын гишүүд төдийлөн сайн мэддэггүй, түүнчлэн үр дүн муутай байгаа нь харагдаж байна. Тухайлбал, Үндэсний танхимын 2018 оны зорилтуудад зааснаар "Бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, бодлогын бичиг баримтыг боловсруулах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, сайжруулах бүх шатанд бизнес эрхлэгчдийн нийтлэг арх ашгийг илэрхийлэн хамгаалах" зорилт тавьсан байх бөгөөд хуулийн төсөл ба бодлогын баримт бичгийн төсөлд тусгагдсан байх саналын хувийг 10 хувиар тооцсон байгаа нь тухайн үед идэвхтэй ажиллаж буй 13 ажлын хэсгийн тоотой харьцуулахад хангалтгүй гэж үзэхээр байна. Хэрвээ Үндэсний танхимын зүгээс энэ чиглэлд ажиллах тусгайлсан бүтэц, судалгааны институц байгуулсан тохиолдол хуулийн төсөл, бодлогын баримт бичиг зэрэгт тусгагдсан байх саналын хувийг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

Дээрхээс дүгнээд үзвэл ХАҮТ-Х-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлж, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал оруулах" зохицуулалт нь

¹² МҮХАТ-ын Бизнес итгэлийн индекс 2016 судалгааны тайлан, УБ 2018 он., 2 дахь тал

практикт хэрэгжиж байгаа боловч тухай бүр зорилгодоо хүрч чадахгүй байх, үүнээс үүдэн Үндэсний танхимын зүгээс авч хэрэгжүүлж буй бодлогын өмгөөлөл нь үр дүнгүй байх зэрэг асуудлууд үүсч байна. Монгол Улсын хурдацтай өсч буй эдийн засаг нь олон боломжуудыг санал болгож байгаагаас гадна мөн шинэ сорилтуудыг бий болгож бана. Төрийн сайн засаглалын үндсэн зарчим болох хууль дээдлэх, байгууллагуудтай ил тод, хариуцлагатай хамтран ажиллах, түүнчлэн ЗГ-ын зүгээс хөрөнгө оруулалтын тогтвортой орчин бий болгох зэрэг асуудлууд нь дараагийн стратегийн бодлого байх хэрэгтэй. Энэхүү нөхцөл байдалд Үндэсний танхим нь бүрэн эрхийнхээ хүрээнд ЗГ-т бизнес эрхлэгчдийн эрх ашгийг төлөөлж ажиллахад голлон анхаарч, бодлогын өмгөөллийг шинэ, мэргэжлийн түвшинд хүргэх зүй ёсны шаардлага бий болсон гэж үзлээ.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 4 дэх заалт. Үндэсний танхимын дэргэд гадаад худалдааны арбитр байгуулан ажиллуулах зохицуулалт зорилгодоо хүрсэн үү?

ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт Үндэсний танхимын нийтлэг зорилт, бүрэн эрхээс гадна хэрэгжүүлэх бүрэн эрхийг заасан бөгөөд тус хэсгийн 4-т “хуульд зааснаар дэргэдээ гадаад худалдааны арбитр байгуулан ажиллуулах” эрхтэй талаар заасан байна. Тэгэхээр энэхүү зохицуулалтын зорилго нь гадаад худалдааны арбитр байгуулах юм.

Арбитр нь үүссэн маргааныг талуудын тохиролцсоны дагуу, маргаан таслах хараат бус бүрэлдэхүүний өмнө шийдвэрлэх арга юм. Монгол Улсад арбитртай холбоотой харилцааг зохицуулсан БНМАУ-ын Арбитрын байгууллагын тухай, Гадаад худалдааны арбитрын тухай зэрэг хуулиуд үйлчилж байсан бөгөөд Үндэсний танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр нь 1960 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд 1995 онд Гадаад худалдааны арбитрын тухай хууль батлагдсанаар гадаад худалдаа, эдийн засгийн хэлцлээс үүдсэн болон гадаадын хөрөнгө оруулалттай компанийг үүсгэн байгуулагчдын хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх Гадаад Худалдааны Арбитр нэртэй байгуулагдан ажиллаж байв. Үүний дараа 2003 онд Арбитрын тухай хууль шинэчлэгдэн батлагдсан нь олон талын ач холбогдолтой болсон байна. Тухайлбал, арбитрын маргаан шийдвэрлэх харилцаанд оролцож байгаа маргагч талуудад илүү өргөн эрхийг олгосон буюу талууд өөрсдөө тохиролцож, нэгдсэн шийдэлд хүрсэн тохиолдолд ямар ч журмаар асуудлыг шийдэх боломжийг олгосон байна.¹³

2003 оны Арбитрын тухай хуулийг НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын Олон улсын худалдааны арбитрын тухай загвар хуульд нийцүүлэх чиглэлийг баримтлан боловсруулсан боловч Монгол Улс 2017 оныг хүртэл загвар хуулийг нутагшуулсан орны жагсаалтад бүртгэгдээгүй байна. Арбитрын тухай хуульд 2007 оны 08 дугаар сарын 03-нд, 2011 оны 02 дугаар сарын 10-нд, 2012 оны 05 дугаар сарын 22-ны өдөр тус тус нэмэлт, өөрчлөлт орсон боловч зарчмын шинжтэй өөрчлөлт тусгагдаагүй юм.¹⁴ Эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр УИХ-аас Арбитрын тухайн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан байна.

Тус арбитр нь 21 аймагт салбар арбитртай, Ази Номхон далайн орнуудын арбитрын холбооны гишүүн бөгөөд олон улсын 20 гаруй арбитрын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тус арбитр нь эдийн засаг, бизнесийн холбогдол бүхий гэрээ, хэлцлээс үүссэн маргааныг арбитрын журмаар хянан

¹³ Арбитрын тухай хуулийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, эрх зүйн орчныг сайжруулах арга зам. Хууль зүйн үндэсний хүрээлэн иргэн, эдийн засгийн эрх зүйн сектор. УБ., 2011 он

¹⁴ Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга. <http://2012.parliament.mn/law/project/931/category/1>

шийдвэрлэхээс гадна Монгол Улсад арбитрын үйл ажиллагааг сурталчилах хөгжүүлэх, сургалт судалгаа явуулах, гадаад дотоодод төлөөлөх, хууль зүйн зөвлөгөө өгөх, арбитрын холбогдолтой ном сэтгүүл хэвлэн нийтлэх зэрэг ажиллагааг явуулж байна.¹⁵

Дээрхээс үзвэл ХАҮТХ-д зааснаар дэргэдээ гадаад худалдааны арбитр байгуулан ажиллуулах хуулийн зохицуулалт зорилгодоо хүрсэн гэж үзэж болохоор байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 5. ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6 дахь заалт. Давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндэсний танхимын хэрэгжүүлэх зарим тодорхой бүрэн эрхүүдийг заасан бөгөөд тус хэсгийн 6 дахь хэсэгт “давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх” талаар заасан байна.

Олон улсын бараа худалдах, худалдан авах гэрээний гүйцэтгэл нь дайн, эдийн засгийн хямрал, байгалийн гамшиг зэрэг үйл явдлаас шалтгаалан зогсож болно. Иймд томоохон үнийн дүнтэй гэрээнд тэдгээрийн үр дагаврын талаар тусгах шаардлагатай. Англо-саксоны эрх зүйн системтэй орнуудад ийм байдлыг гэрээг гүйцэтгэх боломжгүй болох буюу force major, эх газрын эрх зүйн системтэй орнуудад давагдашгүй хүчин зүйл гэж нэрлэдэг¹⁶ байна. Үүсгэгдэж буй шалтгаан нөхцлөөр нь үүргийн гүйцэтгэлд саад болох дээрх тохиолдлуудыг Force major болон Hardship гэж хоёр ангилдаг. Ийнхүү ангилах нь гэрээний талууд үүргээ гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал юунаас үүссэнийг тодорхойлоход ач холбогдолтой байдаг. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэг нь тухайн гэрээ хэлцэл байгуулах үед урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал үүссэн, эсвэл тухайн нөхцөл байдал талуудын хяналтаас гадуур болсон, түүнийг даван туулах боломжгүй болсон нөхцөл байдал юм. Ихэнх улс орны хууль тогтоомжоор гэрээний үүрэг биелэгдэхгүй болоход нөлөөлөх нөхцөл байдлыг зохицуулсан байдаг бөгөөд үүний сонгодог зарчим нь форс мажор буюу гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл юм.

Олон Улсын Худалдааны Танхим нь бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалж, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих зорилготой байгууллага болохын хувьд бизнесийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээг төрөлжүүлэн эмхэтгэх, уялдуулах, ижилсүүлэх чиглэлээр ихээхэн ажил хийдэг. Эдгээрийн нэг нь 2003 онд force major болон hardship-ийн журмуудыг гаргасан явдал бөгөөд эдгээрийг нэг мөр ойлгоход ихээхэн хувь нэмэр оруулсан гэж судлаачид дүгнэсэн байна.¹⁷ Манай улсын хувьд Иргэний хуулийн 101.7, 220, 221, 255.1, 319.2, 321.3, 352.5.3, 356, 374.3, 384.2, 393.7, 419.2, 427.2, 500.2 дугаар зүйлүүдэд гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас үүсэх хариуцлага, үр дагаврын талаар зохицуулсан байдаг бөгөөд Үндэсний танхимаас авсан мэдээллээр 2015-2019 онд нийт 259 давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын гэрчилгээ гаргуулах хүсэлт хүлээн авсан байна.

Шигтгээ 2

“МУХАҮТ”-аас тодорхойлсон давагдашгүй хүчин зүйлийг гэрчилсэн баримт нь шүүх

¹⁵ Монголын Олон Улсын арбитрын тухай. <http://www.arbitr.mn/index.php/about-us>

¹⁶ Force majeure, hardship /гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдал/ судалгаа. https://www.ubchamber.mn/uploads/Force_majeure_Hardship.pdf

¹⁷ Force majeure, hardship /гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдал/ судалгаа. https://www.ubchamber.mn/uploads/Force_majeure_Hardship.pdf

болон арбитраж нотлох баримтын түвшинд үнэлэгдэж чаддаг уу” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан гишүүдийн 15 хувь нь “чаддаггүй” гэж хариулсан.

Судалгаанд оролцогчид ...

Дээрхээс үзвэл ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндэсний танхимын хэрэгжүүлэх зарим тодорхой бүрэн эрхүүдийг заасан бөгөөд тус хэсгийн 6 дахь хэсэгт “давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх” зохицуулалт зорилгодоо хүрсэн байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 6. ХАҮТХ-ийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Үндэсний танхим нь экспортын барааны гарал үүслийг гэрчлэх, экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах, давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх албыг байгуулах зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

ХАҮТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Үндэсний танхим нь энэ хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3,5,6-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх албыг байгуулан ажиллуулна. Түүний ажиллах журмыг зөвлөл тогтооно” гэж заасан бөгөөд дээрх шалгуур үзүүлэлтийн хүрээнд Үндэсний танхим нь тухайн албыг байгуулсан эсэхийг тодорхойлох юм. Судлаачийн зүгээс энэхүү шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор мэдээллийн олон эх сурвалжуудыг нягталж үзээд тодорхой мэдээлэл олоогүй тул Үндэсний танхимын холбогдох албан тушаалтнуудаас тусгайлан тодруулга хүссэн болно.

Өнөөдрийг хүртэлх хугацаанд Үндэсний танхимын хувьд экспортын барааны гарал үүслийг гэрчлэх, экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах болон давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлэхтэй холбоотой тусгай алба болон газар хэлтсүүд байгуулан ажиллуулж иржээ. Харин тус албаны журмыг зөвлөл тогтоох ёстой байтал энэхүү зохицуулалт одоо болтол хэрэгжээгүй байна. Үндэсний танхимын дэргэд 1999 оноос “гадаад худалдаа, бичиг баримт баталгаажуулах товчоо” нэртэйгээр экспортын барааны гарал үүсэл гэрчлэх алба байгуулагдсан. Үүнээс хойш экспортыг дэмжин хөгжүүлэх газар, хэрэглэгч үйлчилгээний газар гэсэн нэршлүүдээр танхимын газар хэлтэс болон явж ирсэн. Одоо хэрэглэгч үйлчилгээний газар нь гарал үүслийн гэрчилгээг “Монгол Улсаас гарал үүсэлтэй экспортын барааны гарал үүслийг тодорхойлох, гарал үүслийн гэрчилгээ олгох, баталгаажуулах журам”-ын дагуу олгож байна.

1999 оны 3 сараас арбитражын товчоо ба гадаад худалдааны баримт бичиг баталгаажуулах товчоо ажиллаж давагдашгүй хүчин зүйлийн баталгааг олгож ирсэн. 2000 оноос тус хэлтэс нь үйл ажиллагаагаа өргөжүүлж Монгол улсын экспортын барааны гарал үүслийг тодорхойлох, үүнтэй холбоотой хяналт шалгалтыг хийх, давагдашгүй хүчин зүйлийн баталгаа гаргах, гарал үүслийн гэрчилгээ олгох, гадаад худалдааны баримт бичиг баталгаажуулахад чиглэгдэн ажиллаж ирсэн. Одоогоор хэрэглэгч үйлчилгээний газар нь давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх гэрчилгээг олгодог.

Экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах үйлчилгээ нь 1961 оны 7 сарын 26-ны Сайд нарын зөвлөлийн 400 дугаар тогтоолоор “Импортын барааны тоо, чанарын зөрчлийг илрүүлэх үүрэг бүхий “Экспертизийн групп”-ийг байгуулсан. Улмаар 1989 оны 2 сарын 17-нд уг хэлтсийг танхимын Экспортын барааны магадлан шалгах газар болгон өөрчлөн байгуулсан. Одоогоор танхимын хэрэглэгч үйлчилгээний газарт Экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах чиг үүрэг харьяалагддаг байна.

Иймд Үндэсний танхим нь экспортын барааны гарал үүслийг гэрчлэх, экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах, давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх албыг байгуулах зохицуулалт зорилгодоо хүрсэн байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 7. ХАҮТХ-ийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. Танхим нь гишүүний татвар, иргэд байгууллагын хандив, үйлчилгээний орлогоор санхүүжилтээ шийдэх зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

ХАҮТХ-ийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Танхимын санхүүжилт гишүүний татвар, иргэд, байгууллагын хандив, үйлчилгээний орлогоос бүрдэхээр заасан байна. Тухайн байгууллагын санхүүгийн мэдээлэл нь нууц мэдээлэл тул судлаачийн хувьд судалгаанд ашиглах зорилгоор зарим мэдээллийг авсан болно. Тухайн мэдээлэлд зааснаар Үндэсний танхимын 2015-2018 оны орлого нь гишүүдийн татвар, хөтөлбөр төслийн орлого болон бусад орлогоос бүрдсэн байна. Гэсэн хэдий ч тухайн онуудад үндсэн үйл ажиллагааны зардал нь үндсэн үйл ажиллагааны орлогоос давсан үр дүн гарчээ. Эндээс үзвэл Үндэсний танхимын санхүүжилт нь хангалтгүй буюу тухайн зохицуулалт зорилгодоо бүрэн хүрч чадахгүй байна.

3.2. Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. ХАҮТХ-ийн 5 дугаар зүйлийн 2 дах хэсэг. Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим байгуулах зохицуулалтыг өнөөдрийг хүртэл практикт хэчнээн удаа хэрэглэсэн бэ? Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын хэчнээн танхим байгуулсан бэ?

ХАҮТХ-ийн 5 дугаар зүйлээр танхимын тогтолцоог зохицуулсан бөгөөд тус зүйлийн 2 дугаар хэсэгт “Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим байж болно.” гэж заасан бөгөөд тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Аймаг, нийслэлийн, аймаг дундын танхимыг 50-иас доошгүй аж ахуйн нэгж, байгууллага Иргэний хууль болон Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу үүсгэн байгуулж болно.” гэж заасны дагуу байгуулах эрх нь аж ахуйн нэгж, байгууллагуудад нээлттэй байна.

Харин Үндэсний танхимаас авсан мэдээллээс үзэхэд хамгийн анхны салбар танхимыг 1997 онд байгуулсан бөгөөд салбар танхимыг байгуулахдаа ХАҮТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан шаардлагын дагуу 50 байгууллага гарын үсэг цуглуулж, бүх гишүүд нь хурлаа хийн тэргүүлэгчээ сонгосноор салбар танхимыг байгуулж байна. Харин үүний дараа холбогдох хуульд заасан баримт бичгийг бүрдүүлж салбар танхимын гэрчилгээг нөхөн гаргуулж байжээ. Эдгээр салбар танхимууд нь Үндэсний танхимын гарал үүслийн гэрчилгээ олгох, экспертиз зэрэг үйлчилгээг зарим орон нутагт явуулдаг бөгөөд ингэхдээ тухайн үйлчилгээнээс олсон орлогыг салбар танхимууд нь Үндэсний танхимд шилжүүлдэг. Харин Үндэсний танхимаас журмын дагуу салбар танхимуудад оруулсан орлогынх нь хувиар урамшуулал олгодог байна. Салбар танхим нь ганц гишүүнчлэлийн татвараа өөрсдийн орлого болгон зарцуулж явдаг. Эндээс үзвэл тухайн орон нутагт байгуулагдсан салбар танхимуудыг нь бие даасан танхим гэж үзэхгүй бөгөөд өнөөдрийн байдлаар УБЕГ-ийн мэдээллийн санд нийслэлийн танхимаас өөр аймаг болоод аймаг дундын танхим бүртгэгдээгүй байна.

Мөн өнөөдрийн байдлаар аймаг дундын танхим байгуулагдаагүй бөгөөд аймаг тус бүрт Үндэсний танхимын салбар танхим үйл ажиллагаа явуулж тэдгээр салбар танхимууд нь 4 жилд нэг удаа бүх гишүүдийн хурлаа хийж, тэргүүлэгч болон

танхимын даргаа сонгож байна. Эдгээр салбар танхимын дарга нь Үндэсний танхимын дүрмийн дагуу Удирдах зөвлөлийн гишүүн болдог.

Дээрхээс үзвэл ХАҮТТХ-ийн тухайн зохицуулалт нь практикт нийцэхгүй зохицуулалт байна. Өөрөөр хэлбэл ХАҮТТХ анх 1995 онд байгуулагдсан цагаас хойш хуульд заасан шаардлагын дагуу бие даасан танхим нэг удаа, аймаг дундын танхим огт байгуулагдаагүй байгаа нь манай орны нөхцөлд танхимын тогтолцоог бүс нутгийн зарчимд суурилж байгуулах нь практикт хэрэгжихгүй байгаа нь харагдаж байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. ХАҮТТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 1 дэх заалт. Үндэсний танхим нь төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах, түүний дотоод гадаадад таниулах, хэрэгжилтэд тус дэмжлэг үзүүлэх зохицуулалт практикт хэрэгжиж байна уу?

Монгол Улс уул уурхайн хөгжлийн нөлөөгөөр 2006-2013 онд нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ ойролцоогоор 4 дахин өссөн бөгөөд бодит ДНБ-ийн өсөлт 2011 онд 17,3% гэж эдийн засгийн өсөлтийг бий болгосон. Гэвч сүүлийн жилүүдийн дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнийн уналт болон баялгийн үндсэрхэг үзлийн хөдөлгөөн эрчимжсэнээр гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах хууль тогтоомж гаргах зэргээр улс төрийн эрсдэл нэмэгдсэн. Түүнчлэн экспортын 80%-ийг эзэлдэг БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширсны улмаас Монгол улсын эдийн засгийн өсөлт мөн адил огцом удааширсан байна.¹⁸

Иймд богино хугацаанд эдийн засгийг сэргээхийн зэрэгцээ сүүлийн жилүүдэд уул уурхайн салбараас хараат үйлдвэрлэлийн бүтцийн шинэчлэл, өсөлт уналт давтагдах мөчлөгийг даван туулахын тулд эдийн засгийн тогтвортой бөгөөд жигд өсөлтийг бий болгохоор аж үйлдвэрийг төрөлжүүлэн хөгжүүлэх шаардлагатай бөгөөд бизнесийн орчны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах асуудал нь өнөөдрийг хүртэл томоохон сорилт байсаар ирсэн ба энэхүү сорилтод худалдаа үйлдвэрлэл эрхлэгчдийн дуу хоолой болж, эрх ашгийг төлөөлөх гол институт бол Үндэсний танхим юм. Энэ ч үүднээс Үндэсний танхим нь төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход бизнес эрхлэгчдийн дуу хоолой болох ёстой. Танхим нь дээрх чиг үүргээ хууль эрх зүй, бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэг болон хороодод бизнес эрлэгчдийн оролцоог хангах, танхимаас төлөөлөн оролцох байдлаар хэрэгжүүлж байна.

Гэсэн хэдий ч зарим судалгаанаас дээрх зохицуулалт практикт хэрэгжиж чадахгүй байгааг харж болно. Тухайлбал,

2016 оны УИХ-ын сонгууль явагдаж Монгол улс шинэ УИХ, Засгийн газраа байгуулан улс орны өмнө тулгараад байгаа эдийн засгийн хүндрэлийг даван туулахаар ажиллаж эхэлсэн он жилүүдэд Үндэсний танхимаас жил бүр явуулдаг “Бизнес итгэлийн индекс” судалгаагаар дамжуулан бизнесийн орчин дахь талуудын дуу хоолойг холбогдох байгууллагуудад хүргэсэн байна.

2012-2016 оны судалгааны дүнгээс үзэхэд иргэд, бизнес эрхлэгчид эдийн засаг, бизнесийн талаар авч хэрэгжүүлж буй төр, засгийн бодлого шийдвэр, түүний хэрэгжилт, үр дүнд сэтгэл хангалуун биш байна. 2012 онд нийт судалгаанд оролцогсдын 13% нь бизнесийн орчинд “муу” үнэлгээ өгч байсан бол энэ үзүүлэлт 2012 оноос хойш тасралтгүй нэмэгдэн 2016 онд судалгаанд оролцогсдын 43% нь өнөөгийн Монгол улсын бизнесийн орчинд “муу” дүн тавьжээ. Бизнесийн орчинг

¹⁸ Монгол Улсын бизнесийн орчны суурь судалгаа эцсийн тайлан. Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), УБ., 2018 он

сайжруулахад авч хэрэгжүүлсэн арга, хэмжээ нь дорвитой өөрчлөлт оруулахад нөлөөлж чадаагүй гэж 73,1% нь үзсэн байна. Төрийн нүсэр аппарат, тооцоо судалгаа багатай хариуцлагагүй төсвийн зарцуулалт, авилга хээл хахууль, зээлийн өндөр хүү, зээлийн хугацаа, хууль эрх зүйн тогтворгүй байдал зэрэг нь бизнес эрхлэхэд хамгийн их саад болж байгааг судалгаанд оролцогчид онцолсон¹⁹ нь 2016 он юм. Тэгвэл энэхүү судалгаанд үндэслэн Үндэсний танхим болоод төр засгийн зүгээс дорвитой арга хэмжээ авсан тохиолдолд 2017 болон 2018 оны бизнес итгэлийн индекс нэмэгдэх ёстой байсан.

2017 оноос эхлэн олон улсын аргачлалын дагуу бизнесийн орчин, ашиг, орлого, хөрөнгө оруулалт, макро эдийн засгийн орчин гэсэн 4 үзүүлэлтээр судалгаанд оролцогсдын эерэг болон сөрөг хариултын зөрүүгээр бизнес итгэлийн индексийг тооцон гаргадаг болсон²⁰ байна. Энэхүү шинэ аргачлалын дагуу сүүлийн таван жилийн индексийг тооцоход 2017 онд өнөөгийн байдлын бизнес итгэлийн индекс нь -0.32 гэсэн дүнтэй гарсан бөгөөд энэ нь 2012 оноос хойш өмнөх онуудаас хамгийн сайн дүн болж байна. Гэсэн хэдий ч 2017 онд бизнесийн орчинг сайжруулахад хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд бизнес эрхлэгчдийн 65% нь хангалтгүй буюу энэ онд бизнесийн орчин “муудсан” буюу “огт өөрчлөгдөөгүй” гэсэн хариулт өгсөн байна. Мөн бизнес эрхлэгчдээс бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр хамгийн түрүүнд өөрчилж сайжруулах шаардлагатай гэж үзсэн асуудлуудыг аваад үзвэл “зээлийн өндөр хүү, бодлогын тогтворгүй байдал, татварын хувь хэмжээ, хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал, авлига, хээл хахууль, төрийн албаны нүсэр бүтэц, төрийн хүнд суртал” зэргийг нэрлэсэн байна.²¹

Харин 2018 онд бизнес итгэлийн ерөнхий индекс 0.47 гарсан нь сүүлийн 6 жилийн хугацаанд анх удаагийн эерэг үр дүн болж байгаа бөгөөд 2017 онтой харьцуулахад 0.79 нэгжээр өссөн²² үзүүлэлт гарсан хэдий ч бизнесийн орчны шийдвэрлэвэл зохих асуудлуудыг “зээлийн хүү өндөр, бодлогын тогтворгүй байдал, авилга, хээл хахууль, татварын хувь хэмжээ, төрийн хүнд суртал, хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал, төрийн нүсэр бүтэц” зэргийг дахин нэрлэсэн байгаа нь Засгийн газрын зүгээс болон Үндэсний танхимын зүгээс дээрх асуудлуудыг шийдвэрлэх дорвитой арга хэмжээ авч чадаагүй нь харагдаж байна.

Шигтгээ 3

“МҮХАҮТ-ын зүгээс өнгөрсөн хугацаанд төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах бүрэн эрхээ хангалттай хэрэгжүүлж чадсан уу” гэсэн асуултанд 51 хувь нь “зарим талаар хэрэгжүүлсэн”, 33 хувь нь “хэрэгжүүлсэн” гэж хариулсан бөгөөд 22,9 хувь нь “гишүүн байгууллагуудаас ирүүлж буй саналуудаас”, 40 хувь нь “судалгаанд үндэслэсэн санал дүгнэлт бага байдаг” гэсэн хариулт өгсөн.

Судалгаанд оролцогчид...

Засгийн газрын зүгээс ч тэр, Үндэсний танхимын зүгээс ч тэр тухайн жилийн бизнес итгэлийн судалгаагаар бизнес эрхлэгчдийн сайжруулахыг хүссэн зүйл дээр илүү анхаарч, холбогдох хууль тогтоомжуудад үндэслэл бүхий санал өгч, тухайн саналыг бодлогын түвшинд хүлээн авснаар энэхүү шалгуур үзүүлэлтэд яригдаж буй зохицуулалт зорилгодоо хүрсэн гэж үзэж болох юм. Иймд дээрх нөхцөл байдлаас дүгнээд үзвэл Үндэсний танхим нь төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг

¹⁹ МҮХАТ-ын Бизнес итгэлийн индекс 2016 судалгааны тайлан, УБ 2016 он., 19 дэх тал

²⁰ МҮХАТ-ын Бизнес итгэлийн индекс 2016 судалгааны тайлан, УБ 2017 он., 1 дэх тал

²¹ Мөн тэнд, 13 дахь тал

²² МҮХАТ-ын Бизнес итгэлийн индекс 2016 судалгааны тайлан, УБ 2018 он., 4 дэх тал

тодорхойлоход санал дүгнэлт оруулах, түүний дотоод гадаадад таниулах, хэрэгжилтэд тус дэмжлэг үзүүлэх зохицуулалт зорилгодоо бүрэн хүрээгүй гэж дүгнэж болохоор байна. Иймд энэхүү зохицуулалтыг практикт бодитоор хэрэгжих нөхцөл боломжийг хуульд тусгах зайлшгүй шаардлагатай гэж үзлээ.

Шигтгээ 4

“Төрийн эдийн засаг, нийгмийн бодлогын хэрэгжилтэд тус дэмжлэг үзүүлэх чиг үүргээ танхим ямар түвшинд гүйцэтгэсэн бэ” гэсэн асуултад судалгаанд оролцсон гишүүдийн 58,3 хувь нь “зарим талаар хэрэгжүүлсэн”, 5 хувь нь “хэрэгжүүлж чадаагүй”, 21,7 хувь нь “хэрэгжүүлсэн” гэж хариулсан.

Судалгаанд оролцогчид ...

Шигтгээ 5

Судалгаанд оролцогчдын 23,3 хувь нь “ХАҮТмХ”-д заасан бүрэн эрх хангалтгүй” учраас МҮХАҮТ нь төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах, дотоод гадаадад тайлбарлан таниулах болон хэрэгжилтэд тус дэмжлэг үзүүлэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна гэж үзсэн бол 16,7 хувь нь “ХАҮТХ-д заасан санхүүжилт хангалтгүй”, 10 хувь нь “ХАҮТмХ-д заасан танхимын тогтолцоо буруу” гэсэн хариулт өгсөн бол эдгээрийг засах аргыг “санхүүжилтийг нэмэгдүүлэх, МҮХАҮТ-ын бүрэн эрхийг нэмэгдүүлэх, салбарын танхимын тогтолцоонд шилжих, тэдгээрийн эрх зүйн байдлыг хуульчлах, танхимын хуулийг шинэчлэх” зэрэг арга хэмжээг нэрлэсэн байна.

Судалгаанд оролцогчид ...

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. ХАҮТтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 2 дахь заалт. Худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлж, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал оруулах зохицуулалт практикт хэрэгжиж байна уу?

Үндэсний танхим нь 2015-2018 оныг хүртэлх нийт 4 жилийн хугацаанд 25 бодлогын баримт бичиг, хуулийн болон журмын төсөл боловсруулах ажилд оролцон ажилласан байх бөгөөд 35 хэлэлцүүлэг уулзалтуудыг зохион байгуулж, 23 мэдэгдэл, уриалга гаргасан²³ гэсэн тоон үзүүлэлт байна. Оролцон ажилласан бодлогын баримт бичгийг салбар тус бүрээр нь аваад үзвэл эдийн засаг, санхүүгийн чиглэлээр 5, Худалдааны чиглэлээр 6, Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр 2, Органик хүнсний чиглэлээр 7, бусад чиглэлээр 5, нийт 25 бодлогын баримт бичигт санал өгөх байдлаар оролцож ажилласан байна. Гэсэн хэдий ч тус судалгааны өмнөх үе шатанд тодорхойлсны дагуу Үндэсний танхимаас 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд явуулсан “Танхимын гишүүдийн сэтгэл ханамжийн судалгаа”-д оролцсон нийт 432 гишүүн байгууллагын дийлэнх хэсэг нь “хууль эрх зүй, бодлогын чиглэлээр УИХ болон ЗГ агентлагуудад хүчтэй нөлөө үзүүлдэг бүтэц зохион байгуулалтад орох”-ыг цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ болгохыг хүссэн байгаагаас харвал Үндэсний танхимын энэхүү үйл ажиллагааны талаар танхимын гишүүд төдийлөн сайн мэддэггүй, түүнчлэн үр дүн муутай байгаа нь харагдаж байна. Тухайлбал, Үндэсний танхимын 2018 оны зорилтуудад зааснаар “Бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, бодлогын бичиг баримтыг боловсруулах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, сайжруулах бүх шатанд бизнес

²³ МҮХАҮТ-ын 2015-2018 оны үйл ажиллагааны тайлан, УБ 2019 он., 20 дахь тал

эрхлэгчдийн нийтлэг арх ашгийг илэрхийлэх хамгаалах” зорилт тавьсан байх бөгөөд хуулийн төсөл ба бодлогын баримт бичгийн төсөлд тусгагдсан байх саналын хувийг 10 хувиар тооцсон байгаа нь тухайн үед идэвхтэй ажиллаж буй 13 ажлын хэсгийн тоотой харьцуулахад практикт хэрэгжиж байгаа ч зорилгодоо хүрсэн байдалтай нь уялдуулан аваад үзвэл хангалтгүй гэж үзэхээр байна.

Шигтгээ 6

Судалгаанд оролцсон гишүүд “МҮХАҮТ нь эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал оруулах чиг үүргээ хэрэгжүүлж чаддаг уу” гэсэн асуултад 40 хувь нь “зарим хууль тогтоомжийн хувьд хэрэгжүүлдэг”, 25 хувь нь “хэрэгжүүлдэг” гэсэн бол 18,3 хувь нь “хэрэгжүүлж чаддаггүй” гэсэн хариулт өгсөн бөгөөд 38,2 хувь нь “судалгаанд үндэслэсэн санал дүгнэлт бага байдаг”, 32,4 хувь нь “саналыг хүлээж авах эсэх нь төрийн байгууллагуудын асуудал” гэсэн хариулт өгчээ.

Судалгаанд оролцогчид...

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 4 дэх заалт. Үндэсний танхимын дэргэд гадаад худалдааны арбитр байгуулан ажиллуулах зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Үндэсний танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын шийдвэрлэсэн хэргийн тоо баримтыг аваад үзвэл 2015 онд 65 хэрэг, 2016 онд 100 хэрэг, 2017 онд 71 хэрэг, 2018 онд 74 хэрэг, 2019 онд 87 хэрэг нийт 397 хэрэг маргаан шийдвэрлүүлэх нэхэмжлэл хүлээн авсан бөгөөд 351 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн байна. Үлдэх 46 хэргийн тухайд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна. Зөвхөн 2017-2019 оны хооронд нийт 128,7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 231 хэрэг маргаан шийдвэрлэсэн байна.

Харин иргэний хэргийн шүүхийн тухайд 2017 онд 45,233 иргэний хэргийг анхан шатны журмаар, 2018 онд 48,155 иргэний хэрэг анхан шатны журмаар шийдвэрлэсэн бол 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 30,501 иргэний хэргийг шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн байна. Эндээс үзвэл шүүхээр шийдвэрлэгдэж байгаа иргэний хэрэг арбитрын байгууллагаар шийдэгдэж байгаа хэргээс хэд дахин их байна.

2014 онд Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр Үндэсний танхимын дэргэд эвлэрүүлэн зуучлах төв байгуулагдан ажиллаж эхэлсэн бөгөөд тухайн үедээ эвлэрүүлэн зуучлалын албаны дарга, нарийн бичиг, 18 эвлэрүүлэн зуучлагчдын бүрэлдэхүүнтэй байгуулагдаж байсан байна. Гэвч Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол нөгөө тал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй” гэж заасан бөгөөд энэ нь тухайн эвлэрүүлэн зуучлалын төвийн шийдвэрийг шүүгч баталгаажуулж, захирамж гаргадгүйгээс заавал биелэгдэх шинжгүй болсон байна. Энэхүү шалтгааны улмаас тухайн эвлэрүүлэн зуучлалд хандах үйлчлүүлэгч байхгүйгээс сүүлийн 3 жилийн хугацаанд огт үйл ажиллагаа явуулаагүй байдалтай байгаа талаар Үндэсний танхимын холбогдох албан тушаалтнаас авсан мэдээлэлд дурдсан байна.

Иймд арбитраар шийдвэрлүүлж байгаа хэрэг маргааны тоог нэмэгдүүлэх, үүний тулд арбитрын талаархи ойлголтыг олон нийтэд хүргэх, эвлэрүүлэн зуучлах

төвийн үйл ажиллагааг сэргээх зэргээр шүүхийн ачааллыг бууруулах чиглэлд арбитр, эвлэрүүлэн зуучлалын практик ач холбогдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5. ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6 дахь заалт. Давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Шигтгээ 7

Судалгаанд хамрагдсан гишүүдийн 86,7 хувь нь “Давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх чиг үүрэг МҮХАҮТ-д байх нь “зөв” гэж үзжээ.

Судалгаанд оролцогчид ...

Давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын талаар өмнөх үе шатанд тодорхой тайлбарласан бөгөөд энэ хэсэгт зөвхөн практикт ямар байдлаар хэрэгжиж байгаа талаархи мэдээллийг өгөх болно. Үндэсний танхимаас 2015-2019 онд нийт 259 давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын гэрчилгээ гаргуулах хүсэлт хүлээн авсан бөгөөд дараах байдлаар шийдвэрлэсэн байна.

№	Он	Давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ (Force majeure)	Хүнд нөхцөл байдлын гэрчилгээ (Hardship)	Хүсэлтийг хүлээн авах боломжгүй хариу хүргүүлсэн	Нийт шийдвэрлэсэн хүсэлтийн тоо
1	2015	10	22	4	36
2	2016	10	43	7	60
3	2017	14	28	7	49
4	2018	24	20	5	49
5	2019	34	11	6	51
	Нийт	106	124	29	259

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 6. ХАҮТХ-ийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Үндэсний танхим нь экспортын барааны гарал үүслийг гэрчлэх, экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах, давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх албыг байгуулах зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Үндэсний танхимын зүгээс ХАҮТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Үндэсний танхим нь энэ хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3,5,6-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх албыг байгуулан ажиллуулна. Түүний ажиллах журмыг зөвлөл тогтооно” гэж заасан бөгөөд Үндэсний танхимын зүгээс экспортын барааны гарал, үүслийг гэрчлэх, экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах, давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх зэрэг үйлчилгээнүүд дээр тусгай алба буюу газар, хэлтсүүд байгуулан ажиллуулж ирсэн байна. Харин тус албаны буюу газар, хэлтсүүдийн журмыг зөвлөл тогтоохоор заасан боловч энэхүү зохицуулалт өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй талаар Үндэсний танхимын холбогдох албан тушаалтнуудаас авсан мэдээлэлд дурджээ.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 7. ХАҮТХ-ийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. Танхим нь гишүүний татвар, иргэд байгууллагын хандив, үйлчилгээний орлогоор санхүүжилтээ шийдэх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Үндэсний танхимын 2015-2018 оны орлого нь гишүүдийн татвар, хөтөлбөр төслийн орлого болон бусад орлогоос бүрдсэн байна. Гэсэн хэдий ч тухайн онуудад үндсэн үйл ажиллагааны зардал нь үндсэн үйл ажиллагааны орлогоос давсан үр дүн гарчээ. Эндээс үзвэл Үндэсний танхимын санхүүжилт нь хангалтгүй буюу тухайн зохицуулалт зорилгодоо бүрэн хүрч чадаагүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Үнэлэх үе шатны төгсгөлд томъёолсон шалгуур үзүүлэлт, 2016-2018 оны бизнес итгэлийн индекс болон судлаачдын зүгээс Үндэсний танхимын гишүүн байгууллагуудад 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 31-ний хооронд явуулсан судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг гаргаж, холбогдох зөвлөмжийг боловсрууллаа. Үүнд:

1. Үнэлгээг илэрхийлсэн дүгнэлт гаргах;
2. Үнэлгээний үр дүнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох зөвлөмж гаргах.

4.1. Үнэлэлт, дүгнэлт

ХАҮТтХууль нь 1995 онд таван бүлэг, 14 зүйлтэй батлагдсан бөгөөд 2002, 2011 болон 2015 онуудад тус тус нэмэлт өөрчлөлт орж байжээ. Нэмэлт өөрчлөлтөөр 2 хэсэг, 1 заалт нэмж, 5 хэсэгт өөрчлөлт орж, 2 хэсгийг хассан байна. Тус хуулиар танхимын тухай ойлголт, түүний зорилт, бүрэн эрх, үйл ажиллагааны тухай болоод тогтолцоог тодорхойлон заасан бөгөөд олон улсын жишигтэй харьцуулан үзвэл Монгол улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль нь товч бөгөөд маш цөөн асуудлыг хамарсан байгаагаас үүдэн танхимын эрх хэмжээ хязгаарлагдмал байдалтай байна.

ХАҮТтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалт, 6.2.2 дахь заалт, 6.2.6 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг болон 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн зохицуулалт тус бүрийн хэрэгжилтийн үр дагаварт "Зорилгод хүрсэн түвшин", "Практикт хэрэгжсэн байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийж гүйцэтгэлээ. Үнэлгээний үр дүнг зүйл, заалт бүрээр, шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэхэд дараах байдалтай байна:

ХАҮТтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг "Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим байж болно."

Дээрх зохицуулалт болон тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Аймаг, нийслэлийн, аймаг дундын тахимыг 50-иас доошгүй аж ахуйн нэгж, байгууллага Иргэний хууль болон Төрийн бүс байгууллагын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу үүсгэн байгуулж болно." гэж заасны дагуу бие даасан танхим байгуулах эрхийг аж ахуйн нэгж, байгууллагуудад нээлттэй болгосноор манай улс 1995 оноос эхлэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг бүс нутгийн зарчмаар хөгжүүлэхийг зорьсон байна. Гэсэн хэдий ч энэ тогтолцоо нь ХАҮТтХ-ийн зорилттой уялдаа холбоо муун улмаас зорилгодоо хүрж чадаагүйн дээр "танхим" гэх нэрийн хамгаалалтыг хийгээгүй улмаас тухайн нэрийг үндсэн зорилгоос өөрөөр ашиглах явдал түгээмэл байгаа нь судалгааны үр дүнд харагдлаа. Өнөөдрийн байдлаар "танхим" гэсэн нэр агуулсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо нийт 69 байгаагаас ТББ-ын хэлбэрээр 65 аж ахуйн нэгж байгаагаас ХАҮТтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан 50-иас доошгүй аж ахуйн нэгж, байгууллага нийлэн үүсгэн байгуулсан, хуульд заасан шаардлага хангасан цорын ганц бие даасан танхим нь 2015 онд байгуулагдсан Улаанбаатар хотын танхим байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм.

Үндэсний танхимын 20 дугаар Их хурлын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдөр баталсан танхимын дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Аймаг, нийслэл Улаанбаатар хот дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим /цаашид "Салбар танхим" гэх/ нь Үндэсний танхимын үндсэн чиг үүргийг тухайн орон нутагт бүхэлд нь буюу хэсэгчлэн гүйцэтгэх албан ёсны салбар мөн", 3.2-т "Салбар танхим нь Үндэсний

танхимаас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна”, 3.4-т “Салбар танхим нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг улирал бүр гарган Үндэсний танхимд хүргүүлнэ” зэргээр зохицуулсан бөгөөд Үндэсний танхимын зүгээс 1997 онд анхны салбар танхимыг байгуулж, өнөөдрийн байдлаар 21 аймагт салбар танхимтай үйл ажиллагаа явуулж байна. Тухайн салбар танхимууд нь салбарын гэрчилгээтэй, Үндэсний танхимаас оруулсан орлогынхоо хувиар урамшуулал авдаг, зөвхөн гишүүнчлэлийн татвараа өөрсдийн орлого болгон зарцуулж байгаа, Үндэсний танхимын дүрмийн зохицуулалт зэргээс үзвэл бие даасан танхим бус санхүү, үйл ажиллагааны хувьд Үндэсний танхимаас хамааралтайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бодит нөхцөл байдал байна.

Эдгээрээс үзвэл Монгол Улсын хэмжээнд Үндэсний танхимаас гадна бие даан үйл ажиллагаа явуулж буй цор ганц танхим нь “Улаанбаатар хотын танхим” бөгөөд 21 аймагт үйл ажиллагаа явуулж буй салбар танхимууд нь ХАҮТХ-ийн дагуу байгуулагдаагүй, бие даасан хэлбэрээр үйл ажиллагаа явуулахгүй байгаагаас харвал ХАҮТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим байж болно” гэсэн зохицуулалт зорилгодоо хүрээгүйн дээр практикт хэрэгжиж чадаагүй байна. Цаашид Монгол Улс танхимын тогтолцоог бүс нутгийн зарчмаар хөгжүүлэх бус бизнесийн салбар тус бүрээр хөгжүүлэх цаг нь болсон гэж дүгнэж байна.

ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 1 дэх заалт “төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах, түүний дотоод, гадаадад тайлбарлан таниулах, хэрэгжилтэд нь тус дэмжлэг үзүүлэх”

Үндэсний танхим нь танхимын нийтлэг зорилт, бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ дээр дурдсан бүрэн эрх болон төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах, хэрэгжилтэд нь тус дэмжлэг үзүүлэх зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлж байна. Энэхүү бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ Үндэсний танхим нь хуулийн төсөлтэй холбоотой хэлэлцүүлэг зохион байгуулах, бизнес эрхлэгчидтэй бизнесийн орчны асуудлаар хэлэлцүүлэг хийх, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор бизнесийн үйл ажиллагаанд саад болж буй хүндрэл, бэрхшээл, асуудлуудыг төр засагт хүргэх, тэдгээрийг шийдвэрлэхэд хамтран ажиллах зорилгоор холбогдох байгууллагуудад уриалга, мэдэгдэл хүргүүлэх хэлбэрээр тус бүрэн эрхийг практикт хэрэгжүүлж байна.

Хэдийгээр практикт бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч Үндэсний танхимын гишүүн байгууллагуудын зүгээс төр засагтай аж ахуйн нэгжийг холбох, бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд түлхүү анхаарахыг хүссэн, түүнчлэн 2016-2018 онуудын хооронд бизнес эрхлэгчдээс авсан “бизнес итгэлийн индекс” судалгаагаар эдийн засаг, бизнесийн талаар авч хэрэгжүүлж буй төр, засгийн бодлого шийдвэр, түүний хэрэгжилт, үр дүнд сэтгэл хангалуун биш байгаагийн зэрэгцээ бизнес итгэлийн ерөнхий индекс өсөлт удаан, бизнесийн орчны шийдвэрлэвэл зохих асуудлууд нь 2016-2018 оны хооронд “зээлийн хүү, бодлогын тогтворгүй байдал, авилга, хээл хахууль, татварын хувь хэмжээ, төрийн хүнд суртал, хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал, төрийн нүсэр бүтэц” зэрэг тодорхой хэдэн асуудлуудыг онцолж байгаагаас үзвэл Үндэсний танхимын төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход оруулж буй санал, дүгнэлтүүд нь тооцоо судалгаа муу, төр засгийн зүгээс заавал хүлээн авах үүрэг байхгүй зэргээс үүдэн бизнес эрхлэгчид төр, засгийн бодлогын гадна үлдэх эрсдэлтэй байна.

Дээрхээс харвал Үндэсний танхим нь хуулиар олгогдсон дээрх бүрэн эрхээ практикт хэрэгжүүлж байгаа ч зорилгодоо хүрэх хэмжээнд хэрэгжихгүй, эдийн засаг,

нийгмийн бодлогод оруулж буй санал дүгнэлт нь судалгаа, шинжилгээнд суурилж чадаагүй зэрэг шалтгааны улмаас бодитоор хэрэгжиж чадахгүй, тунхагийн шинжтэй зохицуулалт болсон байна. Цаашид энэхүү бүрэн эрхийг хэрэгжих механизмыг хуульд тусгаж, бизнес эрхлэгчдийн дуу хоолойг төр, засгийн бодлогод тусгах бодит боломжийг бий болгох шаардлагатай байна.

ХАҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 2 дахь заалт “худалдаа үйлдвэрийнхний нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлөн илэрхийлэх, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал оруулах”

Үндэсний танхим нь дээрх чиг үүргийн хүрээнд 2015-2018 оныг хүртэлх нийт 4 жилийн хугацаанд 25 бодлогын баримт бичиг, хуулийн болон журмын төсөл боловсруулах ажилд оролцон ажилласан байх бөгөөд 35 хэлэлцүүлэг уулзалтуудыг зохион байгуулж, 23 мэдэгдэл, уриалга гаргасан²⁴ гэсэн тоон үзүүлэлт байна. Оролцон ажилласан бодлогын баримт бичгийг салбар тус бүрээр нь аваад үзвэл эдийн засаг, санхүүгийн чиглэлээр 5, Худалдааны чиглэлээр 6, Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр 2, Органик хүнсний чиглэлээр 7, бусад чиглэлээр 5, нийт 25 бодлогын баримт бичигт санал өгөх байдлаар оролцож ажиллажээ. Мөн 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Эдийн засгийн бодлогын зөвлөл, Тогтвортой хөгжлийн үндэсний хороо, Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл зэрэг нийт 46 зөвлөл, хороонд оролцон ажиллаж байгаа бөгөөд хууль, тогтоомжийн төсөл боловсруулах болон бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой нийт 45 ажлын хэсэгт хамрагдан ажиллаж байна. Эдгээр зөвлөл, хороо болоод ажлын хэсгүүдийн холбогдох төрийн байгууллагад ЗГ-ийн яамдууд болон харьяа агентлагууд байгаа нь Үндэсний танхимын зүгээс тухайн ажиллаж буй ажлын хэсгээр дамжуулан ЗГ-т бизнес эрхлэгчдийн эрх, ашгийг төлөөлөн үр ашигтай ажиллах бүрэн боломжтой байна. Гэсэн хэдий ч Үндэсний танхимын 2018 оны зорилтуудад “Бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, бодлогын бичиг баримтыг боловсруулах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, сайжруулах бүх шатанд бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэх, хамгаалах” зорилт тавьсан байх бөгөөд хуулийн төсөл болон бодлогын баримт бичгийн төсөлд тусгагдсан байх саналын хувийг 10 хувиар тооцож байгаа нь идэвхтэй ажиллаж буй 13 ажлын хэсгийн тоотой харьцуулахад хангалтгүй гэж үзэхээр байна.

Шигтгээ 8

Судалгаанд оролцсон гишүүдийн 36,7 хувь нь “МҮХАҮТ-ийг гарааны бизнес болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч бизнесийн салбарынханд хүрч ажиллаж чаддаг уу” гэсэн асуултад “хангалтгүй” гэж хариулсан бол дөнгөж 1,7 хувь нь “хүрч ажилладаг” гэж дүгнэсэн.

Судалгаанд оролцогчид ...

Эдгээр нь дээрх зохицуулалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаарх нарийн тодорхой заагаагүй, бодитой хэрэгжих боломж хомс байгаагаас тунхагийн шинжтэй зохицуулалт болсон байна. Өөрөөр хэлбэл Үндэсний танхимын үйл ажиллагааны чиглэл гишүүн байгууллагуудад хүргэх үйлчилгээнд хэтэрхий чиглэсэн байгаагаас үүдэн төр, засгийн бодлогод оролцох, санал оруулах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэх механизм нь хэрхэн бодитой хэрэгжих нь тодорхойгүй болсон байна. Монгол Улсын хурдацтай өсч буй эдийн засаг нь олон боломжуудыг санал болгож байгаагаас гадна мөн шинэ сорилтуудыг бий болгож байна. Төрийн сайн

²⁴ МҮХАҮТ-ын 2015-2018 оны үйл ажиллагааны тайлан, УБ 2019 он., 20 дахь тал

засаглалын үндсэн зарчим болох хууль дээдлэх, чадварлаг байгууллагуудтай ил тод, хариуцлагатай хамтран ажиллах, түүнчлэн ЗГ-ын зүгээс хөрөнгө оруулалтын тогтвортой орчин бий болгох зэрэг асуудлууд нь дараагийн стратегийн бодлого байх хэрэгтэй. Энэхүү нөхцөл байдалд Үндэсний танхимын зүгээс бүрэн эрхийнхээ хүрээнд ЗГ-т бизнес эрхлэгчдийн эрх ашгийг төлөөлж ажиллахад голлон анхаарч, бодлогын өмгөөллийг шинэ түвшинд ахиулах зүй ёсны шаардлага бий болсон гэж үзлээ.

ХАҮТТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 4 дэх заалт “хуульд зааснаар дэргэдээ гадаад худалдааны арбитр байгуулан ажиллуулах”

Монгол Улсад арбитртай холбоотой харилцааг зохицуулсан БНМАУ-ын Арбитрын байгууллагын тухай, Гадаад худалдааны арбитрын тухай зэрэг хуулиуд үйлчилж байсан бөгөөд Үндэсний танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр нь 1960 онд байгуулагдсан бөгөөд 1995 онд Гадаад худалдааны арбитрын тухай хууль батлагдсанаар гадаад худалдаа, эдийн засгийн хэлцлээс үүдсэн болон гадаадын хөрөнгө оруулалттай компанийг үүсгэн байгуулагчдын хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх Гадаад Худалдааны Арбитр нэртэй байгуулагдан ажиллаж байв. 2003 онд Арбитрын тухай хууль шинэчлэгдэн батлагдсан нь олон талын ач холбогдолтой болж, өнөөдрийн байдлаар тус арбитр нь 21 аймагт салбар арбитртай, Ази Номхон далайн орнуудын арбитрын холбооны гишүүн бөгөөд олон улсын 20 гаруй арбитрын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Үндэсний танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын шийдвэрлэсэн хэргийн тоо баримтыг аваад үзвэл 2015 онд 65 хэрэг, 2016 онд 100 хэрэг, 2017 онд 71 хэрэг, 2018 онд 74 хэрэг, 2019 онд 87 хэрэг нийт 397 хэрэг маргаан шийдвэрлүүлэх нэхэмжлэл хүлээн авсан бөгөөд 351 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн байна. Үлдэх 46 хэргийн тухайд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа тоон үзүүлэлт байгаа нь тус зохицуулалт практикт амжилттай хэрэгжиж байгаагын илрэл бөгөөд зорилгодоо хүрсэн гэж үзэж болохоор байна.

Цаашид иргэний хэргийн шүүхийн ачааллыг багасгаж, арбитраар шийдвэрлэж буй хэрэг маргааны тоог нэмэх, мөн эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагааг сэргээх тал дээр ажиллах, гишүүн байгууллагуудад хөнгөлөлттэй нөхцөлөөр үйлчлэх зэргээр үйл ажиллагаандаа анхаарч ажиллах нь зүйтэй байна.

ХАҮТТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6 дахь заалт “давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх”

Үндэсний танхимд 2015-2019 онд давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ болон хүнд нөхцөл байдлын гэрчилгээ авах 259 хүсэлт ирсэнээс 106 хүсэлтэд давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ, 124 хүсэлтэд хүнд нөхцөл байдлын гэрчилгээ олгосон байна. Өөрөөр хэлбэл тухайн зохицуулалт нь зорилгоо биелүүлэхийн зэрэгцээ практикт хэрэгжиж байгаа үзүүлэлттэй байгаа ч шүүхэд нотлох баримтын түвшинд үнэлэгдэх тал дээр анхаарах хэрэгтэй байна. Гол нь Үндэсний танхимын зүгээс бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд гэрээ байгуулахдаа давагдашгүй хүчин зүйл болоод хүнд нөхцөл байдлын талаархи ойлголтыг сайжруулах, энэ талын сургалтыг түлхүү оруулах тал дээр анхаарах нь зүйтэй байна.

ХАҮТТХ-ийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндэсний танхим нь энэ хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3,5,6-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх албыг байгуулан ажиллуулна. Түүний ажиллах журмыг зөвлөл тогтооно.”

Өнөөдрийг хүртэлх хугацаанд Үндэсний танхимын хувьд экспортын барааны гарал үүслийг гэрчлэх, экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах болон давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлэхтэй холбоотой тусгай алба болон газар хэлтсүүд байгуулан ажиллуулж иржээ. Харин тус албаны журмыг зөвлөл тогтоох ёстой байтал энэхүү зохицуулалт одоо болтол хэрэгжээгүй байна. Энэхүү алба нь Хэрэглэгч үйлчилгээний газар гэсэн нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

ХАҮТХ-ийн энэхүү зохицуулалт нь зорилгодоо хүрч, практикт хэрэгжиж байгаа бөгөөд Хэрэглэгч үйлчилгээний газрын ажиллах журмыг зөвлөлөөс баталж хуульд заасан шаардлагыг биелүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

ХАҮТХ-ийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. “Танхимын санхүүжилт нь гишүүний татвар, иргэд, байгууллагын хандив, үйлчилгээний орлогоос бүрдэнэ”

ХАҮТХ-ийн 11 дүгээр зүйлд зааснаар танхим нь гишүүний татвар, иргэд, байгууллагын хандив, үйлчилгээний орлогоос санхүүжилтээ бүрдүүлэхээр заасан байна. Судалгааны явцад Үндэсний танхимаас 2015-2018 оны санхүүгийн мэдээллийг авч дүн шинжилгээ хийж үзсэн бөгөөд нийт орлогыг гишүүдийн татвар, төсөл хөтөлбөрийн орлого болон бусад үйл ажиллагааны орлогоос бүрдүүлж байна. Гэвч тухайн 4 жилийн үндсэн үйл ажиллагааны зардал жил бүр үндсэн үйл ажиллагааны орлогоос давсан буюу алдагдалтай ажиллаж ирсэн дүр зураг харагдаж байна. Үндэсний танхим цаашид ашиггүй ажилласнаар, санхүүжилтийн өнөөгийн механизмаа шинэчилж чадалгүйгээр төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад санал оруулах, бизнес эрхлэгчдийг төлөөлөхөд өнөөдрийн хангалтгүй байгаа байдал цаашид үргэлжлэх болно.

Мөн ХАҮТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Танхимын үйлчилгээний хөлсний хэмжээг танхимын саналыг үндэслэн Сангийн сайд, Худалдаа үйлдвэрийн сайд хамтран тогтооно” гэж заасан нь танхимын дотоод үйл ажиллагаанд төрийн зүгээс оролцох нэг хэлбэр бөгөөд танхим өөрийн үйлчилгээний төлбөрийг өөрөө тогтоох нь бие даасан байдал болоод үйл ажиллагаанд нь нийцэхээр байна. ХАҮТХ-д зааснаар гишүүнчлэлийн татварыг ямар зарчимд үндэслэн, ямар журмаар хураах харилцааг нарийн зохицуулаагүй байгаагаас гадна ямар тохиолдолд татвараас чөлөөлөхийг дурдаагүй байгаа зэргийг анхаарах цаг болжээ.

Шигтгээ 9

“МҮХАҮТ дэргэдээ эдийн засаг, бизнесийн орчны суурь судалгаа хийх зорилготой институт бий болговол та дэмжих үү” гэсэн асуултад судалгаанд оролцсон гишүүдийн 83,3 хувь нь “дэмжинэ” гэсэн хариулт өгсөн.

Судалгаанд оролцогчид ...

Цаашид мэргэжлийн танхим байж, эдийн засаг, бизнесийн орчны суурь судалгаа хийлгэх, төр засагт нөлөөлөх нөлөөллөө хүчтэй байлгахын тулд санхүүжилтийн өнөөдрийн механизмыг шинэчлэх, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, судалгаа шинжилгээ хийх төсвийг тусдаа баталж, үнэн бодитой, чанартай судалгаа хийдэг институт бий болгох хэрэгтэй гэсэн дүгнэлтэд хүрлээ.

4.2. Зөвлөмж

Монгол Улсын хувьд 1960 онд Нийтийн эрх мэдлийн загварт хамаарах Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг үүсгэн байгуулсан бөгөөд социалист систем задран унасны дараа бусад пост социалист орнуудын жишгээр 1995 онд Евроазийн загварыг чиг баримжаа болгон Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийг шинээр баталсан нь өнөөг хүртэл үйлчилж байна. Иймд Монгол Улс өөрийн орны эдийн засгийн хөгжлийг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүднээс эх газрын загвар болон азийн загварын чиг баримжаа бүхий Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тогтолцоонд шилжих боломж нээлттэй гэж үзэж байна.

Шигтгээ 10

“1995 онд батлагдсан ХАҮТХ-ийг шинэчилж, МҮХАҮТ болоод бусад танхимын үйл ажиллагааг орчин цагийн бизнесийн орчинтой уялдуулан хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна уу” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан гишүүдийн 86,7 хувь нь “тийм” гэсэн хариулт өгсөн.

Судалгаанд оролцогчид ...

Иймд үнэлгээний үр дүнд буюу үнэлгээг илэрхийлсэн дүгнэлтэд тулгуурлан хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох талаар дараахь санал, зөвлөмжийг хүргэж байна. Мөн ХАҮТХ-ийн холбогдох зүйл, заалтад хийсэн дээр дурдсан дүгнэлтэд үндэслэн судалгаа хийсэн багийн зүгээс ХАҮТХ-ийг шинэчлэн найруулах санал гаргаж байгаа болно. Хуулийг шинэчлэн найруулахтай холбоотойгоор зарим зөвлөмжийг дараахь байдлаар хүргүүлж байна. **Үүнд:**

1. Хуулийн зорилт: ХАҮТХ-ийн 1 дүгээр зүйлд зааснаар “Энэ хуулийн зорилт нь худалдаа, аж үйлдвэрийн танхим болон худалдааны танхим /цаашид “танхим” гэх/-ын бүрэн эрх, үйл ажиллагааны үндсэн чиглэл, түүний тогтолцоо, зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох, танхим болон төрийн ба бусад байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн хоорондын харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан бөгөөд Үндэсний танхимын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.1-д “Үндэсний танхимын зорилго нь улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих, худалдаа, үйлдвэрлэлийн орчин үеийн тогтолцоо бий болгох, бизнесийн таатай, тогтвортой орчин бүрдүүлэхэд тус дэмжлэг үзүүлэх, үндэсний эдийн засаг, нийгмийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үүднээс санал оруулах, гишүүдийнхээ болон гадаад дотоодын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нийтлэг эрх ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх, хамгаалах, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, жижиг дунд үйлдвэрлэлийг хөхиүлэн дэмжиж үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээ, экспортын чадамжийг нэмэгдүүлэх, Монгол Улсын бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино” гэж заасан бөгөөд хуулийн шинэчилсэн найруулгыг хийхдээ хуулийн зорилтыг илүү дэлгэрүүлэн орчин үеийн эдийн засаг, бизнесийн нөхцөл байдлыг харгалзан үзэж боловсруулах шаардлагатай байна.

2. Танхимын тогтолцоо: Өнөөдрийн Монгол Улсын худалдаа, аж үйлдвэрийн танхимын тогтолцоо нь бүс нутгийн зарчимд суурилсан тогтолцоо бөгөөд дүгнэлтэд зааснаар Үндэсний танхим, Улаанбаатар хотын танхимаас өөрөөр хуульд заасан үндэслэл шаардлагын дагуу үүсгэн байгуулагдсан танхим байгуулагдаагүй байна. Иймд салбар танхимын эрх зүйн статусыг цаашид хуульд баталгаажуулах нь зүйтэй байна. Монгол Улсын хувьд маш өргөн уудам газар нутагтай бөгөөд 2019 оны 3

дугаар улирлын байдлаар 93,426²⁵ аж ахуйн нэгжийн 63,030²⁶ аж ахуйн нэгж нь нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа зэргийг харгалзан үзэж цаашид бүс нутгийн зарчмаар бус бизнесийн салбар тус бүрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нэгдэж бизнесийн салбар тус бүрээр дагнасан танхим байгуулах, тус бүрдээ бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулах, эдгээр танхимуудын нэгдлээр Үндэсний танхимын их хурал, удирдах зөвлөл, тэргүүлэгчдийг бүрдүүлдэг тогтолцоонд шилжих нь оновчтой гэж үзэж байна. Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндэсний аж ахуйн эрхлэгчдийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний танхимын тогтолцоонд салбар, эсхүл салбар дундын үндэсний холбоо, жижиг, дунд, том аж ахуйн үндэсний холбоо, түүнчлэн аж ахуйн үйл ажиллагааны чиглэлийн өөрөө удирдах байгууллагууд үйл ажиллагаа явуулж байгааг харгалзан үзэж хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах нь зүйтэй байна.

3. Нэрийн хамгаалалт: Танхимын нэрийн хамгаалалтыг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах шаардлагатай байна. Учир нь Өнөөдрийн байдлаар “танхим” гэсэн нэр агуулсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо нийт 69 байгаа бөгөөд үүнээс ТББ-ын хэлбэрээр нийт 65 аж ахуйн нэгж байгууллага байгуулагдсан байна. Үүний нэг нь Улаанбаатар хотын танхим бөгөөд 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр 50 аж ахуйн нэгж нийлэн “Гишүүдээ дэмжих, нийслэлийн эдийн засгийн хөгжлийг дэмжих төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, засаг захиргааны бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сурталчлах, бизнес эрхлэгчдийн санал бодлыг уламжлах”²⁷ чиглэлээр үүсгэн байгуулагдсан байна. Өөрөөр хэлбэл ХАҮТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан 50-иас доошгүй аж ахуйн нэгж, байгууллага нийлэн үүсгэн байгуулсан, хуулийн дагуу бие даасан танхим байна. Энэ нь “танхим” гэсэн нэрийг сонирхсон этгээдүүд дурын зорилгодоо ашиглах нөхцөл байдлыг бий болгож байна. Энэхүү нөхцөл байдлыг “танхим” гэсэн нэрэнд хуульд тусгайлсан хамгаалалт оруулах замаар шийдэж болохоор байна. Тухайлбал, БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 52 дугаар зүйлд “Энэ хууль дахь Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим эсхүл Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас бусад байгууллага “Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим” эсхүл “Худалдаа, аж үйлдвэрийн танхим” эсхүл бусад төстэй нэр хэрэглэхийг хориглосон байна. Мөн Япон улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь түүний нэрийн хүрээнд Худалдаа, аж үйлдвэрийн танхим эсхүл японы Худалдаа, аж үйлдвэрийн танхим гэсэн нэр томъёог оруулах үүрэгтэй”, 3.2-т “Худалдаа, аж үйлдвэрийн танхим биш этгээд түүний нэрийн хүрээнд Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг илэрхийлэх нэр томъёо эсхүл Худалдаа, аж үйлдвэрийн танхим хэмээн андуурах нэр томъёо хэрэглэхийг хориглоно. Харин тусгай тохиолдолд эдийн засаг аж ахуйн яамны сайдын зөвшөөрлийн үндсэн дээр хэрэглэхийг хориглохгүй” гэх мэтээр нэрийн хамгаалалт хийсэн сайн туршлагыг нутагшуулах шаардлагатай.

4. Танхимын бүрэн эрх: Үндэсний танхимын хувьд төрийн эрх барих дээд байгууллага болон Засгийн газартай харилцах, түүн дотроо бизнес эрхлэгчдийн

²⁵ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.

https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2600_004V2&13999001_select_all=0&13999001SingleSelect=1&SIC_1_select_all=0&SIC_1SingleSelect=1&YearQ_select_all=0&YearQSingleSelect=201903&viewtype=table

²⁶ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.

https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2600_011V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=T2&Aimags_soums_select_all=0&Aimags_soumsSingleSelect=0501&YearQ_select_all=0&YearQSingleSelect=201903&viewtype=table

²⁷ <http://opendata.burtgel.gov.mn/lesinfo/8172676>

нийтлэг эрх ашгийг илэрхийлэх, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгоход санал өгөх бүрэн эрхийн хувьд хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зохицуулалтуудыг тусгах шаардлагатай гэж үзлээ. **Үүнд:**

а. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд танхимын үйл ажиллагаан дахь төрийн оролцоог бүрэн хязгаарлаад зогсохгүй, төрийн болон танхимын хамтын ажиллагааны талаар тодорхой зохицуулж, танхимын байр суурь, эрх зүйн статусыг тодорхой баталгаажуулах;

б. Төрөөс эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах бүрэн эрхийг олгосон боловч тэдгээрийн оролцоог хангалттай баталгаажуулаагүй байгаа тул дараах тодорхой харилцаанууд дээр танхимаас заавал санал авах, хяналт тавих зохицуулалтыг тусгах шаардлагатай гэж үзсэн бөгөөд Үндэсний танхим нь тухайн үйл ажиллагааны талаарх тайлангаа жил бүр гаргадаг байх нь зөв гэж үзлээ. **Үүнд:**

i. Бизнес эрхлэгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөж буй хэм хэмжээний акт, баримт бичиг боловсруулахад Үндэсний танхимын саналыг заавал авсан байх;

ii. Бизнес эрхлэгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд холбогдож буй хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөлд мэргэжлийн дүгнэлт гаргаж, заавал санал өгөх;

iii. Дэд бүтцийн болон томоохон бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төслийн багт бизнес эрхлэгчдийн эрх ашгийг төлөөлөн оролцох;

iv. Тухайн жилийн Төсвийн тухай хуульд Үндэсний танхимын саналыг заавал авах;

v. Эдийн засаг, бизнесийн чиглэлээр ЗГ-аас гадаадын улс орнуудтай байгуулж буй олон улсын гэрээ, хэлэлцээрт санал өгөх;

vi. ЗГ-аас байгуулж буй хөрөнгө оруулалтын гэрээ, тогтвортой байдлын гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ зэрэг арилжааны шинжтэй гэрээ хэлэлцээр боловсруулах, хэлэлцээр хийх ажлын хэсэгт Үндэсний танхимын төлөөллийг оролцуулах, саналыг заавал авдаг байх;

vii. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтад оролцох, шалгаруулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих;

viii. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Хөдөө аж ахуйг дэмжих сан зэрэг төрийн зарим тусгай сангуудаас аливаа төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх сонгон шалгаруулалтад хяналт тавих;

ix. Төрийн байгууллагуудын зүгээс бизнес эрхлэгчдийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа шийдвэр гаргахдаа Үндэсний танхимыг саналыг заавал авдаг байх;

x. Үндэсний танхим нь үндэсний хэмжээний бизнесийн орчны судалгааг жил бүр хийж гүйцэтгэн, тайланг холбогдох төрийн байгууллагад саналын хамт хүргүүлж хамтран ажиллах;

xi. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглал, засаглалын үр дүнтэй байдалд үнэлгээ хийхэд оролцох;

xii. Төрийн өмчийг хувьчлах болон төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлаар Үндэсний танхим санал, зөвлөмж хүргүүлэх;

xiii. Төрийн өндөр албан тушаалтнуудтай бизнесийн уулзалтыг тогтмол зохион байгуулж ажиллах;

xiv. Төрийн байгууллагын зүгээс бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийх төрийн хяналт шалгалтын талаар нэн тэргүүнд Үндэсний танхимд мэдэгдэх бөгөөд танхим нь гишүүн байгууллагынхаа эрх ашгийг хамгаалах үүднээс хяналт хийх үйл ажиллагаанд оролцоно;

xv. Аливаа хууль тогтоомжийн төсөл нь бизнесийн орчинд сөрөг нөлөө үзүүлэх эсэх асуудлаар Үндэсний танхимаар хөндлөнгийн урьдчилсан үнэлгээ хийлгэх;

xvi. Бизнес эрхлэгчдийн эрх, ашгийг хамгаалах зорилгоор төрийн байгууллагаас холбогдох мэдээллийг аливаа саадгүй гаргуулан авах.

5. Эвлэрүүлэн зуучлах төв: Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд Төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагчийн талаарх харилцааг зохицуулсан бөгөөд 8.1-д “Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулж болно” гэж заасан бөгөөд Үндэсний танхимын дэргэд анх 2014 онд эвлэрүүлэн зуучлах төв байгуулагдсан бөгөөд тухайн үедээ эвлэрүүлэн зуучлалын албаны дарга, нарийн бичиг, 18 эвлэрүүлэн зуучлагчдын бүрэлдэхүүнтэй байгуулагдаж байсан байна. Гэвч Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол нөгөө тал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй” гэж заасан бөгөөд энэ тухайн эвлэрүүлэн зуучлалын төвийн шийдвэрийг шүүгч баталгаажуулж, захирамж гаргадгүйгээс заавал биелэгдэх шинжгүй болсон байна. Иймд Үндэсний танхимын дэргэдэх Эвлэрүүлэн зуучлалын төвийн шийдвэрийг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны нэгэн адил шүүгч баталгаажуулж, захирамж гарган шүүхийн шийдвэрийн нэгэн адил заавал биелэгддэг болгох шаардлагатай байна.

6. Гишүүнчлэл: Олон улсад танхимын гишүүнчлэлийн хувьд заавал, сайн дурын болон холимог гэсэн чиг хандлагатай байна. ХБНГУ болон БНКУ-ын хувьд заавал гишүүнчлэлтэй, ОХУ, Япон, БНУУ сайн дурын гишүүнчлэлийн хэлбэртэй бол Франц, БНСУ гишүүнчлэлийн холимог тогтолцоотой байна. Манай улсын хувьд сайн дурын гишүүнчлэлийн хэлбэртэй байгаа бөгөөд үүнийгээ дагаад танхимын санхүүжилт нь үндсэн үйл ажиллагааны зардлаа нөхөж чадахгүй, алдагдалтай ажиллаж байгаагаас судалгаа, шинжилгээ хийх төсөвгүй, энэхүү шалтгааны улмаас УИХ, ЗГ-т хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр хүргэж байгаа, бизнесийн орчны талаар хүргэж байгаа санал нь төрийн бодлогод тусах магадлал бага байгаа зэрэг хүндрэлүүд байгаа тул заавал гишүүнчлэлийн хэлбэрт шилжих хэрэгтэй гэж үзлээ. Гишүүнчлэлийн асуудал нь танхимын санхүүжилттэй салшгүй холбоотой бөгөөд гишүүнчлэлийг заавал болгосноор танхим нь санхүүгийн хувьд хараат бусаар үйл ажиллагаа явуулах, бие даасан байдал бэхжих, мэргэжлийн танхим болох боломж бүрдэх юм.

7. Дотоод бүтэц: Танхимын дотоод бүтэц буюу танхимын удирдах дээд байгууллага, удирдлага (Их хурал, Ерөнхийлөгч, Удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, Тэргүүлэгчид), хяналтын бүтэц, эрх хэмжээ зэргийг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах. Тухайлбал, Франц, Унгар, Солонгос, Герман, Казахстан зэрэг улс орнуудад нийт гишүүдээс сонгогдсон Их хурал, түүнээс томилогдсон Удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, мөн зарим улсад танхимын үйл ажиллагаанд хяналт тавих хяналтын нэгж зэргийг хуульд тодорхой заасан байна. Ингэснээр Үндэсний танхимын удирдах байгууллагад эрх хэмжээний давхардал, зөрчил үүсэхгүй бөгөөд танхимын дүрэм өөрчлөгдсөнөөс үл хамааран хуульд заасан бүтэц, эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжтой болох юм.

8. Санхүүжилт: Үндэсний танхим нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар гишүүний татвар, иргэд, байгууллагын хандив, үйлчилгээний орлогоос

санхүүжилтээ бүрдүүлж байгаа бөгөөд тухайн харилцааг хуулиар тодорхой зааж, хувь хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлт зэрэг асуудлуудыг дүрмээр зохицуулах нь зүйтэй юм. Ингэхдээ дараах зүйлүүдийг анхаарах хэрэгтэй байна. **Үүнд:**

- а. Эмэгтэй бизнес эрхлэгчид болон старт-ап зэрэг зарим төрлийн бизнес эрхлэгчдийг танхимын гишүүнчлэлийн татвараас тодорхой хугацаанд чөлөөлөх;
- б. Аж ахуйн нэгжийн орлогын түвшингээс хамааран гишүүний төлөх татварын хувь хэмжээг ялгаатай тогтоож болох бөгөөд энэ нь танхимд эдлэх гишүүдийн эрхэд үл нөлөөлөхөөр зохицуулах. Харин танхимын зүгээс гишүүдэд үзүүлдэг нэмэлт үйлчилгээтэй холбоотойгоор, эсхүл гишүүдийн ангиллаас хамааран нэмэлт татвар төлөх эрхийг нээлттэй үлдээх;
- с. Дээрх байдлаар татварын хувь хэмжээг ялгаатай тогтоохдоо Татварын ерөнхий хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуультай нийцүүлэн орлогын түвшингээс хамааран хэд хэдэн ангилалд хуваах;
- д. Танхим өөрийн үйлчилгээний хөлсний хувь хэмжээг бие даан тогтоодог байх;
- е. Гишүүдийн татварын хувь хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлт зэрэг асуудлуудыг үндсэн дүрмээрээ дэлгэрүүлэн зохицуулдаг байх.

9. Төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх: Захиргааны эрх зүйн онолын үүднээс Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг “нийтийн эрх зүйн гишүүнчлэл бүхий нэгдэл” гэж үздэг бөгөөд нийтийн эрх зүйн хэм хэмжээнд тулгуурлан үйл ажиллагаа явуулна гэж тайлбарладаг. Түүнчлэн одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ХАҮТтХ-ийн 6 дугаар зүйлд зааснаар экспортын барааны гарал үүслийг гэрчлэх, экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах, давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх зэрэг төрийн байгууллагад хамаарах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нь нийтийн эрх зүйн ангилалд хамаарах нэг хүчин зүйл болж байна. Цаашид танхимын чиг үүргийг өргөжүүлэх, нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд захиргааны байгууллагын зарим чиг үүргийг шилжүүлэн авах эрхийг нь нээсэн ерөнхий зохицуулалтыг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд оруулах нь зүйтэй бөгөөд зарим чиг үүргийг шилжүүлэн авснаар захиргааны байгууллагын ачаалал багасах, цаг хугацаа, зардал багасах эерэг үр дүн гарах юм.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль, эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Монгол Улсын Иргэний хууль, 2002
3. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль, 1995
4. Төрийн бус байгууллагын тухай хууль, 1997
5. Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2016

Статистик мэдээ, судалгааны тайлан, ном, сурах бичиг

6. Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын 2011-2014 онуудад хийсэн ажлын тайлан, УБ., 2014 он
7. Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын 2015-2018 онуудад хийсэн үйл ажиллагааны тайлан, УБ., 2018 он
8. МҮХАҮТ-ын гишүүдийн 2016 оны сэтгэл ханамжийн судалгааны тайлан, УБ., 2017 он
9. Монгол Улсын бизнесийн орчны суурь судалгаа-эцсийн тайлан, УБ., 2018 он
10. Монгол орны хувьд баримтлах стратеги, Европын сэргээн босголт хөгжлийн банкны баримт бичиг, УБ., 2013 он
11. Бизнес итгэлийн индекс, 2016 оны судалгааны тайлан, УБ., 2016 он
12. Монголын бизнесийн орчны судалгаа, УБ., 2017 он
13. Монгол Улсын компанийн засаглалын үндэсний тайлан, УБ., 2015 он
14. Бизнес итгэлийн индекс, 2018 оны судалгааны тайлан, УБ., 2018 он
15. Бизнес итгэлийн индекс, 2017 оны судалгааны тайлан, УБ., 2017 он
16. Арбитрын тухай хуулийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, эрх зүйн орчныг сайжруулах арга зам, Хууль зүйн үндэсний хүрээлэн иргэн, эдийн засгийн эрх зүйн сектор, УБ., 2010 он
17. Монголын бизнесийн орчны талаарх үндэсний хэмжээний судалгааны үр дүн, УБ., 2014 он
18. МҮХАҮТ-ын 2018 оны бодлого, зорилтууд, УБ., 2018 он

Цахим эх сурвалж

19. <http://opendata.burtgel.gov.mn/lesinfo/8172676>
20. <http://opendata.burtgel.gov.mn/les?condition=3&text=%D1%82%D0%B0%D0%BD%D1%85%D0%B8%D0%BC>
21. <http://2012.parliament.mn/law/project/931/category/1>
22. <http://www.arbitr.mn/index.php/aboutus>
23. https://www.ubchamber.mn/uploads/Force_majeure_Hardship.pdf
24. <https://www.mongolchamber.mn/>

СУДАЛГААНЫ АСУУЛТ

Сайн байна уу? Танд болон танай хамт олонд энэ өдрийн мэнд хүргэе. Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим /цаашид “МҮХАҮТ” гэх/-ийн зүгээс өөрсдийн үйл ажиллагааны зарим чиглэлийг сайжруулах зорилгоор гишүүн байгууллагуудаас Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /цаашид “ХАҮТ-Х” гэх/-ийн зарим зохицуулалттай холбоотой судалгаа явуулж байгаа бөгөөд доорх асуултуудад үнэн зөв хариулах нь МҮХАҮТ-ын цаашдийн үйл ажиллагааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах болно.

Танай компанийн нэр: “.....” ХХК

1. Танай компани байгуулагдаад хэдэн жил болж байгаа вэ?

- a. 1-5 жил
- b. 6-10 жил
- c. 11-15 жил
- d. 16-20 жил
- e. 20-с дээш жил

2. Танай компани МҮХАҮТ-ын гишүүнчлэлийн ямар ангилалд хамаардаг вэ?

- a. Diamond
- b. Platinum
- c. Gold
- d. Classic
- e. Not member

3. Танай компанийн үйл ажиллаганы чиглэл? (нөхөж бичнэ үү)

- a.
- b.
- c.
- d.

4. Та МҮХАҮТ-д хуулиар олгогдсон бүрэн эрхийн талаар хэр мэдэх вэ?

- a. Сайн мэднэ
- b. Мэднэ
- c. Зарим талаар мэднэ
- d. Мэдэхгүй

5. МҮХАҮТ-ын зүгээс өнгөрсөн хугацаанд төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах бүрэн эрхээ хангалттай хэрэгжүүлж чадсан уу?

- a. Хангалттай хэрэгжүүлсэн
- b. Хэрэгжүүлсэн
- c. Зарим талаар хэрэгжүүлсэн
- d. Хэрэгжүүлж чадаагүй

6. Хэрвээ хэрэгжүүлж чадаагүй бол ямар хүчин зүйл нөлөөлсөн гэж үзэж байна вэ? (5 дахь асуултад "Хэрэгжүүлж чадаагүй" гэсэн хариулт сонгосон тохиолдолд хариулна.)
- a. Тухайн үеийн удирдлагуудаас хамааралтай
 - b. Судалгаанд үндэслэсэн санал дүгнэлт бага байдаг
 - c. Гишүүн байгууллагуудаас ирүүлж буй саналуудаас хамааралтай
 - d. Саналыг хүлээж авах эсэх нь төрийн байгууллагын асуудал
7. Төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг дотоодод болон гадаадад тайлбарлан таниулах чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж чадсан уу?
- a. Хангалттай хэрэгжүүлсэн
 - b. Хэрэгжүүлсэн
 - c. Зарим талаар хэрэгжүүлсэн
 - d. Хэрэгжүүлж чадаагүй
8. Төрийн эдийн засаг, нийгмийн бодлогын хэрэгжилтэд тус дэмжлэг үзүүлэх чиг үүргээ ямар түвшинд хэрэгжүүлсэн вэ?
- a. Хангалттай хэрэгжүүлсэн
 - b. Хэрэгжүүлсэн
 - c. Зарим талаар хэрэгжүүлсэн
 - d. Хэрэгжүүлж чадаагүй
9. МҮХАҮТ-ын зүгээс төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлод санал дүгнэлт оруулах, дотоод гадаадад тайлбарлан таниулах болон хэрэгжилтэд тус дэмжлэг үзүүлэх чиг үүргээ хэрэгжүүлэх ажилд ямар хүчин зүйл хүндрэл учруулж байгаа вэ?
- a. ХАҮТтХ-д заасан бүрэн эрх нь хангалтгүй
 - b. ХАҮТтХ-ийн санхүүжилт хангалтгүй
 - c. ХАҮТтХ-ийн тогтолцоо буруу
 - d. ХАҮТтХ-ийн удирдлагын баг хангалтгүй ажиллаж байсан
10. Өмнөх асуулт буюу 9 дэх асуултад дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд МҮХАҮТ-д ямар дэмжлэг хэрэгтэй вэ? (нөхөж бичнэ үү)
- a.
 - b.
 - c.
 - d.
11. МҮХАҮТ нь худалдаа үйлдвэрийнхний нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлөх чиг үүргээ ямар түвшинд хэрэгжүүлж байгаа вэ?
- a. Хангалттай хэрэгжүүлдэг
 - b. Хэрэгжүүлдэг
 - c. Зарим талаар хэрэгжүүлдэг
 - d. Хэрэгжүүлж чаддаггүй

12. МҮХАҮТ нь эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал оруулах чиг үүргээ хэрэгжүүлж чаддаг уу?
- a. Хангалттай хэрэгжүүлж чаддаг
 - b. Хэрэгжүүлдэг
 - c. Зарим хууль тогтоомжийн хувьд хэрэгжүүлдэг
 - d. Хэрэгжүүлж чаддаггүй
13. Хэрвээ хэрэгжүүлж чадаагүй бол ямар хүчин зүйл нөлөөлсөн гэж үзэж байна вэ? (11 эсхүл 12 дахь асуултын аль нэгэнд нь “Хэрэгжүүлж чадаагүй” гэсэн хариулт сонгосон тохиолдолд хариулна.)
- a. Тухайн үеийн удирдлагуудаас хамааралтай
 - b. Судалгаанд үндэслэсэн санал дүгнэлт бага байдаг
 - c. Гишүүн байгууллагуудаас ирүүлж буй саналуудаас хамааралтай
 - d. Саналыг хүлээж авах эсэх нь төрийн байгууллагын асуудал
14. Та МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын чиг үүргийн талаар хэр мэдэх вэ?
- a. Хангалттай сайн
 - b. Дунд зэрэг мэднэ
 - c. Бага зэрэг мэднэ
 - d. Мэдэхгүй
15. Та Монголын Олон Улсын Арбитраар хэрэг шийдвэрлүүлэхийн гол ач холбогдлыг юу гэж үзэж байна вэ?
- a. Шат дамжлага бага
 - b. Зардал бага
 - c. Хараат бус, мэргэшсэн, өндөр ур чадвар
 - d. Олон улсын түвшинд хэргийг шийдвэрлэнэ
16. Таны бодлоор МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр нь чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадаж байгаа юу?
- a. Хангалттай хэрэгжүүлж байгаа
 - b. Дунд зэргийн түвшинд хэрэгжүүлж байгаа
 - c. Бага хувиар хэрэгжүүлж байгаа
 - d. Хэрэгжүүлж чадахгүй байна
17. МҮХАҮТ-ын зүгээс хэрэгжүүлдэг “давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх” үйлчилгээ хараат бус, мэргэжлийн түвшинд байж чаддаг уу?
- a. Хангалттай сайн
 - b. Дунд зэрэг
 - c. Бага зэрэг
 - d. Хангалтгүй
18. МҮХАҮТ-аас тодорхойлсон давагдашгүй хүчин зүйлийг гэрчилсэн баримт нь шүүх болон арбитрд нотлох баримтын түвшинд үнэлэгдэж чаддаг уу?

- a. Чаддаг
 - b. Чаддаггүй
19. Давагдашгүй хүчин зүйлийн гэрчлэх энэхүү чиг үүрэг МҮХАҮТ-д байх нь зөв гэж боддог уу?
- a. Тийм
 - b. Үгүй
20. Таны хувьд танхимын санхүүжилт нь тухайн байгууллагыг үйл ажиллагаагаа саадгүй явуулахад хангалттай байж чаддаг гэж бодож байна уу?
- a. Хангалттай
 - b. Үйл ажиллагааны зардалдаа хүрэлцдэг
 - c. Хангалтгүй
 - d. Мэдэхгүй
21. ХАҮТtХ-д заасан танхимын тогтолцоог та монгол улсын нөхцөлд тохирсон тогтолцоо гэж үзэж байна уу?
- a. Тийм
 - b. Үгүй
22. МҮХАҮТ-ын гишүүнчлэл сайн дурын байгаа нь зөв гэж үзэж байна уу?
- a. Тийм
 - b. Үгүй
23. Танхимын дотоод бүтэц, зохион байгуулалт үйл ажиллагааны онцлогтой уялдсан зөв бүтэц байж чаддаг уу?
- a. Тийм
 - b. Үгүй
24. МҮХАҮТ-ын дотоод засаглал хангалттай сайн түвшинд байж чаддаг уу?
- a. Хангалттай сайн
 - b. Сайн
 - c. Хангалтгүй
 - d. Мэдэхгүй
25. МҮХАҮТ-ын ерөнхийлөгч болоод гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлагыг шинэчлэх шаардлагатай гэж үзэж байна уу?
- a. Тийм
 - b. Үгүй
26. МҮХАҮТ-ын зүгээс гарааны бизнес эрхлэгч болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч бизнесийн салбарынханд хүрч ажиллаж чаддаг уу?
- a. Хангалттай хүрч ажилладаг
 - b. Хүрч ажилладаг
 - c. Хангалтгүй
 - d. Мэдэхгүй

27. МҮХАҮТ дэргэдээ эдийн засаг, бизнесийн орчны суурь судалгаа хийх зорилготой институт бий болговол та дэмжих үү?

- a. Дэмжинэ
- b. Тийм шаардлагагүй
- c. Тухайн үедээ шийднэ
- d. Мэдэхгүй

28. МҮХАҮТ-ын зүгээс ЖДҮДСан зэрэг төсвийн хөрөнгөөр сонгон шалгаруулалт хийдэг бүтэцтэй байгууллагын бүрэлдэхүүнд орж ажиллахыг зөв гэж үзэж байна уу?

- a. Тийм
- b. Үгүй

29. 1995 онд батлагдсан ХАҮТтХ-ийг шинэчилж, МҮХАҮТ болоод бусад танхимын үйл ажиллагааг орчин цагийн бизнесийн орчинтой уялдуулан хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна уу?


- a. Тийм
- b. Үгүй

30. Хэрэв 29 дэх асуултад “тийм” гэж хариулсан бол ямар байдлаар хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна вэ? (нөхөж бичнэ үү)


.....
.....
.....

Судалгаанд идэвхтэй оролцсон танд баярлалаа.


1. Танай компани байгуулагдаад хэдэн жил болж байгаа вэ?




2. Танай компани МҮХАҮТ-ын гишүүнчлэлийн ямар ангилалд хамаардаг вэ?



4. Та МҮХАҮТ-д хуулиар олгогдсон бүрэн эрхийн талаар хэр мэдэх вэ?




5. МҮХАҮТ-ын зүгээс өнгөрсөн хугацаанд төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах бүрэн эрхээ хангалттай хэрэгжүүлж чадсан уу?




6. Хэрвээ хэрэгжүүлж чадаагүй бол ямар хүчин зүйл нөлөөлсөн гэж үзэж байна вэ? (5 дахь асуултад "Хэрэгжүүлж чадаагүй" гэсэн хариулт сонгосон тохиолдолд хариулна.)

- a. Тухайн үеийн удирдлагуудаас хамааралтай
- b. Судалгаанд үндэслэсэн санал, дүгнэлт бага байдаг
- c. Гишүүн байгууллагуудаас ирүүлж буй саналуудаас хамааралтай
- d. Саналыг хүлээж авах эсэх нь төрийн байгууллагын асуудал




7. Төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг дотоодод болон гадаадад тайлбарлан таниулах чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж чадсан уу?

- a. Хангалттай хэрэгжүүлсэн
- b. Хэрэгжүүлсэн
- c. Зарим талаар хэрэгжүүлсэн
- d. Хэрэгжүүлж чадаагүй
- e. Мэдэхгүй




8. Төрийн эдийн засаг, нийгмийн бодлогын хэрэгжилтэд тус дэмжлэг үзүүлэх чиг үүргээ ямар түвшинд хэрэгжүүлж байгаа вэ?

- a. Хангалттай хэрэгжүүлсэн
- b. Хэрэгжүүлсэн
- c. Зарим талаар хэрэгжүүлсэн
- d. Хэрэгжүүлж чадаагүй
- e. Мэдэхгүй




9. МҮХАҮТ-ын зүгээс төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлход санал дүгнэлт оруулах, дотоод гадаадад тайлбарлан таниулах болон хэрэгжилтэд тус дэмжлэг үзүүлэх чиг үүргээ хэрэгжүүлэх ажилд ямар хүчин зүйл хүндрэл учруулж байна гэж үзэж байна вэ?

- a. ХАҮТТХ-д заасан бүрэн эрх нь хангалтгүй
- b. ХАҮТТХ-ийн санхүүжилт хангалтгүй
- c. ХАҮТТХ-ийн тогтолцоо буруу
- d. ХАҮТТХ-ийн удирдлагын баг хангалтгүй ажиллаж байсан
- e. Мэдэхгүй




11. МҮХАҮТ нь худалдаа үйлдвэрийнхний нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлөх чиг үүргээ ямар түвшинд хэрэгжүүлж байгаа вэ?

- a. Хангалттай хэрэгжүүлдэг
- b. Хэрэгжүүлдэг
- c. Зарим талаар хэрэгжүүлдэг
- d. Хэрэгжүүлж чаддаггүй
- e. Мэдэхгүй




12. МҮХАҮТ нь эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал оруулах чиг үүргээ хэрэгжүүлж чаддаг уу?

- a. Хангалттай хэрэгжүүлж чаддаг
- b. Хэрэгжүүлдэг
- c. Зарим хууль тогтоомжийн хувьд хэрэгжүүлдэг
- d. Хэрэгжүүлж чаддаггүй
- e. Мэдэхгүй




13. Хэрвээ хэрэгжүүлж чадаагүй бол ямар хүчин зүйл нөлөөлсөн гэж үзэж байна вэ? (11 эсхүл 12 дахь асуултын аль нэгэнд нь "Хэрэгжүүлж чадаагүй" гэсэн хариулт сонгосон тохиолдолд хариулна.)

- a. Тухайн үеийн удирдлагуудаас хамааралтай
- b. Судалгаанд үндэслэсэн санал, дүгнэлт бага байдаг
- c. Гишүүн байгууллагуудаас ирүүлж буй саналуудаас хамааралтай
- d. Саналыг хүлээж авах эсэх нь төрийн байгууллагын асуудал




14. Та МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын чиг үүргийн талаар хэр мэдэх вэ?

- a. Хангалттай сайн
- b. Дунд зэрэг мэднэ
- c. Бага зэрэг мэднэ
- d. Мэдэхгүй




15. Та Монголын Олон Улсын Арбитраар хэрэг шийдвэрлүүлэхийн гол ач холбогдлыг юу гэж үзэж байна вэ?




16. Таны бодлоор МҮХАҮТ дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр нь чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадаж байгаа юу?




17. МҮХАҮТ-ын зүгээс хэрэгжүүлдэг “давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх” үйлчилгээ хараат бус, мэргэжлийн түвшинд байж чаддаг уу?




18. МҮХАҮТ-аас тодорхойлсон давагдашгүй хүчин зүйлийг гэрчилсэн баримт нь шүүх болон арбитрд нотлох баримтын түвшинд үнэлэгдэж чаддаг уу?




19. Давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх энэхүү чиг үүрэг МҮХАҮТ-д байх нь зөв гэж боддог уу?




20. Таны хувьд танхимын санхүүжилт нь тухайн байгууллагыг үйл ажиллагаагаа саадгүй явуулахад хангалттай байж чаддаг гэж бодож байна уу?




21. ХАҮТХ-д заасан танхимын тогтолцоог та Монгол улсын нөхцөлд тохирсон тогтолцоо гэж үзэж байна уу?




22. МҮХАҮТ-ын гишүүнчлэл сайн дурын байгаа нь зөв гэж үзэж байна уу?




23. Танхимын дотоод бүтэц, зохион байгуулалт үйл ажиллагааны онцлогтой уялдсан зөв бүтэц байж чаддаг уу?




24. МҮХАҮТ-ын дотоод засаглал хангалттай сайн түвшинд байж чаддаг уу?




25. МҮХАҮТ-ын ерөнхийлөгч болоод гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлагыг шинэчлэх шаардлагатай гэж үзэж байна уу?




26. МҮХАҮТ-ын зүгээс гарааны бизнес эрхлэгч болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч бизнесийн салбарынханд хүрч ажиллаж чаддаг уу?




27. МҮХАҮТ дэргэдээ эдийн засаг, бизнесийн орчны суурь судалгаа хийх зорилготой институт бий болговол та дэмжих үү?



28. МҮХАҮТ-ын зүгээс ЖДҮДСан зэрэг төсвийн хөрөнгөөр сонгон шалгаруулалт хийдэг бүтэцтэй байгууллагын бүрэлдэхүүнд орж ажиллахыг зөв гэж үзэж байна уу?



29. 1995 онд батлагдсан ХАҮТтХ-ийг шинэчилж, МҮХАҮТ болоод бусад танхимын үйл ажиллагааг орчин цагийн бизнесийн орчинтой уялдуулан хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна уу?



ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

**ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ**

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

Судалгааны арга зүй

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын чиг хандлага

1. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хөгжлийн нийтлэг хандлага
2. Пост-социалист улсууд дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хөгжлийн чиг хандлага

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын олон улсын жишиг

1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
2. Бүгд Найрамдах Франц Улс
3. Бүгд Найрамдах Казахстан Улс
4. Бүгд Найрамдах Солонгос Улс
5. Япон Улс
6. Унгар Улс

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

Зөвлөмж

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ХАВСРАЛТ

ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны арга зүй

Уг судалгаанд улс орнуудын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын эрх зүйн байдлыг зохицуулах хуулийн хүрээнд харьцуулсан судалгааны арга болон логик анализийн аргыг ашигласан болно. Танхимын дотоод дүрэм, журам уг судалгаанд хамрагдаагүй болно.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТОГТОЛЦООНЫ ЧИГ ХАНДЛАГА

1. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хөгжлийн нийтлэг хандлага

Худалдаа, аж үйлдвэрийн танхим (Chamber of Commerce and Industry) нь бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийг бэхжүүлэх, дэд бүтцийг сайжруулах, сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох зэрэг олон талт үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм. Түүний үүслийг 1599 оны Францын Марсель боомт хотод байгуулагдсан худалдааны танхим (chamber de commerce)-тай холбон авч үздэг. Харин өнөөгийн байдлаар НҮБ-ийн гишүүн 191 улсад худалдаа аж үйлдвэрийн танхим байгуулагдсан байна.¹

Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг эрх зүйн статус, гишүүнчлэлийн шинж зэргээр ангилан авч үзэх нь түгээмэл байдаг. Харин уг судалгааны хүрээнд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хөгжлийн ерөнхий хандлагыг тодорхойлох үүднээс ерөнхий загварыг гаргаж тавьсан Виктор Федотовын 2007 онд гаргасан ангилалд тулгуурласан болно.

Федотов нь Худалдаа аж үйлдвэрийн танхимыг Нийтийн эрх мэдлийн загвар (Public model), Англи саксоны загвар (Anglo-Saxon model), Эх газрын загвар (Continental model), Азийн загвар (Asian model), Евро-Азийн загвар (Eurasian model) хэмээн таван загварт хуваасан байна.

Эдгээрээс Нийтийн эрх мэдлийн загвар нь засгийн газрын байгууллага худалдаа, аж үйлдвэрийн үйл ажиллагааг зохицуулдаг социалист эсхүл тоталитар дэглэм бүхий улс орнуудад оршдог бөгөөд чөлөөт зах зээлийн системд нийцдэггүй. Энэхүү загварт Беларусь, Хятад, Куб, Иран зэрэг улс орнууд хамаарна. Үүний эсрэгээр Англи-саксоны загвар нь нийтийн эрх мэдлийн загварын эсрэг шинжийг агуулдаг бөгөөд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын эрх зүйн статус нь мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагаас төдийлэн ялгардаггүй ба танхимын статусыг хуулиар тусгайлан зохицуулдаггүй байна.

¹ 2000 онд 194 орныг хамруулсан судалгаа, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын байгууллагын болон хууль зүйн модель, Виктор Федотов, (Victor I. Fedotov, Organizational and legal models of chambers, Business associations study (2007))

Эх газрын загварын хувьд засгийн газрын эдийн засгийн сонирхлыг хэрэгжүүлэх, аж ахуй эрхлэгчийг дэмжих үндсэн дээр үүсэж хөгжсөн бөгөөд аж ахуйн үйл ажиллагаанд томоохон байр суурийг эзэлдэг. Энэхүү загварт улсын бүх аж ахуй эрхлэгчид заавал худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүн болж татвар төлдөг бөгөөд танхим нь төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна төрд ихээхэн баталгаажсан байр суурьтайгаар аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхлыг илэрхийлэх эрх хэмжээг хуулиар нь тусгайлан олгодог байна. Энэ загвар нь анх Франц улсад үүсэн Герман улсад ихээхэн хөгжсөн байдаг бол Казахстан улс 2013 онд энэхүү загварт шилжсэн байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд бусад улс оронд англи саксоны загвар болон эх газрын загварын онцлог шинжийг хослуулсан Азийн загвар болон Евро-Азийн загвар хэлбэржин тогтож байна.

Эх газрын загвар нь нийтийн эрх мэдлийн загвараас илүү либералчлагдсан бол Азийн загвар нь эх газрын загвараас илүү либералчлагдсан гэж үзэж болно. Энэхүү загварт гишүүнчлэл нь заавал болон сайн дурын хэлбэрийг хослуулсан холимог гишүүнчлэлийн загвартай бөгөөд энэхүү загварыг бий болсон гол зорилго нь олон улсын худалдааг хөгжүүлэх, жижиг бизнесийг дэмжих ажиллагаанд төр болон томоохон корпорацийн хүчин чадлыг дайчлахад байсан юм. Томоохон төлөөлөгч нар нь Япон, Кувейт, Сингапур болон Тайланд улс билээ.

Евро-Азийн загварын хувьд сайн дурын гишүүнчлэлтэй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бүс нутгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх, гишүүдийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой танхимын тогтолцоотой байна. Азийн загвартай харьцуулахад сайн дурын гишүүнчлэлтэй байдаг боловч эх газрын загварын жишгийг даган танхимын нэр, газар нутаг, үйл ажиллагааг хуулиар баталгаажуулдаг бөгөөд захиргааны байгууллагын чиг үүргийг мөн хэрэгжүүлдэг байна.

Үүнээс үзэхэд нийтийн эрх зүйд суурилсан эх газрын загвар, хувийн эрх зүйн суурилсан англи саксоны загвар болон уг хоёр загварын хэв шинж, онцлогыг хослуулах замаар хөгжсөн Азийн загвар болон Евро-Азийн загвар нь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж байна. Төлөөлөгч нь Гүрж, Монгол, Унгар, Польш зэрэг улс орнууд хамаарч байна.

2. Пост социалист улсууд дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хөгжлийн хандлага

Пост социалист улсад социалист тогтолцоотой байсан улс орнуудыг хамааруулан ойлгох бөгөөд эдгээрээс Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тогтолцоо бүхий улсууд нь нийтийн эрх мэдлийн загварт суурилж байв.

Харин 1990 оны үеэс социалист систем задран унаснаар пост социалист улсууд хувийн эрх зүйд суурилсан Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тогтолцооруу шилжих болсон байна. Улмаар пост социалист улсуудын ихэнх нь дараах үндсэн хоёр загварыг сонгосон. Нэгтдүгээрт, цэвэр хувийн эрх зүйд хамаарах Англи саксоны загвар, Хоёрдугаарт, Эх газрын загварын зарим шинжийг агуулсан боловч Хувийн эрх зүйд суурилсан Евро-Азийн загварыг баримталсан байна. Үүний шалтгааныг 1. Пост

социалист улсуудад эдийн засаг дахь төрийн оролцоог хумих үзэл баримтлал хүчтэй байсан, 2. Зах зээлийн болон худалдаа, аж үйлдвэрийн харилцааны хөгжил сул байсан, 3. Худалдаа, аж үйлдвэрийн харилцаа өндөр хөгжсөн Англи, Америк зэрэг нь хувийн эрх зүйд суурилсан Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тогтолцоотой байсантай холбон авч үзэж болох юм.

Монгол улсын хувьд ч 1960 онд Нийтийн эрх мэдлийн загварт хамаарах Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг үүсгэн байгуулсан байдаг. Харин Социалист систем задран унасны дараа бусад пост социалист улсуудын жишгээр 1995 онд Евро-Азийн загварын чиг баримжаа бүхий худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийг шинээр баталсан бөгөөд уг хууль нь өнөөг хүртэл үйлчилж байна.

Эндээс үзэхэд Монгол улсыг оруулаад бусад пост социалист улсууд нь ихэвчлэн англи саксон болон Евро-Азийг загварыг баримталж байна. Харин цаашид эдгээр улсууд нь өөрийн улсын эдийн засгийн хөгжлийг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүднээс эх газрын загвар болон азийн загварын чиг баримжаа бүхий Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тогтолцоонд шилжих боломж нээлттэй байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ОЛОН УЛСЫН ЖИШИГ

Энэхүү судлагаанд Эх газрын, Азийн болон Евро-Азийн чиг хандлагт хамаардаг дараах зургаан улсыг хамруулсан болно. Үүнд:

Эх газрын загвар:

1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
2. Бүгд Найрамдах Франц Улс
3. Бүгд Найрамдах Казахстан Улс
4. Бүгд Найрамдах Солонгос Улс

Азийн загвар:

5. Япон Улс

Евро-Азийн загвар:

6. Унгар Улс

НЭГ. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Наполеоны үеийн Францын эзлэн түрэмгийллээр Германы Ринланд мужид орчин цагийн хэв шинжийг агуулсан анхны Худалдаа, аж үйлдвэрийн танхим (цаашид “ХАҮТ” эсхүл ерөнхий “*Танхим*” гэх) байгуулагдсан бөгөөд түүний үндсэн чиг үүрэг нь төрийн удирдлагуудад аж үйлдвэрлэл болон худалдааг дэмжих талаар зөвлөгөө өгөх байв.

Герман улсын нутаг дэвсгэр Францудаас эрх чөлөөтэй болж Наполеоны хэв журмын нөлөө багассанаар өөрөө удирдах ёс бүхий ХАҮТ-ууд бий болж эхэлсэн ба 1848 онд Прусс улсын Хааны зарлигаар танхимын гишүүн аж ахуйн нэгж бүр танхимын удирдлагыг сонгох эрхийг анхлан албан ёсоор баталгаажуулсан байна.² Энэхүү Пруссын хуулийн дагуу бий болсон танхимын модель нь өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэн сонгууль явуулах, бие даасан санхүүжилтийн бүтэцтэй байхаас гадна гишүүддээ дэмжлэг үзүүлэх, гишүүд хоорондын харилцан туслалцааг дэмжих болон төрд зөвлөгөө өгөх үүргүүдэд ихээхэн ач холбогдол өгдөг байв.³ Гэвч, 1933 онд Үндэсний социалист дэглэм буюу нацизмын үеэр өөрөө удирдах ёс бүхий ХАҮТ-уудыг буулгаж Гау буюу дүүргийн эдийн засгийн танхимуудыг бий болгосон байна.⁴

1945 онд Дэлхийн хоёр дугаар дайн дууссанаар хуучны ХАҮТ-ын модель сэргэсэн боловч өмнөх дэглэмийн гажуудал болон Германыг эзэлсэн бусад улс орнуудын нөлөөгөөр ХАҮТ-ын эрх зүйн орчинд тодорхойгүй, замбараагүй байдал бий болсон байв.⁵

1956 оны 12 дугаар сарын 18-ны өдөр “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын урьдчилсан зохицуулалтын тухай”⁶ (цаашид “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль” гэх) холбооны хууль гарсанаар ХАҮТ-ийн эрх зүйн орчны ойлгомжгүй байдал эцэс болсон байна. Энэхүү хууль нь 15 зүйлтэй бөгөөд 1 – 11-р зүйл хүртэл танхимын үйл ажиллагаа, чиг үүрэг, эрх хэмжээ, гишүүнчлэл, санхүүжилт болон бүтцийг зохицуулсан байдаг бөгөөд 12 – 15-р зүйлүүдэд энэ хуулийг дагаж мөрдөх журмыг зохицуулдаг байна.

1. ГИШҮҮНЧЛЭЛ

ХАҮТ нь ХБНГУ-ын хуулийн дагуу байгуулагдсан корпораци юм (*Худалдаа, аж үйлдвэрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн (1)*). Өөрөөр хэлбэл нийтийн болон хувийн эрх зүйн институтын шинжийг нэгэн зэрэг агуулсан холимог институт юм.

Танхимын гишүүнд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 2 дугаар зүйлийн дагуу дараах этгээд хамаарна. Үүнд:

a) *Худалдааны татвар төлөгч бүх этгээд*

b) *Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2(1)-т “Аливаа Худалдаа, аж үйлдвэрийн танхимын нутаг дэвсгэр дээр үйл*

² Худалдаа, аж үйлдвэрийн танхимын байгууллагын болон хууль зүйн модель, Виктор Федотов, х 32 (Victor I. Fedotov, Organizational and legal models of chambers, Business associations study (2007)).

³ Худалдаа, аж үйлдвэрийн танхим-Чиг үүрэг, хуулийн зохицуулалт, Германы Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гарын авлага, (Chambers of Commerce and Industry, Functions and Legal Provisions, (2013))

⁴ мөн тэнд.

⁵ мөн тэнд

⁶ Хамгийн сүүлд 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орсон.

ажиллагаа явуулдаг, худалдааны татвар төлөх үүрэгтэй бүх хувь хүн, худалдааны нөхөрлөл болон компани, хувийн болон нийтийн эрх зүйн хуулийн этгээд болон бусад этгээд нь тухайн Худалдаа, аж үйлдвэрийн танхимд хамаарна (танхимын гишүүн)" гэж заасны дагуу бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг бүх байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн Танхимын гишүүн болох үүрэгтэй байна. Түүнчлэн танхимын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг гадаад улсын хуулийн этгээдийн салбар нэгж болон аливаа байгууллагын охин компани бие даан гишүүн болох үүрэгтэй байдаг байна.

с) Бизнес эрхэлдэг нутгийн захиргааны байгууллага өөрийн сонголтоор

Зөвхөн бизнесийн үйл ажиллагаа явуулдаг нутгийн захиргааны байгууллага эсхүл түүний холбоод нь Танхимын гишүүн болох эсэхээ сонгох эрхтэй (Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2(5)).

д) Бүртгэгдсэн хөдөө аж ахуй болон ойн аж ахуй эрхлэгч

Хөдөө аж ахуй болон ойн аж ахуй эрхэлдэг хувь хүн болон компани нь арилжааны бүртгэлд бүртгэгдсэн тохиолдолд заавал Танхимын гишүүн болох үүрэгтэй (Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2(2)).

е) Гар урлал болон түүнтэй холбоотой бус үйл ажиллагааныхаа хүрээнд гар урлалын мэргэжлийн этгээд

Гар урлалын мэргэжлийн танхимд хамаардаг хувь хүн, хуулийн этгээд болон нөхөрлөл нь гар урлал болон гар урлалтай холбоотой бус бизнесийн үйл ажиллагааныхаа хүрээнд Худалдаа, аж үйлдвэрийн танхимд хамаарна. Өөрөөр хэлбэл гар урлал болон гар урлалаас бусад төрлийн бизнесийн үйл ажиллагааг зэрэг явуулдаг этгээд нь Гар урлалын мэргэжлийн танхим болон Худалдаа, аж үйлдвэрийн танхимд давхар гишүүнчлэлтэй болдог байна. (Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2(3)).

Танхимын гишүүн бус этгээдэд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2(4)-ийн дагуу дараах этгээд хамаарна. Үүнд:

- a) Хөдөө орон нутгийн зээлийн нэгдэл, ихэнхи гишүүн нь фермер бол;
- b) Хөдөө аж ахуйн үйл ажиллагаагаа туслах, туслах бизнес хэлбэрээр явуулдаг ферм;
- c) Үндсэн үйл ажиллагаа нь хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж хамтран ашиглах, эсхүл хөдөө аж ахуйг тоног төхөөрөмжөөр хангах, эсхүл хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн түгээх, хадгалах, боловсруулах зорилго бүхий хоршоо;
- d) Холбооны засгийн газрын Эдийн засаг, технологийн яамны тогтоолоор баталсан хөрөнгийн хэмжээгээр iii-т заасан хөдөө аж ахуйн хоршоодын нэгдэл.

Заавал гишүүнчлэлийн ач холбогдол нь Танхимын бие даасан, тусгаар байдал болон санхүүжилтыг баталгаажуулдаг байна. Танхим нь аж үйлдвэрийн бүх салбаруудыг хамарч, том дунд жижиг хэмжээтэй бүх компаниудыг болон бүхий л

хэлбэрийн этгээдүүдийг хамруулж чаддаг. Бүгдийг хамруулах нь худалдаа, аж үйлдвэрлэлийн салбарыг бүхэлд нь төлөөлөх цор ганц арга гэж германчууд үздэг байна.

2. ТАНХИМЫН САНХҮҮЖИЛТ

Танхимын санхүүжилтын асуудлыг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлээр зохицуулдаг байна.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3(2)-т *"Худалдаа, аж үйлдвэрийн танхим үүсгэн байгуулах болон түүний үйл ажиллагааны зардлын төсвийг, бусад эх сурвалжаар санхүүжүүлээгүй тохиолдолд, бизнесийн төлөвлөгөөнд үндэслэн, татварын журмын дагуу гишүүдийн татвараас бүрдүүлнэ. Бизнесийн төлөвлөгөөг жил бүр гаргах ба төлөвлөгөөг эдийн засгийн болон санхүүгийн үр ашигтай менежментийн зарчим болон танхимын гишүүдийн санхүүгийн бололцоонд суурилан боловсруулна"* гэж заасан байдаг. Энэ нь Танхим төлбөр болон бусад орлогоор санхүүжилтээ бүрдүүлж болдог гэсэн үг ба Танхимын нийт зарлагад эдгээр орлого хүрлцэхгүй тохиолдолд гишүүн компаниудын татвараар нөхөж болдог байна. Өөрөөр хэлбэл Танхимын зардлыг нэн тэргүүнд гишүүдийн татвараас бус өөр эх үүсвэрээр бүрдүүлдэг бөгөөд хүрэлцэхгүй тохиолдолд зөвхөн бизнес төлөвлөгөөний дагуу гишүүдийн татвараар төлдөг байна. Энэхүү татвар нь олон нийтийн үүрэг гэж үздэг бөгөөд Танхимын олон нийтийн үйлчилгээ болон бизнесийн ерөнхий ашиг сонирхлыг хамгаалахад зориулдаг байна.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3(3)-ийн дагуу гишүүнчлэлийн татварыг гишүүнчлэлийн суурь хураамж болон ноогдуулсан хураамжийн хэлбэрээр авдаг байна. Татварын хэмжээг Танхим бүр өөрийн онцлог, зарлага, гишүүнчлэлийн тоо зэрэг дээр үндэслэн бие даан тогтоодог байна. Гишүүнчлэлийн татварыг дараах хэлбэрээр тогтооно. **Үүнд:**

- a) Гишүүнчлэлийн суурь хураамжийг тухайн байгууллагын бизнесийн үйл ажиллагааны төрөл, хүрээ болон санхүүгийн чадварт үндэслэн тогтоодог ба тухайн нутгийн Танхимаас шалтгаалан жижиг компаниас 20 еврогоос эхлэн том хэмжээний корпорациас 50,000 евро хүртэл авдаг байна.
- b) Гишүүн бүр суурь хураамжаас гадна ноогдол хураамжийг төлөх ба тухайн Танхимаас шалтгаалан ашиг орлогын 0.05% - 0.39% хүртэл буюу дунджаар 0.22% тогтоодог байна. Бизнес эрхлэгч хувь хүн болон аж ахуйн нэгж нь хуулийн дагуу 15,430 евро хүртэл хэмжээгээр энэхүү ноогдол хураамжаас чөлөөлөгддөг байна.
- c) Танхимд бүртгэлтэй гар урлалын мэргэжлийн хувь хүн болон аж ахуйн нэгжийн гар урлалтай холбоогүй үйл ажиллагаанаас олсон ашиг орлого нь 130,000 еврогоос давсан тохиолдолд гишүүнчлэлийн татвар төлнө.
- d) Эмийн сангийн өмчлөгчид нь нийт орлогын 25%-д тэнцэх дүнгээс тооцож гишүүнчлэлийн суурь хураамж болон ноогдол хураамжийн хэмжээг тогтооно. *(Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3(4))*
- e) Танхимын гишүүн болох бие даан мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг этгээд, тухайн Танхимын нутаг дэвсгэр дээр хөдөө аж ахуй эсхүл ойн аж ахуй эрхэлдэг этгээд, тухайн Танхимын нутаг дэвсгэр дээр цэнгэг усны загасны аж ахуй эрхэлдэг этгээд нь нэг болон хэд хэдэн танхимд татвар төлдөг бол орлогын

10%-д тэнцэх дүнгээс тооцож гишүүнчлэлийн суурь хураамж болон ноогдол хураамжийн хэмжээг тогтооно. (Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3(4))

Гишүүдийн татварыг дараах хэлбэрээр чөлөөлж болдог байна. Үүнд:

- а) Арилжааны бүртгэлд ороогүй орлого нь 5,200 еврогоос бага хувь хүн, аж ахуйн нэгж татвараас чөлөөлөгдөнө
- б) Шинээр бизнесийн үйл ажиллагаа эхлүүлсэн, Арилжааны бүртгэлд ороогүй, орлого нь 25,000 еврогоос бага хувь хүн үйл ажиллагаа эхэлсэнээс эхний хоёр жил гишүүнчлэлийн суурь хураамжаас, эхний дөрвөн жил ноогдуулсан хураамжаас тус тус чөлөөлөгдөнө. Хөдөө аж ахуй болон ойн аж ахуй эрхэлдэг эсхүл үйл ажиллагаа эхлүүлэхээс тав хүртэлх жилийн хугацаанд хязгаарлагдмал компанид арваас дээш хувийн хувьцаа эзэмшдэг хувь хүнд энэ нөхцөлд хамаарахгүй байна.

Гэхдээ дээрхи чөлөөлөлтөөс болж Танхимын орлого 55 болон түүнээс дээш хувиар багасах тохиолдолд Танхим нь дээрх орлогын доод хэмжээний босгыг багасгах эрхтэй бөгөөд Танхимын гишүүд хуулийн дагуу төлөх татварын хэмжээг тогтооход шаардлагатай бүхий л баримт бичиг, мэдээллийг Танхимд гаргаж өгөх үүрэгтэй ба Танхим нь эдгээр баримт бичгүүдийг хянан шалгах эрхтэй байна.

Бусад орлого:

- а) Гишүүний бизнес нь Танхимын эзэмшлийн барилга байгууламж эсхүл аливаа байгууллагаас тусгайлан үр ашиг хүртдэг бол үүний хариуд Танхимд *Тусгай татвар* төлнө (Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3(5)).
- б) Танхимын эзэмшлийн барилга байгууламж эсхүл байгууллагыг ашигласан тохиолдолд ашиглалтын төлбөр авч болно (Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3(6)).

Журам:

Танхим нь санхүүжилт бүрдүүлэхдээ Гишүүнчлэлийн татвар авах журам, Тусгай татварын журам болон Ашиглалтын төлбөрийн журам гэх гурван журмыг батлах үүрэгтэй бөгөөд энэхүү журмуудад гишүүнийг татвар, төлбөр болон зардлаас чөлөөлөх, тэдгээрийг багасгах нөхцлийг заавал оруулахыг шаарддаг байна (Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3(7)).

ХБНГУ-д танхимын гишүүнчлэл нь заавал байдаг тул танхимд төлөх татвар нь мөн адил албадлагын шинжтэй байдаг. Иймд Танхимын татвар, төлбөр авах журам, танхимын бизнес төлөвлөгөө зэрэг санхүүтэй холбоотой бүх ажиллагаанууд заавал хуулийн дагуу явагдах ёстой тул Худалдаа, аж үйлдвэрийн тухай хуулинд ямар асуудал ямар хууль, журмаар зохицуулагдахыг тодорхой заасан байдаг байна. Үүнд:

- а) Танхимын бизнес төлөвлөгөө, жилийн санхүүгийн тайлан болон тэдгээрийн нягтлан бодох бүртгэл, нэхэмжлэл, бүрдүүлэлт болон гүйцэтгэл зэрэг нь Арилжааны хуулийн гуравдугаар дэвтэрт заасны дагуу болон нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудад тулгуурласан байхыг шаарддаг байна. Түүнчлэн эдгээр нь танхимын дүрэм болон төрийн төсвийн эрх зүйн зарчмуудад нийцсэн байхыг шаарддаг байна. (Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3(7а)).

- б) Гишүүнчлэлийн татвар, тусгай татвар болон ашиглалтын төлбөрийн хөөн хэлэлцэх хугацаа нь Татварын хуулийн орлого болон эд хөрөнгийн татварын хөөн хэлэлцэх хугацааны журмыг мөрдөнө (*Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3(8)*).
- с) Түүнчлэн эдгээр татваруудыг хураах, цуглуулахтай холбоотой асуудлыг Холбооны мужийн орон нутгийн татварын журмыг баримтлах бөгөөд татвар хураах, цуглуулах үйл ажиллагаа болон хариуцлагыг Холбооны мужуудын хуулийн дагуу өөр өөрөөр зохицуулж болно гэж заасан байна (*Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3(8)*).

3. ТАНХИМЫН ЧИГ ҮҮРЭГ

ХАҮТ-ын чиг үүргийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1(1)-д *"Худалдаа, аж үйлдвэрийн танхимууд нь өөрийн бүс нутагт оршиж буй бизнесийн нийтлэг ашиг сонирхлыг төлөөлөх, хувиараа аж ахуй эрхлэгч болон аж ахуйн нэгжийн ашиг сонирхлыг тэнцвэртэй байдлаар анхаарах замаар аж үйлдвэр, худалдааг дэмжих үүрэгтэй. 1953 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр батлагдсан Урлах мэргэжлийн зохицуулалтын тухай хуулийн дагуу гар урлалын мэргэжлийн байгууллагууд энэхүү заалтанд хамаарахгүй болно. Түүнчлэн төсөл, мэргэжлийн санал болон мэдээлэл өгөх хэлбэрээр төрийн байгууллагад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх болон боловсон, ёс зүйт бизнесийн практикийн зарчмуудыг хамгаалж ажиллах нь тэдгээрийн үүрэг мөн болно"* гэж зохицуулсан байна.

Ийнхүү чиг үүргийг ерөнхийлөн томъёолсноор танхимуудад тухайн цаг үеийн эдийн засгийн нөхцөл болон тухайн нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан үйл ажиллагаагаа уян хатан, хараат бусаар явуулах боломжийг нь олгодог байна. Танхим нь өөрийн гишүүн компанийн эрх ашгийг хамгаалах, нутаг дэвсгэрийн хүрээнд аж үйлдвэрээ дэмжих ёстой бөгөөд ингэхдээ салбар бүрийн ашиг сонирхлыг харгалзах үүрэгтэй байдаг байна. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 1(1) дүгээр зүйлийн дагуу ХАҮТ нь *"ариун шудрага бизнес эрхлэгчийн ёс журам болон ёс суртахууныг сахин хамгаалах"* үүрэгтэй гэж заадаг. Энэхүү үүргийг ХАҮТ нь практикт хууль бус зар сурталчилгаа явуулсан компаниудыг мэдээллэх, тэдгээрийн зөрчилд сануулга өгөх зэрэг арга хэмжээ авч шудрага бус өрсөлдөөнтэй тэмцэх, хууль, эрх зүйн орчны талаар компаниудад мэдээлэл өгөх, мөнгө угаах болон авилгын эрсдлийн талаар зөвлөгөө өгөх хэлбэрээр хэрэгжүүлдэг байна.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1(3а)-д *"Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд Холбооны мужууд нь захиргааны байгууллагын чиг үүргийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимд хуулийн дагуу шилжүүлж болно. Энэ хууль нь тухайн хуваарилсан үйл ажиллагааны хүрээг зохицуулна. Энэ зүйлд заасан үйл ажиллагааны хүрээнд Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь гишүүн бус этгээдэд үйлчилнэ. Хяналтыг энэ хуулийн дагуу хэрэгжүүлнэ"* гэж заасны дагуу захиргааны байгууллагын чиг үүргийг ХАҮТ-ууд гүйцэтгэж болдог байна.

Дээрхийн дагуу, ХБНГУ-д ХАҮТ нь 50 гаруй хуулийн тусгайлсан зохицуулалтын дагуу захиргааны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд зарим нь зөвхөн ХАҮТ-ын л эрх хэмжээнд хамаарах үүргүүд байдаг байна.

ХАҮТ-ын чиг үүргийг таван үндсэн хэсэгт хувааж болно. Үүнд: (1) Эдийн засаг болон хууль зүйн үнэлгээ, (2) шинжээчийн дүгнэлт гаргах, (3) дэмжлэг үзүүлэх, (4) мэргэжлийн сургалт зохион байгуулах болон (5) захиргааны үйл ажиллагаа хамаардаг байна.

1. Эдийн засаг болон хууль зүйн үнэлгээ

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1(1)-ийн дагуу танхим нь төрийн үйл ажиллагааны бүх шатанд эдийн засаг болон хууль зүйн асуудлуудад үнэлгээ өгөх хэлбэрээр нийгмийн санал бодлыг илэрхийлдэг байна. Орон нутгийн хэмжээнд танхим нь орон нутгийн төсөв, худалдааны татварын хэмжээ, барилга, хот тохижилтын төлөвлөгөө, дэд бүтэц болон байгаль орчин хамгаалах зэрэг асуудлуудаар санал өгөх эрхтэй байдаг. Холбооны хэмжээнд Танхимууд нь холбооны засгийн газар болон яамдуудтай нягт холбоотой ажиллаж бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөө, бизнесийн хөгжлийн төлөвлөгөө болон замын төлөвлөлт зэрэгт оролцдог байна.

Үндэсний хэмжээнд танхимууд нь дээд байгууллага болох Германы Худалдаа, аж үйлдвэрийн танхимаараа дамжуулан Холбооны засгийн газрын, Европын болон олон улсын эдийн засгийн бодлогод нөлөөлдөг байна. Холбооны холбогдох яам, парламентийн хороод болон холбогдох Европын институциуд худалдаа, аж үйлдвэрлэлтэй холбоотой хууль эсхүл тогтоол гаргах тохиолдолд Танхимтай зөвлөлдөх үүрэгтэй байна. Энэ тохиолдолд Танхим нь мэргэжлийн компани болон тухайн хууль, тогтоолоор эрх ашиг нь хөндөгдөж буй бизнесүүдтэй зөвлөлдөж, дараагаар нь танхимын мэргэжлийн хороодуудтай нарийвчилсан хэлэлцүүлэг хийдэг байна. Эцэст нь, Нэгдсэн хурал эсхүл Удирдах зөвлөл дээр эцсийн байр сууриа тодорхойлж төрийн байгууллагуудад хүргүүлдэг байна.

2. Шинжээчийн дүгнэлт гаргах

Танхимууд нь эдийн засгийн бодлого болон эрх зүйн асуудлаар нийгмийн дуу хоолойг хүргэхээс гадна, шүүх болон захиргааны байгууллагад тодорхой асуудлаар шинжээчийн дүгнэлт гаргаж өгдөг байна. Тухайлбал, Арилжааны бүртгэлд бүртгэгдсэн компанийн мэдээлэллийн үнэн зөв, тодорхой байдлыг баталгаажуулдаг. Худалдааны заншил болон шилдэг туршлага (best practice), барааны тэмдэгт болон худалдааны стандартын хэрэглээний талаар шинжээчийн дүгнэлт гаргадаг. Түүнчлэн төрийн зээл болон худалдааны захиалга найдвартай эсэх талаар төрийн байгууллагад зөвлөгөө өгдөг байна.

3. Дэмжлэг үзүүлэх

Аж ахуйн нэгжүүд бие даан өөрийн удирдлага хэрэгжүүлэх зорилгоор ХАҮТ хэлбэрээр нэгддэг. Иймд Танхимын дэмжлэг үзүүлэх нь дотоод үйл ажиллагаад тооцогддог бөгөөд танхим нь өөртөө туслах хэлбэрээр энэхүү чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Үүнд нь гишүүн компаниудад мэдээлэл өгөх ажил нэн тэргүүний ээлжинд хамаардаг. Үндэсний хэмжээнд томоохон эргэлттэй Танхимын сэтгүүлүүд 2,6 сая хүртэлх тоогоор хэвлэгддэг бөгөөд цахим хуудас хөтөлж, цахим мэдээллийн товхимолыг гишүүддээ илгээдэг байна. Мөн тодорхой сэдэв эсхүл шинээр батлагдаж буй хуулийн талаар мэдээллийг хүргэж семинар, хэлэлцүүлэг болон бусад арга хэмжээг зохион байгуулдаг байна. Танхим нь гадаад худалдаа болон хууль зүйн асуудлын талаарх мэдээлэлд их ач холбогдол өгч ажилладаг.

Танхим нь жижиг дунд бизнес эрхлэгчидэд гадаад худалдаа, инноваци, патентын талаар, шинэ аж ахуйн нэгжийн анхан шатны зөвлөгөө болон гарааны бизнес буюу старт-ап бизнесийн зөвлөгөө зэргийг өгдөг байна. Түүнчлэн гишүүдэд тулгарсан аливаа асуудлын талаар анхан шатны зөвлөгөө өгдөг боловч хууль ёсны төлөөлөл хийдэггүй харин мэргэжлийн туслалцаа авах талаар чиглэл өгдөг.

4. Мэргэжлийн сургалт зохион байгуулах

1920, 30-иад оноос ХАҮТ нь компанийн дотоод мэргэжлийн сургалтын тогтолцоог бий болгож ажлын байрны танилцуулгын бүртгэлийг хөтлөх болсон байна. 1969 онд Мэргэжлийн сургалтын тухай хууль батлагдсанаар Танхим нь мэргэжлийн сургалтын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх болсон байна.

Түүнчлэн Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1(2)-т *“Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь аж үйлдвэрлэл, худалдаа эхсүл бизнесийн аль нэг салбарт дэмжлэг үзүүлэх, түүнчлэн холбогдох хуулийн дагуу, ялангуяа Мэргэжлийн сургалтын хуульд нийцүүлэн бизнесийн болон мэргэжлийн ур чадварыг бэлтгэх үйл ажиллагаа явуулах болон дэмжих зорилгоор аливаа байгууламж болон байгууллага байгуулах, тэтгэх болон дэмжлэг үзүүлж болно”* гэж заасны дагуу Танхим нь өөрөө сургалтын үйл ажиллагаа явуулаад зогсохгүй сургалтын байгууллага бий болгох эсхүл бусад байгууллагыг дэмжиж болдог байна.

Танхим нь сургалт зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд мэргэжлийн сургалтын бүртгэлд бүх сургалтын гэрээг бүртгэдэг байна. 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 850,000 гаруй гэрээ бүртгэгдсэн байна. Холбогдох журмын дагуу сургалтын гэрээ бүртгэгдэсний дараа сургалт хүсэж буй компани болон сургагч багшийг олж, тэдгээр хоорондоо тохирох эсэхийг шинжилсэний үндсэн дээр талууд сургалт авах гэрээ байгуулдаг байна. Сургалт дууссаны дараа танхим сургачдаас шалгалт авч сертификат өгөх эрх хэмжээтэй байна. Шалгалтын материал болон шалгууруудыг төв байгууллагаас нэгдсэн байдлаар тогтоодог учир Танхим бүрээс олгогдсон сертификатууд нь ХБНГУ даяар хүчинтэй байдаг байна.

Аж үйлдвэр хурдацтай хөгжиж байгаатай холбогдуулан шинэ чадвартай ажилчид болон менежерүүд шаардлагатай болсон тул Танхимууд маш өргөн сонголттой сургалтын арга хэмжээнүүдийг санал болгодог болсон байна. Энэхүү курс сургалтуудад сууснаар Танхимаас сертификат олгодог бөгөөд ажлын байран дээр эрэлттэй байгаа мэргэжлийн болон практикийн ур чадваруудыг цогцоор нь сургадаг байна. Түүнээс гадна Танхимууд нэг өдрийн семинар зохион байгуулж мэргэжлийн ур чадваруудыг шинэчлэх, сайжруулах, өргөсгөх боломжийг олгодог байна. Өөрөөр хэлбэл Танхим нь жижиг дунд бизнесийн менежерүүдэд өөрийн туршлага болон сурсан ур чадваруудаа солилцох боломжийг олгодог форум болсон юм.

5. Захиргааны үйл ажиллагаа

Танхимуудад хууль болон тогтоолын дагуу төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх эрхийг олгодог байна. Энэхүү чиг үүрэг нь Танхимын өөрөө удирдах ёсны нэг хэсэг болох бөгөөд Танхим бие даан, хараат бусаар хэрэгжүүлдэг байна. Дээрх чиг үүргүүдэд арбитрын үйл ажиллагаа явуулахаас гадна худалдаа болон аж ахуйн эрх зүйн зохицуулалтын тусгай шинжилгээ явуулах, барьцааны үйлчилгээ болон анхлан нээж буй зоогийн газруудад зааварчилгаа өгөх зэрэг чиг үүргүүд хамаарна. 2007 оноос Танхимууд нь даатгалын төлөөлөгчийн зөвшөөрлийг гаргах эрхийг авсан бөгөөд тэдгээрийн чадварыг шалгах, бүртгэх үйл ажиллагааг явуулдаг байна. 2013 оноос Танхим нь санхүүгийн хөрөнгө оруулалтын төлөөлөгч нарыг бүртгэж ур чадварыг нь шалгах чиг үүрэгтэй болсон байна.

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1(3)-т *“Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь, хуулийн дагуу бусад байгууллагад шилжүүлээгүй тохиолдолд, гарал үүслийн гэрчилгээ болон худалдаатай холбоотой*

бусад баримт бичгийг гаргах үүрэгтэй болно" гэж заасны дагуу гадаад худалдааны хүрээнд Танхим нь гарал үүслийн гэрчилгээ гаргах, олон улсын худалдаанд шаардлагатай баримт бичгүүдийг гэрчлэх болон арилжааны нэхэмжлэлийг баталгаажуулах ажлыг хийдэг байна. Танхимууд нь олон улсын гаалийн батлан даагчдын сүлжээний гишүүд бөгөөд түр хугацааны экспортын зөвшөөрөл олгодог байна.

Түүнчлэн Танхим нь 250 гаруй салбарын албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн зөвлөхүүдийг томилж тангараг өргүүлэх ажлыг зохион байгуулдаг байна. Эдгээр зөвлөхүүдийг сонгон шалгаруулж тасралтгүй мониторингоор хянадаг бөгөөд 8,000 гаруй баталгаатай зөвлөхүүдийг бүртгэж авсан байдаг байна. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1(4)-т *"Хууль эсхүл тогтоолоор бусад чиг үүргийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимд шилжүүлж болно"* гэж заасны дагуу ХАҮТ-д захиргааны чиг үүргийг хуулиар эсхүл тогтоолоор бүрэн шилжүүлэх боломжийг нээлттэй олгож зохицуулсан байна.

Мэдээлэл цуглуулах:

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14(8) 1 болон 2 дугаар заалт болон Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14(14)-ийн дагуу гарсан тогтоолын дагуу Танхим нь үйл ажиллагаагаа явуулах зорилгоор гишүүдээсээ мэдээлэл цуглуулах эрхтэй боловч эдгээр мэдээллийг хэрхэн ашиглах талаар Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 9 дүгээр зүйлд нарийвчлан зохицуулсан байна. **Үүнд:**

- a) Танхим нь Аж үйлдвэрийн тухай хуульд заасан мэдээллээс гадна гишүүдээсээ бүтээгдэхүүн, үйлчилгээнийх нь талаарх болон байгууллагын хэмжээ, төрлийн талаар мэдээлэл авч болно. *(9(1)-р зүйл)*
- b) Гишүүний талаарх дээрх мэдээллийг зөвхөн түүний өмчлөгч, хуулийн дагуу итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд болон Арилжааны бүртгэлд бүртгэлтэй тусгайлан томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч болон тусгай эрх бүхий төрийн албан тушаалтан өгөх эрхтэй. *(9(1)-р зүйл)*
- c) Дараах тохиолдолд олон нийтийн бус газраас болон нээлттэй эх үүсвэрээс мэдээлэл цуглуулж болно. **Үүнд:**
 - Хэрэгжүүлж буй захиргааны чиг үүргийн хэлбэрээс эсхүл тухайн асуудлын онцлогоос шалтаалан асуулга явуулах шаардлагатай болсон;
 - Мэдээллийн субъект болсон этгээдээс мэдээлэл авахад их хэмжээний хүчин чармайлт гарах шаардлагатай эсхүл амжилт олох боломжгүй бол;
 - Мэдээлэл нь нээлттэй эх үүсвэрт тавигдсан бол. *(9(1)-р зүйл)*
- d) Танхим нь Холбооны мэдээлэл хамгаалах хуулийн 2 дугаар зүйлийн 2(2)-ийн хүрээнд төрийн байгууллага гэж үзэгддэг учир Танхимын гишүүн үйл ажиллагаа явуулж байгаа эсэх болон түүний татварын хэмжээг тогтоох зорилгоор холбогдох төрийн санхүүгийн байгууллагаас гишүүний худалдааны татварын үнэлгээ болон татварын үнэлгээний эх үүсвэр буюу татварт ноогдох орлого, эд хөрөнгө зэргийн талаар мэдээлэл авах эрхтэй байна. *(9(2)-р зүйл)*
- e) Дээрхид заасан мэдээллүүдийг Танхим нь зөвхөн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд заасан үйл ажиллагаа явуулахад ашиглана. Хуулийн 9(1)-р зүйлд зааснаас бусад мэдээллийг зөвхөн бусад хуулиар зөвшөөрөгдсөн тохиолдолд цуглуулж болох бөгөөд зөвхөн тухай хуулийн зорилгод нийцүүлэн ашиглана. *(9(3)-р зүйл)*

- f) Танхим нь бусад Худалдаа, аж үйлдвэрийн танхимуудад, тэдгээрийн хуульд заасан эрх, үүргийг гүйцэтгэхэд туслах зорилгоор, гишүүний нэр, хаяг, үйл ажиллагааны төрөл болон 9(1)-р зүйлд заасан мэдээллийг шилжүүлж болох бөгөөд хүсэлт гаргагч Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь бичгэн хүсэлтэндээ дараах мэдээллийг оруулна. Үүнд:
- Мэдээлэл шилжүүлэн авах шалтгаан болон зорилго;
 - Мэдээлэл шилжүүлэх газар;
 - Шилжүүлэх мэдээллийн төрөл;
 - Мэдээлэл хадгалах журмын дагуу авч хэрэгжүүлэх техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээ зэрэг байна. (9(4)-р зүйл)
- g) Танхим нь гишүүнийхээ бизнесийг дэмжих болон арилжааны бусад зорилгоор гишүүнийхээ нэр, хаяг, үйл ажиллагааны төрлийн талаарх мэдээллийг захиргааны бус байгууллагуудад шилжүүлж болох бөгөөд бусад мэдээллийг тухайн гишүүний зөвшөөрлийг авснаар шилжүүлж болно. (9(5)-р зүйл)
- h) Танхим нь гишүүнийхээ мэдээллийг захиргааны бус байгууллагуудад шилжүүлэх тохиолдолд түүнд бичгээр мэдэгдэж татгалзах эрхээр нь хангана. (9(5)-р зүйл)
- i) Нэгдсэн хурлын сонгуульд өрсөлдөх болсон мөн өрсөлдөх хүсэлтэй Танхимын гишүүнд түүний сонгуулийн тойрогт орсон гишүүдийн мэдээллийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах зорилгоор өгч болох бөгөөд зөвхөн зориулалтын дагуу ашиглах ёстой ба сонгууль дууссаны дараа заавал устгах ёстой байна. (9(6)-р зүйл)
- j) Холбооны мэдээлэл хамгаалах хуулиуд нь 9(1) болон 9(2)-р зүйлд заасны дагуу цуглуулсан болон 9(1)-ий дагуу шилжүүлсэн мэдээллийг өөрчлөх, боловсруулахыг хязгаарлах, устгахад хамаарна. (9(7)-р зүйл)

Чиг үүргээ бусад танхимд шилжүүлэх:

Танхим нь өөрийн дүрмийн дагуу эсхүл хуулийн дагуу хэрэгжүүлэх чиг үүргээ бусад танхимд шилжүүлэх, эсхүл бусад танхимтай холбоо байгуулах замаар хамтран хэрэгжүүлэх боломжтой. (10(1)-р зүйл) Хуулиар хориглосноос бусад тохиолдолд өөр өөр мужуудад байршилтай танхимууд мөн адил энэхүү холбоонд нэгдэж болдог байна. (10(3)-р зүйл)

Танхимуудын байгуулсан холбооны чиг үүрэг, үйл ажиллагааг холбооны дүрмээр зохицуулна. (10(2)-р зүйл) Танхим нь хуулийн дагуу заавал хэрэгжүүлэх чиг үүргээ бусад танхим эсхүл танхимуудын холбоонд шилжүүлэх тохиолдолд төрөөс зөвшөөрөл авдаг байна.

4. ДОТООД БҮТЭЦ

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын удирдлагад Нэгдсэн хурал, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал нар багтана.

Танхимын удирдах дээд байгууллага нь Нэгдсэн хурал бөгөөд Нэгдсэн хурал нь Удирдах зөвлөл, түүний Ерөнхийлөгчийг (6(1)-р зүйл) сонгож Гүйцэтгэх захирлыг томилох (7(1)-р зүйл) бөгөөд шаардлагатай тохиолдолд бусад зөвлөлийг мөн байгуулна (8-р зүйл). Түүнээс гадна Нэгдсэн хуралд тусгай саналын хороодыг (special voting groups) байгуулдаг ба эдгээр бүлгүүдийг Танхимын хариуцсан газар нутгийн эдийн засгийн онцлог болон тухайн бүлгийн эдийн засгийн ач холбогдолоос шалтгаалан бүлэг болон түүний гишүүдийн тоог тогтоодог байна (5(3)-р зүйл).

Танхимын нийт гишүүд Нэгдсэн хурлын гишүүдийг сонгох (5(1)-р зүйл) бөгөөд тухайн танхимын дүрмээс шалтгаалан 4,5 эсхүл 6 жилээр сонгогддог ба гишүүдийн тоо нь тухайн газар нутгийн эдийн засгийн бүтцээс шалтгаалан харилцан адилгүй байдаг байна.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар Танхимын Нэгдсэн хурал дараах асуудлыг шийдвэрлэх эрхтэй байна. Үүнд:

- Танхимын дүрэм батлах;
- Сонгуулийн журам, гишүүнчлэлийн татварын журам, тусгай татварын журам болон төлбөрийн журам батлах;
- Бизнес төлөвлөгөөг батлах;
- Гишүүнчлэлийн татвар болон тусгай татварын хэмжээг батлах;
- Тайлан хүлээн авах;
- Бусад Худалдаа, аж үйлдвэрийн танхимд үүрэг (үйл ажиллагаа) шилжүүлэх, хүлээн авах, хуулийн дагуу холбоо байгуулах болон тухайн холбоонд оролцох болон энэхүү хуулийн 1(3b)-д заасан байгууллагад оролцох;
- Олон нийтэд мэдээлэл зарлах журам;
- Энэхүү хуулийн 3(7a)-д заасан санхүүгийн дүрэм.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5(2)-ын дагуу Нэгдсэн хурлын гишүүнд дараах шаардлагыг хангасан этгээд сонгогдох эрхтэй. Үүнд:

- Танхимд санал өгөх эрхтэй;
- Сонгуулийн өдрийн байдлаар насанд хүрсэн байх;
- Танхимийн хувь гишүүн эсхүл Танхимын гишүүн байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд. Түүнчлэн, Худалдааны бүртгэлд бүртгэгдсэн Танхимын гишүүний төлөөлөх эрхтэй итгэмжлэгдсэн төлөөлөгч болон тусгай эрх бүхий төрийн албан тушаалтан.

Танхим бүр сонгуулийн журамтай байх бөгөөд энэхүү журам нь дараах асуудлуудыг зохицуулсан байх ёстой байна (5(4)-р зүйл). Үүнд:

- Идэвхитэй болон идэвхигүй санал өгөх эрх;
- Санал хураалтын үйл ажиллагаа;
- Нэгдсэн хурлын гишүүнчлэлийн хугацаа;
- Нэгдсэн хурлын гишүүнчлэл дуусгавар болох нөхцөл;
- Тусгай саналын хороодын тоо;
- Тусгай саналын хорооны гишүүдийг хуваарилах, тэдгээрийн Нэгдсэн хурал дахь суудлын тоо зэрэг асуудлуудыг тусгадаг байна.

Танхимын Ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэх бөгөөд Нэгдсэн хурлыг зарлаж түүнийг даргалах үүрэгтэй.

Танхимын гүйцэтгэх захирлыг Нэгдсэн хурал томилох ба Танхимын дүрэмд нарийвчлан заасан журмын дагуу гүйцэтгэх захирал болон ерөнхийлөгч нар нь бүхий л эрх зүйн хэлцэл, гэрээнд болон шүүхийн өмнө Танхимыг итгэмжлэлгүйгээр төлөөлнө.

5. ТӨРИЙН ХЯНАЛТ

ХБНГУ-д Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь төрийн институт гэж үздэг учраас төрийн хяналтанд хамаардаг байна. Холбооны мужийн Эдийн засгийн яамдууд нь Танхимын зөвхөн хууль болон танхимын дүрмээ (*төрийн институт гэж үздэг тул танхимын журам, сонгуулийн журам, татварын зэрэг журмууд нь заавал биелэх шинжтэй байдаг байна*) зөрчсөн тохиолдолд л түүний үйл ажиллагаанд оролцох эрхтэй байна. (11(1)-р зүйл)

Танхимын дүрмүүд болон сонгуулийн, гишүүнчлэлийн татварын, тусгай татварын болон төлбөрийн журмуудыг Холбооны муж батладаг байна. (11(2)-р зүйл) Түүнээс гадна, танхим нь өөрийн хэрэгжүүлэх чиг үүргээ бусад танхим эсхүл танхимуудын холбоонд шилжүүлэх тохиолдолд төрөөс зөвшөөрөл авдаг ба эдгээр холбоодын дүрмийг Холбооны муж мөн баталдаг. (11(2), 11(2a) болон 11(2b)-р зүйл) Төрийн байгууллага нь Танхимын өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд баталгаа болгох үүднээс түүний хүний нөөц, санхүү болон зохион байгуулалтаа бие даан өөрөө удирдах ёсны баталгаа болгон эдгээр асуудлуудад нь оролцдоггүй байна.

ХОЕР. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛС

Францын Марсельд 1599 онд хамгийн анхны худалдааны танхим бий болсон түүхтэй бөгөөд энэ нь өдгөөгийн Францын Худалдаа, аж үйлдвэрийн танхим (Chambres de commerce et d'industrie France)-ын эхлэл болсон байна⁷.

Марсель дахь анхны худалдааны танхимаас хойш 1700 - 1724 оны хооронд Dunkirk, Lyon, Rouen, Toulouse, Bordeaux гэх мэт газруудад хэд хэдэн танхим нээгдэж, 1761 онд анх удаа үйлдвэрлэгч нар өөрсдийн гэсэн танхимын төлөөллийг байгуулсан байдаг байна. Энэ нь Францын хуучин дэглэм (l'Ancien Régime)-ийн үеийн хамгийн сүүлийн худалдааны танхим байжээ⁸. 1789 оноос эхэлсэн Францын хувьсгалын нөлөөгөөр Loi Le Chapelier (14 June 1791) буюу Ле Шателье хууль батлагдаж, Францын хуучин дэглэм (l'Ancien Régime)-ийн үеийн худалдааны танхимыг хориглосон байна⁹. Үүний дараа 1802 оноос дахин 22 худалдааны танхимыг Наполеоны үед байгуулж, 1803 онд Парисын худалдааны танхим байгуулагдаж, 1898 оноос хуулийн дагуу худалдааны танхимын тогтолцоог бүрэн хуульчилжээ.

Одоогийн Францын худалдаа, аж үйлдвэрийн танхим нь 2000 онд батлагдсан Францын худалдааны хуулийн дагуу зохицуулагдаж байгаа бөгөөд шинээр бизнес эхлүүлэх, Европ болон Олон улсын хамтын ажиллагаа, инноваци, сургалт, ажил эрхлэлтийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж, 4,000 инновацийн төсөл хэрэгжүүлж, 30,000 жижиг, дунд аж ахуйн нэгж хамтран ажиллаж байна.

Өдгөө Франц улсад Францын худалдаа, аж үйлдвэрийн танхим (цаашид CCI France гэх) нэг, бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхим 18, үүнээс 5 нь далайн чанад дахь бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхим, нийт 107 нутаг дэвсгэрийн худалдаа, аж үйлдвэрийн танхим, үүнээс Франц арал муж дахь 6 мужийн танхим, Artois, Grand Lille, Grand Hainaut, Littoral Hauts de France and Beaujolais гэсэн 5 газарт орон нутгийн танхим, далайн чанад дахь 6 орон нутгийн байгууллага ажиллаж байна.¹⁰

Франц Улсад Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь Францын Арилжаа (Худалдаа)-ны хуулиар зохицуулагддаг бөгөөд энэхүү хуулинд хамгийн сүүлд 2019 оны 5-р сарын 22-нд нэмэлт, өөрчлөлт орсон байна.

1. ТАНХИМЫН ГИШҮҮНЧЛЭЛ

Францын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хувьд хэд хэдэн шатлал бүхийн сүлжээг байгуулсан байх тул юун түрүүнд гишүүнчлэл нь mandatory model-д тулгуурлаж, сонгуульд оролцох эрхийг олгох бөгөөд сонгуулиар сонгогдсон этгээд нь нутаг дэвсгэрийн болон бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүнээр сонгогдоно (L712-1). Тус танхимын гишүүнээр сонгогдсон гишүүд нь дундаасаа ерөнхийлөгчөө сонгодог байна (L712-1).

⁷ Байгууллагын түүх, Францын Худалдаа, аж үйлдвэрийн танхим, <https://www.cci.fr/web/organisation-du-reseau/histoire> (хамгийн сүүлд 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэвтэрсэн)

⁸ Мөн тэнд.

⁹ John Hall Stewart, A Documentary Survey of the French Revolution, New York: Macmillan, 165 – 66, (1951).

¹⁰ Францын Худалдаа, аж үйлдвэрийн танхим, www.cci.fr (хамгийн сүүлд 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэвтэрсэн)

CCI France нь Францын бүх худалдаа, аж үйлдвэрийн танхимын дээд байгууллага бөгөөд тус CCI France-ийн нэр нь 2015 оны 5-р сарын 17-ноос өмнө нь Assembly of French Chambers of Commerce and Industry (ACFCI) байсан. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд Францын худалдаа, аж үйлдвэрийн танхим буюу CCI France гэж нэрлэгдэх болсон.

Тус CCI France-ийн удирдах байгууллага буюу Ерөнхий ассамблейгийн гишүүдийг Франц арал дахь мужийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгчид, Нутаг дэвсгэрийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгчид, Бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгчид, далайн чанад дахь худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгчид бүрдүүлдэг. Эдгээр нь дотроосоо CCI France-ийн ерөнхийлөгчийг сонгоно. Энэхүү сонгогдсон этгээд өөрийн нутаг дэвсгэрийн болон бүс нутгийн танхимын ерөнхийлөгчийн албанаас чөлөөлөгдөнө (L712-1).

CCI France-ийн Ерөнхийлөгч нь ерөнхий ассамблейн даргын чиг үүргийг гүйцэтгэж, танхимыг хуулийн дагуу төлөөлөх бүрэн эрхтэй этгээд байна (L712-1). CCI France-ийн Ерөнхийлөгчийг сонгох, саналыг тоолох журмыг захиргааны ерөнхий шүүхийн тогтоолоор тодорхойлно (L712-1).

Нутаг дэвсгэрийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхий ассамблей нь бүс нутгийн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүнээр сонгогдсон гишүүд дундаасаа ерөнхийлөгчөө сонгоно. Хэрвээ тухайн гишүүн нь бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгчөөр сонгогдвол нутаг дэвсгэрийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгчийн албанаас чөлөөлөгдөнө. Нутаг дэвсгэрийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч нь өөрийн харъяалагддаг бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэд ерөнхийлөгч байна (L712-1).

Нутаг дэвсгэрийн болон бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүд нь 5 жилийн хугацаатайгаар сонгогдоно (L713-1).

Сүлжээн дэх нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох танхимын гишүүн нь 15-аас дээш жилийн хугацаатайгаар гишүүнээр ажиллах боломжгүй. Гэхдээ өөрийн бүрэн эрхийн хугацаандаа 15 дахь жилдээ хүрвэл тухайн бүрэн эрхийн хугацаагаа дуустал ажиллаж болно (L713-1).

Францын худалдааны хуулийн L713-11 дахь зүйлийн дагуу гишүүдийг сонгох сонгуульд оролцогчид нь арилжааны, аж үйлдвэрийн болон үйлчилгээний гэсэн гурван категорид хуваагдан саналаа өгнө.

Худалдааны хуулийн L713-1-II-т заасны дагуу дараах субъектууд сонгогч байж болно. Үүнд:

1. Шууд саналаа өгөх эрхтэй субъектууд нь:

- a) Худалдааны болон компанийн бүртгэлд бүртгэгдсэн merchant буюу арилжаа эрхлэгчид нь шууд саналаа өгөх эрхтэй. Гэхдээ бүртгэлээ хийсэн газрын харъяалах нутаг дэвсгэрийг хариуцдаг худалдаа, аж үйлдвэрийн танхимын сонгуульд оролцоно.
- b) Компанийн менежер бөгөөд худалдааны болон компанийн бүртгэлд бүртгэгдсэн этгээд байх,
- c) Өмнөх а болон в-д заасан этгээдийн эхнэр болон нөхөр,
- d) Францад бүртгэлтэй худалдааны хөлгийн ахмад бөгөөд зогсоол нь тухайн танхимын харъяалах дүүрэгт байдаг бол,

2. Төлөөлөгчөөрөө дамжуулан сонгуульд оролцох эрхтэй субъектууд:

- a) Худалдааны хуулийн L210-1-д заасан арилжааны компаниуд болон аж үйлдвэрийн болон арилжааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг нийтийн эрх зүйн хуулийн этгээд бөгөөд удирдах газар нь тухайн дүүрэгт байдаг байх,
- b) L713-1-II-ийн 1-ийн а болон в-д заасан этгээд болон 2-ийн а-д заасан хуулийн этгээд бөгөөд өөрсдийн сонгох эрхийг хэрэгжүүлэх дүүрэг байхгүй бол,
- c) Арилжааны компани ба удирдах байгууллага нь далайн чанадад байдаг бөгөөд арилжааны болон компанийн бүртгэлд бүртгэгдсэн хамаарал бүхий этгээд байгаа бол.

Сонгуулийн саналыг олонхийн саналаар шийдэх бөгөөд гэхдээ хоёр нэр дэвшигч адил тооны санал авбал насаар ахмадыг нь сонгогдсонд тооцно (L713-16). Бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүнд нэр дэвшигчид нь эсрэг хүйсний хүмүүс байна (L713-16).

2. ТАНХИМЫН САНХҮҮЖИЛТ

Францын худалдаа, аж үйлдвэрийн танхимын сүлжээн дэх нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн санхүүжилт нь дараах эх үүсвэртэй байхаар хуульчилсан байна (L710-1). Үүнд:

- 1. Хууль болон бусад эрх зүйн хэм хэмжээгээр тухайн танхимд хураах эрх олгосон бүх төрлийн татварын орлого;
- 2. Тухайн танхимын явуулдаг үйл ажиллагаанаас олсон орлого, хөлс;
- 3. Салбар, нэгжийн үйл ажиллагаанаас хүртэх хувь;
- 4. Татаас, хандив, өв залгамжлалын дагуу хүлээн авсан хөрөнгө.

Мөн худалдаа, аж үйлдвэрийн танхимын сүлжээн дэх нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь түүний удирдлагыг хэрэгжүүлэгч төрийн байгууллагын зөвшөөрөлтэйгээр sociétés civiles буюу иргэний компани болон sociétés par actions буюу хувьцаат компанийг үүсгэн байгуулахад оролцох боломжтой бөгөөд гагцхүү тухайн компанийн зорилго нь танхимын зорилготой адил байх ёстой (L710-1).

3. ТАНХИМЫН ЧИГ ҮҮРЭГ

Францын Худалдааны хуулийн L710-1-д зааснаар Францын худалдаа, аж үйлдвэрийн танхимын сүлжээ нь эдийн засгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн төлөвлөлтөд хувь нэмрээ оруулах, бизнес болон өөрсдийн хамтрагчдыг дэмжих чиг үүрэгтэй бөгөөд тогтоолоор батлагдсан нөхцлийн дор өөрийн чиг үүргийг гүйцэтгэхэд шууд хамааралтай бүхий л чиг үүргийг гүйцэтгэнэ гэж ерөнхий байдлаар хуульчилж өгсөн байна.

Түүнчлэн тус улсын танхимын нэг онцлог нь өөрийн чиг үүргийн хүрээнд эмэгтэй болон эрэгтэйчүүдийн тэгш байдлыг хангахад хувь нэмрээ оруулах ёстой бөгөөд ялангуяа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих чиг үүргийг тусгайлан гүйцэтгэдэг байна (L710-1).

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын сүлжээнд багтаж буй байгууллага нь дараах чиг үүргийг гүйцэтгэхээр хуульчилсан. Үүнд:

1. Хууль болон бусад дүрэм, журмын дагуу олгосон ерөнхий ашиг сонирхолд тулгуурласан чиг үүргийг гүйцэтгэх (L710-1-1);
2. Өрсөлдөөний тухай хуульд заасны дагуу бизнес шинээр эрхлэгчид болон бусдын аж ахуйн үйл ажиллагааг шилжүүлэн авсан этгээдүүдийг дэмжих, холбох, зөвлөгөө өгөх зэрэг чиг үүргийг гүйцэтгэх (710-1-2);
3. Компаниудын олон улсад гарах, өрсөлдөх боломжийг хангах, экспортын үйл ажиллагааг дэмжих зорилгоор дэмжих, зөвлөгөө өгөх чиг үүргийг гүйцэтгэх (710-1-3);
4. Өөрийн байгуулж, удирдаж, санхүүжүүлдэг нийтийн болон хувийн байгууллагаар дамжуулан мэргэжлийн тодорхой сургалтыг явуулах чиг үүргийг гүйцэтгэх (710-1-4);
5. Боомт болон нисэх буудлуудын тодорхой байгууламжийг бий болгох, удирдах чиг үүрэг (710-1-5);
6. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн зүгээс олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх (710-1-6);
7. Төрийн эрх бүхий байгууллагын зүгээс хүсэлт гаргасны дагуу аж үйлдвэр, худалдаа, арилжаа, үйлчилгээ, эдийн засгийн хөгжил, мэргэжлийн сургалт, дадлага болон бүс нутгийн төлөвлөлттэй холбоотой мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмж гаргах, судалгаа хийх чиг үүргийг гүйцэтгэх (710-1-7).

CCI France нь Францын нийт худалдаа, аж үйлдвэрийн танхимын сүлжээг удирдах чиг үүргийг гүйцэтгэдэг (L711-16). Үүнд:

1. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын сүлжээний үндэсний стратегийг хөгжүүлэх, боловсруулах;
2. Сүлжээний гишүүн нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн оролцоог зохицуулсан стандартыг баталж, мөрдүүлэх;
3. Үндэсний хэмжээний төслийг хэрэгжүүлэх болон ийнхүү хэрэгжүүлэх эрхийг сүлжээний өөр гишүүн нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд шилжүүлэх;
4. Франц арал дахь танхимуудад техникийн, санхүүгийн болоод хууль, эрх зүйн туслалцааг үзүүлэх;

5. Сүлжээний бүх гишүүдтэй гэрээ байгуулах эрхтэй;
6. Бусад гишүүдийн өмнөөс худалдан авах ажиллагааг явуулах эрхтэй;
7. Хувийн эрх зүйн гэрээг байгуулахад түүнийг хөлс болон ажилд авах нөхцлийг тодорхойлох;
8. Захиргааны ерөнхий шүүхийн тогтоолын дагуу CCI France-ийн Ерөнхийлөгчийн саналын үндсэн дээр бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхий захирлыг томилох;
9. Өөрийн санаачлагаар болон сүлжээний гишүүн нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хүсэлтээр аудитын шалгалт хийлгэх;
10. Далайн чанад дахь Францын худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагааг нэгтгэн удирдах;
11. Сүлжээний гишүүн танхимын хүсэлтээр танхим хоорондын маргааныг шийдвэрлэхээр эвлэрүүлэн зуучлал явуулах;
12. Сүлжээний гишүүн танхимын үл хөдлөх хөрөнгийн талаарх бүртгэл, тооллогыг явуулах эрхтэй.

Дээрх дурьдсан CCI France-ийн чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцлийг захиргааны ерөнхий шүүхийн зүгээс тогтооно.

Бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхим нь Францын Худалдааны хуулийн L710-1-т заасан нийтлэг чиг үүргийг мөн адил гүйцэтгэнэ (L711-7). Үүнд:

1. Тухайн бүс нутгийн зөвлөлд бизнесийг дэмжих төлөвлөгөөтэй холбоотой өөрийн саналыг хүргүүлэх;
2. Бүс нутгийн төлөвлөгөө болон нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг боловсруулахад оролцох;
3. Нутаг дэвсгэрийн төлөвлөлтийн хуульд заасны дагуу тухайн нутаг дэвсгэрийн байгууллагуудын төлөвлөгөөг боловсруулахад оролцох;
4. Дэд бүтцийн болон байгууламж барих төсөлд голлох үүрэгтэйгээр оролцох, ялангуяа тээврийн төсөл, мөн өөрийн чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой аливаа үйлчилгээг хэрэгжүүлэх;
5. Төр, бүс нутаг болон бусад нутаг дэвсгэрийн удирдлага, нийтийн эрх зүйн хуулийн этгээдтэй гэрээ байгуулах;
6. Les établissements d'enseignement supérieur consulaire ¹¹ буюу Дээд боловсролын байгууллагыг удирдахад оролцох эрхтэй бөгөөд хувьцаа эзэмшигч болох боломжтой.

Харин Франц арал дахь нутаг дэвсгэрийн болон мужийн худалдаа, аж үйлдвэрийн танхим нь өөрийн үйл ажиллагаа явуулдаг нутаг дэвсгэрийн хүрээнд аж үйлдвэрлэл болон арилжаа, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг компаниудад дараах үйлчилгээг үзүүлэх чиг үүргийг гүйцэтгэдэг (L711-3). Үүнд:

¹¹ Энэ нь sociétés par actions буюу хувьцаат компанийн нэг төрөл бөгөөд долоогоос доошгүй хувьцаа эзэмшигчтэй байх шаардлагатай бөгөөд хувьцаа эзэмшигчид нь merchant гэж тооцогддоггүй sociétés anonymes гэх төрөлд нь хамаардаг дээд боловсролын байгууллага юм. Жишээ нь ESCP business school гэх мэт сургуулийг дурьдаж болно. Хувьцаа эзэмшигч нь бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхим болон төгсөгчдийн холбоо, сургуулийн сан байх жишээтэй. ESCP Бизнес, www.escpeurope.eu (хамгийн сүүлд 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэвтэрсэн)

1. Гарааны бизнесийн төвийг байгуулж, үйл ажиллагааг нь эрхлэн явуулах;
2. Дэд бүтцийн болон тодорхой байгууламжийг барих төсөлд голлон оролцох, эсхүл өөрсдийн чиг үүрэгт хамаарах бүхий л үйлчилгээг удирдаж, эрхлэн явуулах;
3. Төр болон нутаг дэвсгэрийн засаг, захиргааны нэгж, бусад нийтийн эрх зүйн хуулийн этгээд (établissements publics)-тэй дэд бүтэц, байгууламж эсхүл өөрийн чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой үйлчилгээ, ялангуяа тээвэрлэлтийн үйлчилгээтэй холбоотой гэрээ байгуулах;
4. Conseil d'Etat буюу Захиргааны дээд шүүх¹²-ийн тогтоолд заасан нөхцлийн дагуу бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын байнгын төлөөлөгч байх тохиолдолд, төрийн албан хаагчийг ажилд авах бөгөөд энэ нь тус танхимын чиг үүргийг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай байна. Гэхдээ төрийн албан хаагчийг хувийн эрх зүйн хүрээнд ажилд авах бөгөөд хэрэв аж үйлдвэрийн, боомт болон нисэх буудлын дэд бүтэцтэй холбоотой ажил, үйлчилгээг үзүүлэх тохиолдолд зайлшгүй шаардлагатай бол нийтийн эрх зүйн хүрээнд төрийн албан хаагчийг авч ажиллуулна.
5. Мөн Франц арал дахь нутаг дэвсгэрийн болон мужийн танхим нь өөрсдийн чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотойгоор өөрийн үйл ажиллагаа явуулдаг нутаг дэвсгэр дэх компаниудын талаарх эдийн засгийн мэдээллийг цуглуулж ажиллана. Энэхүү мэдээллийг гарааны бизнесийн төвөөр дамжуулан цуглуулж, хадгалах бөгөөд зөвхөн өөрсдийн чиг үүргийг гүйцэтгэх зорилгоор ашиглана.

Бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхим нь өөрт хамаарах Франц арал дахь нутаг дэвсгэрийн болон мужийн танхимыг удирдаж, дэмжих чиг үүргийг гүйцэтгэхээр хуульчилсан байдаг (L711-8).


4. ТАНХИМЫН ДОТООД БҮТЭЦ

Францын худалдаа, аж үйлдвэрийн танхимын сүлжээ нь дотроо Францын худалдаа, аж үйлдвэрийн танхим (Chambres de commerce et d'industrie France, CCI France), Бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхим (des chambres de commerce et d'industrie de région), нутаг дэвсгэрийн худалдаа, аж үйлдвэрийн танхим (des chambres de commerce et d'industrie territoriales), орон нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхим (des chambres de commerce et d'industrie locales), Франц арал мужийн худалдаа, аж үйлдвэрийн танхим (des chambres de commerce et d'industrie départementales d'Ile-de-France), Харилцан туслалцах нэгдэл (des groupements interconsulaires)-ийг тус тус байгуулж болно. Харилцан туслалцах нэгдэл нь хэд хэдэн бүс нутгийн болон нутаг дэвсгэрийн худалдаа, аж үйлдвэрийн танхимаас бүрдэнэ (L710-1).

Францын худалдаа, аж үйлдвэрийн танхим нь худалдаа, аж үйлдвэрийн танхимын сүлжээтэй байх (L.710-1) бөгөөд тус сүлжээг тэргүүлэгч нь Францын Худалдаа, аж үйлдвэрийн танхим (Chambres de commerce et d'industrie France, CCI France) байна. Зөвхөн Францын Худалдаа, аж үйлдвэрийн танхим буюу CCI France нь тухайн сүлжээг төрийн болон Европын холбооны өмнө, олон улсад төлөөлөх бүрэн

¹² Монгол Улсын ном, зохиолд судлаачид “захиргааны дээд шүүх” гэх нэр томъёог ашигласан байх тул уг нэр томъёог ашиглалаа.

эрхтэй байдаг. Францын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дотоод бүтцийг доорхи схемээр илэрхийлсэн болно.



Дээрх схемд харуулсны дагуу CCI France нь сүлжээг тэргүүлэгч байх бөгөөд бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхимд хамаарах орон нутгийн танхим, Франц арал дахь Парисын бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхимд хамаарах Франц арлын буюу мужийн худалдаа, аж үйлдвэрийн танхим нь хуулийн этгээдийн эрхгүй байдаг (L710-1). Мөн дээрх схемд саарал өнгөөр тэмдэглэсэн сүлжээний гишүүд нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд байх боловч, эдгээр нь өөрсдийн чиг үүргийг гүйцэтгэхдээ хувийн эрх зүйн хуулийн этгээдийн хувиар явуулах бөгөөд энэ талаарх журмыг CCI France-ын ерөнхийлөгч болон L712-11-т заасан үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчид хамтран батална (L710-1).

Орон нутгийн Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь бүс нутгийн Худалдаа, аж үйлдвэрийн танхимд хамаарахаар хуульчилсан байна (L711-1).

Бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхим нь тухайн бүс нутаг бүрт тогтоолын үндсэн дээр байгуулагдана. Бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаа явуулах газар нутаг нь бүс нутаг эсхүл Корсика (Corsica буюу газар дундын тэнгист байрлах Францын 18 бүс нутгийн нэг) байна (L711-6). Бүс нутгийн танхимын удирдах газрыг түүнд хамаарах нутаг дэвсгэрийн болон мужийн танхимтай зөвшилцөж байрлах газрыг нь тогтооно (L711-6).

Хэрвээ тухайн бүс нутаг нь хуваагдахгүй, дотроо нэг л нутаг дэвсгэрийн танхимтай байвал нэг нийтийн эрх зүйн хуулийн этгээд бүс нутгийн болон нутаг дэвсгэрийн танхимын чиг үүргийг давхар гүйцэтгэнэ. Гэхдээ нэршлийн хувьд бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхим байна (L711-6).

Гэхдээ бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхимууд нь хоёр болон түүнээс дээш бүс нутгийг хариуцан ажиллаж болно. Энэ тохиолдолд захиргааны дээд шүүхийн тогтоол гарсан байхыг шаардана (L711-6).

CCI France-ын удирдах чиг үүргийг гүйцэтгэдэг байгууллага (General Assembly)-ыг Франц арал (Ile-de France)-ын танхим, нутаг дэвсгэрийн худалдаа, аж үйлдвэрийн танхим, Үндсэн хуулийн 74-р зүйлийн дагуу зохицуулагддаг далайн чанад дахь мужийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч нар бүрдүүлдэг байна (L 711-15).

Францын Худалдааны хуулийн L712-1-ийн дагуу Францын худалдаа, аж үйлдвэрийн танхимын сүлжээн дэх нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хувиар үйл ажиллагаа явуулдаг танхимуудын хувьд тэдгээрийн эрх барих дээд байгууллага нь General Assembly буюу Ерөнхий ассамблей байна.

Худалдааны хуулийн L710-1-д заасны дагуу CCI France, Бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхим, Нутаг дэвсгэрийн худалдаа, аж үйлдвэрийн танхим, Харилцан туслалцах нэгдэл нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна гэж заасан. Тиймээс эдгээр танхимын хувьд эрх барих дээд байгууллага нь ерөнхий ассамблей байна.

5. ТӨРИЙН ХЯНАЛТ

CCI France, бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхим, нутаг дэвсгэрийн худалдаа, аж үйлдвэрийн танхим, харилцан туслалцах нэгдэл нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд (établissements publics¹³) байх бөгөөд эдгээр нь төрийн удирдлага дор байх ёстой (L710-1).

¹³ Тус ойлголт нь Францын Захиргааны эрх зүйн хувьд авч үзэгддэг төдийгүй, тодорхойлолтын хувьд хэд хэдэн онолын ойлголт байгааг анхаарах зайлшгүй шаарлагатай. R.Connors, La Notion D'Etablissement Public en Droit Administratif Francais (1959) at 31. Ийм хуулийн этгээдэд мужийн галт унтраах алба, сургуулийн сан, шашны байгууллага хамаардаг байна. Ерөнхий агуулга нь нийтийн байгууламжийг ашигладаг хуулийн этгээд гэсэн утгыг илэрхийлж буйг энд зайлшгүй анхаарах шаардлагатай болно. Монгол Улсад нэр томъёоны нэг мөр хэвшээгүй байгаа учраас нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэх нэр томъёог хэрэглэлээ.

ГУРАВ. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

Бүгд Найрамдах Казахстан Улс нь хувийн эрх зүйн чиг хандлагыг баримталдаг, сайн дурын гишүүнчлэлтэй худалдаа аж үйлдвэрлэлийн танхимын тогтолцоотой байсан бөгөөд 2005 оны "Худалдаа аж үйлдвэрлэлийн танхимын тухай хууль"-ийг дагаж мөрддөг байсан.

Тухайн цаг үед 700 гаруй холбоод байгуулагдсан боловч хэд хэдэн асуудлаас болж нийт аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхол хамгаалагдаж чадахгүй байсан байна. Учир нь, нэгт, ихэнхи холбоодууд нь томоохон хотуудад төвлөрсөн буюу 1/3 нь Алматыд бүртгэлтэй байв. Хоёрт, холбоодуудын хамрах хүрээ маш бага буюу 2-3% байсан бөгөөд эргэх холбоо маш муу, холбоодуудын ажилд бизнесийн оролцоо маш бага байв. Ялангуяа нийт 800 000 гаруй идэвхитэй бизнесийн 90%-ийг эзэлдэг хөдөө орон нутгийн болон жижиг хотын бизнесүүд холбоодын үйл ажиллагаанд хамрагдаж чадахгүй байв.

Түүнчлэн ихэнхи холбоодууд мэргэжилтэн, шинжээчдийн нөөцөөр дутмаг байснаас төрийн байгууллагын өмнө бизнес эрхлэгчдийн ашиг сонирхлыг хангалттай хамгаалж чадахгүй байсан бөгөөд улс хоорондын Гаалийн холбоо бий болсоноор эл асуудал улам хурцадсан байв. ОХУ-ын Аж үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн холбоонд 2 000 мэргэжилтэн бүртгэгдсэн байсан боловч Казахстаны зарим холбоодуудад нэг ч мэргэжилтэн байсангүй. Иймд улс хоорондын интеграцчлалын үед Казахстаны бизнесийн ашиг сонирхол хаягдах аюул улам ихссэн байв.

Иймд Казахстан улс бизнес, аж ахуй эрхлэгчдийнхээ эрх, ашиг сонирхлыг бүрэн хамгаалах зорилгоор 2013 онд эрх зүйн шинэчлэл хийж Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндэсний аж ахуй эрхлэгчдийн танхимын тухай хууль (О Национальной палате предпринимателей Республики Казахстан) (цаашид "ҮААЭТХ" гэх)-г баталсан байна.

Энэхүү хуулинд "Атамекен" Үндэсний танхим нь бизнес, аж ахуй эрхлэгчдийн холбоод, танхимуудын албан ёсны толгой байгууллага болж, нэгдсэн удирдлагын системд оруулсан бөгөөд Казахстан улсын бүх аж ахуй эрхлэгч нэгж, байгууллага заавал гишүүнчлэлтэй болж хамрах хүрээгээ үнэмлэхүй болгосноор том, дунд, жижиг, хөдөө орон нутгийн бүх бизнесийг хамруулж чадсан байна. Ингэснээр хөдөө орон нутгийн жижиг бизнесүүд хүртэл ашиг сонирхолоо төлөөлүүлэх, танхимын үйлчилгээ болон зах зээлийн мэдээлэл авах болон бусад боломжууд тэдгээрт нээлттэй болсон байна.

ҮНДЭСНИЙ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛИЙН БҮТЭЦ, ЗОХИЦУУЛАЛТ

ҮААЭТХ-ийн хуулиар Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндэсний аж ахуй эрхлэгчдийн танхим (цаашид "Үндэсний танхим" гэх)-ын эрх зүйн байдлыг баталгаажуулсан бөгөөд энэхүү хуулийн 1-р зүйлийн 1.2-т заасны дагуу дараах зорилгоор байгуулагдсан ашгийн бус аж ахуй эрхлэгчдийн холбоо гэж заасан байна.
Үүнд:

- аж ахуй эрхлэгчдийн санаачилгыг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн, эдийн засгийн болон нийгмийн таатай нөхцөл бүрдүүлэх;
- Казахстан улсын төрийн байгууллага болон бизнес эрхлэгчдийн хоорондын харилцан ашигтай түншлэлийг хөгжүүлэх;

- аж ахуй эрхлэгчдийн нэгдэл болон хуулийн этгээдийн статустай холбооны үйл ажиллагааг дэмжих, идэвхитэй байхад туслалцаа үзүүлэх юм.

1. ЗАРЧИМ

ҮААЭТХ-ийн 4 дүгээр зүйлийн дагуу Үндэсний танхим нь дараах зарчим дээр тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

- Бие даан үйл ажиллагаа явуулах;
- Бүх аж ахуй эрхлэгчид тэгш эрхтэй байх;
- Улсын гадаадын болон дотоодын үндсэн бодлогод харшлахгүй шийдвэр гаргах;
- Үйл ажиллагаагаа ил тод явуулах, гишүүдэд тайлагнах, хариуцлагатай ажиллах;
- Шийдвэр гаргах болон хэрэгжүүлэхэд үр дүнтэй, эмх цэгцтэй болон түргэн ажиллах;
- Салбарын, салбар-дундын болон бүс нутгийн холбоодыг хөгжүүлэх;
- Бизнесийн нийгмийн хариуцлагыг мөрдөх;
- Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний аюулгүй байдлыг хангах, хүний амьдрал, эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд хөнөөлгүй байдлыг хангах; болон
- Нийгэм болон аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхолын тэнцвэртэй байдлыг хангах байна.

2. ТАНХИМЫН ГИШҮҮНЧЛЭЛ

Казахстаны Үндэсний танхим нь заавал гишүүнчлэлтэй байх зарчмыг дагаж мөрдөнө гэж ҮААЭТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2 болон 28 дугаар зүйлийн 28.1¹⁴-т заасан байдаг. Өөрөөр хэлбэл Казахстан улсад бүртгэлтэй аж ахуй эрхлэгч бүр энэхүү хуулийн дагуу танхимын гишүүн болох үүрэгтэй байна.

Мөн хуулийн 1 зүйлийн 1.1-1-д заасны дагуу аж ахуй эрхлэгч гэдэгт БНКУ-д бүртгэлтэй, түүний нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг дараах этгээдүүдийг хамаардаг байна. Үүнд:

- Арилжааны хуулийн этгээдүүд
- Хувиараа бизнес эрхлэгчид
- Фермерийн аж ахуйчид багтана.

ҮААЭТХ-ийн 4.2-р зүйлд Казахстан улсын хуулийн дагуу өөр ашгийн бус байгууллагад эсхүл засгийн газрын байгууллагад гишүүн болохыг үүрэгдсэн этгээд нь Үндэсний танхимын гишүүнд хамаарахгүй байна.

ҮААЭТХ-ийн 28.1-р зүйлд гишүүн болгон заавал гишүүнчлэлийн татвар төлөх үүрэгтэй (28.3-р зүйл), гишүүд бүр тэгш эрхтэй (28.4-р зүйл), Үндэсний танхим нь гишүүдийнхээ үйл ажиллагаанд оролцохгүй байх (28.5-р зүйл) бөгөөд тэдгээрийн хооронд үүссэн маргаан нь Казахстан улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ (28.6-р зүйл) гэж заан гишүүдийнхээ хараат бус байдлыг тогтворжуулдаг байна.

Үндэсний танхимын гишүүд дараах эрхтэй байна. Үүнд:

¹⁴ ҮААЭТХ-ийн 28.1-р зүйл "Энэхүү хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний танхимын гишүүнээр худалдаа аж үйлдвэр эрхлэгч байна."

- Үндэсний танхимын мэргэжлийн дэмжлэг авч, хамгаалалт эдлэх бөгөөд түүний дүрэмд заасан үйлчилгээг авах;
- Үндэсний танхимын удирдлагыг сонгох, удирдлагаар сонгогдох;
- Үндэсний танхимд бичгэн хүсэлт гаргаж, түүний эрх хэмжээний хүрээнд нийцсэн хариулт авах болон танхимын үйл ажиллагааг сайжруулах талаар санал гаргах;
- Энэхүү хууль болон Үндэсний танхимын дүрмийн хүрээнд түүний удирдлаганд оролцох;
- Үндэсний танхимаас зохион байгуулж буй сургалт, мэргэшил дээшлүүлэх болон давтан сургалтуудад хамрагдах;
- Төрөл бүрийн салбарын хараат бус шинжээчдийн үйлчилгээ зэрэг мэргэшсэн мэдээлэл шинжилгээний дэмжлэг авах;
- Үндэсний танхимын дүрэмд заасны дагуу түүний үйл ажиллагааны талаарх тайлантай танилцах; болон
- БНКУ-ын хууль тогтоомжийн актад заасан бусад эрхийг эдлэнэ.

3. ТАНХИМЫН САНХҮҮЖИЛТ

Үндэсний танхимын санхүүжилт нь гишүүнчлэлийн татвар, үйлчилгээний хөлс болон бусад орлогоос бүрддэг байна. (16.1, 16.4-р зүйл)

Үндэсний танхимын аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогыг зөвхөн танхимын зориулалтаар ашиглах бөгөөд түүний гишүүдэд хуваарилах эрх байхгүйг тусгайлан зүйлчилсэн байна.

2019 оны байдлаар Үндэсний танхимын нийт орлогын 60,7%-ийг гишүүдийн татвар бүрдүүлсэн бол 39,1%-ийг үзүүлсэн үйлчилгээний хөлс бөгөөд 0,2% нь бусад төрлийн орлого бүрдүүлсэн байна.¹⁵

4. ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТАТВАР

Үндэсний танхимын гишүүн бүр заавал гишүүнчлэлийн татвар төлөх үүрэгтэй. Гишүүнчлэлийн татварын хэмжээг хуулиар хатуу тогтоогоогүй байдаг бөгөөд Үндэсний танхим нь татварын хэмжээг жил бүрийн 6-р сарын 1-ны өдрөөс өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдэгддэг байна. (29.1-р зүйл)

Татвар төлөх гишүүдийг гурван үндсэн бүлэгт хуулиар хуваадаг (29.2-р зүйл) бөгөөд эдгээр бүлгүүд доторх шатлалыг танхимын Их хурал тогтоодог байна (29.3-р зүйл). Үндсэн гурван бүлгийг дараах байдлаар тогтооно. Үүнд:

1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжих Бүгд найрамдах улсын төсвийн тухай хуулиар тогтоосон өмнөх тайлант жилийн сарын тооцооны дундаж үзүүлэлтийг

1. 60,000 дахин үржүүлсэн хэмжээнээс хэтрэхгүй жилийн нийт орлоготой этгээд 1-р бүлэгт;
2. 60,000 дахин үржүүлсэн хэмжээнээс их бөгөөд 1,500,000 дахин үржүүлсэн хэмжээнээс хэтрэхгүй жилийн нийт орлоготой этгээд 2-р бүлэгт;
3. 1,500,000 дахин үржүүлсэн хэмжээнээс их жилийн нийт орлоготой 3-р бүлэгт тус тус хамаарна.

¹⁵ Бүгд Найрамдах Казахстан Улсын "Атамекен" Үндэсний аж ахуй эрхлэгчдийн танхим, <https://atameken.kz/ru/pages/749-byudzh-et-i-finansovaya-otchetnost> (хамгийн сүүлд 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэвтэрсэн)

Сарын тооцооны үзүүлэлтийг жил болгон тогтоодог. Жишээ нь: 2020 онд мөрдөгдөх сарын тооцооны үзүүлэлт нь 2,651 тэнги байсан бол 2019 оных нь 2,525 тэнги байсан байна.¹⁶

Үндэсний танхим нь гишүүний төлөх татварыг “Татвар болон төсөвт суух бусад төлбөрийн үүргүүдийн тухай” хуулийн дагуу улсын төсөв бүрдүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл дээр үндэслэн тогтоодог байна. (29.4-р зүйл)

Гишүүд нь татвараа гурван хэсэгт буюу 5 дугаар сарын 25-ны өдөр, 8 дугаар сарын 25 болон 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хувааж төлж болдог байна. (29.5-р зүйл)

Татвараас чөлөөлөх: Гишүүний нийт ажиллагсдын 51-с дээш хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байх тохиолдолд түүнийг гишүүнчлэлийн татвараас чөлөөлдөг байна. (29.6-р зүйл)

5. ТАНХИМЫН ТОГТОЛЦОО

ҮААЭТХ-ийн 3-р зүйлийн 3.3-т заасны дагуу Үндэсний танхим нь дараах хэлбэрийн тогтолцоотой байна. Үүнд:

1. Улсын түвшинд:
 - а) Үндэсний танхим;
 - б) Үндэсний танхимаар магадлан итгэмжлэгдсэн:
 - Салбар эсхүл салбар-дундын үндэсний холбоо;
 - Үндэсний танхимаар магадлан итгэмжлэгдсэн жижиг, дунд, том аж ахуйн үндэсний холбоо;
 - Аж ахуйн үйл ажиллагааны чиглэлийн өөрөө удирдах байгууллага.
2. Орон нутгийн түвшинд:
 - а) Бүс нутаг, улсын хэмжээнд ач холбогдолтой хот болон нийслэлийн танхим (цаашид “бүс нутгийн танхим” гэх)
 - б) Бүс нутгийн танхимаар магадлан итгэмжлэгдсэн:
 - Салбар эсхүл салбар-дундын бүс нутгийн холбоо;
 - Үндэсний танхимаар магадлан итгэмжлэгдсэн жижиг, дунд, том аж ахуйн бүс нутгийн холбоо;
 - Орон нутгийн болон улсын болон орон нутгийн хэмжээнд ач холбогдолтой хот болон нийслэлийн холбоо болон аж ахуйн үйл ажиллагааны чиглэлийн өөрөө удирдах байгууллага;
 - Дүүргийн болон дүүргийн хэмжээний холбоо болон аж ахуйн үйл ажиллагааны чиглэлийн өөрөө удирдах байгууллага.
3. Хот болон дүүргийн түвшинд:

Холбогдох орон нутаг, улсын болон орон нутгийн ач холбогдолтой хот болон нийслэл, түүнчлэн дүүргийн хэмжээний хот дахь Бүс нутгийн танхимуудын салбар (цаашид “Бүс нутгийн танхимын салбар” гэх)
4. ҮААЭТХ-ийг хэрэгжүүлэх зорилгоор Үндэсний танхимын оролцоотой үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд.

¹⁶ Бүгд Найрамдах Казахстан Улсын сарын тооцооны үзүүлэлт (1995 – 2020 оны архив) https://online.zakon.kz/document/?doc_id=1026672 (хамгийн сүүлд 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэвтэрсэн)

5. Гадаад улсад байрших Үндэсний танхимын салбар, төлөөлөгчийн газар.

6. ҮНДЭСНИЙ ТАНХИМЫН ЧИГ ҮҮРЭГ

ҮААЭТХ-ийн 3-р бүлэгт Үндэсний танхимын чиг үүрэг болон танхимын тогтолцооны дагуу чиг үүрэг хэрэгжүүлэх шатлалыг тогтоосон байдаг.

ҮААЭТХ-ийн 8-р зүйлд дараах шатлалаар ҮААЭТХ болон Казахстан улсын бусад хуульд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

1. Казахстан улсын Парламент, Засгийн газар болон төрийн төв байгууллагуудтай, тэдгээрийн үйл ажиллагаатай холбоотойгоор улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүргийг Үндэсний танхим;
2. Нутгийн өөрөө удирдах байгууллага, гүйцэтгэх засаглал болон төлөөллийн байгууллагуудтай, тэдгээрийн үйл ажиллагаатай холбоотойгоор орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүргийг Бүс нутгийн танхим;
3. Гадаадын болон олон улсын байгууллагатай холбоотой хэрэгжүүлэх, түүнчлэн аж ахуй эрхлэгчдийн гадаад эдийн засгийн үйл ажиллагааг хөгжүүлэх болон Казахстан улсад гадаад хөрөнгө оруулалт татах олон улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүргийг Үндэсний танхим, түүний гадаад улсад байрлах салбар, төлөөлөгчийн газар болон түүний үүсгэн байгуулсан бусад хуулийн этгээд тус тус хэрэгжүүлнэ.

Үндэсний танхимын хэрэгжүүлэх чиг үүрэг

1. **Аж ахуй эрхлэгчдийн эрх болон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах (ҮААЭТХ-ийн 9-р зүйл)**

Үндэсний танхим нь олон улсад, гадаад болон дотооддоо аж ахуй эрхлэгчдийнхээ эрх болон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалдаг байна.

Энэ чиг үүргийн хүрээнд Үндэсний танхим нь:

- a) Казахстан улсын Засгийн газар, Парламент болон бусад захиргааны байгууллагад аж ахуйн салбарын ашиг сонирхлыг төлөөлөх;
- b) Аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхлыг хөндөж буй эрх зүйн норматив баримт бичиг боловсруулах ажиллагаанд оролцох;
Үл хамаарах нөхцөл: (1) Төв болон нутгийн захиргааны байгууллагын эрх зүйн норматив акт (2) Хорио цээрийн бүс тогтоох болон чөлөөлөх тухай шийдвэр (3) Хорио цээр болон хязгаарлалтын арга хэмжээ тогтоох болон чөлөөлсөн шийдвэр (4) Байгаль орчин болон технологийн асуудал гарсантай холбоотойгоор онцгой байдал зарлах шийдвэр.
- c) Хувийн аж ахуйн салбарын ашиг сонирхлыг хөндөж буй хуулийн төслийн үзэл баримтлал, хууль болон бусад эрх зүйн норматив актын төсөлд мэргэжлийн дүгнэлтийг зайлшгүй гаргах;
- d) төв болон (эсвэл) орон нутгийн захиргааны байгууллагын аж ахуйн чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны чиг үүргээ өрсөлдөөнт орчинд шилжүүлэх тухай санал боловсруулж, танилцуулах;

Үл хамаарах нөхцөл: Засгийн газрын санхүүгийн байгууллага болон санхүүгийн зах зээлд хяналт тавих чиг үүрэг.

- i. Үндэсний танхимд магадлан итгэмжлэгдсэн аж ахуй эрхлэгч болон түүний нэгдэл нь төв болон (эсхүл) орон нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийг өрсөлдөөнт орчинд шилжүүлэх ажиллагаанд зохицуулалт хийх;
 - ii. төв болон (эсхүл) орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран тэдгээрээс шилжүүлж болох чиг үүргийг сонгох;
 - iii. энэхүү асуудалтай холбоотой шилжүүлэхээр санал болгож буй чиг үүргийн талаар санал цуглуулах, дүн шинжилгээ хийх, олон нийтэд мэдээллэх;
 - iv. тухайн зах зээлийн орчин нь захиргааны байгууллагын шилжүүлж буй чиг үүргийг хүлээн авахад бэлэн эсэх талаар дүн шинжилгээ хийх ажилд оролцох;
 - v. өрсөлдөөнт орчинд шилжүүлсэн захиргааны байгууллагын чиг үүргийг чанартай хэрэгжүүлж буй эсэх талаарх асуудлыг шийдвэрлэхэд оролцох.
- e) Төв болон орон нутгийн төрийн байгууллагын зөвлөх байгууллагын аж ахуй эрхлэгчдийн эрх үүргийг хөндөж буй ажилд оролцох;
- f) БНКУ-ын Арбитрын тухай хуулийн дагуу Арбитр үүсгэн байгуулах;
- g) Аж ахуйн салбартай холбоотой нийтийн сонсгол зохион байгуулах.

Нийтийн сонсголыг ҮААЭТХ болон Үндэсний танхимын дүрэмд заасан журмын дагуу зохион байгуулна.

Нийтийн сонсголд: 1. Парламентын гишүүд 2. Нутгийн төлөөлөх байгууллагын гишүүд 3. Төрийн байгууллагын төлөөлөгчид 4. Нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчид 5. Аж ахуй эрхлэгч байгууллагууд 6. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл 7. Үндэсний танхимын урилгаар Засгийн газрын бүрэлдэхүүнд ордог төв болон нутгийн захиргааны байгууллагуудын төлөөлөгчид оролцдог байна. (ҮААЭТХ-ийн 9.3-р зүйл)

2. Олон нийтийн хяналт (ҮААЭТХ-ийн 10-р зүйл)

Энэхүү чиг үүргийн хүрээнд Үндэсний танхим нь:

- a) Олон нийтийн мониторинг явуулах;
- b) Бизнестэй холбоотой төв болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар санал гаргах;
- c) Төрийн мэдлийн хувьцаат компанид компанийн засаглалын үр нөлөөг үнэлэхэд оролцох;
- d) Жил бүр Казахстан улсын бизнес эрхлэлтийн төлөв байдлын талаар тайлан бэлтгэж олон нийт болон төрийг мэдээллээр хангах;
- e) Төрийн байгууллагууд болон төрийн албан хаагчид нь бизнесийн эрх болон хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж байгаа эсэх талаар тогтмол асуулга явуулж нэгтгэн дүгнэлт хийх бөгөөд үр дүнг Казахстаны Засгийн газар болон бусад эрх бүхий байгууллага руу явуулдаг байна. Энэхүү судалгааны дүн нь Казахстан улсын Ерөнхийлөгчийн жил бүрийн тайланд тусгагддаг.

3. Бизнес дэмжих, хөгжүүлэх үйл ажиллагаа (ҮААЭТХ-ийн 11-р зүйл)

Үндэсний танхим бизнесийг хэрхэн дэмжих, хөгжүүлэх талаар хуулинд маш нарийн заасан байдаг байна. Үүний хүрээнд үндэсний танхим нь:

- a) Эдийн засгийн тусгай бүсийг удирдахад оролцоно;
- b) Тээвэр, харилцаа холбооны байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр хөрөнгө оруулалт татах замаар хяналтын цэгийн дэд бүтэц, гаалийн үйлчилгээний дэд бүтцийг барих, ашиглах болон тэдгээрийн тоног төхөөрөмж болон техникээр хангах, түүнчлэн барилгын засвар үйлчилгээг явуулахад оролцоно;
- c) Компанийн удирдлага, засаглалын практикийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх;
- d) “Алтан сапа” болон “Казахстаны шилдэг бүтээгдэхүүн” уралдаан шалгаруулалтыг зохион байгуулах;
- e) Аж үйлдвэрийн бүс байгуулах асуудлаар төрийн байгууллагатай хамтрах, дүгнэлт гаргах;
- f) БНКУ-ын төрийн төлөвлөгөөний тогтолцооны дагалдах баримт бичгийн дагуу бизнес эрхлэх сонирхолтой этгээдийн дэмжлэг болон аж ахуй эрхлэгчдэд үйлчилгээний дэмжлэг зэрэг санхүүгийн бус тусламжийг олгох ажлыг хариуцах;
- g) Мөн баримт бичгийн дагуу дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортыг дэмжих, хөгжүүлэх ажлыг хариуцах;
- h) Бизнес эхлэх болон эрхлэх талаар сургалт зохион байгуулж зөвлөгөө өгөх;
- i) Импортлогч орнуудаас явуулж буй хорио цээрд орсон объект, бүс, газар, үйлдвэрлэлийн газар болон харийн гаралтай бүтээгдэхүүний шалгалтыг хэрэгжүүлэх;
- j) Казахстан улсаас экспортонд гаргах зорилгоор явуулж буй амьтан үржүүлгийн үйл ажиллагаа, амьтан, амьтны гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн бэлтгэл (нядалгаа), хадгалалт, боловсруулалт, борлуулалт болон мал эмнэлгийн тоног төхөөрөмж, малын тэжээл, нэмэлт тэжээлийн үйлдвэрлэх, хадгалах болон борлуулалтын процессийн шалгалт, шинжилгээг хэрэгжүүлэх;
- k) Стандарт болон техникийн зохицуулалт боловсруулахад оролцох, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулах;
- l) Гаалийн үйлчилгээг сайжруулах зорилгоор гаалийн дэд бүтцийн орчин үеийн стандартыг боловсруулахад оролцох.
- m) Төрийн холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран эдийн засгийн салбарт түүхий эд болон бүтээгдэхүүний борлуулалт болон хэрэглээний “үндэсний түлш-эрчим хүчний тэнцвэр”-ийг тогтоох. (YAAЭТmX-ийн 11.2-р зүйл)
- n) Аж ахуй эрхлэгчдэд зориулсан мэдээллийн нэгдсэн цахим платформ бий болгох, хөгжүүлэх, зохицуулах. (YAAЭТmX-ийн 11.3-р зүйл)

4. Дотоодын үйлдвэрлэл болон бараа худалдан авах ажиллагаанд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх (YAAЭТmX-ийн 12-р зүйл)

Үндэсний танхим нь дотоодын үйлдвэрлэл болон худалдан авах ажиллагаанд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах чиг үүргийг хуулийн хүрээнд хэрэгжүүлдэг байна.

Энэхүү чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллгааг явуулна. Үүнд:

- a) Үндэсний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ажил үйлчилгээ үзүүлэгч нарын сайн дурын бүртгэлийг бий болгож түүнийг хөтлөх, түүнчлэн бүртгүүлэх хүсэлтэй этгээдэд тавигдах шаардлагыг тодорхойлох;

- b) Дүн шинжилгээ болон хяналтын зорилгоор эрх бүхий байгууллагаас ирүүлсэн үйлдвэрлэгдсэн, үйлдвэрлэгдэж буй мөн худалдан авахаар төлөвлөсөн бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний талаарх жил бүрийн эсхүл дунд болон урт хугацааны мэдээллийг цуглуулан боловсруулж нэгтгэх;
- c) Бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний зах зээлийн дүн шинжилгээ явуулах, түүнчлэн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний талаар мэдээллийн аналитик мониторингийн системийг бий болгох, хөтлөх;
- d) Бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа болон орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх талаарх аналитик судалгаа шинжилгээ хийх;
- e) Худалдан авах ажиллагаанд оролцох нэгдсэн цэгийг байгуулах, хөгжүүлэх, техникийн болон системийн засвар үйлчилгээг явуулах, нэгдсэн цэг байгуулах болон түүний үйл ажиллагааны журмыг батлах;
- f) Газрын хэвлий ашиглагч этгээд нь орон нутгаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хүний нөөцөө бүрдүүлж байгаа эсэх, түүнчлэн тухайн нутгийн нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах талаарх гэрээний үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавина.

5. Эдийн засгийн салбарын хүний нөөцийн бэлтгэл, дахин сургалт, мэргэжил дээшлүүлэх, сертификатчлах, аттестатчлах, техникийн болон мэргэжлийн боловсролыг дээшлүүлэх чиг үүрэг (ҮААЭТмХ-ийн 13-р зүйл)

Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Үндэсний танхим нь дараах үйл ажиллагааг явуулдаг байна. Үүнд:

- a) Салбарын мэргэшлийн хүрээг тодорхойлоход оролцох, мэргэжлийн стандарт батлах;
- b) Бүх үйл ажиллагааны чиглэлээр нэгдсэн эсхүл салбар дундын стандарт хэм хэмжээ болон хөдөлмөрийн стандарт батлах;
- c) Техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллагын улсын аттестатчлалд оролцох (бие даасан байгууллага үүнд хамаарахгүй болно);
- d) Техникийн болон мэргэжлийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэгч хуулийн этгээдэд боловсролын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгодог зөвлөх байгууллагын ажилд оролцох;
- e) Мэргэжилтэний мэргэшлийн талаарх хараат бус сертификат олгох;
- f) Техникийн болон мэргэжлийн боловсролын улсын байгууллагын удирдах бүтцэд орох (бие даасан байгууллага үүнд хамаарахгүй болно);
- g) Эдийн засгийн салбарын хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэнд тулгуурлан хүний нөөц бэлдэх улсын захиалгыг бэлдэхэд санал өгөх, энэхүү захиалгыг өгөх;
- h) Техникийн болон мэргэжлийн боловсролын хөгжил, хүний нөөц бэлтгэх зорилго бүхий салбарын болон бүс нутгийн зөвлөлүүдийн үйл ажиллагаанд оролцох;
- i) Улсын бүх нийтийн боловсролын стандарт, боловсролын сургалтын програм, техникийн болон мэргэжлийн боловсролын төлөвлөгөө зэрэг сургалт, арга зүйн материал бэлтгэхэд оролцох;
- j) Аж ахуй эрхлэгчдийн мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээнд хяналт тавих;
- k) Мэргэжлийн бэлтгэл, дахин бэлтгэл, мэргэшил дээшлүүлэх, техник болон үйлчилгээний салбарын мэргэжлүүдэд мэргэшил олгох сургалтын төв байгуулах;

- l) Газрын хэвлийн ашиглагч этгээд нь холбогдох гэрээний дагуу БНКУ-ын иргэн ажилтнуудын сургалт, мэргэшил дээшлүүлэх, дахин сургалтанд хамруулахад чиглэгдсэн санхүүжилт гаргах үүргээ хэрэгжүүлж буй эсэх талаар мэдээлэл цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх ажиллагаанд оролцох.

6. Аж ахуй эрхлэгчдийн гадаад худалдааг дэмжих, хөрөнгө оруулалт татах болон үндэсний эдийн засгийг төрөлжүүлэх чиг үүрэг (ҮААЭТmX-ийн 14-р зүйл)

Энэхүү чиглэлээр Үндэсний танхим нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Үүнд:

- a) Гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах;
- b) Казахстан улсын хууль болон олон улсын гэрээний дагуу гадаад улсын байгууллагуудтай хамтран бизнесийн болон зөвлөх байгууллага байгуулах;
- c) Казахстанд зохион байгуулагдах олон улсын, улсын болон бүс нутгийн хэмжээний үзэсгэлэн худалдаа, Казахстан улсын оролцож буй гадаад улсад зохион байгуулагдах үзэсгэлэн худалдааны бүртгэлийг хөтлөх;
- d) Олон улсын зах зээлд Казахстаны бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилах олон улсын маркетинг болон зар сурталчилгааг дэмжих;
- e) Гадаад худалдааны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн, үнэлгээний, брокерын, маркетингийн, зар сурталчилгааны, орчуулгын болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- f) Гадаадын бүх улсын экспорт, импортыг зохицуулж буй хууль тогтоомж, зохион байгуулагдаж буй үзэсгэлэн худалдаа, олон улсын барааны эргэлт, төлбөр, олон улсын худалдаа болон дотоодын аж ахуйтай холбоотой бусад мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, гишүүддээ хүргэх;
- g) Эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ олгох, бүртгэх, гэрчлэх болон хүчингүй болгох;
- h) Тогтоосон журмын дагуу бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ олгосноос хойш гурван жилийн хугацаанд гэрчилгээний болон гарал үүслийг нотлох бусад баримт бичгүүдийн хуулбарыг хадгалах;
- i) Бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ олгох эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгийн дардсын загварыг гаалийн асуудал хариуцсан байгууллага болон техникийн хяналт шалгалт зохицуулагч төрийн байгууллага руу илгээх;
- j) Улирал тутам шинээр олгогдсон бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээний талаарх мэдээллийг холбогдох захиргааны байгууллагад илгээх;
- k) Бүтээгдэхүүний гарал үүсэл тогтоохоос бусад асуудлаар бүтээгдэхүүний талаар хараат бус шинжээчийн дүгнэлт гаргах;
- l) Гадаад худалдаа, эдийн засгийн үйл ажиллагаа явуулдаг санхүү, эдийн засгийн хувьд найдвартай түншид тооцогдох аж ахуй эрхлэгчдийг, тэдгээртэй зөвшилцсөний үндсэн дээр бүртгэлд оруулах, бүртгэлийг хөтлөх;
- m) Казахстан улсын олон улсын гэрээ болон гадаад худалдааны гэрээнд заасан нөхцөлийн дагуу давагдашгүй нөхцөл байдлыг гэрчлэх, түүнчлэн Казахстан улсад хүлээн зөвшөөрөгдсөн худалдааны болон боомтын заншлыг гэрчлэх;

- п) Казахстан улсын олон улсад хүлээсэн үүргийн дагуу гаалиар түр хугацаагаар оруулах баримт бичгийг олгох, батлан даах;
- о) Евро-Азийн эдийн засгийн холбооны болон гадаад улсын бүтээгдэхүүний статусыг тодорхойлох;
- р) Эрх бүхий байгууллагын баталсан загвар маягтын дагуу бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээний маягт боловруулах.

7. ҮНДЭСНИЙ ТАНХИМЫН УДИРДЛАГА, ДОТООД БҮТЭЦ

Үндэсний танхимын удирдлага нь дараах бүтэцтэй байна. (ҮААЭТмХ-ийн 18-р зүйл) Үүнд:

1. Их хурал – удирдах дээд нэгж;
2. Удирдах зөвлөл – удирдах нэгж;
3. Гүйцэтгэх удирдлага – гүйцэтгэх нэгж;
4. Шалгалтын комисс – санхүү хяналтын нэгж.

Бүс нутгийг танхим болон түүний салбарын бүтэц нь:

1. Бүс нутгийн зөвлөл – хяналтын нэгж;
2. Захиргаа – бүс нутгийн танхимын гүйцэтгэх нэгж;
3. Захирал – бүс нутгийн танхимын төлөөлөгчийн удирдлага.

Үндэсний болон бүс нутгийн танхим нь дүрмийнхээ дагуу өөр бусад нэгжийг байгуулж болно.

Танхимын удирдах албан тушаалд ажиллахад цалин хөлс авдаггүй байна.

1. ҮНДЭСНИЙ ТАНХИМЫН ИХ ХУРАЛ (ҮААЭТмХ-ийн 19-р зүйл)

Бүтэц:

- a. Удирдах зөвлөлийн дарга (тэргүүлнэ);
- b. Магадлан итгэмжлэгдсэн салбарын болон салбар дундын холбоо;
- c. Магадлан итгэмжлэгдсэн жижиг, дунд, том бизнесийн холбоо;
- d. Бүс нутгийн зөвлөлийн төлөөлөгчдөөс тус тус бүрдэнэ.

ҮААЭТмХ-д ii – iv –т заасан төлөөлөгчдийн тоо заавал тэгш байна гэж заасан боловч Их хурлын гишүүдийн тоог нарийвчлан тогтоогоогүй байна.

Эрх хэмжээ:

1. Үндэсний танхимын дүрэм батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
2. Үндэсний танхимын Удирдах зөвлөлийн болон Шалгалтын комиссийн гишүүдийг сонгох, чөлөөлөх;
3. Бүс нутгийн зөвлөлийг байгуулах, түүний төлөөлөгчдийг сонгох болон бүрэн эрхийн хугацааг тогтоох журмыг батлах;
4. Тухайн газар нутаг, хот, нийслэлд бүртгэгдсэн аж ахуй эрхлэгчдийн болон холбоодын тооноос хамааран бүс нутгийн зөвлөлийн гишүүдийн тоог тогтоох;
5. Үндэсний танхимын Удирдах зөвлөлийн болон Гүйцэтгэх удирдлагын жилийн тайланг батлах;
6. Гишүүнчлэлийн татварын хэмжээг батлах;

7. Үндэсний танхимын оролцоотойгоор хуулийн этгээд үүсгэн байгуулах тухай шийдвэр гаргах, түүний зорилго, зорилт, эрх хэмжээг тогтоох;
8. Үндэсний танхимын төсвийг батлах;
9. Үндэсний танхимын Шалгалтын комиссын тайланг батлах;
10. Гадаад улсад Үндэсний танхимын салбар, төлөөлөгчийн газар нээх тухай шийдвэр гаргах;
11. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гаргах Үндэсний танхимын жилийн тайланг батлах;
12. Үндэсний танхимаас үзүүлэх үнэ төлбөргүй үйлчилгээг батлах;
13. Гишүүнчлэлийн татвараас чөлөөлөх шийдвэрийг гаргах.

2. ҮНДЭСНИЙ ТАНХИМЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ҮААЭТмХ-ийн 21-р зүйл)

Бүтэц:

Удирдах зөвлөл нь 51 гишүүнээс бүрдэх бөгөөд Удирдах зөвлөлийн дарга даргалана, тэдгээрийг Их хурал томилж чөлөөлнө. Гишүүд дараах этгээдүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. 16 хүн –Казахстан улсын Парламентийн гишүүн болон нийгмийн зүтгэлтэн;
2. 1 хүн – Аж ахуй эрхлэгчдийн эрхийг хамгаалагч албан тушаалтан;
3. 17 хүн – магадлан итгэмжлэгдсэн улсын салбарын болон салбар дундын холбоодын, жижиг, дунд, том бизнесийн холбоодын төлөөлөгч;
4. 17 хүн – бүс нутгийн зөвлөлийн төлөөлөгч.

Эрх хэмжээ:

1. Үндэсний танхим зорилтоо хэрэгжүүлж, зорилгодоо хүрч буй эсэхэд хяналт тавих;
2. Үндэсний танхимын үйл ажиллагааны үр дүнг ихэсгэх талаар санал гаргах;
3. Үндэсний танхимын Гүйцэтгэх удирдлага болон гишүүдийг сонгох;
4. Төрийн, төрийн бус, нийтийн болон олон улсын байгууллагатай хамтарч ажиллахад нь Гүйцэтгэх удирдлаганд дэмжлэг үзүүлэх;
5. Үндэсний танхимын Шалгалтын комиссийн хяналт шалгалтыг даалгах, эцсийн тайланг батлах;
6. Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний танхимын дүрэм, журам болон үйл ажиллагааны бусад баримт бичгийг батлах;
7. Холбоог магадлан итгэмжлэхэд тавигдах шаардлага болон түүний журмыг батлах;
8. Үндэсний танхимын байгуулсан хуулийн этгээдийн дээд удирдлагыг томилох;
9. Удирдах зөвлөлийн дэргэдэх хороо байгуулах, хорооны гишүүний тоо, тавигдах шаардлага болон түүний журмыг батлах;
10. Бүс нутгийн танхимын загвар дүрмийг батлах, түүний салбарын загвар журмыг батлах;
11. Үндэсний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ажил үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийг хөтлөх журмыг батлах, аж үйлдвэрийн гэрчилгээ олгох;
12. Гүйцэтгэх удирдлага болон Үндэсний танхимын үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн үйл ажиллагааны талаар мэдээлэл шаардах эрхтэй;
13. Үндэсний танхимын дүрмээр бусад эрх үүрэг олгож болно.

3. УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРОО (ҮААЭТмХ-ийн 22-р зүйл)

Удирдах зөвлөлийн дэргэдэх хороо нь байнгын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд салбарын тодорхой салбарын чиглэлээр байгуулагддаг байна. Хорооны гишүүдийн тоо гурваас багагүй байх бөгөөд Үндэсний танхимд бүртгэлтэй улсын хэмжээний хороодын гишүүдээс сонгогддог байна.

4. ҮНДЭСНИЙ ТАНХИМЫН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА (ҮААЭТмХ-ийн 23-р зүйл)

Гүйцэтгэх удирдлага нь Их хурал болон Удирдах зөвлөлд үйл ажиллагаагаа тайлагнадаг. Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээ болон гишүүдийн тоог (гишүүдийн тоо таваас багагүй байна) Их хурал тогтоодог бөгөөд түүний захирал болон гишүүдийг Удирдах зөвлөл сонгодог.

Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээ нь Их хурал болон Удирдах зөвлөлийн эрх үүрэгт ороогүй бусад асуудлын талаар шийдвэр гаргах юм. Гүйцэтгэх удирдлагын захирлаас бусад гишүүд нь Их хурал болон Удирдах зөвлөлд орж болдоггүй байна.

Гүйцэтгэх захирлын эрх хэмжээ:

1. Казахстан улсад болон олон улсад Үндэсний танхимыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх;
2. Үндэсний танхимын өдөр тутмын удирдлагыг хэрэгжүүлэх;
3. Үндэсний танхимын үндсэн үйл ажиллагааны хүрээнд түүний нэрийн өмнөөс гэрээ болон бусад баримт бичиг байгуулах;
4. Үндэсний танхимын ашиг сонирхлыг төлөөлж төрийн болон бусад байгууллагатай харилцах;
5. Гүйцэтгэх захирлын орлогчийг гүйцэтгэх удирдлагын гишүүдээс томилох, чөлөөлөх;
6. Үндэсний танхимын үйл ажиллагааг зохион байгуулах, хүний нөөц, албан тушаалын болон үндсэн цалингийн жагсаалт гаргах, батлах Казахстан улсын хөдөлмөрийн хуулийн дагуу ажилд авах, ажлаас чөлөөлөх, шагнал урамшуулал олгох, хариуцлага тооцох;
7. Банкинд харилцах данс нээх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах;
8. Энэхүү хууль болон Үндэсний танхимын дүрмийн хүрээнд түүний эд хөрөнгө, төсвийг захиран зарцуулах;
9. Үндэсний танхимын гишүүний бүртгэлийг хөтлөх;
10. Үндэсний танхим, Их танхим, Удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага болон шалгалтын комиссын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон цахим орчинд байршуулах ажлыг зохион байгуулах;
11. Хууль болон Үндэсний танхимын дүрмэнд харшлаагүй бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

5. ҮНДЭСНИЙ ТАНХИМЫН ШАЛГАЛТЫН КОМИСС (ҮААЭТмХ-ийн 24-р зүйл)

Үндэсний танхимын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор байгуулагдах бөгөөд таваас доошгүй тооны гишүүнтэй байна. Шалгалтын комиссын гишүүд болон тэдгээрийн төрөл, садангийн хүмүүс Их хурал, Удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын гишүүн болж болохгүй.

6. БҮС НУТГИЙН ЗӨВЛӨЛ (ҮААЭТмХ-ийн 25-р зүйл)

Бүс нутгийн зөвлөл гэж бүс нутгийн танхимын хяналтын байгууллага бөгөөд Их хурлаас бүс нутаг, улсын хэмжээний хот болон нийслэлд тогтоосон квотын дагуу аж ахуй эрхлэгчид, холбоо болон өөрөө удирдах байгууллагын төлөөллөөс бүрддэг. Бүс нутгийн зөвлөлийн гишүүнийг дүүргийн болон салбарын зөвлөлөөр аж ахуй эрхлэгчдийн шууд саналаар дөрвөн жилийн хугацаатайгаар сонгоно. Бүс нутгийн зөвлөлийг дарга нь удирдах бөгөөд тухайн дарга нь Удирдах зөвлөлийн гишүүн болно.

Бүс нутгийн зөвлөлийн эрх хэмжээ нь:

1. Бүс нутгийн танхим нь Захиргааг төрийн, төрийн бус, олон нийтийн болон олон улсын байгууллагатай харилцахад нь дэмжлэг үзүүлэх;
2. Удирдах байгууллагуудын баталсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
3. Их хуралд орох төлөөлөгчөө сонгох;
4. Бүс нутгийн танхим болон түүний салбар нь өөрийн эрх хэмжээний хүрээнд Үндэсний танхимын зорилтыг хэрэгжүүлж, зорилгод нь хүрч буй эсэхэд хяналт тавих;
5. Бүс нутгийн танхимын үйл ажиллагаанд эдийн засгийн тодорхой салбар, секторын ашиг сонирхлыг харгалзан үзэх;
6. Үндэсний танхимын үйл ажиллагааны үр дүнг ихэсгэх талаар санал гаргах;
7. Бүс нутгийн танхим болон түүний салбарын удирдлагад нэр дэвшсэн этгээдийг томилохыг зөвшөөрөх;
8. Аж ахуйн салбарын нийтийн сонсголыг явуулах;
9. Бүс нутгийн дүрэмд заасан хүрээнд тавигдсан бусад асуудлыг шийдвэрлэх.

Бүс нутгийн зөвлөл нь бүс нутгийн танхим болон түүний салбарын гүйцэтгэх удирдлага болон Үндсэний танхимын үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн үйл ажиллагааны талаар мэдээлэл шаардах эрхтэй тавьж болно.

7. БҮС НУТГИЙН ТАНХИМ БОЛОН ТҮҮНИЙ ДҮҮРЭГ, ХОТ ДАХЬ САЛБАРЫН УДИРДЛАГА (ҮААЭТмХ-ийн 26-р зүйл)

Бүс нутгийн танхим болон түүний дүүрэг, хот дахь салбарын удирдлагыг Захиргаа болон тэдгээрийн Захирал удирдана. Бүс нутгийн танхимын Захиргааг бүс нутгийн зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр Үндэсний танхимын Гүйцэтгэх удирдлага томилно. Бүс нутгийн танхимын Захирлыг бүс нутгийн зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр Захиргаа томилж чөлөөлнө. Бүс нутгийн зөвлөл болон Үндэсний танхимын Гүйцэтгэх удирдлага нар санал зөрөлдсөн тохиолдолд Үндэсний танхимын Удирдах зөвлөл шийдвэр гаргана.

8. АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАГЧ АЛБАН ТУШААЛТАН (ҮААЭТмХ-ийн 26-1-р зүйл)

Аж ахуй эрхлэгчдийн эрхийг хамгаалагч албан тушаалтныг БНКУ-ын Аж ахуйн хуулинд заасны дагуу тодорхойлно. Аж ахуй эрхлэгчдийн эрхийг хамгаалагч албан тушаалтны мэдээлэл шинжилгээний, хууль эрх зүйн, зохион байгуулалтын болон бусад үйл ажиллагааны дэмжлэгийг түүний аппарат гүйцэтгэх бөгөөд энэхүү аппаратын бүтэц, боловсон хүчний тоо болон түүнд тавигдах шаардлагыг Үндсэний

танхимын Их хурал болон Аж ахуй эрхлэгчдийн эрхийг хамгаалагч албан тушаалтан нар зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.

9. ҮНДЭСНИЙ ТАНХИМ БОЛОН ТӨРИЙН ХАРИЛЦАА

БНКУ-ын Засгийн газар болон Үндэсний танхим нь түүний зорилт болон зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хамтран ажиллана. (ҮААЭТмХ-ийн 5-р зүйл)

Казахстан улсын Засгийн газар дараах эрхтэй байна. **Үүнд:**

1. Гишүүнчлэлийн татварын дээд хязгаарыг тогтоох;
2. Үндсэн хууль, Үндэсний аж ахуй эрхлэгчдийн танхимын тухай хууль, бусад хууль тогтоомж болон БНКУ-ын Ерөнхийлөгчийн зарлигт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх.

Үндэсний танхим болон Засгийн газар дараах арга хэлбэрээр хамтрана. **Үүнд:**

1. Хувийн аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхлыг хөндөж буй эрх зүйн норматив актын төслийг бэлтгэхэд болон шинжлэхэд Үндэсний танхим оролцох;
2. Аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхлыг хөндөж болзошгүй БНКУ-ын байгуулах гэж буй олон улсын гэрээнд болон түүний нэгдэн орох гэж буй олон улсын гэрээ, конвенцид шинжилгээ хийхэд мөн төслийг бэлтгэхэд Үндэсний танхим оролцох;
3. Үндэсний танхим нь Төвийн болон орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран зөвлөх байгуулага байгуулах;
4. Үндэсний танхимын үүсгэн байгуулагдсан үндсэн зорилго, зорилт болон чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад хэлбэрээр хамтран ажиллана.

БНКУ-ын хуульд заасан журмын дагуу аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхлыг хөндөж буй аливаа мэдээллийг Засгийн газрын байгууллагууд Үндэсний танхимын хүсэлтээр гаргаж өгөх үүрэгтэй. Худалдааны, банкны болон бусад хуулиар хамгаалагдсан нууцтай холбоотой мэдээлэл үүнд хамаарахгүй болно.

ДӨРӨВ. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Солонгос улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үүслийг 1884 онд Хангсонг (одоогийн Сөүл) хотод байгуулагдсан Худалдааны танхимтай холбон авч үздэг. Улмаар, 1895 онд Худалдааны танхимын тухай хуулийг баталж гаргасан байдаг.

Харин 1946 онд Жусон (Одоогийн Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим)-ыг байгуулагдснаар өнөөгийн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тогтолцоо хэлбэржсэн байна. Үүний дараа 1952 онд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийг баталж, 1953 оноос нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн статустай болжээ.

Энэхүү тогтолцоо нь Эх газрын загварт хамаарах бөгөөд өнөөгийн байдлаар Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим 1 (KCCI), орон нутгийн Худалдаа, аж үйлдвэрийн танхим 73 (CCI) гэсэн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

1. ТАНХИМЫН БҮТЭЦ

Солонгос улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь шаталсан тогтолцоотой бөгөөд Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим болон бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас бүрддэг байна.

1. Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим (The Korea chamber of commerce and industry)
2. Бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим (chamber of commerce and industry)

Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь бусад Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд удирдлага болон хяналтыг хэрэгжүүлдэг.

Энэ талаар Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 50-р зүйлийн 50.1-д Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим нь бусад худалдаа аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаа болон тайлан тооцоонд чиглэсэн удирдлага болон хяналтыг хэрэгжүүлнэ. Мөн 50.2-т Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим нь бусад Худалдаа, аж үйлдвэрийн танхимд үйл ажиллагаа болон тайлан тооцооны талаар тайлан тавихыг тушаах, аудит оруулах эрхтэй болох талаар зохицуулжээ.

Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дотоод бүтэц (KCCI)¹⁷

Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дотоод бүтцийг хуулиар тусгайлан зохицуулжээ. Ингэхдээ, доорх хоёр зүйлийг тогтоосон байна.

Нэгдүгээрт, Гишүүнчлэлийн хүрээнд үндэсний танхим нь бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг илэрхийлэх ердийн гишүүнээс гадна тусгай гишүүнтэй байх талаар зохицуулсан. Бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим

¹⁷ KCCI, Organizational Chart, (Солонгосын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтэц)
<http://english.korcham.net/nChamEng/Service/About/appl/Organization.asp> (last visited, Jan 22, 2020)

нь ердийн гишүүнд хамаарна. Харин тусгай гишүүнд үндэсний хэмжээний ашгийн бус хуулийн этгээд, байгууллагыг хамааруулан авч үздэг байна (37.2-р зүйл).

Хоёрдугаарт, Дотоод бүтцийн байгууллагын талаар зохицуулсан. Өөрөөр хэлбэл, Их хурал (40.1-р зүйл), ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчид, байнгын хороо (45-р зүйл), хяналтын гишүүд (43.1-р зүйл), захиргааны алба (46-р зүйл)-ыг байгуулахаар тогтоосон байна.

Эдгээр дотоод бүтцийн байгууллага, албан тушаалтны чиг үүрэг нь бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дотоод бүтцийн байгууллага, албан тушаалтныхтай адил тул хураангуйлан авч үзлээ.

Бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дотоод бүтэц

Танхимын дотоод бүтцийг танхимын хурал болон албан тушаалтан гэсэн хоёр бүлэгт ангилан авч үзье.

Бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хурал

а. ИХ ХУРАЛ

Танхим нь их хуралтай байх (18.1-р зүйл) бөгөөд ердийн гишүүн болон тусгай гишүүдээс бүрдэнэ. Их хурлын гишүүдийн тоог 100 хүртэл байхаар танхимын дүрмээр тогтоох (21.1-р зүйл) бөгөөд тусгай гишүүдийн тоо нь тавны нэгээс хэтэрч болохгүй (21.2-р зүйл). Ердийн гишүүд нь танхимын нийт гишүүдийн дундаас сонгогдох бол тусгай гишүүд нь танхимын тусгай гишүүдийн дундаас сонгогдоно (22.1-р зүйл). Тэдгээрийн сонгуулийн хугацаа 3 жил байна (25.1-р зүйл).

Мөн танхим нь ээлжит болон ээлжит бус хуралтай байна. Ээлжит хурлыг танхимын дүрэмд заасны дагуу жилд доод тал нь нэг удаа хуралдуулна (18.3-р зүйл). Харин ээлжит бус хурлыг шаардлагатай тохиолдолд ерөнхийлөгч эсхүл гишүүдийн гуравны нэгээс дээш нь зорилго болон шалтгааныг бичсэн хүсэлтийг тавьсанаар ерөнхийлөгч зарлан хуралдуулна (18.4-р зүйл).

Их хурлаар танхимын суурь шинжтэй зүйлсийг шийдвэрлэнэ. Үүнд, 1-т танхимын дүрэмд өөрчлөлт оруулах, гишүүнчлэлийн татварт хамаарах асуудал, их хурлын гишүүдийн сонгоход хамаарах асуудал, албан тушаалтнуудыг сонгох, чөлөөлөхөд хамаарах асуудал, татан буулгах, гишүүнийг хасах, танхимыг нэгтгэх нийлүүлэх болон дүрэмд заасан бусад асуудал хамаардаг байна (19-р зүйл).

б. БАЙНГЫН ХОРОО

Танхим нь байнгын хороотой байх бөгөөд хорооны бүрэлдэхүүнд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчид, байнгын гишүүд орно (30.2-р зүйл). Мөн байнгын дэд

ерөнхийлөгчтэй байж болохоор зохицуулсан том хотуудын хувьд байнгын дэд ерөнхийлөгч нь хорооны бүрэлдэхүүнд орно.

Ерөнхийлөгч нь өөрөө шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эсхүл байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй гишүүд хороог хуралдуулах зорилго болон шалтгаанаа бичгэн хэлбэрээр хүргүүлсэн тохиолдолд ерөнхийлөгч байнгыг хороог хуралдуулна (30.3-р зүйл).

Байнгын хороо нь дараах зүйлсийг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд, 1-т ажлын төлөвлөгөө, төсөв батлах, дотоод засаглал, үйлчилгээнд хамаарах хэм хэмжээг өөрчлөх, нарийн бичгийн даргын цалинг тогтоох, танхимын дүрэмд заасан бусад зүйлсийг харъяалан авч үздэг (31-р зүйл).

Бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын албан тушаалтнууд

с. ЕРӨНХИЙЛӨГЧ

Танхим нь 1 ерөнхийлөгчтэй байх (27.1-р зүйл) бөгөөд ерөнхийлөгч нь танхимыг төлөөлж, танхимын үйл ажиллагаанд нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлнэ (29.1).

д. ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

Танхим нь дэд ерөнхийлөгчидтэй байх (27.1-р зүйл) бөгөөд дэд ерөнхийлөгчид нь ерөнхийлөгчөөс тогтоосон дарааллын дагуу ерөнхийлөгч албан үүргээ гүйцэтгэх боломжгүй үед түүний ажил үүргийг орлон гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллага юм (29.2-р зүйл).

е. ХЯНАЛТЫН ГИШҮҮД

Танхим нь хяналтын гишүүдтэй байх (27.1-р зүйл) бөгөөд хяналтын гишүүд нь танхимын үйл ажиллагаа, хөрөнгийг шалгах, аудит хийх чиг үүрэг бүхий байгууллага юм (29.4-р зүйл).

ф. НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Танхим нь нарийн бичгийн даргатай байх бөгөөд наргийн бичгийн дарга нь захиргааны асуудлыг хариуцан ажиллах чиг үүргийг хүлээнэ (32.1-р зүйл). Улмаар түүний ажил үүргийг талаар танхимын дүрмээр нарийвчлан тусгахаар зохицуулжээ (32.2-р зүйл).

2. ТАНХИМЫН ГИШҮҮНЧЛЭЛ

Солонгос улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүнчлэлийн шинжийг авч үзэхдээ Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим болон бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим хэмээн салгах нь зүйтэй.

Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим

Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим (KCCI) нь хоёр төрлийн гишүүнчлэлтэй байдаг. Үүнд:

Ердийн гишүүн (regular membership)

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн дагуу бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь KCCI-ийн ердийн гишүүнд байх бөгөөд өнөөгийн байдлаар 73-н ердийн гишүүнтэй байна.

Тусгай гишүүн (special membership)

Тусгай гишүүн нь Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын сайн дурын гишүүн байна. Өөрөөр хэлбэл, Ашгийн бус байгууллага (Non-profit institutions), ашгийн бус зохион байгууллалттай нэгдлийн холбоо (federations of non-profit organizations), худалдаа, аж үйлдвэрийн секторт хамаарах бизнесийн холбоод нь KCCI-ийн тусгай гишүүн болох боломжтой байдаг. Өнөөгийн байдлаар 105-н байгууллага KCCI-ийн тусгай гишүүнээр бүртгүүлсэн байна.

Бүс нутаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхим

Өнөөгийн байдлаар бүс нутаг дахь 73-н Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь нийт 180,000 гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр нь дөрвөн өөр төрийн гишүүдээс бүрддэг.

а. Албан ёсны гишүүн

Албан ёсны гишүүн нь хуульд заасан шалгуурыг хангасан тохиолдолд заавал гишүүнээр бүртгүүлэх агуулгийг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэх дүрэмд тусгайлан зааснаас дээш худалдааны эргэлт бүхий компаниуд тухайн бүс нутгийн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын албан ёсны гишүүнд хамаарна.

Харин Худалдаа эргэлтийн хэмжээ тухайн бүс нутгийн эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан харилцан адилгүй тогтоогдсон байна. Тухайлбал, Сөүл хотын бүс нутагт 16,000,000,000 (16 billion) вон, бусад 6-н том хотууд 5,000,000,000 (5 billion) вон байдаг, бусад жижиг хотууд болон орон нутагт 2,500,000,000 (billion) вон байхаар зохицуулжээ.

Энэхүү худалдаа эргэлтийн хэмжээг гурван жилд нэг удаа шинэчлэн тогтоох бөгөөд ингэхдээ инфляцийн түвшин болон эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзэхээр хуульчилсан байна (10.4-р зүйл).

б. Сайн дурын гишүүн

Албан ёсны гишүүнчлэлд хамаарах хуулийн шалгуурт нийцээгүй компаниуд нь сайн дурын үндсэн дээр худалдаа аж үйлдвэрийн танхимын гишүүн болох хүсэлтийг гаргаж болох бөгөөд тэдгээрийг гишүүнээр бүртгэх эсэхийг тухайн танхим шийдвэрлэдэг(11.1-р зүйл).

с. Тусгай гишүүн

Худалдаа аж үйлдвэрт хамаарах үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус хуулийн этгээд эсхүл байгууллагууд нь худалдаа аж үйлдвэрийн тусгай гишүүн болох хүсэлтийг гаргаж болно.

d. Дэд гишүүн (Associate Membership)

Худалдаа аж үйлдвэрийн үйл ажиллагаанд оролцох эсхүл түүний байгууламжийг ашиглах сонирхол бүхий этгээд нь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэд гишүүн болох хүсэлтийг гаргаж болно.

Дэд гишүүд нь бусад танхимын гишүүдийн адил гишүүнчлэлийн татвар төлөх бөгөөд татварын хэмжээг танхимын дүрмээр зохицуулна (12.2-р зүйл).

3. ТАНХИМЫН НЭРИЙН ХАМГААЛАЛ

Солонгос улсад Худалдаа, аж үйлдвэрийн танхимын нэрийг тусгайлан хамгаалсан байна. Энэ талаар Худалдаа аж үйлдвэрийн тухай хуулийн 52-р зүйлд зохицуулжээ.

Тухайлбал, 52.1-д Энэ хууль дахь Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим эсхүл Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас бусад байгууллага “Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим” (The Korea chamber of commerce and industry) эсхүл “Худалдаа, аж үйлдвэрийн танхим” (chamber of commerce and industry) эсхүл бусад төсөөтэй нэрийг хэрэглэхийг хориглосон.

Улмаар, 52-р зүйлийн зөрчсөн этгээд нь уг хуулийн 57.1-ийн дагуу 1,000,000 хүртэлх вонын торгууль хүлээх бөгөөд торгуулийг Худалдаа, үйлдвэрлэл, энергийн яам ногдуулдаг байна.

4. ТАНХИМЫН ЧИГ ҮҮРЭГ

Худалдаа аж үйлдвэрийн танхим нь худалдаа, аж үйлдвэрийг бэхжүүлж, нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах хүрээнд олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг. Энэ талаар Худалдаа, аж үйлдвэрийн тухай хуулийн 3-р зүйлд тодорхой тусгасан байна.

1. Худалдаа, аж үйлдвэрийн талаарх засгийн газар болон орон нутгын захиргааны бодлогын асуудалд зөвлөх, дэмжлэг үзүүлэх;
2. Худалдаа, аж үйлдвэрийн асуудлаар олон нийтийг хамарсан судалгаа болон судалгааны ажил хийх;
3. Худалдаа, аж үйлдвэрийг дэмжихэд чиглэсэн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;
4. Худалдаа, аж үйлдвэрийн секторт хамаарах материал болон мэдээлэлийг цуглуулах, хэвлүүлэх; Худалдаа, аж үйлдвэрийн удирдлага, боловсрол болон худалдааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зуучлах;

6. Худалдаа, аж үйлдвэрт хамаарах гэрчилгээ, шалгалт, үнэлгээг гүйцэтгэх;
7. Худалдаа, аж үйлдвэрт хамаарах чадвар болон технологийг тогтоох, хувиарлах;
8. Том, дунд, жижиг аж ахуй нэгжийг холбох, хамтран ажиллах;
9. Худалдааны арбитрын үйл ажиллагаанд хамаарах дотоодын болон гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах;
10. Худалдаа, аж үйлдвэрийн секторт үйл ажиллагаа явуулж байгаа этгээдүүдийн эрх ашгийг хамгаалж, нийгмийн хамгаалалыг сайжруулах;
11. Худалдаа, аж үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд арга хэмжээ, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, дэмжиж оролцох;
12. Худалдаа, аж үйлдвэрт хамаарах үзэсгэлэн яармаг түүнд чиглэсэн байгууламж оруулж ирэх, хариуцаж ажиллуулах;
13. Эдийн засгийн ёс зүйг тогтоож, бизнесийн ёс суртахууныг бэхжүүлэх;
14. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа болон олон улсын худалдааг бэхжүүлэх;
15. Мэргэжлийн боловсрол болон дадлага, мэргэжлийн чадварыг хөгжүүлэх;
16. Орон нутгын захиргаа болон төв засгийн газрын даалгасан ажлыг гүйцэтгэх;
17. Бусад ажил үүрэг.

5. ТАНХИМЫН САНХҮҮЖИЛТ

Худалдаа аж үйлдвэрийн санхүүгийн эх үүсвэрийн талаар Худалдаа аж үйлдвэрийн тухай хуулийн 38 болон 53, 54-р зүйлд тусгасан байна. Энд зааснаар танхимын санхүүжилт нь доорх гурван төрлийн эх үүсвэрээс бүрдэнэ.

1. Гишүүнчлэлийн татвар

Танхим нь гишүүнчлэлийн татвараар санхүүжинэ (38, 53.1-р зүйл).

2. Үйлчилгээний хураамж

Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим болон бусад аж үйлдвэрийн танхим нь үйлчилгээний хураамжаас санхүүжинэ (53.1-р зүйл).

3. Төрийн дэмжлэг

Танхимын төсвийн төлөвлөгөөний хүрээнд түүний үйл ажиллагаанд орон нутгийн захиргаанаас санхүүгийн дэмжлэг үзүүлдэг байна (54.1-р зүйл).

6. ТӨРИЙН ХЯНАЛТ

Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд төрийн зүгээс хяналт тавьдаг бөгөөд энэ талаар Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 51-т тусгайлан зохицуулсан.

Тухайлбал, 51.1-т Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь Худалдаа, үйлдвэрлэл, энергийн яаманд ажил үүргээ хариуцан тайлагнах үүрэг хүлээнэ. Мөн 51.2-т Худалдаа, үйлдвэрлэл, энергийн яам нь Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас түүний бизнес, тайлан тооцоотой холбоотой шаардлагатай материалыг гаргаж өгөхийг шаардах болон өөрийн албан тушаалтнаар дамжуулан түүний бизнес,

тайлан тооцоотой холбоотой шаардлагатай материалыг шалгах эрхтэй байхаар зохицуулсан байна.

ТАВ. ЯПОН УЛС

Японы улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үүслийг 1878 онд Токёо, Оосака, Кобэ хотод байгуулагдсан Худалдааны танхимтай холбон авч үздэг. Улмаар 1892 онд томоохон хотуудад байгуулагдсан Худалдааны танхимыг нэгтгэсэн Худалдааны танхимуудын холбоог байгуулсан.

Харин 1922 онд Худалдааны танхимуудын холбоонд шинэчлэл хийж, байнгын үйл ажиллагаа бүхий Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг үүсгэн байгуулсан байна. Үүний дараа, 1954 онд өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Худалдааны танхимын тухай хуулийн баталж, нийт 515 Худалдаа, аж үйлдвэрийн танхимын 1,250,000 гишүүдийг¹⁸ багтаасан томоохон тогтолцоо бүрэлдсэн байна.

Энэхүү тогтолцоо нь Азийн загварт хамаардаг бөгөөд дараах үндсэн зарчим (4-р зүйл)-ын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

1. Ашгийн бус байх
2. Тодорхой хувь этгээд, хуулийн этгээд, бусад этгээдийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахгүй байх
3. Тодорхой намын эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахгүй байх

1. ТАНХИМЫН БҮТЭЦ

Япон улс нь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулиар Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтцийн талаар тусгайлсан зохицуулсан байна. Энэхүү бүтцийн зохицуулалт нь бүхий л Худалдаа, аж үйлдвэрийн танхимд үйлчлэх бөгөөд тэдгээрийн хэмжээнээс шалтгаалан тодорхой ялгаа харагддаг.

Японы Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь дараах бүтэцтэй байна.¹⁹

1. Үндсэн Худалдаа, аж үйлдвэрийн танхим (1)
2. Бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим (515)

Бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь тухайн бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн хөгжилд дэмжлэг үзүүлж, нийгмийн халамжийг сайжруулахыг зорих бөгөөд худалдаа, аж ахуй эрхлэгчдийн саналыг цуглуулж, бодлого боловсруулах, бизнесийн менежментийг сайжруулах, бүс нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах зэрэг олон төрлийн үйл ажиллагааг явуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Харин Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь бүс нутаг дахь худалдаа аж үйлдвэрийн танхимыг гишүүн болгож, нэгдсэн удирдлагаар хангах бөгөөд тэдгээрийг төлөөлөх чиг үүрэгтэй байдаг.

¹⁸ 2015 оны 3 сарын байдлаарх бүтэц болно.

¹⁹ “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын олон улсын харьцуулалт”, Тенфордын Лорд Хэсэлтайн, х29. (The Rt Hon the Lord Heseltine of Thenford CH, Chamber of Commerce International Comparisons, (2012)).

Хүснэгт 1. Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим болон бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын харьцуулалт²⁰

	Ангилал	Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	Бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим
1	Гишүүнчлэл	Бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим (66-р зүйл)	Тухайн бүс нутагт 6 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулах худалдаа, аж үйлдвэр эрхлэгч
3	Албан тушаалтан	Ерөнхийлөгч 1, Тэргүүлэгчид 5-аас доош, Удирдах зөвлөлийн гишүүн 51-ээс доош, Хяналтын гишүүн 2-3, Байнгын захирал 1, захирал 4-өөс доош (69-р зүйл)	Ерөнхийлөгч 1, Тэргүүлэгчид 4-өөс доош, Удирдах зөвлөлийн гишүүн (тогтмол гишүүний 3/1-ээс доош), Хяналтын гишүүн 2-3, Ерөнхий захирал 1, захирал 4-өөс доош(32-р зүйл)
4	ИХ-ын гишүүдийн тоо	102-оос доош (42-р зүйл)	30-150 (75-р зүйл)
5	Хурал	Бүх гишүүдийн хурал (73-р зүйл) Их хурал (74-р зүйл) Удирдах зөвлөлийн хурал (76-р зүйл)	Их хурал (41-р зүйл) Удирдах зөвлөлийн хурал (51-р зүйл)
6	Салбарын хурал	-	Гишүүдийн салбар (54-р зүйл)

Ийнхүү, Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим болон бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь гишүүнчлэл болон дотоод бүтцийн байгууллагын хүрээнд тодорхой ялгаатай байна.

Улмаар Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дотоод бүтцийн байгууллагыг тодорхой байдлаар авч үзье. Ингэхдээ, бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дотоод бүтцэд хамаарах эрх зүйн зохицуулалтад тулгуурлан авч үзнэ. Учир нь Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дотоод бүтэцийн байгууллагуудыг чиг үүрэг нь бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дотоод бүтэцийн байгууллагуудаас төдийлэн ялгарахгүй байна.

Мөн Бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь эмэгтэйчүүдийн холбоотой байх бөгөөд тэдгээрийн нэгдсэн холбоог Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын доор байгуулсан байдаг.

²⁰ Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай, Японы Худалдаа, аж үйлдвэрийн танхим, <https://www.jcci.or.jp/aboutcci.pdf> (хамгийн сүүлд 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэвтэрсэн)

Бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хурал

I. ИХ ХУРАЛ

Танхим нь их хуралтай байх бөгөөд түүний гишүүний тоог танхимын дүрмээр 30-150-ийн хооронд тогтооно (42.1-р зүйл). Улмаар, дараах гишүүдээс бүрдэнэ (41.1-р зүйл). Үүнд, 1-т танхимийн гишүүн болон тусгай худалдаа, аж үйлдвэр эрхлэгч тус бүрийн дундаас сонгуулийн үндсэн дээр сонгогдсон гишүүн, 2-т Салбарын хурлын гишүүдийн дундаас сонгогдсон гишүүн, 3-т танхимын дүрэмд заасны дагуу танхимын гишүүдийн дундаас сонгогдсон гишүүн (41.2-р зүйл).

Мөн ажил үүргийг гүйцэтгэх боломжгүй, танхимын гишүүний төлбөрийг төлөөгүй, танхимын өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй, танхимын нэр хүндийг унагаасан эсхүл зорилгод үл нийцэх үйлдэл хийсэн, танхимын дүрмээр тогтоосон үйлдлийг хийсэн гишүүнийг их хурлын гишүүний үүрэгт ажилаас огцруулж болно (44-р зүйл).

Түүнчлэн, их хурал нь ээлжит болон ээлжит бус хуралтай байх бөгөөд ээлжит хурлыг жилд хамгийн багадаа нэг удаа хуралдуулна (45.1-р зүйл). Харин танхимын ерөнхийлөгч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд дүрэмд заасны дагуу ээлжит бус хурлыг хуралдуулж болно (45.2-р зүйл). Мөн нийт гишүүдийн тавны нэгээс дээш гишүүдийн зөвшөөрлийг авсан гишүүн ээлжит бус хурал хуралдуулах зорилго болон шалтгааныг ерөнхийлөгчид хүргүүлсэн тохиолдолд ерөнхийлөгч 30 хоногын дотор ээлжит бус хурлыг хуралдуулах үүрэг хүлээнэ.

Танхимын их хурлаар танхимыг татан буулгах, нийлэх нэгдэх, гишүүний төлбөр болон үйлчилгээний төлбөр, сонгуульд хамаарах журмын өөрчлөлт, бусад дүрэм журам батлах, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн шийдвэр, гишүүний эрхийг зогсоох, гишүүнээс хасах, хурлын гишүүнээс огцруулах болон бусад дүрэмд шийдвэрлэхээр заасан зүйлсийг авч хэлэлцдэг байна (46.1-р зүйл). Эдгээрийн дундаас дүрэмд өөрчлөлт оруулах шийдвэр гарсан тохиолдолд ерөнхийлөгч эдийн засаг, аж үйлдвэрийн сайдаас зөвшөөрөх авах бөгөөд зохих зөвшөөрлийг авахгүй дүрмийн өөрчлөлтөд эрх зүйн үр дагавар үүсэхгүй байхаар зохицуулжээ (49.2 болон 3-р зүйл).

Танхим их хурал нь гишүүдийн гуравны нэгээс дээш гишүүд оролцсоноор ирц бүрдэж, оролцсон гишүүдийн олонхийн саналаар түүний шийдвэр нь хүчин төгөлдөр болно (48.1 болон 2-р зүйл).

II. УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Танхим нь удирдах зөвлөлтэй байх бөгөөд гишүүдийн тоо нь их хурлын нийт гишүүний гуравны 1-ээс дээшгүй байна (32.2-р зүйл). Улмаар, Удирдах зөвлөл нь ерөнхийлөгчээс даалгасан тажил үүргийг хэрэгжүүлнэ (33.4-р зүйл). Удирдах зөвлөлийн гишүүнийг танхимын дүрэмд заасны дагуу их хурлаас танхимын гишүүдийн дундаас сонгож, чөлөөлөнө (35.4-р зүйл)

Ерөнхийлөгч шаардлагатай гэж үзсэн эсхүл удирдах зөвлөлийн гишүүдийн тавны нэгээс дээш гишүүд шаардсан тохиолдолд удирдах зөвлөлийг хуралдуулна (51.3-р зүйл).

Бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын албан тушаалтнууд

I. ЕРӨНХИЙЛӨГЧ

Танхим нь 1 ерөнхийлөгчтэй байх (32.1-р зүйл) бөгөөд ерөнхийлөгч нь танхимыг төлөөлж, нэгдсэн удирдлагаар хангана (33.1-р зүйл). Ерөнхийлөгчийг танхимын дүрэмд заасны дагуу их хурлаар танхимын гишүүдийн дундаас сонгож, чөлөөлнө (35.1-р зүйл).

II. ТЭРГҮҮЛЭГЧИД

Танхим нь 4-өөс доош тооны тэргүүлэгчтэй байх (32.1-р зүйл) бөгөөд тэргүүлэгчид нь ерөнхийлөгчид туслах чиг үүргийг хэрэгжүүлж, ерөнхийлөгч эзгүй үед түүнээс тогтоосон дарааллын дагуу түүний ажил үүргийг орлон гүйцэтгэнэ (33.2-р зүйл).

Тэргүүлэгчдийг танхимын дүрэмд заасны дагуу их хурлын зөвшөөрсөнөөр ерөнхийлөгч танхимын гишүүний дундаас сонгож, чөлөөлнө (35.2-р зүйл)

III. ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Танхим нь 1 ерөнхий захиралтай байх (32.1-р зүйл) бөгөөд ерөнхий захирал нь ерөнхийлөгч болон тэргүүлэгчид туслах чиг үүргийг хэрэгжүүлж, танхимын үйл ажиллагааг хариуцаж, ерөнхийлөгч болон тэргүүлэгчдийн эзгүйд тэдгээрийг ажил үүргийг орлон гүйцэтгэнэ (33.3-р зүйл).

Ерөнхий захирлыг танхимын дүрэмд заасны дагуу их хурлын зөвшөөрсөнөөр ерөнхийлөгч танхимын гишүүний дундаас сонгож, чөлөөлнө (35.3-р зүйл)

IV. ЗАХИРАЛ

Танхим нь 4 хүртэл тооны захиралтай байж болох бөгөөд тэдгээр нь ерөнхий захиралд туслах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Захирлыг танхимын дүрэмд заасны дагуу удирдах зөвлөлийн зөвшөөрсөнөөр ерөнхийлөгч танхимын гишүүдийн дундаас сонгож, чөлөөлнө (35.6-р зүйл).

V. ХЯНАЛТЫН ГИШҮҮН

Танхим нь 2-3 тооны хяналтын гишүүнийг ажиллуулах (32.3-р зүйл). бөгөөд хяналтын гишүүн нь танхимын үйл ажиллагаа, эдийн засгийн тооцоог хянаж, өөрийн үнэлгээг их хуралд тайлан тавих үүрэгтэй (33.5-р зүйл). Мөн хяналтын гишүүн нь

ерөнхийлөгч, тэргүүлэгч, ерөнхий захирал, бусад захирлын албан тушаалыг хавсарч эрхлэхийг хориглогдог байна (34-р зүйл).

Хяналтын гишүүнийг танхимын дүрэмд заасны дагуу их хурлаас танхимын гишүүдийн дундаас сонгож, чөлөөлнө (35.5-р зүйл).

Түүнчлэн, Танхим нь албан тушаалтнуудын томилгооны хугацааг нийтлэг байдлаар 3 жилээс дээшгүй байхаар дүрмээр тогтоох (36.1-р зүйл) бөгөөд тэдгээрийн тухайн албан тушаалд дахин томилж болно (36.2-р зүйл)

VI. САЛБАРЫН ХУРАЛ

Танхим нь танхимын гишүүний үйл ажиллагааны салбар бүрт нь тухайн үйл ажиллагаанд түлхэц болоход чиглэсэн салбарын хурлыг зохион байгуулна (54.1-р зүйл). Салбар хурлын төрөл, зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар танхимын дүрмээр тогтооно (54.3-р зүйл)

VII. ХОРООД

Танхим нь танхимын дүрэмд заасны дагуу зорилгодоо хүрэхийн тулд чухал зүйлсийг судлахад чиглэсэн хороодыг байгуулж болно (55-р зүйл).

VIII. АЖЛЫН АЛБА

Танхим нь ажлын албатай байх бөгөөд зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар өөрийн дүрмээр зохицуулна (56-р зүйл).

IX. БУСАД БАЙГУУЛЛАГУУД:

Эмэгтэйчүүдийн холбоо

Танхим нь өөрийн дэргэд эмэгтэйчүүдийн холбоог байгуулж болох бөгөөд эмэгтэй бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа бэхжүүлэх замаар эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг түлхүү явуулдаг. Өнөөгийн байдлаар худалдаа аж үйлдвэрийн дэргэд 417 эмэгтэйчүүдийн холбоо байна²¹.

Тухайлбал, Токёо хотын Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь 1 ерөнхий захирал, 4 дэд захирлын бүрэлдэхүүн бүхий эмэгтэйчүүдийн холбоог үүсгэн байгуулсан бөгөөд эмэгтэй бизнес эрхлэгч болон албан тушаалтныг гишүүнээр элсүүлдэг.

Гишүүнчлэлийн татвар нь жилд 10,000 еэн байх бөгөөд эхний жилд гишүүнчлэлийн татвараас чөлөөлөх, гишээнээр элссэн сараас шалтгаалан гишүүнчлэлийн татварыг багасгах зэрэг тусгай зохицуулалтуудыг хийж өгчээ²².

²¹ Эмэгтэйчүүдийн холбооны албан ёсны цахим хуудас, <http://joseikai.icci.or.jp/> (хамгийн сүүлд 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэвтэрсэн)

²² Холбооны тухай танилцуулга, Эмэгтэйчүүдийн холбооны албан ёсны цахим хуудас <http://joseikai.tokyo-cci.or.jp/signup/> (хамгийн сүүлд 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэвтэрсэн)

Залуучуудын хэлтэс

Танхим нь өөрийн дэргэд залчуудын хэлтэс байгуулж болох бөгөөд худалдаа, аж үйлдвэрийн үйл ажиллагааг хөгжүүлж, бизнес эрхлэгчийн чадварыг дээшлүүлэх замаар томоохон шинэчлэл, өөрчлөлтийг хийх зорилго бүхий байгууллага юм.

Залуучуудын хэлтэсийн гишүүнчлэл нь танхимын гишүүн бизнес эрхлэгч (хуулийн этгээд бол албан тушаалтан байж болно), түүний хамаатан садан, залгамжлагч болох 45-аас хүртэлх насны этгээдээр хязгаарлагдана²³.

2. ТАНХИМЫН ГИШҮҮНЧЛЭЛ

Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүнчлэл нь бүс нутаг дахь худалдаа аж үйлдвэрийн танхимаас бүрдэнэ. Харин бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүнчлэл нь сайн дурын байна.

Гэхдээ сайн дурын гишүүнчлэлийн хүрээнд тодорхой шалгуурыг хуульчилж өгсөн байна. Өөрөөр хэлбэр, тухайн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын харъяалах бүсэд 6 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулах газар, ажлын байр, үйлдвэр бүхий аж ахуй эрхлэгч нь гишүүнээр элсэх эрхтэй (15-р зүйл) байдаг. Улмаар, танхим нь дээрх шалгуурыг хангасан этгээдийг тодорхой шалтгаангүйгээр бүртгэхээс татгалзахгүй байхыг үүрэг хүлээдэг(16-р зүйл).

Түүнчлэн, гишүүнээр элсэх хураамж болон гишүүнчлэлийн татвар нь тухайн танхимаас шалтгаалан ялгаатай байна. Тухайлбал, Токёо хотын бүс дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь дараах байдлаар гишүүнээр элсэх хураамж болон гишүүнчлэлийн татварын хэмжээг тогтоосон байна²⁴.

Хүснэгт 2. Гишүүнээр элсэх хураамж

1	Хуулийн этгээд, групп	3000 еэн
2	Хувь хүн (Хувиараа аж ахуй эрхлэгч)	3000 еэн

Гишүүнээр элсэх хураамжийг гишүүнээр элсэгчийн зохион байгуулалтын хэлбэр, түүний үйл ажиллагаанаас үл хамааран нийтлэг байдлаар 3000 еэн хэмээн тогтоожээ.

Хүснэгт 3. Хуулийн этгээдийн гишүүнчлэлийн татвар

Дүрмийн сангийн хэмжээ	Дахин	1 жилийн гишүүнчлэлийн татвар
5,000,000 еэн хүртэл	1	15,000 еэн

²³ Залуучуудын хэлтэсийн танилцуулга, <https://21impulse.jp/info/> (хамгийн сүүлд 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэвтэрсэн)

²⁴ Төлбөрийн хэмжээ, <https://www.tokyo-cci-nyukai.jp/fee/> (хамгийн сүүлд 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэвтэрсэн)

5,000,000 еэнээс дээш	2	30,000 еэн
1000,0000 еэнээс дээш	3	45,000 еэн
3000,0000 еэнээс дээш	4	60,000 еэн
5000,0000 еэнээс дээш	5	75,000 еэн
8000,0000 еэнээс дээш	6	90,000 еэн
1,0000,0000 еэнээс дээш	8	120,000 еэн
4,0000,0000 еэнээс дээш	10	150,000 еэн
7,0000,0000 еэнээс дээш	13	195,000 еэн
10,0000,0000 еэнээс дээш	16	240,000 еэн

Хуулийн этгээдийн гишүүнчлэлийн татвар нь ашгийн төлөө хуулийн этгээд болон компаниудад голчлон чиглэгдсэн бөгөөд тэдгээр байгууллага нь дүрмийн сангийн хэмжээндээ тохируулан гишүүнчлэлийн татварийн төлдөг байна.

Хүснэгт 4. Группын гишүүнчлэлийн татвар

Ажилтны тоо	Дахин	1 жилийн гишүүнчлэлийн татвар
10 хүртэлх хүн	1	15,000 еэн
10 дээш	2	30,000 еэн
30 дээш	3	45,000 еэн
50 дээш	4	60,000 еэн
100 дээш	5	75,000 еэн
200 дээш	6	90,000 еэн
500 дээш	8	120,000 еэн
1000 дээш	10	150,000 еэн
2000 дээш	20	300,000 еэн

Группын гишүүнчлэлийн татвар нь олон улсын байгууллага, сургууль, эмнэлэг, нийгмийн халамжийн байгууллага зэрэгт зориулагдсан бөгөөд тэдгээр байгууллага нь ажилтны тооноосоо хамааран гишүүнчлэлийн татварийг төлдөг байна. Харин Хувь хүн буюу хувиараа аж ахуй эрхлэгчид нийтлэг байдлаар 10,000 еэн байхаар тогтоосон.

3. ТАНХИМЫН НЭРИЙН ХАМГААЛАЛТ

Танхимын нэрийн талаарх Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3-р зүйлд тусгайлан зохицуулсан. Ингэхдээ, худалдаа аж үйлдвэрийн танхимын чиг үүргийг хэрэгжүүлэгч этгээдэд холбогдох тодотголыг хэрэглэхийг үүрэг болгосноос гадна танхимын нэрийг тусгайлан хамгаалсан байна.

Тодорхой агуулгийг доорх эрх зүйн зохицуулалтаас үзнэ үү.

- 3.1. “Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь түүний нэрийн хүрээнд худалдаа аж үйлдвэрийн танхим эсхүл японы Худалдаа, аж үйлдвэрийн танхим гэсэн нэр томъёог оруулах үүрэгтэй.”
- 3.2. “Худалдаа, аж үйлдвэрийн танхим биш этгээд түүний нэрийн хүрээнд Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг илэрхийлэх нэр томъёо эсхүл Худалдаа, аж үйлдвэрийн танхим хэмээн андуурах нэр томъёо хэрэглэхийг хориглоно. Харин тусгай тохиолдолд эдийн засаг аж ахуйн яамны сайдын зөвшөөрлийн үндсэн дээр хэрэглэхийг хориглохгүй.”

Ийнхүү, Японы улсын хувьд Худалдаа, аж үйлдвэрийн танхим гэх нэрийг зөвхөн Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага хэрэглэх байдлаар зохицуулж, нэрийг хамгааллыг эрх зүйн түвшинд бий болгосон байна.

4. ТАНХИМЫН ЧИГ ҮҮРЭГ

Япон улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь худалдаа, аж үйлдвэрийг бэхжүүлж, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах хүрээнд олон төрлийн үйл ажиллагааг явуулдаг²⁵. Эдгээр олон төрлийн үйл ажиллагааг эрх зүйн зохицуулалтад тулгуурлан товчхон авч үзье (9-р зүйл).

I. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын байр суурийг нийтэд илэрхийлж, УИХ, засгийн газарт санал хүргүүлэх, хэлэлцүүлэх

Бүс нутаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимууд нь бүсийн хөгжил, байгаль орчны төлөвлөлт, хот төлөвлөлт, орон нутгийн үйлдвэржилт, гадаад худалдааг дэмжих зэрэг парламент, засгийн газрын бодлогын асуудалд идэвхтэй оролцож ирсэн байна²⁶.

Тухайлбал, 2019 онд гэхэд Оюуны өмчийн талаар төрийн бодлогод санал хүргүүлсэн (2019.03.20), Цахилгаан нийлүүлэгчид хамаарах сэргээгдэх эрчим хүчний дүрмийн өөрчлөлтөд санал хүргүүлсэн (2019.03.07), Оюуны өмчийн маргааныг шийдвэрлэх механизмын шинэчлэлд санал хүргүүлсэн (2019.02.21), Гадаад иргэдийн ажиллуулах асуудалд тавих хяналтын бодлогод санал хүргүүлсэн (2019.01.15) зэргийг дурьдаж болно.

II. Худалдаа, аж үйлдвэрт хамаарах ур чадварыг дээшлүүлэх, түвшин тогтоох

Танхим нь худалдаа, аж үйлдвэрийн салбар дахь ажилчдын ур чадвар, түвшинг тогтооход чиглэсэн үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг байна.

Тухайлбал, 1944 онд шүрийг боловсруулах, 1954 онд тайлан тооцоо, 1974 онд худалдааны мэргэжилтэн, 2006 онд компьютерийн хэрэглээ, 2019 онд Худалдааны программын түвшин тогтоох шалгалтыг нэвтрүүлэх зэрэг замаар тухайн цаг үед

²⁵ Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 9-р зүйл.

²⁶ “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын олон улсын харьцуулалт”, Тенфордын Лорд Хэсэлтайн, х29. (The Rt Hon the Lord Heseltine of Thenford CH, Chamber of Commerce International Comparisons, (2012)).

нийцсэн худалдаа, аж үйлдвэрийн боловсон хүчнийг бэлтгэх, чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд оролцож иржээ²⁷.

III. Аялал жуулчлалын үйл ажиллагааг сайжруулах

Танхим нь аялал жуулчлалын хөгжүүлэх замаар бүс нутгийн хөгжлийг бэхжүүлж, эдийн засгийн эргэлтийн сайжруулах үйл ажиллагааг зохион явуулж, тогтмол оролцдог байна. Тухайлбал, Аомори мужид далайн бүтээгдэхүүнээр хийсэн хоолонд ач холбогдол өгч, шинэ төрлийн хоолыг бий болгох замаар жилд 10,000 хүн зочилдог аялалын маршрутыг хөгжүүлж чадсан байна²⁸.

Дээрх үйл ажиллагаанаас гадна доорх төрлийн үйл ажиллагааг тогтмол явуулдаг байна. Үүнд:

1. Захиргааны байгууллагын асуулгад санал өгөх;
2. Худалдаа, аж үйлдвэрт хамаарах асуудлаар аж ахуй эрхлэгчид чиглэсэн судалгаа хийх;
3. Худалдаа, аж үйлдвэрийн секторт хамаарах мэдээлэл эсхүл материалыг цуглуулах, хэвлэх;
4. Бараа бүтээгдэхүүний чанар, тоо ширхэг, худалдаа, аж үйлдвэрлэгчийн явуулж буй үйл ажиллагаанд хамаарах тодорхойлолт, баталгаажуулалт, шалгалт хийх;
5. Экспортын бүтээгдэхүүнд хамаарах гарал үүслийн бичиг олгох;
6. Худалдаа, аж үйлдвэрийн үйл ажиллагаанд дэмжлэг болох аливаа төв, газар ажиллуулах;
7. Худалдаа, аж үйлдвэрийн асуудлаар хурал, семинар зохион байгуулах;
8. Үзэсгэлэн яармаг зохион байгуулах, зохион байгуулахад оролцох;
9. Худалдааны үйл ажиллагаанд хамаарах зуучлал, маргааныг таслах ассены үйл ажиллагаа явуулах;
10. Худалдааны маргаанд ассен, эвлэрүүлэн зуучлал, арбитрын үйл ажиллагаа явуулах;
11. Худалдаа, үйлдвэрийн үйл ажиллагаа явуулагч этгээдэд зөвлөж, удирдлагаар хангах;
12. Худалдаа, үйлдвэрийн үйл ажиллагаа явуулагч этгээдэд хамаарах аливаа итгэлцлийн судалгаа хийх;
13. Нийгмийн халамжийг сайжруулахад хөрөнгө оруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах;
14. Захиргааны байгууллагаас эрх шилжүүлэн авсан бус үйл ажиллагааг явуулах;
15. Бусад Худалдаа, аж үйлдвэрийн танхимын зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааг явуулах.

5. ТАНХИМЫН САНХҮҮЖИЛТ

²⁷ Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гэрчилгээжүүлэлтийн туршилт, <https://www.kentei.ne.jp/> (хамгийн сүүлд 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэвтэрсэн)

²⁸ Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай, Японы Худалдаа, аж үйлдвэрийн танхим, <https://www.jcci.or.jp/aboutcci.pdf> (хамгийн сүүлд 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэвтэрсэн)

Японы Худалдаа, аж үйлдвэрийн танхимын төсөв нь дараах үндсэн гурван зүйлээс бүрддэг байна²⁹.

1. Гишүүнчлэлийн татвар
2. Үйлчилгээний хураамж
3. Засгийн газрын санхүүжилт

Засгийн газар нь танхимаас хэрэгжүүлэх жижиг бизнес эрхлэгчидэд чиглэсэн зөвлөгөө, тусламжийн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Энэ санхүүгийн дэмжлэг нь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын орлогын дунджаар 20%-ийг эзэлдэг байна.

6. ТӨРИЙН ХЯНАЛТ

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд Засгийн газраас хяналт тавьдаг. Засгийн газрын хяналт дараах гурван хэсгээс бүрдэнэ.

1. Тайланг хянах

Танхим нь жилийн эцсийн тайлан гаргах бөгөөд энэ талаар Эдийн засаг аж үйлдвэрийн яамны сайдад тайлагнах үүрэгтэй.

Тухайлбал, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 57.1-т Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь санхүүгийн жил дууссаны дараа нэн даруй орлого, зарлагын тайлан, үйл ажиллагааны нөхцөл байдал болон бусад холбогдох яамны журамд заасан зүйлсийг Эдийн засаг, аж үйлдвэрийн яамны сайдад тайлагнана хэмээн зохицуулжээ.

2. Шалгалт хийх

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд Эдийн засаг, аж үйлдвэрийн сайд шалгалт хийх эрхтэй байдаг. Тухайлбал, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 58.1-т Эдийн засаг, аж үйлдвэрийн сайд нь уг хуулийг зохистой, тууштай хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай хүрээнд Худалдаа, аж үйлдвэрийн танхимаар тайлан гаргуулж, эсхүл албан тушаалтнаар дамжуулан Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагааны байдал, үйл ажиллагааны тэмдэглэл болон бусад шаардлагатай зүйлсэд чиглэсэн шалгалтыг хэрэгжүүлэх явуулж болно хэмээн зохицуулсан. Мөн 58.2-т ...шалгалт хийх албан тушаалтан нь өөрийн бичиг баримтыг үзүүлж, холбогдох хүмүүсийн хүсэлтэд хүлээцтэй хандаж, шалгалтыг хийхээр тусгасан байна.

3. Арга хэмжээ авах

Танхимын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд Эдийн засаг, аж үйлдвэрийн сайд арга хэмжээ авах эрхтэй байдаг. Тухайлбал, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 59.1-т Эдийн засаг, аж үйлдвэрийн сайд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаа нь уг хууль болон уг хуульд

²⁹ “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын олон улсын харьцуулалт”, Тенфордын Лорд Хэсэлтайн, х29. (The Rt Hon the Lord Heseltine of Thenford CH, Chamber of Commerce International Comparisons, (2012)).

үндэслэсэн хэм хэмжээ, танхимын дүрмийг зөрчсөн эсхүл илт зүй бус үйл ажиллагаа явуулсан тохиолдолд Худалдаа, аж үйлдвэрийн танхимд сануулах арга хэмжээ авах бөгөөд зөрчлийг арилгаагүй бол дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ хэмээн зохицуулсан. Үүнд:

1. Үйл ажиллагааг хэсэгчлэн зогсоох,
2. Үүсгэн байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгох.

Мөн 59.2-т Эдийн засаг, аж үйлдвэрийн сайд нь хот тосгоны нэг хэсгийг бүхэлд харъяалсан эсхүл хэсэгчилэн харъяалсан Худалдаа, аж үйлдвэрийн танхимд холбогдуулан худалдаа, аж үйлдвэрийн нөхцөл байдлыг харгалзсаны үндсэн дээр үргэлжлүүлэн үйл ажиллагаа явуулах нь зохимжгүй гэж үзвэл ...харъяаллыг өөрчлөх эсхүл татан буугдах зөвлөмжийг хүргүүлж болно хэмээн зохицуулсан байдаг. Улмаар, 59.3-т Эдийн засаг, аж үйлдвэрийн сайд нь өмнөх зөвлөмжийг хүлээн авсан Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь тухайн зөвлөмжийг дагаагүй тохиолдолд үүсгэн байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгож болно хэмээн тусгасан.

Хэрэв Эдийн засаг, аж үйлдвэрийн сайд 59.1-т заасан арга хэмээг авах тохиолдолд холбогдох орон нутгийн захиргааны засаг дарга болон Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын саналыг сонсох үүргийг хүлээдэг.

Ийнхүү, Японы улсын төр нь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд Эдийн засаг, аж үйлдвэрийн яамаар дамжуулан хяналт тавьдаг байна.

ЗУРГАА. УНГАР УЛС

Унгар улсын худалдаа, аж үйлдвэрийн танхим нь 1999 онд батлагдсан Эдийн засгийн танхимын тухай хууль (TÖRVENY A GAZDASAGI KAMARAKROL)³⁰ болон Унгарын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дүрэм (A MAGYAR KERESKEDELMI ÉS IPARKAMARA ALAPSZABÁLYA)³¹-иар тус тус зохицуулагддаг болно.

Унгарын худалдаа, аж үйлдвэрийн танхимын үүсэл нь тэртээ 1850 оны 3-р сарын 18-ны өдрийн Австрийн хаан Франц Иосеф 1 болон Унгарын хааны зарлигаар байгуулагдаж байсан түүхтэй. Хамгийн анхны Унгарын танхимын тухай хууль нь 1868 онд батлагдаж, 1934 он хүртэл хүчин төгөлдөр үйлчилсэн. Тухайн үед Унгар дахь бүх худалдаачин, гар урлаач, худалдаа, үйлдвэрийн компаниуд заавал тухайн танхимын гишүүн байхыг шаарддаг байсан байна.³²

Дэлхийн хоёрдугаар дайны дараа тус танхимын үйл ажиллагаа зогсож, хөрөнгийг нь улсын сан хөмрөгөд шилжүүлсэн боловч, 1948 оноос дахин байгуулж, 1985 онд нэрийг нь Эдийн засгийн танхим (Chamber of Economy) хэмээн өөрчилжээ. 1990 оноос бүс нутгийн танхимыг байгуулах боломжтой болж, 1991 онд зургаан бүс нутгийн танхим үйл ажиллагаагаа бие даан эхлүүлсэн байна. Гишүүнчлэл нь мөн л заавал байлаа. 1994 оноос Эдийн засгийн танхимын тухай хуулиар тус танхимыг нийтийн эрх зүйн субъект байхаар хуульчилж, 1999 оны буюу одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Эдийн засгийн танхимын тухай хуулийн дагуу тус улсын Засгийн газрын зүгээс 2000 оны 11-р сараас эхлэн заавал гишүүнчлэлийг халж, сайн дурын гишүүнчлэлийн тогтолцоог бий болгожээ. Тиймээс танхимын үндсэн чиг үүрэг нь жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, гадаад экспортыг эрчимжүүлэх явдал болж хувирчээ.³³

1. ТАНХИМЫН БҮТЭЦ

1999 оны Эдийн засгийн танхимын тухай хуулийн 2-р зүйлийн 9 заалтад заасны дагуу “Эдийн засгийн танхим” гэж бүс нутгийн эдийн засгийн танхим болон үндэсний эдийн засгийн танхимыг ойлгоно. Тус танхим нь хуулийн дагуу байгуулагддаг хуулийн этгээдэд тооцогддог.³⁴

Тус хуулийн 3-р зүйлийн 3.3-ийн дагуу Эдийн засгийн танхим нь дотроо 1. Худалдаа, аж үйлдвэрийн танхим болон 2. Хөдөө, аж ахуйн танхим гэсэн хоёр төрөлтэй. Эдгээр хоёр төрлөөс өөр танхимыг байгуулахыг хуулиар хүлээн зөвшөөрдөггүй.

³⁰ Хамгийн сүүлд 2019 оны 3-р сарын байдлаар нэмэлт, өөрчлөлт орсон.

³¹ 2018 онд нэмэлт, өөрчлөлт орсон.

³² Товч түүх, Унгарын Худалдаа, аж үйлдвэрийн танхим, <https://mkik.hu/en/history> (хамгийн сүүлд 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нэвтэрсэн)

³³ Мөн тэнд.

³⁴ 1959 оны Унгарын Иргэний хуулийн 65-р зүйлийн дагуу ийм хуулийн этгээдэд худалдаа, аж үйлдвэрийн танхим болон шинжлэх ухааны академийг тооцдог байна.

Бүс нутгийн эдийн засгийн танхим нь мужийн³⁵ хэмжээнд болон мужийн эрхтэй дүйцэхүйц эрх бүхий хот, Будапештэд үйл ажиллагаа явуулна (4.1). Мөн бүс нутгийн эдийн засгийн танхимууд нь хоорондоо нэгдэх боломжтой. Нэгдсэний үр дүнд байгуулагдсан танхим нь нэгдсэн танхимуудын эрхтэй адил эрхтэй байна (4.2).

Эдийн засгийн танхим нь орон нутгийн салбарыг өөрийн дүрмийн дагуу байгуулах эрхтэй (4.3).

Тус хуулийн 6-р зүйлийн 6.1-д заасны дагуу Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь Унгарын худалдаа, аж үйлдвэрийн танхимыг байгуулах үүрэгтэй бөгөөд тус танхим нь үндэсний хэмжээнд үйл ажиллагаагаа явуулна.

Танхим нь тухайн байгуулагдаж буй бүс нутгийн буюу мужийн шүүхэд бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд энэхүү бүртгэлийн талаар төрийн бус байгууллагын тухай хууль тогтоомжийг нэгэн адил хэрэглэнэ (6/A).

Хуулийн 15-р зүйлд заасны дагуу танхим нь өөрийн бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэхдээ өөрийн баталсан дүрмийг удиртгал болгоно. Тус дүрэмд дараах асуудлыг зохицуулсан байх ёстой (16.1). Үүнд:

1. Танхимын нэр, албан ёсны үйл ажиллагаагаа явуулдаг оффисын тухай;
2. Танхимын байгууллагын болон түүний бүтэц, албадуудын үйл ажиллагааны зарчим;
3. Хэлтэс, алба, орон нутгийн болон бусад салбар болон байгууллагын нэгжийн үүргийг тодорхойлох, танхим болон бусад байгуулагатай хэрхэн харилцах талаарх журмыг тогтоох;
4. Үндэсний ашиг сонирхлыг төлөөлдөг байгууллагатай хэрхэн хамтран ажиллах талаарх журам;
5. Гишүүдийн тооны доод хязгаар, гишүүдийн эрх болон үүрэг, шинээр гишүүнээр элсүүлэхтэй холбоотой журам;
6. Гишүүдийн нэрсийн жагсаалт болон санал хураалтын талаар;
7. Гишүүний татвар болон тооцох аргачлал болон төлбөр төлөх хэлбэрийн талаар;
8. Төлөөлөгчдийг сонгох журам;
9. Үндэсний эдийн засгийн танхимын конгрессын төлөөлөгчийг томилох тухай;
10. Танхимын албаны тоо болон төрөл;
11. Конгрессын төлөөлөгчдийн тоо болон удирдах зөвлөл, хяналтын хороо болон ёс зүйн хорооны гишүүдийн тоо;
12. Танхимын нарийн бичгийн дарга (дэд нарийн бичгийн дарга), зөвлөлийн гишүүд, хяналтын хороо болон ёс зүйн хороо, бусад сонгогдсон албан хаагчдыг сонгох болон бүрэн эрхийг нь дуусгавар болгох журам;
13. Ээлжит конгрессыг зарлан хуралдуулах журам болон давтамж;
14. Тус хуульд зааснаас гадна конгресст хамаарах бүрэн эрхийг тодорхойлох;

³⁵ Унгар нь улс нь нэгдмэл улс бөгөөд дотроо 19 мужтай. Муж нь дотроо дүүрэгт хуваагддаг.

15. Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулах болон үйл ажиллагааг явуулах, хурлын шийдвэрийг гаргах тухай журам;
16. Тус хуульд зааснаас бусад гуравны хоёр эсхүл дийлэнх олонхиор шийдвэрлэх асуудлын талаар тодорхойлох;
17. Нарийн бичгийн дарга (дэд нарийн бичгийн дарга)-ын бүрэн эрх болон тусгай тохиолдолд тус бүрэн эрхийг шилжүүлэх журмын талаар;
18. Танхимын жилийн төсөв болон балансыг хэлэлцэн батлах тухай;
19. Тус хуульд зааснаас бусад тухайн танхимын албан хаагчдын сонирхлын зөрчлийн тодорхойлолтыг тогтоох.

Бүс нутгийн эдийн засгийн танхимын эрх барих дээд байгууллага нь төлөөлөгчдийн конгресс байх бөгөөд тус конгресс нь сонгогчдын жагсаалтад бүртгэгдсэн танхимын гишүүдээс сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ (17.1).

Бүс нутгийн эдийн засгийн танхимын конгресс нь жилд дор хаяж нэг удаа хуралдах бөгөөд дүрэмд заасны дагуу хуралдана (18.1). Конгресс нь танхимын нарийн бичгийн даргын шийдвэрээр хуралдана (18.2). Тус конгресс нь талаас дээш хувийн ирцтэйгээр хуралдаж байж хүчин төгөлдөр болно (18.3). Конгрессын шийдвэр нь төлөөлөгчдийн ердийн олонхийн саналаар батлагдана.

Харин дараах асуудлыг хуралдсан оролцсон төлөөлөгчдийн гуравны хоёрын саналаар батална (18.4). **Үүнд:**

1. Дүрэм болон бусад өөрөө удирдах ёсонд хамаарах дүрэм, журмыг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;
2. Бусад танхимтай нэгдэх, тусгаарлах;
3. Хэлтсийн автономи байх эрхэд нөлөөлөх аливаа шийдвэр;
4. Дүрэмд заасан бусад шийдвэр.

Үндэсний эдийн засгийн танхимын Конгресс нь түүний эрх барих дээд байгууллага байх бөгөөд тус конгресс нь бусад эдийн засгийн танхимын конгрессоос бүрдэнэ (19.1).

Эдийн засгийн танхимын Удирдах зөвлөл нь конгрессын чөлөө цагт эдийн засгийн танхимын үйл ажиллагааг удирдах чиг үүрэгтэй бөгөөд танхимын үндсэн байгууллага байна (20.1).


Танхимын нарийн бичгийн дарга нь тухайн танхимыг бие даан төлөөлөх эрхтэй субъект байна (21.1). Дэд нарийн бичгийн даргын тоог танхим дүрмээрээ тогтооно (21.2).

Хяналтын хороо нь конгрессын хурлаар томилогдох бөгөөд дор хаяж гурван гишүүнтэй байна (21.1). Тус хороо нь танхимын үйл ажиллагаа болон санхүүгийн менежмент нь хууль тогтоомж болон дүрэмд нийцэж буй эсэхийг хянах чиг үүрэгтэй байна (21.2). Хяналтын хорооны гишүүд нь танхимын албан хаагчид болон удирдах байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг цуглуулах, бүхий л баримт бичигтэй

танилцах эрхтэй байна (21.3). Хяналтын хороо нь жилд дор хаяж нэг удаа хараат бус аудиторoor танхимын санхүүгийн нөхцөл байдалд шалгалт хийлгүүлэх ёстой (21.4). Хяналтын хороо нь удирдах зөвлөлд хандан танхимын үйл ажиллагааг хууль тогтоомж, танхимын дүрэм, болон бизнесийн үндсэн зарчимд нийцүүлэхийг сануулж, шаардах эрхтэй (23.1). Уг шаардлагыг удирдах зөвлөл биелүүлээгүй бол хяналтын хороо нь конгрессыг хуралдуулах эрхтэй (23.2). Танхимын нарийн бичгийн дарга конгрессыг хуралдуулах үүргээ биелүүлээгүй бол хяналтын хорооны нарийн бичгийн дарга конгрессыг хуралдуулна (23.3).

Танхимын ёс зүйн хороо нь танхимын зүгээс зах зээлийн шударга практик, заншил, арилжаа эрхлэгч ба хэрэглэгч хоорондын шударга арилжааны практикийг төлөвшүүлэхэд шаардлагатай ёс зүйн дүрмийг хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, аж үйлдвэрийн өмчийн эрхийг зөрчиж байгаа этгээдэд анхааруулга хүргүүлэхэд дэмжлэг үзүүлэх, бусдын нэр хүндийг гутаасан үйлдэлд анхааруулга хүргүүлэхэд болон ёс зүйн дүрмийн зөрчилд анхааруулга хүргүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана (24.1).

Ерөнхий нарийн бичгийн дарга нь эдийн засгийн танхим болон үндэсний эдийн засгийн танхимын удирдах албан тушаалтан байна (25.1). Ерөнхий нарийн бичгийн дарга нь танхимын албан хаагчдын хувьд ажил олгогчийн эрх, үүргийг хэрэгжүүлнэ (25.2).



2. ТАНХИМЫН ГИШҮҮНЧЛЭЛ

Унгарын худалдаа, аж үйлдвэрийн танхим нь үндэсний эдийн засгийн танхим бөгөөд тус танхим нь бүс нутгийн танхимын төлөөлөгчдөөс конгрессоо бүрдүүлдэг. Бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхим нь мужийн эдийн танхимыг ойлгох бөгөөд тухайн танхим бүр өөрсдийн гэсэн гишүүдтэй байна. 2000 оны 11-р сараас хойш Унгар нь сайн дурын гишүүнчлэл болсон талаар өмнө дурьдсан билээ. Эдийн

засгийн танхимын хуулийн 8-р зүйлийн 8.1-д заасны дагуу тухайн танхим гишүүнээр бүртгэснээр танхимын гишүүнчлэл эхэлнэ гэж заасан байгаа нь үүнийг тодорхой гэрчилнэ.

Унгарын худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүнээр ашгийн төлөө хуулийн этгээд (бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани, хувьцаат компани), хувиараа бизнес эрхлэгч, мэргэжлийн холбоод, тодорхой хуулийн этгээдийн хамаарал бүхий компани, компанийн салбар, гадаадад бүртгэлтэй компанийн Унгар дахь салбар, хоршоо (орон сууцны хоршоо үүнд хамаарахгүй), хөдөө аж ахуйн үйлдвэрлэгч нар элсэх боломжтой (2а).

Танхимын гишүүнээр бүртгүүлсэнээр дараах эрх үүснэ (8.2). **Үүнд:**

1. Конгрессын төлөөлөгч, Танхимын нарийн бичгийн дарга, дэд нарийн бичгийн дарга, Танхимын байгууллагын гишүүнээр сонгогдох;
2. Танхимд өөрийн гэсэн оффистой байх;
3. Үндэсний эдийн засгийн танхимын төлөөлөгчдийн конгресст төлөөлөгчөөр оролцох, Байгууллагын гишүүд, нарийн бичгийн дарга, үндэсний эдийн засгийн танхимын албан хаагчдыг сонгох;
4. Тус хууль болон үндэсний эдийн засгийн танхимын дүрэмд заасан бүс нутгийн эдийн засаг, аж үйлдвэрийн танхимын үнэ төлбөргүй болон бусад үйлчилгээг авах.

Танхимын гишүүний эрх нь дараах тохиолдолд дуусгавар болно (8.4). **Үүнд:**

- А) Тухайн эдийн засгийн байгууллага ³⁶ нь эрх залгамжлагчгүйгээр татан буугдсан эсхүл хувиараа аж ахуй эрхлэгч өөрийн үйл ажиллагаагаа зогсоосон;
- В) Эдийн засгийн байгууллага нь өөрийн гишүүнчлэлээ хуанлийн жилийн сүүлчийн өдрөөр цуцалсан бол;
- С) Гишүүний үүргээ ноцтойгоор болон удаа дараа зөрчсөн үйлдэл гаргасан бол, түүнчлэн гишүүнчлэлээ бүртгэлээс гарсан бол.

Түүнчлэн тус хуулийн 8-р зүйлийн 8.5-д заасны дагуу танхимын гишүүнчлэл нь тус хуулийн 8-р зүйлийн 8.4.с-д заасан үндэслэлээр дуусгавар болсон бол тухайн цуцалсан шийдвэр гарсан өдрөөс хойш, шүүхээр шийдвэрлэсэн бол шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш нэг жилийн хугацаанд дахин гишүүнээр бүртгэхгүй байхаар зохицуулжээ.

Эдийн засгийн танхимын зүгээс өөрийн бүртгэлтэй эдийн засгийн оролцогч нарт дараах үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх үүрэгтэй (8.2а). **Үүнд:**

1. Эдийн засаг, санхүү, татвар болон зээлийн талаарх зөвлөгөө өгөх,
2. Бизнесийн шинэ хамтрагч олж өгөхөд туслах,

³⁶ Эдийн засгийн байгууллага гэж танхимд гишүүнээр элсэх боломжтой этгээдүүдийг нийтэд нь ойлгоно (2а).

3. Тендерийн талаар мониторинг хийх,

3. ТАНХИМЫН ЧИГ ҮҮРЭГ

Үндэсний эдийн засгийн танхим (Унгарын худалдаа, аж үйлдвэрийн танхим) нь дараах чиг үүрэгтэй ажиллана (12.1). Үүнд:

1. Эдийн засгийн холбогдолтой төлөвлөгөө болон хуулийн төслийг үнэлэх, санал өгөх;
2. Олон улсын эдийн засгийн байгууллагууд болон гадаадын эдийн засгийн танхимын үндэсний байгууллагуудтай харилцаа, холбоо тогтоож, хэрэгжүүлэх;
3. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын зүгээс эдийн засгийн талаарх мэдээллийг гадаадын орнуудад, Унгарын зүгээс бусад оронд болон Унгар дахь гадаадын иргэдэд хэрхэн хүргэх, нийтэд мэдэгдэх явдлыг хангаж ажиллах;
4. Унгарын эдийн засгийн талаар танилцуулах арга хэмжээг зохион байгуулах;
5. Эдийн засгийн танхимын бүртгэлтэй гишүүдийн хувьд мөрдөх тогтолцоог хөгжүүлэх;
6. Зах зээлийн шударга бус практикийг зохицуулах ёс зүйн дүрмийг өөртөө багтаасан ёс зүйн дүрмийг боловсруулах;
7. Бусад хуульд заасан зохицуулалтын дагуу үндэсний зөвлөл болон байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох;
8. Танхимуудын өөрийн удирдлагын дүрмийг тогтоох;
9. Хуульд гэрээний стандарт нөхцлийн талаар тодорхойлоогүй бол хэрэглэгсийн гэрээний стандарт нөхцөл нь шударга бус эсэх талаар саналаа илэрхийлэх.

Үндэсний эдийн засгийн танхим нь байнгын арбитрыг ажиллуулна. Унгарын худалдаа, аж үйлдвэрийн танхим нь байнгын арбитрын хувьд олон улсын худалдаатай холбоотой үйл ажиллагаа явуулах болон арбитрчдыг сонгох болон бүрэн эрхийг нь дуусгавар болгох талаарх нөхцөлийг тодорхойлно (12.2).

Унгар улсын хувьд худалдаа, аж үйлдвэрийн танхим нь арбитрын үйл ажиллагааг хариуцдаг бол харин Хөдөө, аж ахуйн танхим нь эвлэрүүлэн зуучлах зөвлөлийг ажиллуулах эрхтэй байдаг (12.4). Унгарын хөдөө, аж ахуйн танхим нь тухайн эвлэрүүлэн зуучлах зөвлөлийн үйл ажиллагааг хариуцаж, процессын дүрэм, эвлэрүүлэн зуучлалын хөлсийг хэрхэн төлөх зэрэг асуудлын талаар тодорхойлох үүрэгтэй байдаг байна.

Бүс нутгийн эдийн засгийн танхимын хувьд дараах чиг үүргийг гүйцэтгэдэг байна (9.1). Үүнд:

1. Өөрийн дүрэмдээ заасны дагуу өөрийн орлогын тодорхой хэсгийг ашиглан эдийн засгийн үйл ажиллагаанд хамаарал бүхий дэд бүтцийг хөгжүүлэхэд оролцох;
2. Тодорхой арилжаа эрхлэгчийн ашиг сонирхолтой хамааралгүй үндэсний эдийн засгийн хувьд нөлөө үзүүлэхүйц асуудлыг биелэгдэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллах, үүний тулд төв болон орон нутгийн засгийн газрын агентлаг болон эдийн засгийн ашиг сонирхлыг илэрхийлэгч байгууллагатай хамтран ажиллах;

3. Унгарын болон гадаад орнуудын эдийн засгийн талаарх хууль, эрх зүйн мэдээллийг өгөх, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах, Бүс нутгийг хөгжүүлэх төлөвлөгөөний үе шатыг хэрэгжүүлэх, бэлтгэл ажилд оролцох;
4. Мэргэжлийн сургалтын тухай 1993 оны хуулийн дагуу олгогдсон үүргийг хэрэгжүүлж, мэргэшсэн ажилчдын сургалтыг зохион байгуулж, шалгалтыг авах.

Мөн бүс нутгийн эдийн засгийн танхим нь бизнесийн хэлцлийн баталгаат байдлыг хангахын тулд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ (10.1). Үүнд:

1. Барааны гарал, үүслийн гэрчилгээ болон баримт бичгийг олгох, гэрчлэх болон бизнесийн хэлцэлтэй холбоотой бусад баримт бичгийг олгох, гэрчлэх;
2. Бизнесийн практикийн талаар мэдээллийг эмхэтгэж, хэвлүүлэх;
3. Эдийн засгийн ашиг сонирхлыг илэрхийлэгч байгууллагатай хамтран арилжаа эрхлэгч болон хэрэглэгч хоорондын шударга зах зээлийн практикийн талаарх ёс зүйн дүрмийг хөгжүүлэх, Арилжаа эрхлэгч болон хэрэглэгчийн шударга бус арилжааны практикийг хориглох тухай хууль болон Зах зээлийн шударга бус практикийн тухай хуулийн зохицуулалтын хэрэгжилтэд мониторинг хийх, Зөрчлийн талаар эдийн засгийн ашиг сонирхол илэрхийлэгч байгууллагад анхааруулга гаргах;
4. Эдийн засгийн ашиг сонирхол илэрхийлэгч байгууллагад хандан аливаа аж үйлдвэрийн өмчийн зөрчлийн талаар анхааруулга хүргүүлэх;
5. Хэрэглэгчийн ашиг сонирхолтой холбоотой эдийн засгийн үйл ажиллагааны талаар болон эдийн засгийн байгууллагын нэр хүндийг зөрчсөн үйл ажиллагааны талаар анхааруулга хүргүүлэх, Эдийн засгийн өрсөлдөөний болон Хэрэглэгчийг хамгаалах байгууллагуудтай хамтран ажиллах бөгөөд эдгээр байгууллагуудын шийдвэрийн талаар мэдээлэл авах;
6. 1997 онд батлагдсан Компанийн бүртгэлийн тухай хуулийн дагуу хяналт явуулах, Нээлттэй компанийн талаарх мэдээлэл болон Шүүхэд бүртгүүлэх процедурын талаар хяналт явуулах, мөн татварын асуудал хариуцсан байгууллагад хандан хувиараа аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагааг зогсоох талаар хүсэлт явуулах;
7. Хэрэглэгчийг хамгаалах хуулийн дагуу Арбитрын зөвлөлийг ажиллуулах,
8. Эдийн засгийн байгууллагын зүгээс олон улсын худалдаатай холбоотойгоор чанар болон тээвэрлэлттэй холбоотой хохирол нэхэмжлэхэд оролцох;

Мөн эдийн засгийн танхим нь дараах үйл ажиллагааг явуулах чиг үүрэгтэй байна (11.1). Үүнд:

- А) Мэдээлэл олгох, санал, төслөө танилцуулах байдлаар эдийн засгийн байгууллагатай холбоотой хууль тогтоомжийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, Эдийн засгийн хөгжил, бизнесийн хэлцлийн баталгаат байдал болон зах зээлийн практикийн шударга байдлыг хангах зорилгоор Засгийн газар болон орон нутгийн засгийн газартай хамтран ажиллах;
- В) Статистикийн тухай хуульд заасны дагуу а-д заасан төсөл, санал, мэдээллийг боловсруулахын тулд мэдээлэл цуглуулах,

Дээр дурьдсан эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор эдийн засгийн байгууллагатай холбоотой хууль тогтоомжийн талаар жилд дор хаяж хоёр удаа Ерөнхий сайдын томилсон сайдтай хамтран хурал зохион байгуулах үүрэгтэй (11.3).

4. ТАНХИМЫН САНХҮҮЖИЛТ

Эдийн засгийн танхимын тухай хуульд заасны дагуу Унгарын худалдаа, аж үйлдвэрийн танхим нь дараах эх үүсвэрээс санхүүжинэ (34.1). Үүнд:

1. Гишүүдийн татвар;
2. Хандив;
3. Үйлчилгээ үзүүлсний хөлс;
4. Танхимын бизнесийн хамтрагчдаас олсон орлого;
5. Бусад орлого, сайн дурын хандив;
6. Тусламж.

Мөн танхим нь өөрийн чиг үүргийг гүйцэтгэх зорилгоор тодорхой ашгийн төлөө хуулийн этгээд³⁷ байгуулах боломжтой бөгөөд энэ тохиолдолд тухайн хуулийн этгээдийн татварын дараах ашгийг өөрийн чиг үүргийг гүйцэтгэхдээ ашиглаж болно (35.2).

5. ТӨРИЙН ХЯНАЛТ

Дүүргийн прокурорын албанаас хуулиар олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд хяналт тавьж хэрэгжүүлдэг (28.1).

Тухайн хяналт нь тухайн худалдаа, аж үйлдвэрийн танхимын дүрэм болон өөрөө удирдах ёсонд хамаарах дүрэм, журам нь хууль тогтоомжид нийцэж буй эсэх, үйл ажиллагаа болон аливаа шийдвэр нь хууль тогтоомж, тухайн танхимын дүрэм болон өөрөө удирдах ёсонд хамаарах дүрэм, журмыг зөрчсөн эсэхээр хязгаарлагддаг (28.2 а, b).

Хэрвээ танхимын үйл ажиллагаа болон шийдвэр, дүрэм, журам нь хууль тогтоомжийг зөрсөн гэж дүүргийн прокурорын албанаас үзвэл шүүхэд хянуулахаар хандах эрхтэй (28.3).

Дүүргийн прокурорын албанаас хандсаны дагуу шүүхийн зүгээс тухайн танхимын хууль тогтоомжийг зөрсөн шийдвэрийг хүчингүй болгож, гаргах ёстой шийдвэрийг даалгах шийдвэр гаргах эрхтэй бөгөөд үйл ажиллагааг нь хууль тогтоомжид нийцүүлэх зорилгоор ерөнхий ассамблейг хуралдуулах, танхимын тодорхой байгууллагын чиг үүргийг түр түдгэлзүүлэх, шаардлагатай хугацаагаар хяналтын комиссарыг томилох, үйл ажиллагаагаа хууль тогтоомжид нийцүүлээгүй бол үндэсний эдийн засгийн танхимаас бусад танхимыг татан буугдсаныг зарлах эрхтэй (28.3.а, b, c, d).

³⁷ Унгар улсын хувьд Иргэний хуулиндаа заасны дагуу бүх гишүүд бүрэн хариуцлагатай компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани, хувьцаат компанийг ашгийн төлөө хуулийн этгээдэд хамааруулдаг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль 1995 онд батлагдсан бөгөөд таван бүлэг 14 зүйлтэй байна. Батлагдсанаас хойш 2002, 2011 болон 2015 онд тус тус нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд 2 хэсэг, 1 заалт нэмж, 5 хэсэгт өөрчлөлт орж, 2 хэсэг хассан байна.

Энэхүү хуулинд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай ойлголт, түүний зорилт, бүрэн эрх, үйл ажиллагаа болон тогтолцоог ерөнхий тодорхойлсон байх бөгөөд Үндэсний танхимын бүрэн эрхийг мөн товчхон тусгасан байна.

Танхимын санхүүжилтын хэлбэр болон эд хөрөнгийн хариуцлагыг тодорхойлохоос гадна, танхимын дүрэмд байх ёстой асуудлуудыг мөн тусгажээ.

Цаашлаад танхимыг үүсгэн байгуулах, бүртгэх, өөрчлөн байгуулах болон татан буулгах асуудлуудыг зохицуулсан байна. Танхимыг үүсгэн байгуулах зүйлээс түүний бүтцийн талаар товч зохицуулалт авч болохоор байна.

Олон улсын жишигтэй харьцуулахад Монгол Улсын одоогийн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль нь маш товч бөгөөд зохицуулсан асуудал цөөн бөгөөд танхимын эрх хэмжээ харьцангуй хумигдмал байгаа нь харагдлаа.

Гадаад улс орнуудын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын талаар зохицуулсан хуулиудын бүтэц харьцангуй өөр өөр бөгөөд тухайн улс орны сонгосон танхимын модель, эрх зүйн соёл, тогтолцоо зэргээс хамаарч байна. Жишээ нь ХБНГУ-ын “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын урьдчилсан зохицуулалтын тухай” хууль нь танхимын чиг үүргийг ерөнхий зохицуулсан бөгөөд ингэснээр танхимын үйл ажиллагааг хязгаарлахгүй тухайн цаг үеийн хэрэгцээнээс шалтгаалан эрх хэмжээ нь өргөсөх эсхүл багасгах боломжийг нь олгодог бол танхимын санхүү, гишүүнчлэлийн татвартай холбоотой зохицуулалт нь нарийн тусгагдсан байдаг байна. Энэ нь танхим гишүүдийнхээ татварыг хариуцлагатай зарцуулах, түүнчлэн гишүүдэд татварын дарамт учруулахгүй байх мөн тодорхой салбарыг дэмжих зорилготой байдаг байна.

БНКУ-ын хувьд Герман болон Франц зэрэг улсуудаас ялгаатай нь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын олон зуун жилийн түүхгүй юм. Иймд аж ахуй эрхлэгчдийн эрхийг хамгаалж, ашиг сонирхлыг нь бүрэн хамгаалах зорилгоор 2013 оны шинэ хуулиндаа танхим нь төрийн үйл ажиллагаанд хэрхэн оролцох талаар маш нарийн зохицуулалт оруулж танхимын нөлөөг баталгаажуулдаг байна.

Монгол Улсын хувьд Казахстан улстай адил худалаа, аж үйлдвэрийн танхимын урт түүхгүй, бизнес нь цөөн тооны эдийн засгийн төв цэгүүдэд төвлөрсөн, хөдөө орон нутгийн бизнесийн дуу хоолой Засгийн газрын түвшинд хүрдэггүй зэрэг ижил талуудтай.

Иймд Монгол Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн бүтэц болон зохицуулах асуудлуудын цар хүрээг Монгол Улсын эдийн засаг болон гадаад,

дотоод худалдааны онцлогоос төдийгүй улс төрийн нөхцөл байдал, хүн ам зүйн тархалт, аж ахуй эрхлэгчдийн төвлөрөлт, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой холбоодын үйл ажиллагааны үр дүнтэй байдал, аж ахуй эрхлэгчдэд дутмаг байгаа санхүүжилтийн төдийгүй техник, боловсон хүчний нөхцөл байдал зэрэгт тулгуурлан шийдвэрлэх хэрэгтэй байна.

Түүнээс гадна Солонгос, Япон, Герман, Франц, Унгар зэрэг эдийн засаг нь хөгжсөн, төр болон хувийн хэвшлийн харилцаа харьцангуй тогтворжсон улс орнуудын практикийг шууд нутагшуулахаас зайлсхийж Монгол Улсын онцлогт тохирсон эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

1. ГИШҮҮНЧЛЭЛ

Олон улсад танхимын гишүүнчлэлийн хувьд заавал гишүүнчлэлтэй (Герман, Казахстан), сайн дурын (ОХУ, Япон, Унгар) болон холимог (Франц, Солонгос) чиг хандлагатай байна.

Судалгаанаас үзвэл гишүүнчлэлийн хэлбэрийг зарим улс орнууд тухайн улсын нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагаас хамааран өөрчлөх хандлагууд мөн ажиглагдаж байна.

Жишээ нь Франц улс заавал гишүүнчлэлтэй байсан бол энэ хэлбэрээс татгалзаж холимог хэлбэр лүү шилжсэн бол Казахстан улс эсрэгээрээ сайн дурын хэлбэрээс заавал гишүүнчлэлтэй хэлбэрийг 2013 онд сонгосон байна.

Казахстан улс заавал гишүүнчлэлийг сонгосон шалтгаан нь бизнес эрхлэгчдийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой олон тооны холбоодууд өөрсдийн зорилгоо хангалттай биелүүлж төр, засгийн газарт гишүүдийнхээ эрх ашгийг төлөөлж чадахгүй байгаагаас гадна хангалттай мэргэжлийн болон техникийн туслалцаа үзүүлж чадахгүй байсан тул аж ахуй эрхлэгчдийг нэг танхимд нэгтгэж эрхийг нь хамгаалахаас гадна хүртээмжтэй, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх болсон юм. Үүнээс гадна, ашигт малтмал ашиглагч компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд байгуулсан гэрээгээр биелүүлж байгаа эсэх зэрэг хяналтын чиг үүргийг мөн нэгдсэн тогтолцооны дор хэрэгжүүлдэг байна.

Түүнчлэн Солонгос улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь аж ахуй эрхлэгчийн эдийн засгийн чадавхи болон үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан гишүүнчлэлийн төрлийг ялгаатай байдлаар зохицуулсан нь анхаарал татаж байна.

Тухайлбал, Хууль болон журамд заасан томоохон хэмжээний худалдааны эргэлт бүхий компаниудыг танхимын заавал гишүүн байхаар зохицуулсан байна. Түүнээс гадна сайн дурын үндсэн дээр танхимын гишүүн байж болох этгээдүүдийг тэдгээрийн онцлогоос шалтгаалан ялгамжтай байдлаар өөр өөр төрөл болгон хуульчилсан.

(1) Монгол Улсын хувьд Казахстан улсын адил бизнес нь нэг цэгт буюу Улаанбаатарт төвлөрсөн шинжтэй байна. Бусад 45 мянга гаруй бизнес нь Монгол Улсын өргөн уудам нутаг дэвсгэрээр тархасан бөгөөд тэдгээр нь хоорондоо нэгдэж ашиг сонирхлоо Засгийн газрын түвшинд хүргэх чадвар нь хомс байдаг байна.

Иймд Казахстан Улсын адил бүх бизнес эрхлэгчид нэгэн дээвэр дор нэгдсэнээр тэдгээрийн дуу хоолой мөн адил нэгдэх боломжтойгоос гадна мэргэжлийн болон техник дэмжлэг, туслалцаа авах, экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээгээ гаргахад дэмжлэг авах, мэдээллээр хангагдах зэрэг бусад туслалцааг мэргэжлийн түвшинд авч болох юм.

Түүнчлэн бүх гишүүд гишүүнчлэлийн татвар төлсөнөөр танхим нь төрөөс болон гадны бусад эх үүсвэрүүдээс хандив хүсэх шаардлагагүй болж санхүүгийн хараат бус байдал цаашлаад танхимын бие даасан байдал бэхжиж улс төрийн болон гадны бусад нөлөөнд автахгүй байх боломжийг бүрдүүлэх юм.

(2) Үүнээс гадна Монгол улс Солонгос улсын туршлагад үндэслэн хувьцаат компани болон томоохон хэмжээний аж ахуйн нэгжүүдийг заавал танхимын гишүүн байхаар хуульчлах боломжтой. Харин жижиг хэмжээний компаниуд болон нөхөрлөлийн хэлбэрүүдийг сайн дурын үндсэн дээр танхимын гишүүн байж болохоор зохицуулж болох юм.

Мөн ашгийн бус хуулийн этгээдүүд аж ахуйн үйл ажиллагааныхаа хүрээнд танхимын гишүүн байж болох тусгай төрлийн гишүүнчлэлийн хэлбэрийг ч бий болгохыг үгүйсгэхгүй.

Гишүүнчлэлийн хэлбэрээс гадна олон улсад гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах зарчмуудыг баталгаажуулдаг байна. Үүнээс хамгийн чухал нь гишүүд бүгд эрх тэгш байх буюу татвар хэр хэмжээгээр төлж байгаагаас үл хамааран бүх гишүүд адил тэгш харилцах, танхимын үйл ажиллагаанд оролцох, сонгууль өгөх, сонгогдох зэрэг эрхийг нь заавал баталгаажуулдаг байна.

Зөвлөмж: Монгол Улсын өнөөгийн улс төр, эдийн засгийн нөхцөл байдлаас болон бусад хүчин зүйлсээс үзвэл танхимын заавал гишүүнчлэлийн хэлбэрт шилжих нь төвийн төдийгүй хөдөө орон нутгийн бүх бизнес эрхлэгчдийн ашиг сонирхлыг хамгаалах, дуу хоолойг нь төрийн шийдвэр гаргах түвшинд хүргэхээс гадна нэгдсэн дэмжлэг, үйлчилгээний системд холбох боломжтой болно. Түүнчлэн гишүүд бүр төлж буй татвараасаа үл хамааран адил, тэгш эрхтэйг баталгаажуулах нь нэн тэргүүний анхаарах зүйл мөн болно.

2. САНХҮҮЖИЛТ

Олон улсын жишигт гишүүнчлэлийн орлого, үйлчилгээний хөлс, хандив зэргээр танхимын санхүүжилтийг бүрдүүлэх жишиг тогтсон бөгөөд Франц, Казахстан, Унгар зэрэг улсуудад аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн онцлог байдаг боловч

эдгээр орлогыг зөвхөн танхимын үйл ажиллагаанд зарцуулна гэх зэрэг танхимын төсвийг хамгаалсан заалтуудыг давхар оруулдаг байна.

Гишүүнчлэлийн татварыг тогтоох арга хэлбэрийг улс болгон өөрийн аргачлалаар баталдаг боловч татварын хэмжээг танхим өөрийн дүрэм, журмын дагуу тогтоох чиг хандлага давамгайлж байна.

Япон улсын танхим нь гишүүнчлэлийн татварыг тогтоохдоо тухайн гишүүний гишүүнчлэлийн төрлөөс компанийн дүрмийн сангийн хэмжээ болон ажилтны тоонд тулгуурлан тогтоодог байна. Харин Солонгос улсын танхим нь тухайн гишүүний худалдааны эргэлтэд тулгуурлан ялгамжтай байдлаар тогтоодог байна.

Герман улсад гишүүнчлэлийн суурь хураамж болон ноогдол хураамж гэх хоёр татварыг танхимын гишүүд нь төлдөг байна.

- f) Гишүүнчлэлийн суурь хураамжийг тухайн байгууллагын бизнесийн үйл ажиллагааны төрөл, хүрээ болон санхүүгийн чадварт үндэслэн тогтоодог ба тухайн нутгийн Танхимаас шалтгаалан жижиг компаниас 20 Еврогоос эхлэн том хэмжээний корпорациас 50 000 Евро хүртэл авдаг бол
- g) Ноогдол хураамжийн хэмжээг тухайн Танхимаас шалтгаалан ашиг орлогын 0.05% - 0.39% хүртэл буюу дунджаар 0.22% тогтоодог байна. Бизнес эрхлэгч хувь хүн болон аж ахуйн нэгж нь хуулийн дагуу 15,430 Евро хүртэл хэмжээгээр энэхүү ноогдол хураамжиас чөлөөлөгддөг байна.

Өөрөөр хэлбэл суурь хураамж нь тогтсон дүнтэй байдаг бол ноогдол хураамж нь үйл ажиллагааны орлогоос хамаардаг байна.

Түүнчлэн, тусгай шинжтэй гишүүд буюу гар урлалын үйл ажиллагаа явуулдаг боловч гар урлалын бус үйл ажиллагааны хүрээгээр гишүүн болсон этгээд, хөдөө аж ахуй эрхлэгч, эмийн санч, шинэ бизнес зэрэгт хуулиар татвар ноогдуулах тусгай нөхцлүүдийг тусгасан байдаг байна. (*дэлгэрэнгүйг Герман улсын судалгааны Санхүүжилт хэсгээс харж болно*)

Казахстан улсын хувьд татварыг шаталсан хэлбэрээр өгдөг буюу нийт аж ахуй эрхлэгчдийн орлогоос шалтгаалан дөрвөн бүлэгт хуваадаг ба бүлэг дотроо мөн санхүүгийн чадавхиас хамааран дэд бүлгүүдэд хуваагддаг байна. Харин тухайн бүлэг, дэд бүлэг ямар хэмжээний татвар төлөхийг танхим журмын дагуу шийддэг байна.

Аж ахуй эрхлэгчийг ямар бүлэг, дэд бүлэгт хамаарахыг нь түүний өмнөх жилийн орлого болон Казахстан улсаас жил бүр тогтоодог “*өмнөх тайлант жилийн сарын тооцооны дундаж үзүүлэлт*” –нд тулгуурлаж шийдвэрлэдэг байна. Гишүүний төлөх татвар жил бүр өөр байдаг учир Үндэсний танхим нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр татварын хэмжээг зарлах үүрэгтэй байдаг байна. Түүнчлэн энэхүү татварыг гурав хувааж төлөх боломжийг хуулиар олгосон байдаг бөгөөд нийт

ажиллагсдын 51-с дээш хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг аж ахуй эрхлэгчийг хуулийн дагуу татвараас чөлөөлдөг байна.

Монгол Улсын хувьд Худалдаа, аж үйлдвэрлэлийн танхимын тухай хуульд гишүүнчлэлийн татварыг ямар журам, зарчмаар хураахыг нарийн тодорхойлоогүйгээс гадна чөлөөлөх үндэслэлүүдийг мөн дурьдаагүй байдаг байна.

Танхимын үйлчилгээний төлбөрийг гишүүнчлэлийн татварын адил танхим өөрийн дүрэм, журмаар шийдвэрлэх хандлага их байна.

Монгол Улсын хувьд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т заасны дагуу танхимын үйлчилгээний хөлсийг танхимын саналыг үндэслэн Сангийн сайд болон Худалдаа үйлдвэрийн сайд хамтран тогтооно гэж заасан нь танхимын үйл ажиллагаанд төр оролцож буй нэг хэлбэр юм.

үйлчилгээний хөлс өөрчлөгдөх, шинэ үйлчилгээ бий болсоноор түүний үнийг тогтоох, зарим бизнесийг дэмжих зорилгоор үнэ, хөлсийг бууруулах эсхүл чөлөөлөх арга хэмжээ авах шаардлагатай байдаг боловч энэ тохиолдолд бүр хоёр сайдын шийдвэрийг хүлээх нь танхимын бие даасан, хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх юм. Үүнээс гадна хоёр сайдын шийдвэр гаргах процесс маш удаан буюу хоёр сараа жил гарны хүртэл хугацаа өнгөрөх эрсдэлтэй тул аж ахуй эрхлэгч, гишүүдийн хувьд мөн хохиролтой байх юм.

Танхим нь үйлчилгээний хөлсөө өөрөө тогтоох нь дураараа эсхүл өндөр үнэ тогтоох эрсдэл үүсгэн гэсэн үг биш юм. Ингэснээр танхимын үйл ажиллагаа хурдан явагдах боломжтойгоос гадна гишүүдийн цаг хугацаа болон хөрөнгийг хэмнэх ач холбогдолтой юм.

Зөвлөмж: Монгол Улс нь гишүүнчлэлийн татвар авах журам болон зарчмыг хуулиар тодорхойлохоос гадна нийт гишүүд, ялангуяа бага орлоготой гишүүнд дарамт учруулахгүйн тулд орлогоос шалтгаалсан шатлалын хэлбэрээр татварын хэмжээг тогтоох, чөлөөлөгдөх болон хөнгөлөгдөх нөхцөлүүдийг тогтоож тодорхой салбар, бизнесийг дэмжих нь ач холбогдолтой юм. Түүнчлэн санхүүжилт нь танхимын хараат бус бие даасан байдлын баталгаа тул гишүүнчлэлийн татвар, үйлчилгээний хөлс зэргийг төрөөс хараат бусаар бие даан тогтоох нь зохимжтой болно.

3. ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

Зөвлөмж: Танхим нь гишүүнийхээ үндсэн мэдээллийг цуглуулахаас гадна өөрийн үйл ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээний хүрээнд хувь хүн, байгууллагын аливаа мэдээллийг бүрдүүлдэг тул эдгээрийн нууцлал, цуглуулах, шилжүүлэх, устгах журам болон гуравдагч этгээдээс хамгаалах зохицуулалтыг шинэ хуулинд тусгах нь гишүүдийнхээ эрхийг хамгаалах нэг баталгаа болох юм.

4. ТАНХИМЫН ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Монгол Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 4 болон 6 дугаар зүйлүүдэд танхим болон үндэсний танхимын бүрэн эрхийг тус тус зохицуулсан байна.

Монгол Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Танхим нь:

- улс орны эдийн засгийн хөгжилд тус дэмжлэг үзүүлэх,
- аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх таатай нөхцөл бүрдүүлэх,
- аж ахуйн нэгж, байгууллагуудаас гадаад, дотоодын байгууллагатай худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх,
- өөрийн орны бараа, бүтээгдэхүүнийг экспортод гаргахад дэмжлэг үзүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Үүнээс танхим нь “... улс орны эдийн засгийн хөгжилд тус дэмжлэг үзүүлэх ...” гэх зорилтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар нарийн тодорхойлоогүйгээс бодитоор хэрэгжих боломжгүй, тунхагийн шинжтэй заалт болсон харагдаж байна. Учир нь мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т заасан танхимын үйл ажиллагаанд ихэвчлэн гишүүддээ хүргэх үйлчилгээний хэлбэрийн үйл ажиллагаануудаар хязгаарлагдаж байна.

Харин энэхүү хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т Үндэсний танхим буюу Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүрэн эрхэд “*төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах ...*” болон “*худалдаа, үйлдвэрийнхний нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлөн илэрхийлэх, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал оруулах*” эрх хэмжээ тус тус хамаарсан байна.

Харин энэхүү заалтын үр дагаврыг хангалттай тогтоогоогүй байна. Өөрөөр хэлбэл танхим санал өгөх эрхтэй боловч уг санал хүлээн авах, харгалзах үүргийг төрийн байгууллагад өгөөгүй байна.

Энэхүү соёл нь хангалттай тогтворжоогүй тохиолдолд төрийн байгууллагатай хэрхэн, ямар эрх хэмжээний хүрээнд бизнес эрхлэгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахыг чиг үүрэгтээ нарийвчлан зохицуулсан байна. Жишээ нь, Казахстан улсын Аж ахуй эрхлэгчдийн үндэсний танхимын тухай хуулийн 9 дүгээр зүйлд нарийвчлан тоочсон байна. Үүнд зөвхөн эрх зүйн баримт бичгүүдэд санал өгөөд зогсохгүй тэдгээрийг боловсруулахад оролцох эрхийг нь олгосон байдаг байна.

Аж ахуй эрхлэгчдийн үндэсний танхимын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

- 1) Казахстан улсын Засгийн газар, Парламент болон бусад захиргааны байгууллагад аж ахуйн салбарын ашиг сонирхлыг төлөөлөх;

- 2) Аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхлыг хөндөж буй эрх зүйн норматив баримт бичиг боловсруулах ажиллагаанд оролцох;
- 3) Хувийн аж ахуйн салбарын ашиг сонирхлыг хөндөж буй хуулийн төслийн үзэл баримтлал, хууль болон бусад эрх зүйн норматив актын төсөлд мэргэжлийн дүгнэлтийг зайлшгүй гаргах;
- 4) Төв болон орон нутгийн төрийн байгууллагын зөвлөх байгууллагын аж ахуй эрхлэгчдийн эрх үүргийг хөндөж буй ажилд оролцох;
- 5) Аж ахуйн салбартай холбоотой нийтийн сонсгол зохион байгуулах зэрэг эрх хэмжээг нь баталгаажуулсан байна.

Мөн Унгар улсын хувьд Эдийн засгийн танхимын тухай хуулийн 12.1-д Үндэсний эдийн засгийн танхим буюу Унгарын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын чиг үүргийг “Эдийн засгийн холбогдолтой төлөвлөгөө болон хуулийн төслийг үнэлэх, санал өгөх” гэж, 9.1-д Бүс нутгийн эдийн засгийн танхимын чиг үүрэг нь “Тодорхой арилжаа эрхлэгчийн ашиг сонирхолтой хамааралгүй үндэсний эдийн засгийн хувьд нөлөө үзүүлэхүйц асуудлыг биелэгдэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллах, үүний тулд төв болон орон нутгийн засгийн газрын агентлаг болон эдийн засгийн ашиг сонирхлыг илэрхийлэгч байгууллагатай хамтран ажиллах”, “Бүс нутгийг хөгжүүлэх төлөвлөгөөний үе шатыг хэрэгжүүлэх, бэлтгэл ажилд оролцох” гэж тус тус хуульчилсан байдаг байна.

Түүнчлэн Франц улсын хувьд Худалдааны хуулийн L711-7-д “Төр, бүс нутаг болон бусад нутаг дэвсгэрийн удирдлага, нийтийн эрх зүйн хуулийн этгээдтэй гэрээ байгуулах” боломжийг олгосон нь танхим болон төр хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх явдлыг хангахад анхаарсан төдийгүй, тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэхдээ агуулгыг нь хэрхэн тодорхойлох талаар илүү уян хатан зохицуулалтыг бий болгосон байна.

Иймд төрийн байгууллагууд бизнес эрхлэгчдийн ашиг сонирхол хөндсөн аливаа шийдвэр, захиргааны акт, хууль тогтоомж гаргах тохиолдолд Үндэсний танхимын саналыг заавал харгалзахыг баталгаажуулсан байна.

Танхимын хэрэгжүүлэх бусад чиг үүргийн хувьд бусад улс орнуудад нэлээд өргөн хүрээнд хуульчлагдсан нь анхаарал татаж байна.

Тухайлбал, Солонгос улсын танхим нь худалдаа, аж үйлдвэрийг хөгжүүлэх нийтлэг чиг үүргээс гадна худалдаа, аж үйлдвэрийн талаарх засгийн газар болон орон нутгийн захиргааны бодлогын асуудалд зөвлөх, дэмжлэг үзүүлэх, худалдаа, аж үйлдвэрт хамаарах чадвар болон технологийг тогтоох, хуваарилах, засгийн газар болон орон нутгийн захиргааны даалгасан ажлыг гүйцэтгэх зэрэг нийтийн захиргааны чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Казахстан улс мөн адил нарийн зохицуулсан байдаг бөгөөд үүнд танхимын өөрийн эрх хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүргээс гадна олон нийтийн мониторинг³⁸

³⁸ Олон нийтийн мониторинг (ҮААЭТмХ-ийн 10-р зүйл)

хэрэгжүүлэхээс эхлүүлэн мэргэжлийн боловсролын сурах бичиг боловсруулахад оролцох, техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллагын улсын аттестатчлалд оролцох зэрэг төр, захиргааны байгууллагын хэрэгжүүлдэг чиг үүргүүдэд оролцох эрхтэй байдаг байна.

Герман улсын хувьд танхимын чиг үүргийг харьцангуй ерөнхий зүйлчилсэн байдаг ба ингэснээр танхимын үйл ажиллагааг хязгаарлахгүй гэж үздэг байна. Түүнээс гадна танхим Захиргааны байгууллагын чиг үүргийг хууль болон тогтоолын дагуу шилжүүлж авах боломжийг нь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1(4)-ийн дагуу баталгаажуулсан байна.

Унгар улсын хувьд танхимын зүгээс “Зах зээлийн шударга бус практикийг зохицуулах ёс зүйн дүрмийг өөртөө багтаасан ёс зүйн дүрмийг боловсруулах”, “Хуульд гэрээний стандарт нөхцлийн талаар тодорхойлоогүй бол хэрэглэгсийн гэрээний стандарт нөхцөл нь шударга бус эсэх талаар саналаа илэрхийлэх”, “Өөрийн дүрэмдээ заасны дагуу өөрийн орлогын тодорхой хэсгийг ашиглан эдийн засгийн үйл ажиллагаанд хамаарал бүхий дэд бүтцийг хөгжүүлэхэд оролцох” гэх мэт байдлаар хуульчилсан байх бөгөөд энэ нь аж ахуй эрхлэгч нарыг дэмжихээс гадна хэрэглэгчдийн эрх ашгийг дээдэлсэн үйл ажиллагаа явуулахад нь анхаарал хандуулах, дэд бүтцийн хөгжилд гишүүдийн татварыг зарцуулах боломжийг олгосон сайн жишгийг бий болгосон байна.

Харин Франц улсын хувьд “Дэд бүтцийн болон тодорхой байгууламжийг барих төсөлд голлон оролцох, эсхүл өөрсдийн чиг үүрэгт хамаарах бүхий л үйлчилгээг удирдаж, эрхлэн явуулах”, “Боомт болон нисэх буудлуудын тодорхой байгууламжийг бий болгох, удирдах” гэсэн чиг үүргийг танхимд олгосон байгаа нь бусад орноос ихээхэн ялгаатай байна.

Монгол Улсын хувьд танхим нь экспортын барааны гарал, үүслийг гэрчлэх, экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах зэрэг захиргааны чиг үүргийг хэрэгжүүлдэг учир Герман улсын нэгэн адил захиргааны байгууллагын чиг үүргийг хүлээн авах ерөнхий зохицуулалтыг мөн адил хуульчлах нь хууль зүйн техникийн хувьд оновчтой болно.

Захиргааны эрх зүйн үүднээс Монгол Улсын хувьд худалдаа, аж үйлдвэрийн танхимыг “нийтийн эрх зүйн гишүүнчлэл бүхий нэгдэл” гэж үздэг бөгөөд нийтийн эрх

Энэхүү чиг үүргийн хүрээнд Үндэсний танхим нь:

- a) олон нийтийн мониторинг явуулах;
- b) Бизнестэй холбоотой төв болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар санал гаргах;
- c) Төрийн мэдлийн хувьцаат компанид компанийн засаглалын үр нөлөөг үнэлэхэд оролцох;
- d) “Бизнесийн уур амьсгал” нэртэй хараат бус рейтингийн системийг бэлдэж авч явах;
- e) жил бүр Казахстан улсын бизнесийн эрхлэлтийн төлөв байдлын талаар тайлан бэлтгэж олон нийт болон төрийг мэдээллээр хангах;
- f) төрийн байгууллагууд болон төрийн албан хаагчид нь бизнесийн эрх болон хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж байгаа эсэх талаар тогтмол асуулга явуулж нэгтгэн дүгнэлт хийх бөгөөд үр дүнг Казахстаны Засгийн газар болон бусад эрх бүхий байгууллага руу явуулдаг байна. Энэхүү судалгааны дүн нь Казахстан улсын Ерөнхийлөгчийн жил бүрийн тайланд тусгагддаг байна.

зүйн хэм хэмжээнд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулна гэж тайлбарладаг. Гэвч Франц улсын хувьд нийтийн байгууламжийг ашигладаг хуулийн этгээд гэсэн ойлголт ч мөн адил хөндөгдөж байх бөгөөд танхим нь тус ангилалд хамаардаг учраас төртэй гэрээ байгуулах замаар өөрсдийн чиг үүргийг тодорхойлох боломжийг олгосон байна.

Түүнчлэн Монгол Улсын танхимд нийт 15 ширхэг бүрэн эрх олгосноор түүний үйл ажиллагааг хязгаарлагдмал, хумигдмал болгож байгаа тул танхимд өөрийн үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд тодорхойлох эрх чөлөөг олгосноор Монгол Улсын бизнесийн дэмжлэг сайжирч улмаар эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх юм.

Зөвлөмж: Монгол Улсын хувьд танхимын чиг үүргийг өргөжүүлэх, нэмэгдүүлэх мөн шаардлагатай асуудал дээр чиг үүргийг нарийвчлан зохицуулан танхимын төрийн үйл ажиллагаанд оролцох эрхийг нь олгож баталгаажуулсанаар Монгол Улсын бизнес эрхлэгчдийн дуу хоолой шийдвэр гаргах түвшинд бодитоор хүргэгдэх юм. Түүнчлэн захиргааны байгууллагын чиг үүргийг шилжүүлэн авах ерөнхий заалт оруулсанаар төр, захиргааны байгууллага шаардлагатай гэж үзсэн чиг үүргээ танхимд шилжүүлэх боломжтой болж төрийн ачаалал хөнгөрч, зардал багасахын сацуу үйлчилгээний чанар мөн сайжрах боломжтой юм.

Түүнчлэн Монгол Улсын хувьд бизнесийн үйл ажиллагаа нь Улаанбаатар хотод илүү төвлөрсөн байгаа учраас заавал гишүүнчлэлийн хэлбэрийг оновчтой хэрэглэх нь зохистой гэж дүгнэсэн. Тиймээс бизнес эрхлэгчдийг нэгтгэсэн танхимын зүгээс эдийн засагт нөлөө үзүүлэхүйц, бизнесийн үйл ажиллагаанд хамааралтай хууль тогтоомжийн төсөлд бизнес эрхлэгчдийн саналыг нэгтгэж хүргэх, төслийг боловсруулахад албан ёсоор саналаа заавал өгдөг байх, үнэлгээ хийдэг байх чиг үүргийг олгох нь маш чухалд тооцогдоно.

5. ТАНХИМЫН ДОТООД БҮТЭЦ

Танхимын дотоод ерөнхий бүтэц буюу танхимын дотоод удирдлага, хяналтын бүтэц, шат дараалал, эрх хэмжээг хуулинд тусгасан практик олон улсад өргөнөөр хэрэглэгдэж байна.

Франц, Унгар, Солонгос, Герман, Казахстан зэрэг улс орнуудад нийт гишүүдээс сонгогдсон Их хурал, түүнээс томилогдсон Удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага зарим улсад хяналтын нэгж байгуулахыг шаарддаг байна. Ингэснээр танхимын гишүүн болгоны оролцоо хангагдаж, хяналт тавих боломжийг олгохоос гадна танхимын үйл ажиллагаа эмх цэгцтэй, ил тод явуулах боломжийг бүрдүүлэх юм.

Түүнчлэн танхимын санхүүгийн бичиг баримт, тайлан гаргах, хяналт тавих зэрэг асуудлуудыг мөн зохицуулдаг байна.

Монгол Улсын хувьд танхим нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн нөхцөл, журмыг дагана (8 болон 9-р зүйл) гэж заасны дагуу төрийн бус байгууллагын бүтцийг дагаж мөрддөг байна. Гэвч олон улсын практикаас үзвэл танхим нь өөрийн гэсэн онцлог бүтэцтэй байж болдог байна. Жишээ нь Казахстан улсад салбар, салбар-

дундын, жижиг, том, дунд бизнесийн төлөөлөгч нарын холбоо магадлан итгэмжлэгдэх замаар Үндэсний танхимын Их хуралд төлөөлөгчөө оруулах эрхтэй болдог байна.

Эмэгтэйчүүд болон залуучуудын буюу тусгай бизнесийн хүрээнд

Бусад улс орнуудад старт-ап, эмэгтэйчүүдийн бизнес зэрэгт дэмжлэг үзүүлэх зорилгоор тухай салбарт зориулан тусгай хороо, хэлтэс байгуулах хандлагатай байна.

Япон улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь нийгмийн тодорхой бүлгийн худалдаа, аж үйлдвэрийн үйл ажиллагаанд чиглэсэн бүтцийн нэгжийг бий болгож, түүгээр дамжуулан тэдгээр бүлгийн нийгэмд эзлэх байр суурийг дээшлүүлэх, худалдаа аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа нь анхаарал татаж байна.

Энэ хүрээнд эмэгтэйчүүдийн холбоо болон залуучуудын хэлтэсийг дурьдаж болно. Тухайлбал, Япон улсад эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь доогуур, эмэгтэй бизнес эрхлэгчдийн тоо цөөн байдаг тул энэ бүлгийн худалдаа, аж үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн танхим дахь эмэгтэйчүүдийн холбоог үүсгэж, бодлогын түвшинд дэмжиж ажилладаг байна. Мөн танхим дахь залуучуудын хэлтэс нь төстэй үзэл санаанд тулгуурладаг.

Иймд хүн амын 70-аас илүү хувийг залуучууд эзэлдэг Монгол улсын хувьд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэд залуучуудын худалдаа, аж үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжин ажиллах тусгай гишүүнчлэл бүхий хэлтэсийг байгуулан ажиллуулах нь оновчтой байж болох юм.

Түүнчлэн Франц улсын хувьд старт-ап бизнесийг дэмжих төвийг байгуулах боломжийг танхимд олгосон байх төдийгүй, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих чиг үүргийг танхимд тусгайлан олгосон байх бөгөөд танхимын ассамблейн гишүүдийг сонгоход хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахад тусгайлан анхаарч хуульдаа тодорхой зохицуулалт оруулсан байна.

Зөвлөмж: Худалдаа, аж үйлдвэрийн салбарыг бодлогын түвшинд дэмжих үүднээс танхимын чиг үүрэг, түүний үйл ажиллагаанд томоохон ач холбогдол өгч байгаа Монгол улсын хувьд танхимын дотоод бүтэц, засаглал, хяналтын асуудлыг Монгол Улсын танхимын бүтцийн онцлогийг харгалзан Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд заавал тусах шаардлагатай бөгөөд ингэснээр гишүүн бүрийнхээ оролцоог хангаж, эрх тэгш байдлыг нь баталгаажуулах юм. Түүнчлэн, эмэгтэйчүүдийн бизнес, старт-ап бизнес зэргийг дэмжих тусгай нэгж, хэлтэсийг хуулиар баталгаажуулж болох юм.

6. ТАНХИМЫН ТОГТОЛЦОО

Танхимын тогтолцооны хувьд нутаг дэвсгэрийн тогтолцоо давамгайлж байна.

Улсад нэг үндэсний танхим байх бөгөөд холбооны улс, муж, бүс нутаг, аймаг, нийслэл, хотуудад мөн адил танхимуудтай байх бөгөөд эдгээр нь үндэсний танхимаас хараат бусаар бие даан ажиллах юм. Түүнчлэн эдгээр танхимуудын төлөөлөл үндэсний танхимын удирдлагад хэрхэн оролцох талаар баталгаажуулсан тохиолдол мөн байгаа юм.

Монгол Улсын хувьд бусад улсаас ялгарах онцлог нь маш өргөн уудам нутаг дэвсгэрт ердөө л гурван сая хүн амьдардагт оршиж байгаа юм. Үүнийг дагаад аж ахуйн үйл ажиллагааны тархалт нь жигд бус байгаа юм.

Бусад нутгуудын аж ахуй эрхлэгчид танхим болон нэгдсэн хэдий ч Казахстан Улсын нэгэн адил гишүүдийнхээ эрх, ашиг сонирхлыг хамгаалж чадахуйц мэргэжлийн болон техникийн чадамжтай танхим бий болж чадаагүй байна. Иймд Монгол Улс өөрийн онцлогт тохирсон танхимын тогтолцоо шаардлагатай байна.

***Зөвлөмж:** Монгол Улсын эдийн засаг төдийгүй, нутаг дэвсгэр, хүн ам зүйн тархалт зэргийг харгалзан өөрт тохирсон үйл ажиллагаа нь идэвхитэй байж чадах танхимын бүтэц шаардлагатай байна.*

7. ТӨР, ТАНХИМЫН ХАРИЛЦАА

Төр болон танхимын харилцаа маш чухал юм. Танхимын гол чиг үүргүүдийн нэг нь төр, төрийн үйл ажиллагаанаас бизнес эрхлэгч цаашлаад бизнес, эдийн засгийн орчинг хамгаалах билээ.

Иймд төрийн оролцоог Худалдаа, аж үйлдвэрийн танхимын эрх зүйн байдлыг зохицуулах хуулинд төрийн оролцооны цар хүрээ, заагийг тогтоох мөн танхимын бие даасан, хараат бус байдлыг баталгаажуулах шаардлагатай байдаг.

Төрөөс хараат танхим төрийн шийдвэрийн эсрэг саналаа өгч чадахгүй тул хуулиар ихэвчлэн танхимын үйл ажиллагаан дахь төрийн оролцоог хязгаарлаж харин төрийн үйл ажиллагаан дахь танхимын оролцоог баталгаажуулдаг байна.

Түүнчлэн төр болон танхимын харилцааг тусдаа зүйл, заалтаар зохицуулсан жишиг байх бөгөөд ингэснээр тэд ямар цар хүрээ, эрх хэмжээнд хамтран ажиллах нь тодорхой болдог төдийгүй, төр нь танхимын үйл ажиллагаанд халдах боломжийг хязгаарлах юм.

Жишээ нь Казахстан Улсад Засгийн газар нь танхимын гишүүнчлэлийн татварын дээд хязгаар тогтоох (бизнес эрхлэгчдэд танхим өөрөө дарамт үзүүлэхээс сэргийлэх зорилгоор) болон Үндсэн хууль, бусад хууль болон Ерөнхийлөгчийн зарлигийн хүрээнд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж заасан байдаг.

Танхимын хувьд аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхлыг хөндөж буй эрх зүйн норматив акт, олон улсын гэрээний төслийг бэлтгэхэд оролцох, төрийн байгууллагатай

хамтран зөвлөх байгууллага байгуулах болон бусад хэлбэрээр хамтран ажиллана гэж заасан байдаг.

Энэхүү зохицуулалтын онцлог нь хууль, эрх зүйн акт болон олон улсын гэрээний төсөлд танхим санал өгөхөөр хязгаарлагдахгүй эдгээрийн төслийг бэлтгэхэд оролцох эрхийг нь нээж өгсөнд байгаа юм.

Үүнээс гадна аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхлыг хөндөж буй аливаа мэдээллийг Засгийн газрын байгууллагууд Үндэсний танхимын хүсэлтээр гаргаж өгөх үүргийг хүлээдэг байна.

Дээрх асуудлуудыг шууд хуульд зохицуулж өгсөнөөр танхимын оролцоог төр өөрийн шийдвэрийг гаргахдаа хангах бодит боломж, нөгөөтэйгүүр хууль зүйн үүргийг оногдуулж байгаа хэрэг юм. Энэ нь танхимын дуу хоолой төрийн түвшинд хүрч аж ахуй эрхлэгчдийн эрх, ашиг сонирхол бодитойгоор хамгаалагдахад тодорхой хувь нэмрийг оруулдаг байна.

Монгол Улсын хувьд танхимд төрийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал оруулах зэрэг бүрэн эрхийг өгсөн боловч тэдгээрийн оролцоог хангалттай баталгаажуулаагүй байна. Өөрөөр хэлбэл төрд танхимын саналыг харгалзахгүй байх эрх нь нээлттэй юм.

Түүнчлэн аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхлыг хөндөж буй хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, захиргааны актууд гарч байгаа нь танхимын оролцоог хангаагүй буюу санал авах төдий, зарим тохиолдолд саналыг нь авахгүйгээр тэдгээрийг баталж байгаатай салшгүй холбоотой.

Иймд Монгол Улсын бизнес эрхлэгчдийн ашиг сонирхлыг хөндсөн эрх зүйн орчин бүрдээд зогсохгүй Монгол Улсын эдийн засагт сөрөг нөлөө бий болох эрсдэлтэй юм.

Зөвлөмж: Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найрууллагын төсөлд танхимын үйл ажиллагаан дахь төрийн оролцоог хязгаарлаад зогсохгүй, төрийн үйл ажиллагаанд танхим хэрхэн оролцох, төр болон танхим хэрхэн хамтран ажиллах талаар тодорхой зохицуулж танхимын байр суурийг баталгаажуулах шаардлагатай байна.

----oOo-----

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль, 1995 он
2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын урьдчилсан зохицуулалтын тухай хууль, 1956 он, <https://www.gesetze-im-internet.de/ihkg/BJNR009200956.html>
3. Бүгд Найрамдах Франц Улсын Арилжаа (Худалдаа)-ны хууль
4. Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндэсний аж ахуй эрхлэгчдийн танхимын тухай хууль, 2013 он, https://online.zakon.kz/document/?doc_id=31416500#pos=3;-114
5. Бүгд Найрамдах Солонгос Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль, 1952 он
6. Япон Улсын Худалдааны танхимын тухай хууль, 1954 он
7. Унгар Улсын Эдийн засгийн танхимын тухай хууль, 1999 он
8. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын байгууллагын болон хууль зүйн модель, Виктор Федотов, (Victor I. Fedotov, Organizational and legal models of chambers, Business associations study (2007))
9. Худалдаа, аж үйлдвэрийн танхим-Чиг үүрэг, хуулийн зохицуулалт, Германы Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гарын авлага, (Chambers of Commerce and Industry, Functions and Legal Provisions, (2013))
10. John Hall Stewart, A Documentary Survey of the French Revolution, New York: Macmillan, 165 – 66, (1951).
11. Францын Худалдаа, аж үйлдвэрийн танхим, <https://www.cci.fr/web/organisation-du-reseau/histoire>
12. Францын Худалдаа, аж үйлдвэрийн танхим, www.cci.fr
13. ESCP Бизнес, www.escpeurope.eu
14. Бүгд Найрамдах Казахстан Улсын “Атамекен” Үндэсний аж ахуй эрхлэгчдийн танхим, <https://atameken.kz/ru/pages/749-byudzh-et-finansovaya-otchetnost>
15. Бүгд Найрамдах Казахстан Улсын сарын тооцооны үзүүлэлт (1995 – 2020 оны архив) https://online.zakon.kz/document/?doc_id=1026672
16. KCCI, Organizational Chart, (Солонгосын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтэц) <http://english.korcham.net/nChamEng/Service/About/appl/Organization.asp>

- 17.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын олон улсын харьцуулалт”, Тенфордын Лорд Хэсэлтайн, х29. (The Rt Hon the Lord Heseltine of Thenford CH, Chamber of Commerce International Comparisons, (2012))
- 18.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай, Японы Худалдаа, аж үйлдвэрийн танхим, <https://www.icci.or.jp/aboutcci.pdf>
- 19.Эмэгтэйчүүдийн холбооны албан ёсны цахим хуудас, <http://joseikai.icci.or.jp/>
- 20.Залуучуудын хэлтэс, <https://21impulse.jp/info/>
- 21.Төлбөрийн хэмжээ, <https://www.tokyo-cci-nyukai.jp/fee/>
- 22.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гэрчилгээжүүлэлтийн туршилт, <https://www.kentei.ne.jp/>
- 23.Товч түүх, Унгарын Худалдаа, аж үйлдвэрийн танхим, <https://mkik.hu/en/history>

ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ

Энэхүү харьцуулалтанд улс орнуудын зөвхөн Худалдаа, аж үйлдвэрлэлийн танхимын эрх зүйн байдлыг зохицуулсан хуулиар хязгаарлагдсан бөгөөд танхимуудын дүрэм, дотоод журам зэрэг ороогүй болно.

1. ЧИГ ХАНДЛАГА (MODEL)

№	Модель	Монгол	Герман	Франц	Казахста н	Солонгос	Япон	Унга р
1	Эх газрын		✓	✓	✓	✓		
2	Евро-Азийн	✓						✓
3	Азийн						✓	

2. ТАНХИМЫН НЭРИЙН ХАМГААЛАЛТ

№	Нэрийн хамгаалалт	Монгол	Герман	Франц	Казахстан	Солонгос	Япон	Унга р
1	Байгаа					✓	✓	✓
2	Байхгүй	✓	✓	✓	✓			

3. ГИШҮҮНЧЛЭЛ COMPULSORY MEMBERSHIP БУЮУ “ЗААВАЛ” ЭСХҮЛ
“АЛБАДАН” ГИШҮҮНЧЛЭЛ

№	Гишүүнчлэл	Монгол	Герман	Франц	Казахстан	Солонгос	Япон	Унга р
1	Сайн дурын	✓					✓	✓
2	Сайн дурын бус		✓		✓			
3	Холимог			✓		✓		

4. САНХҮҮЖИЛТ

№	Улс	Гишүүнчл элийн татвар	Үйлчилгээн ий орлого	Үйл ажиллагааны орлого	Төрийн санхүүжилт	Хандив	Бусад
---	-----	-----------------------------	-------------------------	------------------------------	----------------------	--------	-------

1	Монгол	✓	✓			✓	
2	Герман	✓	✓				✓
3	Франц	✓	✓	✓	✓	✓	✓
4	Казахстан	✓	✓	✓			✓
5	Солонгос	✓	✓		✓		
6	Япон	✓	✓		✓		
7	Унгар	✓	✓	✓	✓	✓	✓

Гишүүнчлэлийн татвар авах аргачлал

№	Татвар авах хэлбэр, шинж	Монгол	Герман	Франц	Казахстан	Солонгос	Япон	Унгар
1	Албадан		✓		✓			
2	Сайн дураар							
3	Хуулиар тогтоосон		✓		✓	✓		
4	Танхим Дүрэм болон өөрийн гаргасан бусад баримт бичгээр тогтоодог		✓	✓			✓	✓
5	Хатуу тогтоосон (fixed)							
6	Жил бүр өөрчлөгддөг				✓	✓		
7	Үйл ажиллагааны орлогоос хамаардаг		✓		✓		✓	
8	Төрийн байгууллага гишүүний орлогын талаар		✓		✓			

	мэдээлэл өгөх үүрэгтэй							
9	Дүрмийн сангийн хэмжээ						✓	
10	Худалдааны эргэлт						✓	
11	Ажилтаны тоо						✓	
12	Гишүүдийн тоо						✓	

Гишүүнчлэлийн татвараас чөлөөлөх нөхцөл

№	Улс	Гишүүний татвараас чөлөөлөгдөх субъект/ нөхцөл	Татвараас чөлөөлөх нөхцөл хуульд байхгүй
1	Монгол		✓
2	Герман	– Арилжааны бүртгэлд ороогүй орлого нь 5 200 Еврогоос бага хувь хүн, аж ахуйн нэгж – Шинээр бизнесийн үйл ажиллагаа эхлүүлсэн, Арилжааны бүртгэлд ороогүй, орлого нь 25 000 Еврогоос бага хувь хүн үйл ажиллагаа эхэлсэнээс эхний хоёр жил гишүүнчлэлийн суурь хураамжаас, эхний дөрвөн жил ноогдуулсан хураамжаас тус тус чөлөөлөгдөнө.	
3	Франц		✓
4	Казахстан	Нийт ажиллагсдын 51-с дээш хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байх тохиолдолд чөлөөлнө	
5	Солонгос	Эмэгтэйчүүдийн бизнес эхний нэг жил эмэгтэйчүүдийн хорооны татвараас чөлөөлөгдөнө	
6	Япон		✓
7	Унгар		✓

5. ТАНХИМЫН ЧИГ ҮҮРЭГ

№	Чиг үүрэг	Монго л	Герма н	Франц	Казахстан	Солонгос	Япон	Унгар
1	Бизнес эрхлэгчдийн эрх ашгийг төлөөлөх	✓	✓		✓	✓	✓	✓
2	Аж ахуй эрхлэгчдийн бүртгэл хөтлөх							
3	Олон нийтэд мэдээлэл олгох		✓		✓			✓
4	Бизнес дэмжих/ туслалцаа үзүүлэх	✓	✓	✓	✓	✓	✓	✓
5	Гишүүддээ үйлчилгээ үзүүлэх	✓	✓	✓	✓	✓	✓	✓
6	Бизнесийн үйл ажиллагаа явуулах			✓				✓
7	Тендер зохион байгуулах/ хянах/ бусад оролцоо				✓			
8	Экспертиз буюу шинжээчийн дүгнэлт гаргах		✓	✓	✓	✓	✓	✓
9	Шинжээчдийн бүртгэл хөтлөх				✓			
10	Бусад хэлбэрийн бүртгэл хөтлөх		✓		✓			
11	Сургалт явуулах	✓	✓	✓	✓	✓	✓	✓
	Үзэсгэлэн	✓	✓		✓	✓	✓	

12	худалдаа зохион байгуулах							
13	Хуулийн төсөлд санал өгөх		✓		✓			✓

Танхим нь захиргааны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлдэг эсэх

№	Захиргааны байгууллагын чиг үүрэг хэрэгжүүлдэг эсэх	Монгол	Герман	Франц	Казахст ан	Солонго с	Япон	Унгар
1	Тийм		✓	✓	✓	✓	✓	
2	Үгүй	✓						

Танхим нь аж ахуй эрхлэгчдэд аливаа хэлбэрийн зөвшөөрөл олгодог эсэх

№	Улс	Зөвшөөрлийн төрөл	Хяналтын чиг үүрэг
1	Монгол	-	
2	Герман	Даатгалын төлөөлөгчийн зөвшөөрөл	✓ (сургалт)
3	Франц	-	
4	Казахстан	-	✓
5	Солонгос	-	✓
6	Япон	-	✓
7	Унгар	-	

Танхимын хэрэг хянан шийдвэрлэх эрх хэмжээ

№	Улс	Арбитр	Эвлэрүүлэн зуучлал
1	Монгол	✓	-
2	Герман	✓	-
3	Франц	-	-
4	Казахстан	✓	-
5	Солонгос	-	-
6	Япон	✓	✓
7	Унгар	✓	-

Онцгой бизнес дэмжих (Старт-Ап, Эмэгтэйчүүдийн Бизнес Г.М.)

№	Улс	Бизнесийн төрөл	Үзүүлэх дэмжлэг	Аливаа дэмжлэг үзүүлдэггүй
1	Монгол			
2	Герман	- гарааны бизнес буюу старт ап - жижиг дунд бизнес эрхлэгчид	- бизнесийн зөвлөгөө - гадаад худалдаа, инноваци, патентын талаар болон шинэ аж ахуйн нэгж хөтлөлтийн талаар анхан шатны зөвлөгөө	
3	Франц	Гарааны бизнесийн төвийг байгуулж, үйл ажиллагааг нь явуулдаг.	Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих чиг үүргийг танхим нь тусгайлан гүйцэтгэдэг. Мөн бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүнд нэр дэвшигчдийн хүйсийн харьцааг тэнцвэртэй байхыг хуульчилсан байдаг.	
	Казахстан	- бизнес эрхлэх	- Санхүүгийн бус	

4		сонирхолтой этгээд - нийт ажиллагсдын 51% нь хөгжлийн бэрхшээлтэй аж ахуйн нэгж	дэмжлэг - Гишүүнчлэлийн татвараас чөлөөлөх	
5	Солонгос		-	-
6	Япон	- Эмэгтэйчүүдийн бизнес	Эхний нэг жил Эмэгтэй бизнес эрхлэгчдийн хорооны татвараас чөлөөлнө	
7	Унгар		-	-

6. ДОТООД БҮТЭЦ

№	Улс	Дотоод бүтцийг хуульчилс ан эсэх	Дээд хурал	Удирдах зөвлөл	Гүйцэтгэ х удирдлаг а	Мэргэжли йн хороод	Дотоод хяналтын байгууллага
1	Монгол			✓	✓		✓
2	Герман		✓	✓	✓	✓	
3	Франц		✓	✓	✓		
4	Казахстан		✓	✓	✓	✓	✓
5	Солонгос	✓	✓	✓	✓	✓	✓
6	Япон	✓	✓	✓	✓	✓	✓
7	Унгар	✓	✓	✓	✓	✓	✓

Орон нутгийн салбар, төлөөлөгчийн газар

№	Орон нутгийн танхимын хараат байдал	Монго л	Герман	Франц	Казахста н	Солонго с	Япон	Унгар
1	Танхимаас шууд удирддаг эсэх							
2	Танхимаас удирдлага томилдог							

	эсэх							
3	Өөрөө удирдах ёс хэрэгжүүлдэг эсэх	✓	✓	✓	✓	✓	✓	✓

Гадаад болон олон улсын худалдааны төлөөлөл

№	Үйл ажиллагаа	Монгол	Герман	Франц	Казахстан	Солонгос	Япон	Унгар
1	Олон улсад бизнес эрхлэгчдийн ашиг сонирхлыг төлөөлөх эсэх	✓	✓	✓	✓	N/A	N/A	
2	Гадаадад салбар төлөөллийн газартай эсэх	✓	✓	✓	N/A	✓	✓	✓
3	Экспортын дэмжлэг/	✓	✓		✓			
4	Дотоодын баталгаат бизнес эрхлэгчдийн бүртгэл хөтөлдөг эсэх				✓			

7. ТӨРИЙН ОРОЛЦОО

№	Хуулиар төрийн оролцоог	Монгол	Герман	Франц	Казахстан	Солонгос	Япон	Унгар
1	Хориглосон							
2	Хориглоогүй	✓		✓	✓	✓	✓	✓
3	Зөвхөн тодорхой хэмжээний хязгаар тогтоосон		✓					

Танхимын үйл ажиллагаанд төр оролцох эрхтэй эсэх

№	Төрийн оролцоо	Монгол	Герман	Франц	Казахстан	Солонгос	Япон	Унгар
1	Байхгүй							
2	Тодорхой хэмжээнд байдаг	✓	✓		✓	✓	✓	✓
3	Танхимын хэрэгжүүлж буй захиргааны чиг үүргийн биелэлтийн хяналт		✓	✓		✓	✓	
4	Танхимын дотоод бүтцэд төлөөлөлтэй /удирдах зөвлөлд гишүүнчлэлтэй г.м./				✓			

Өөрөө удирдах ёс (self-governance)

№	Хараат бус байдлыг хуулчилсан эсэх	Монгол	Герман	Франц	Казахстан	Солонгос	Япон	Унгар
1	Тийм			✓	✓	✓	✓	✓
2	Үгүй	✓	✓					

Танхим болон төрийн хамтран ажиллах хэлбэр

№	Хамтраж ажиллах хэлбэр	Монгол	Герман	Франц	Казахстан	Солонгос	Япон	Унгар
1	Танхим хуулийн төсөлд санал		✓		✓	✓	✓	✓

	өгөх эрх							
2	Хуулийн төсөлд хориг тавих эрх							
3	Төрд бизнес, аж ахуйн талаар зөвлөгөө өгөх		✓		✓	✓	✓	✓
4	Төртэй гэрээ байгуулах замаар зарим чиг үүргийг татварын мөнгөөр хэрэгжүүлдэг			✓				

**ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСӨЛД БУСАД БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬБОО**

№	Хаанаас	Саналын утга	Саналыг тусгасан байдал
1.	Улаанбаатар Худалдааны Танхим 2022.12.23 02/415	Юуны өмнө Улаанбаатар хотын худалдааны танхимаас "Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл"-д санал авахаар хандсанд талархал илэрхийлье. Бид 2022 оны 12-р сарын 22-нд хүлээн авсан 1/6411 тоот албан бичигт хавсаргасан хуулийн төсөл болон холбогдох баримт бичгүүдтэй танилцан, эдгээртэй холбоотой саналаа Хавсралтаар хүргүүлж байна. Эдгээр баримт бичгүүд болон хуулийн төсөлтэй танилцахад тус хуулийн төсөл нь сайн боловсруулагдсан, олон улсын сайн жишгийг Монгол Улсад нэвтрүүлж ХАҮТ-уудын зөв тогтолцоог бий болгож, танхимуудын үйл ажиллагааг хөгжлийн дараагийн шатанд гаргах сайн хуулийн төсөл болсон байна гэж бид үзэж энэ төслийг боловсруулан Танд болон танай хамт олонд дахин талархал илэрхийлье. Энэ дашрамд УБХТ-аас өмнө нь Танд илгээсэн хүсэлтийн дагуу манай танхимын төлөөлөл тус хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах хүсэлтэй байгаа гэдгийгээ дахин илэрхийлье. 1.Нэршлийн хувьд: Хуулийн төслийн 3.1-р заалтын "... "салбар танхим" гэх ..." гэж нэрлэснийг "орон нутгийн танхим" гэж өөрчлөх. Хуулийн төсөлд тусгагдсан "салбар танхим" гэдэг бүх нэршлийг "орон нутгийн танхим" болгон өөрчлөх. Тайлбар: Тус хуульд тусгагдсан "салбар танхим" нь бие даасан танхим бөгөөд аймаг, нийслэлд байгуулагдан бие даан үйл ажиллагаагаа явуулна. Харин эдгээр аймаг, нийслэлийн ХАҮТ-ууд нь өөрийн аймаг, нийслэлийн сум, дүүрэгт өөрийн салбарыг байгуулан ажиллуулах шаардлага гарч ирэх тохиолдолд тэдгээрийг өөрийн "салбар" гэж нэрлэх шаардлагатай болно. Энэ тохиолдолд нэршил давхардаж ойлгомжгүй байдал үүсгэнэ. Иймд хуулийн төсөлд байгаа "салбар танхим" гэдэг нэршлиүүдийг бүгдийг нь "орон нутгийн танхим" гэж өөрчлөн нэрлэх саналтай байна. 2. Тогтолцооны хувьд: Хуулийн төслийн 6.2 дугаар заалтын "...үндэсний хэмжээнд" гэсний ард "аймаг, нийслэлийн танхим энэ хуулийн 6.1-д заасан зорилгыг тухайн аймаг, нийслэлийн хэмжээнд тус тус хэрэгжүүлнэ" гэж нэмж шинэчлэн найруулах. Тайлбар: Өнөөгийн ХАҮТ-уудын тогтолцооны хүрээнд ХАҮТ-уудын үйл ажиллагааны хүрээ, төрийн байгууллагуудтай харилцах харилцааны түвшин тодорхой биш байгаа	Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нэгдсэн танхимыг "салбарын танхим" гэж өөрчилсөн.
		Төслийн 4.2-т "Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь энэ хуулийн 4.1-д заасан зорилгыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэгч Монголын Үндэсний танхим, аймаг, нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэгч аймаг, нийслэлийн танхим, эдийн засгийн үйл	

	бөгөөд үүнийг дээрх байдлаар тодорхой зааж өгснөөр Үндэсний, аймаг, нийслэлийн ХАҮТ-уудын зорилго, үйл ажиллагааны хүрээ, төрийн байгууллагуудтай харилцах түвшин нь тодорхой болж, зааг, ялгаа нь тодорхой болох болно.	ажиллагааны салбарын хүрээнд хэрэгжүүлэгч салбарын танхим, гадаад улсад хэрэгжүүлэх төлөөлөгчийн газраас бүрдэнэ.” гэж өөрчлөн найруулсан.
	Хуулийн төслийн 6.4 дүгээр заалтын “ ... Үндэсний танхимаас эрх олгосноор бүхэлд нь буюу хэсэгчлэн ... ” гэснийг хасах. Хуулийн төслийн 6.6 дугаар заалтын “ ... Үндэсний танхимаас эрх олгосноор бүхэлд нь буюу хэсэгчлэн ... ” гэснийг хасах. Тайлбар: Мэргэжлийн болон аймаг, нийслэлийн танхимууд нь бие даан үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд бөгөөд эдгээр хуулийн этгээдүүд нийлж Үндэсний танхимыг байгуулна. Ө.х. доороос дээш чиглэсэн тогтолцоотой байхыг дэмжиж байна. Энэ тохиолдолд эдгээр танхимууд Үндэсний танхимаас эрх авч ажиллах тухай заалт оруулснаар энэхүү доороос дээш чиглэсэн зөв тогтолцоог саармагжуулах болно. Иймээс эдгээр үгийг эдгээр заалтуудаас хасах саналтай байна. Үр дагавар: Ингэж хассанаар 1-рт танхимуудын тогтолцоо зөв, тодорхой болно. 2-рт Үндэсний танхим нь 6.1-д заасан зорилгыг үндэсний хэмжээнд, аймаг, нийслэлийн танхимууд нь 6.1-д заасан зорилгыг тухайн орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн тухайн орон нутгийн засаг захиргаатайгаа ажиллахаар болж зааг ялгаа нь тодорхой болох болно.	Саналыг тусгаж, Үндэсний танхимыг доороос дээш чиглэсэн тогтолцоотой байхаар хуулийн төслийн 4.4-т “Монголын Үндэсний танхимыг аймаг, нийслэлийн танхим болон салбарын танхимууд энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу байгуулна.” гэж өөрчлөн найруулсан.
	Хуулийн төслийн 6.9 дүгээр заалтын “ ... Үндэсний танхимын ... ” гэсний оронд “.. тухайн орон нутгийн танхимын ... ” гэж өөрчлөн найруулах. Тайлбар: Хуулийн төслийн 6.1-д заагдсан зорилгыг үндэсний хэмжээнд Үндэсний танхим хэрэгжүүлэх, орон нутагт аймаг, нийслэлийн танхимууд хэрэгжүүлэхээр үйл ажиллагааны зааг, ялгааг тодорхой зааж өгснөөр эдгээр танхимуудын төрийн байгууллагуудтай харилцах харилцаа, түвшин тодорхой болох бөгөөд үүнийг илүү тодорхой болгохын тулд тухайн аймаг, нийслэл өөрийн салбаруудыг сум, дүүрэгтээ байгуулдаг байх саналтай байна. Үр дагавар: Ингэж өөрчлөхгүйгээр хуулийн төслийн 6.9-р заалтыг хэвээр нь үлдээвэл сум, дүүргийн түвшний үйл ажиллагаа, холбогдох төрийн байгууллагуудтай харилцах харилцаанд Үндэсний танхим оролцож, тухайн аймаг, нийслэлийн танхимууд оролцох боломжгүй мэт байдал үүсч, үндэсний ба орон нутгийн танхимуудын үйл ажиллагаа, төрийн байгууллагатай харилцах харилцааны зааг ялгаа ойлгомжгүй болох болно.	Хуулийн төслийн 6.9 дэх хэсгийг хассан.

	Хуулийн төслийн 7.1, 7.4 дүгээр заалтуудын "...өөрийн үйл ажиллагаа явуулж буй чиглэлээр байгуулагдсан мэргэжлийн танхим эсхүл ..." гэснийг хасах. Тайлбар: Тухайн аймаг, нийслэлийн танхимууд дээр ААН-үүд заавал гишүүнчлэлтэй байх нь хуулийн этгээдийн бүртгэлийг тарамдуулахгүй, давхардал үүсгэхгүй байх ач холбогдолтойгоос гадна ААН-үүд мэргэжлийн танхимуудад давхар гишүүнчлэлтэй байх эрх нь нээлттэй байгаа тул ААН-үүдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй.	7.1, 7.4 дүгээр хэсгүүдийг тус тус хасаж, 16.2-т "Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарын танхим, эсхүл өөрийн харьяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах аймаг, нийслэлийн танхимд сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэж болно." гэж тусгасан.
	Хуулийн төслийн 7.11 дүгээр заалтын "... Үндэсний ..." гэснийг "...тухайн танхимын ..." гэж өөрчлөн найруулах. Тайлбар: Бүх танхимууд нь энэ хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах тул тухайн бие даасан танхимууд энэ хуульд нийцсэн дүрмээ өөрсдөө гарган УЗ-өөрөө батлуулдаг болох нь байгууллагын засаглалын хувьд бие даасан байх ашигтайгаас гадна өөрсдийнх нь гол үүрэг болох гишүүн байгууллагууддаа үйлчлэх, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулах боломжийг олгоно. Үр дагавар: Ийнхүү өөрчлөөгүй тохиолдолд ХАҮТ-уудын тогтолцоо доороос дээш чиглэсэн бус, холимог, ойлгомжгүй болохоос гадна Үндэсний танхимаас баталсан дүрэм нь тухайн аймаг, орон нутгийн, эсхүл мэргэжлийн салбарын онцлогт тохирохгүй байх тохиолдол үүсч болзошгүй. Энэ нь тухайн танхимуудын өөрийн гишүүдийнхээ онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн үйл ажиллагааг хөрвөх чадвартайгаар хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж магадгүй гэж үзэж байна.	Саналыг тусгаж, Хуулийн төслийн 12.1.4-т "Аймаг, нийслэлийн болон салбарын танхимын Бүх гишүүдийн хурал энэ хуульд нийцүүлэн аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах" эрхтэй байхаар тусгав.
	Хуулийн төслийн 9.4 дүгээр заалтын "татгалзах үндэслэл"-ийг хуулинд тодорхой зааж тусгах.	Тус зохицуулалтыг хуулийн төслөөс хассан.
	Хуулийн төслийн 11.1 дүгээр заалтад "11.1.4. үйлчилгээний орлого", "11.1.5. төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхэд зориулж олгосон санхүүжилт" гэсэн заалтуудыг нэмэх. Тайлбар: Орон нутгийн танхимууд нь зөвхөн гишүүний хураамж аваад, бүртгээд суудаг байгууллага байж болохгүй. Эдгээр танхимууд нь хуулийн төслийн 6.1-д тусгагдсан зорилгыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх байгууллага байх ёстой тул өөрийн гишүүдээ сургалт, зөвлөгөө өгөх гэх мэт тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлэх замаар хувийн хэвшлийг хөгжүүлэхийн төлөө ажиллах байгууллага байх ёстой. Түүнчлэн орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, тодорхой зарим төрийн үйлчилгээг танхимууд нь үзүүлдэг болох нь төр-хувийн	Саналыг тусгаж төслийн 17.1.3-т "үйлчилгээний орлого", 17.1.4-т "хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр" гэж тус тус нэмж тусгав.

	хэвшлийн хамтын ажиллагааны дараагийн томоохон алхам болох тул ийм төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлснээр хүлээн авах санхүүжилтийг энд нэмэж өгөх шаардлагатай гэж үзэж байна.	
	Хуулийн төслийн 21.1 дүгээр заалтад "21.1.4. улсын төсөв, улсын тусгай сангуудын төлөвлөгөө, санхүүгийн төсөлд хувийн хэвшлийг төлөөлөн санал өгөх, улсын төсөв, улсын тусгай сангуудын орлого, зарлагад хувийн хэвшил, татвар төлөгчдийг төлөөлөн хяналт тавих, шаардлагатай тохиолдолд холбогдох төрийн байгууллагад шаардлага, санал, дүгнэлтээ хүргүүлэн, эдгээрийгээ шийдвэрлүүлэх, энэ талаарх мэдээллийг хувийн хэвшил, олон нийтэд ил тод нээлттэй мэдээлж байх" гэсэн заалтыг нэмэх. Тайлбар: Үндэсний танхим нь хувийн хэвшлийн ААН-үүдийг нэгтгэсэн аймаг, нийслэл, мэргэжлийн танхимуудын нэгдэл учраас эдгээрийг төлөөлөн улсын хэмжээнд хувийн хэвшлийн эрх ашгийг илэрхийлэх, төлөөлөх, хамгаалах эрх үүргийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд Үндэсний танхим хувийн хэвшлийн төлсөн татварын зарцуулалт, хувийн хэвшлийн хөгжилд нөлөөлж буй улсын тусгай сангуудын үйл ажиллагаанд хөндлөнгийн, хараат бус хяналт тавьж ажиллах гол институци болж ажиллах шаардлагатай байгаа тул энэ заалтыг нэмэх саналтай байна. Хуулийн төслийн 22.1.4, 22.1.5, 22.1.6, 23.1.2 дугаар заалтуудыг аймаг, нийслэл, мэргэжлийн танхимын эрхлэх үйл ажиллагааны чиглэл болгон өөрчлөх. Тайлбар: Үндэсний танхимын хувьд Засгийн газар, УИХ-тай бизнесийн орчныг сайжруулах, үндэсний хэмжээний судалгаа хийх, бодлого боловсруулахад хамтран ажиллах зэргээр үндэсний хэмжээнд ажиллах, аймаг, нийслэл, мэргэжлийн танхимууд нь гишүүдээ хөгжүүлэх, гишүүдээ үйлчилгээ үзүүлэх ажлуудыг хийхээр үйл ажиллагааны зааг ялгааг гаргаж өгөх шаардлагатай байна Хуулийн төслийн 2-р бүлэгт ХАҮТ-ын чиг үүргийг "Тус хуулийн 19, 23 дугаар зүйлүүдэд заагдсан Үндэсний танхимын чиг үүргийг аймаг, нийслэлийн танхимууд тухайн орон нутагт, мэргэжлийн танхим тухайн эдийн засгийн салбарын хүрээнд хэрэгжүүлнэ" гэж зааж өгч нэмж оруулах. Тайлбар: Хуулийн төсөлд Үндэсний танхимын чиг үүргийг тодорхой зааж оруулсан боловч аймаг, нийслэл, мэргэжлийн танхимуудын чиг үүрэг тодорхой бус байна. Иймд эдгээр танхимуудын чиг үүргийг ялгаж нэмж оруулах шаардлагатай. ХАҮТ-ЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ ГАРАХ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ Төсвийн тухай хуулийн 8.10 дугаар заалтад "8.10.3-т 8.10.2-т заасан аудитын дүгнэлт гарснаас хойш ажлын 15 хоногийн дотор Үндэсний танхимын саналыг авч УИХ-д хүргүүлэх" гэж нэмэх. • Төсвийн тухай хуулийн 27.1 дүгээр заалтад "27.1.10. Төсвийн төслийг хувийн хэвшилд	Сангийн яамнаас төсөв болон татварын харилцааг зохицуулсан холбогдох хуулиудад өөрчлөлт оруулахыг дэмжээгүй тул саналыг тусгаагүй. Саналыг тусгаж, төслийн 6.2-т "Энэ хуулийн 6.1-д заасан бүрэн эрхийг Монголын Үндэсний танхим Үндэсний болон гадаад улсын хүрээнд, аймаг, нийслэлийн танхим нь тухайн аймаг, нийслэлийн хүрээнд, салбарын танхим нь тухайн эдийн засгийн салбарын хүрээнд тус тус хэрэгжүүлнэ." гэж өөрчлөн найруулсан. Сангийн яамнаас Төсөв болон татварын харилцааг зохицуулсан холбогдох хуулиудад өөрчлөлт оруулахыг дэмжээгүй тул саналыг тусгаагүй.

		танилцуулан хэлэлцүүлж, саналыг нь авч тусгасан байх" гэж нэмэх. Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлд "63.5. Орон нутгийн төсвийн төслийг батлахаас өмнө тухайн орон нутгийн хувийн хэвшилд танилцуулан, саналыг нь авч, тусгасан байх" гэж нэмэх. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлд "60.2. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт, үйл ажиллагаанд тухайн орон нутгийн танхим хөндлөнгийн хяналт тавьж ажиллана" гэж нэмэх.	
2.	Монгол дахь Америкийн Худалдааны Танхим 2022.12.22 2022/130	Юуны өмнө Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах хүсэлт ирүүлсэнд талархал илэрхийлье. Гэхдээ цаашид аливаа хуулийн төсөлд санал авахдаа цагийг нь ийнхүү тулгаж бус, гадаадын хөрөнгө оруулагчид болон бизнесийнхэнд бодитой санал гаргах боломжоор хангаж, дор хаяж 2-3 долоо хоногийн өмнө ирүүлж байхыг хүсье. УИХ-д өргөн баригдсан "Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл"-д АмЧам Монголын зүгээс дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд: 1.Хуулийн төслийн 8.1 болон 8.2-р заалтуудыг бүрмөсөн хасах: 8.1-р заалтанд "Үндэсний танхим, мэргэжлийн танхим, салбар танхим болон төлөөлөгчийн газраас бусад байгууллага, хуулийн этгээдийн оноосон нэрэнд "Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим", "худалдаа, аж үйлдвэрийн танхим", "худалдааны танхим", "мэргэжлийн танхим" эсхүл худалдаа, аж үйлдвэрийн танхимын зорилгыг илэрхийлэх бусад төсөөтэй монгол болон гадаад үг, нэр томьёо хэрэглэх болон хуулийн этгээдийн улсын бүртгэлд нэр баталгаажуулж, бүртгэхийг хориглоно" хэмээн заасан нь хуулийн дагуу өнгөрсөн 11 жилийн хугацаанд үйл ажиллагаа амжилттай явуулж буй манай танхимтай төстэй байгууллагуудын үйл ажиллагааг хуулиар хориглох гэсэн хууль бус ажиллагаа гэж үзэж байна. 2.Төслийн 8.2-р заалтанд: "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 8.1-д заасан хуулийн этгээдийн оноосон нэрийг баталгаажуулах, бүртгэхдээ Үндэсний танхимаас ирүүлсэн саналыг үндэслэнэ" гэж заасан нь МҮХАҮТ эрх мэдлийг өөр дээрээ төвлөрүүлэхээр санаархаж байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь бас хууль бус юм. 3.Түүнчлэн энэхүү хуулийн төслийн талаар нээлттэй хэлэлцүүлгийг Улаанбаатар хотын худалдааны танхим болон Монголын мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөлтэй хамтран 2021 оны 10-р сарын 20-нд зохион байгуулсан бөгөөд тус хэлэлцүүлгийн үеэр оролцогчдоос гаргасан саналуудыг хавсралтаар хүргүүлэв.	Саналыг тусгаж, нэрийн зохицуулалтыг бүхэлд нь хуулийн төслөөс хассан.

---o0o---



Монгол дахь Америкийн Худалдааны Танхим

Найман Зөвхис барилга, 8 давхар
Сүхбаатар дүүрэг, Сүүлийн гудамж 21
Монгол улс, Улаанбаатар 14251

2022/12/22

№ 2022/130

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД
Х.НЯМБААТАР ТАНАА**

Хууль зүй, дотоод хэргийн яам
Засгийн газрын V байр
Б.Ширэндэвийн гудамж 8/4
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар,
Монгол улс

г Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай т
хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал
хүргүүлэх тухай

Эрхэм хүндэт сайд Х.Нямбаатар Танаа:

Юуны өмнө Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах хүсэлт ирүүлсэнд талархал илэрхийлье. Гэхдээ цаашид аливаа хуулийн төсөлд санал авахдаа цагийг нь ийнхүү тулгаж бус, гадаадын хөрөнгө оруулагчид болон бизнесийнхэнд бодитой санал гаргах боломжоор хангаж, дор хаяж 2-3 долоо хоногийн өмнө ирүүлж байхыг хүсье.

УИХ-д өргөн баригдсан "Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл" –д АмЧам Монголын зүгээс дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Хуулийн төслийн 8.1 болон 8.2-р заалтуудыг бүрмөсөн хасах: 8.1-р заалтанд "Үндэсний танхим, мэргэжлийн танхим, салбар танхим болон төлөөлөгчийн газраас бусад байгууллага, хуулийн этгээдийн оноосон нэрэнд "Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим", "худалдаа, аж үйлдвэрийн танхим", "худалдааны танхим", "мэргэжлийн танхим" эсхүл худалдаа, аж үйлдвэрийн танхимын зорилгыг илэрхийлэх бусад төсөөтэй монгол болон гадаад үг, нэр томьёо хэрэглэх болон хуулийн этгээдийн улсын бүртгэлд нэр баталгаажуулж, бүртгэхийг хориглоно" хэмээн заасан нь хуулийн дагуу өнгөрсөн 11 жилийн хугацаанд үйл ажиллагаа амжилттай явуулж буй манай танхимтай төстэй байгууллагуудын үйл ажиллагааг хуулиар хориглох гэсэн хууль бус ажиллагаа гэж үзэж байна.

2. Төслийн 8.2-р заалтанд: "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 8.1-д заасан хуулийн этгээдийн оноосон нэрийг баталгаажуулах, бүртгэхдээ Үндэсний танхимаас ирүүлсэн саналыг үндэслэнэ" гэж заасан нь МҮХАҮТ эрх мэдлийг өөр дээрээ төвлөрүүлэхээр санаархаж байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь бас хууль бус юм.

3. Түүнчлэн энэхүү хуулийн төслийн талаар нээлттэй хэлэлцүүлгийг Улаанбаатар хотын худалдааны танхим болон Монголын мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөлтэй хамтран 2021 оны 10-р сарын 20-нд зохион байгуулсан бөгөөд тус хэлэлцүүлгийн үеэр оролцогчдоос гаргасан саналуудыг хавсралтаар хүргүүлэв.

Энэхүү саналуудын талаар нэмж тодруулах зүйл байвал манай Бодлого хариуцсан захирал Г.Жавхлантөгстэй policy@amcham.mn цахим хаягаар болон 99901983 утсаар холбогдоно уу.

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал
О.Адъяа



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД Х.НЯМБААТАР ТАНАА

2022.12.23 № 02/415 Улаанбаатар

Танай 1/6411 тоот албан бичгийн
хариу хүргүүлэх тухай

Юуны өмнө Улаанбаатар хотын худалдааны танхимаас “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-д санал авахаар хандсанд талархал илэрхийлье.

Бид 2022 оны 12-р сарын 22-нд хүлээн авсан 1/6411 тоот албан бичигт хавсаргасан хуулийн төсөл болон холбогдох баримт бичгүүдтэй танилцан, эдгээртэй холбоотой саналаа Хавсралтаар хүргүүлж байна.

Эдгээр баримт бичгүүд болон хуулийн төсөлтэй танилцахад тус хуулийн төсөл нь сайн боловсруулагдсан, олон улсын сайн жишгийг Монгол улсад нэвтрүүлж ХАҮТ-уудын зөв тогтолцоог бий болгож, танхимуудын үйл ажиллагааг хөгжлийн дараагийн шатанд гаргах сайн хуулийн төсөл болсон байна гэж бид үзэж энэ төслийг боловсруулан Танд болон танай хамт олонд дахин талархал илэрхийлье.

Энэ дашрамд УБХТ-аас өмнө нь Танд илгээсэн хүсэлтийн дагуу манай танхимын төлөөлөл тус хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах хүсэлтэй байгаа гэдгийгээ дахин илэрхийлье.

Асууж тодруулах зүйл байвал бидэнтэй дараах хаягаар холбогдоно уу.
Хаяг: Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж, Лагшан төв, 3а1 тоот
Утас: 7700-3883 (Холбоо барих хүн: Б.Хаш-Эрдэнэ, Гүйцэтгэх захирал)
Э-шуудан: ceo@ubchamber.mn

Хүндэтгэсэн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ХАШ-ЭРДЭНЭ

Утас: (+976) 77003883

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж,
Лагшан төв, 3а1 тоот

info@ubchamber.mn
www.ubchamber.mn

ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ӨГӨХ УБХТ-ЫН САНАЛ

1. Нэршлийн хувьд:

- Хуулийн төслийн 3.1-р заалтын “... “салбар танхим” гэх ...” гэж нэрлэснийг “орон нутгийн танхим” гэж өөрчлөх.

- Хуулийн төсөлд тусгагдсан “салбар танхим” гэдэг бүх нэршлийг “орон нутгийн танхим” болгон өөрчлөх

Тайлбар: Тус хуульд тусгагдсан “салбар танхим” нь бие даасан танхим бөгөөд аймаг, нийслэлд байгуулагдан бие даан үйл ажиллагаагаа явуулна. Харин эдгээр аймаг, нийслэлийн ХАҮТ-ууд нь өөрийн аймаг, нийслэлийн сум, дүүрэгт өөрийн салбарыг байгуулан ажиллуулах шаардлага гарч ирэх тохиолдолд тэдгээрийг өөрийн “салбар” гэж нэрлэх шаардлагатай болно. Энэ тохиолдолд нэршил давхардаж ойлгомжгүй байдал үүсгэнэ. Иймд хуулийн төсөлд байгаа “салбар танхим” гэдэг нэршлүүдийг бүгдийг нь “орон нутгийн танхим” гэж өөрчлөн нэрлэх саналтай байна.

2. Тогтолцооны хувьд:

- Хуулийн төслийн 6.2 дугаар заалтын “... үндэсний хэмжээнд” гэсний ард “ аймаг, нийслэлийн танхим энэ хуулийн 6.1-д заасан зорилгыг тухайн аймаг, нийслэлийн хэмжээнд тус тус хэрэгжүүлнэ” гэж нэмж шинэчлэн найруулах.

Тайлбар: Өнөөгийн ХАҮТ-уудын тогтолцооны хүрээнд ХАҮТ-уудын үйл ажиллагааны хүрээ, төрийн байгууллагуудтай харилцах харилцааны түвшин тодорхой биш байгаа бөгөөд үүнийг дээрх байдлаар тодорхой зааж өгснөөр Үндэсний, аймаг, нийслэлийн ХАҮТ-уудын зорилго, үйл ажиллагааны хүрээ, төрийн байгууллагуудтай харилцах түвшин нь тодорхой болж, зааг, ялгаа нь тодорхой болох болно.

- Хуулийн төслийн 6.4 дүгээр заалтын “...Үндэсний танхимаас эрх олгосноор бүхэлд нь буюу хэсэгчлэн ...” гэснийг хасах.
- Хуулийн төслийн 6.6 дугаар заалтын “...Үндэсний танхимаас эрх олгосноор бүхэлд нь буюу хэсэгчлэн ...” гэснийг хасах.

Тайлбар: Мэргэжлийн болон аймаг, нийслэлийн танхимууд нь бие даан үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд бөгөөд эдгээр хуулийн этгээдүүд нийлж Үндэсний танхимыг байгуулна. Ө.х. доороос дээш чиглэсэн тогтолцоотой байхыг дэмжиж байна. Энэ тохиолдолд эдгээр танхимууд Үндэсний танхимаас эрх авч ажиллах тухай заалт оруулснаар энэхүү доороос дээш чиглэсэн зөв тогтолцоог саармагжуулах болно. Иймээс эдгээр үгийг эдгээр заалтуудаас хасах саналтай байна.

Үр дагавар: Ингэж хассанаар 1-рт танхимуудын тогтолцоо зөв, тодорхой болно. 2-рт Үндэсний танхим нь 6.1-д заасан зорилгыг үндэсний хэмжээнд, аймаг, нийслэлийн танхимууд нь 6.1-д заасан зорилгыг тухайн орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн тухайн

орон нутгийн засаг захиргаатайгаа ажиллахаар болж зааг ялгаа нь тодорхой болох болно.

- Хуулийн төслийн 6.9 дүгээр заалтын “...Үндэсний танхимын...” гэсний оронд “... тухайн орон нутгийн танхимын...” гэж өөрчлөн найруулах.

Тайлбар: Хуулийн төслийн 6.1-д заагдсан зорилгыг үндэсний хэмжээнд Үндэсний танхим хэрэгжүүлэх, орон нутагт аймаг, нийслэлийн танхимууд хэрэгжүүлэхээр үйл ажиллагааны зааг, ялгааг тодорхой зааж өгснөөр эдгээр танхимуудын төрийн байгууллагуудтай харилцах харилцаа, түвшин тодорхой болох бөгөөд үүнийг илүү тодорхой болгохын тулд тухайн аймаг, нийслэл өөрийн салбаруудыг сум, дүүрэгтээ байгуулдаг байх саналтай байна.

Үр дагавар: Ингэж өөрчлөхгүйгээр хуулийн төслийн 6.9-р заалтыг хэвээр нь үлдээвэл сум, дүүргийн түвшний үйл ажиллагаа, холбогдох төрийн байгууллагуудтай харилцах харилцаанд Үндэсний танхим оролцож, тухайн аймаг, нийслэлийн танхимууд оролцох боломжгүй мэт байдал үүсч, үндэсний ба орон нутгийн танхимуудын үйл ажиллагаа, төрийн байгууллагатай харилцах харилцааны зааг ялгаа ойлгомжгүй болох болно.

- Хуулийн төслийн 7.1, 7.4 дүгээр заалтуудын “...өөрийн үйл ажиллагаа явуулж буй чиглэлээр байгуулагдсан мэргэжлийн танхим эсхүл...” гэснийг хасах.

Тайлбар: Тухайн аймаг, нийслэлийн танхимууд дээр ААН-үүд заавал гишүүнчлэлтэй байх нь хуулийн этгээдийн бүртгэлийг тарамдуулахгүй, давхардал үүсгэхгүй байх ач холбогдолтойгоос гадна ААН-үүд мэргэжлийн танхимуудад давхар гишүүнчлэлтэй байх эрх нь нээлттэй байгаа тул ААН-үүдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй.

- Хуулийн төслийн 7.11 дүгээр заалтын “...Үндэсний...” гэснийг “...тухайн танхимын...” гэж өөрчлөн найруулах.

Тайлбар: Бүх танхимууд нь энэ хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах тул тухайн бие даасан танхимууд энэ хуульд нийцсэн дүрмээ өөрсдөө гарган УЗ-өөрөө батлуулдаг болох нь байгууллагын засаглалын хувьд бие даасан байх ашигтайгаас гадна өөрсдийнх нь гол үүрэг болох гишүүн байгууллагууддаа үйлчлэх, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулах боломжийг олгоно.

Үр дагавар: Ийнхүү өөрчлөөгүй тохиолдолд ХАҮТ-уудын тогтолцоо доороос дээш чиглэсэн бус, холимог, ойлгомжгүй болохоос гадна Үндэсний танхимаас баталсан дүрэм нь тухайн аймаг, орон нутгийн, эсхүл мэргэжлийн салбарын онцлогт тохирохгүй байх тохиолдол үүсч болзошгүй. Энэ нь тухайн танхимуудын өөрийн гишүүдийнхээ онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн үйл ажиллагааг хөрвөх чадвартайгаар хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж магадгүй гэж үзэж байна.

- Хуулийн төслийн 9.4 дүгээр заалтын “татгалзах үндэслэл”-ийг хуулинд тодорхой зааж тусгах.

- Хуулийн төслийн 11.1 дүгээр заалтад “11.1.4. үйлчилгээний орлого”, “11.1.5. төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхэд зориулж олгосон санхүүжилт” гэсэн заалтуудыг нэмэх.

Тайлбар: Орон нутгийн танхимууд нь зөвхөн гишүүний хураамж аваад, бүртгээд суудаг байгууллага байж болохгүй. Эдгээр танхимууд нь хуулийн төслийн 6.1-д тусгагдсан зорилгыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх байгууллага байх ёстой тул өөрийн гишүүдээ сургалт, зөвлөгөө өгөх гэх мэт тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлэх замаар хувийн хэвшлийг хөгжүүлэхийн төлөө ажиллах байгууллага байх ёстой. Түүнчлэн орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, тодорхой зарим төрийн үйлчилгээг танхимууд нь үзүүлдэг болох нь төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны дараагийн томоохон алхам болох тул ийм төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлснээр хүлээн авах санхүүжилтийг энд нэмэж өгөх шаардлагатай гэж үзэж байна.

- Хуулийн төслийн 21.1 дүгээр заалтад “21.1.4. улсын төсөв, улсын тусгай сангуудын төлөвлөгөө, санхүүгийн төсөлд хувийн хэвшлийг төлөөлөн санал өгөх, улсын төсөв, улсын тусгай сангуудын орлого, зарлагад хувийн хэвшил, татвар төлөгчдийг төлөөлөн хяналт тавих, шаардлагатай тохиолдолд холбогдох төрийн байгууллагад шаардлага, санал, дүгнэлтээ хүргүүлэн, эдгээрийгээ шийдвэрлүүлэх, энэ талаарх мэдээллийг хувийн хэвшил, олон нийтэд ил тод нээлттэй мэдээлж байх” гэсэн заалтыг нэмэх.

Тайлбар: Үндэсний танхим нь хувийн хэвшлийн ААН-үүдийг нэгтгэсэн аймаг, нийслэл, мэргэжлийн танхимуудын нэгдэл учраас эдгээрийг төлөөлөн улсын хэмжээнд хувийн хэвшлийн эрх ашгийг илэрхийлэх, төлөөлөх, хамгаалах эрх үүргийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд Үндэсний танхим хувийн хэвшлийн төлсөн татварын зарцуулалт, хувийн хэвшлийн хөгжилд нөлөөлж буй улсын тусгай сангуудын үйл ажиллагаанд хөндлөнгийн, хараат бус хяналт тавьж ажиллах гол институци болж ажиллах шаардлагатай байгаа тул энэ заалтыг нэмэх саналтай байна.

- Хуулийн төслийн 22.1.4, 22.1.5, 22.1.6, 23.1.2 дугаар заалтуудыг аймаг, нийслэл, мэргэжлийн танхимын эрхлэх үйл ажиллагааны чиглэл болгон өөрчлөх.

Тайлбар: Үндэсний танхимын хувьд Засгийн газар, УИХ-тай бизнесийн орчныг сайжруулах, үндэсний хэмжээний судалгаа хийх, бодлого боловсруулахад хамтран ажиллах зэргээр үндэсний хэмжээнд ажиллах, аймаг, нийслэл, мэргэжлийн танхимууд нь гишүүдээ хөгжүүлэх, гишүүдээ үйлчилгээ үзүүлэх ажлуудыг хийхээр үйл ажиллагааны зааг ялгааг гаргаж өгөх шаардлагатай байна.

- Хуулийн төслийн 2-р бүлэгт ХАҮТ-ын чиг үүргийг “Тус хуулийн 19 – 23 дугаар зүйлүүдэд заагдсан Үндэсний танхимын чиг үүргийг аймаг, нийслэлийн танхимууд тухайн орон нутагт, мэргэжлийн танхим тухайн эдийн засгийн салбарын хүрээнд хэрэгжүүлнэ” гэж зааж өгч нэмж оруулах.

Тайлбар: Хуулийн төсөлд Үндэсний танхимын чиг үүргийг тодорхой зааж оруулсан боловч аймаг, нийслэл, мэргэжлийн танхимуудын чиг үүрэг тодорхой бус байна. Иймд эдгээр танхимуудын чиг үүргийг ялгаж нэмж оруулах шаардлагатай.

ХАҮТ-ЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ ГАРАХ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

- Төсвийн тухай хуулийн 8.10 дугаар заалтад “8.10.3-т 8.10.2-т заасан аудитын дүгнэлт гарснаас хойш ажлын 15 хоногийн дотор Үндэсний танхимын саналыг авч УИХ-д хүргүүлэх” гэж нэмэх.
- Төсвийн тухай хуулийн 27.1 дүгээр заалтад “27.1.10. Төсвийн төслийг хувийн хэвшилд танилцуулан хэлэлцүүлж, саналыг нь авч тусгасан байх” гэж нэмэх.
- Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлд “63.5. Орон нутгийн төсвийн төслийг батлахаас өмнө тухайн орон нутгийн хувийн хэвшилд танилцуулан, саналыг нь авч, тусгасан байх” гэж нэмэх.
- Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлд “60.2. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт, үйл ажиллагаанд тухайн орон нутгийн танхим хөндлөнгийн хяналт тавьж ажиллана” гэж нэмэх.

**ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ТАНИЛЦУУЛГА,
САНАЛ АВСАН ТАЛААРХ НЭГТГЭСЭН МЭДЭЭЛЭЛ**

I. ХАҮТТХ-ийн төсөлд санал авах тухай мэдээллийг МҮХАҮТ-ын албан ёсны веб сайт www.mongolchamber.mn -д 2 удаа оруулж нийтэлсэн болно.

1.1. 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр. (Хавсралт 1).

1.2. 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдөр. (Хавсралт 2).

II. ХАҮТТХ-ийн төслийг олон нийтэд танилцуулж хэлэлцүүлсэн тухай мэдээлэл

2.1. 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр аймгуудын ХАҮТ-уудын удирдлагуудтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав. (Хавсралт 3. Уулзалтын мэдээ)

2.2. 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр зарим ТББ, мэргэжлийн холбоодод танилцуулах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав. (Хавсралт 4. Уулзалтын мэдээ)

2.3. 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдөр 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Улаанбаатар хотын худалдааны танхимын ерөнхийлөгч А.Ганхуяг, гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ нарт болон 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр тус танхимын Удирдах зөвлөлийн гишүүд ба удирдлагуудтай 2 удаагийн уулзалт зохион байгуулсан. (Хавсралт 5. Хэлэлцүүлгийн үеэр яригдсан гол саналууд)

2.3. 2021 оны 12 дугаар сарын 12-ны өдөр болон 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр МҮХАҮТ-ын тэргүүлэгч, УЗ-ийн гишүүдтэй 2 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг (Хавсралт 6.1. УЗ-ын хурлаар хуулийн төсөлтэй холбоотойгоор гаргасан санал, Хавсралт 6.2 УЗ-ын хурлаар хуулийн төсөлтэй холбоотойгоор гаргасан санал)

2.4. 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр МҮХАҮТ-ын дэргэдэх Хуулийн бодлогын зөвлөл, МОУА-ын Арбитрчдын зөвлөлийн хамтарсан уулзалт хэлэлцүүлэг. (Хавсралт 7. МОУА-ын арбитрчдын зөвлөл, МҮХАҮТ-ын Хуулийн бодлогын зөвлөлийн хамтарсан хэлэлцүүлгээс танхимын тухай Хуулийн төсөлд гаргасан санал)



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА
АН УИЛДВЭРИЙН ТАНХИМЫН



Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авч байна

2020/02/21 0

[f_share](#)

[tweet](#)

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтээр хэлэлцүүлэхээр холбогдох судалгаа, тайлангийн хамт танилцуулж байгаа тул та бүхнийг хуулийн төсөлд 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн дотор саналаа ирүүлэхийг урьж байна.

Хавсралт:

Танилцуулга

Үзэл баримтлал

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Дагалдан гарах хуулиудын төсөл

Хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

Хуулийн төслийн зардлын тооцоо

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн тайлан

Холбоо барих:

МҮХАҮТ, Бодлого, Стратегийн Газар

Мэргэжилтэн И.Төгс-Оюун

Утас: (976) 7727-7070 /43/, 88086993

Цахим шуудан: tugs-oyun@mongolchamber.mn

Сэтгэгдэл бичнэ үү...



Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн төсөлд санал авч байна

2021/08/18 0

f share

tweet



УИХ-ын гишүүн Х.Ганхуягийн санаачилсан "Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай" хуулийн төсөлд олон нийтийн саналыг хүлээн авч эхэлсэн бөгөөд ЭНД ДАРЖ цахим хуудсаар нэвтрэн саналаа үлдээх боломжтой.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль 1995 онд батлагдаж, өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээрх шинэ хуулийн төслийг боловсруулжээ. Хуулийн төсөл 6 бүлэг 34 зүйлтэй. Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, түүний салбар, төлөөлөгчийн газар, дагнасан танхимын зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаа, гишүүнчлэл, санхүүжилт, төрийн болон бусад байгууллагатай харилцах болон худалдаа, аж үйлдвэрийн танхимтай холбоотой бусад харилцааг зохицуулах юм.

Хуулийн төслийг боловсруулахдаа Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Унгар Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын худалдаа, аж үйлдвэрийн танхимын эрх зүйн байдлыг зохицуулсан хууль тогтоомжийг харьцуулан судалжээ. Түүнчлэн олон улсын жишиг зохицуулалтыг харгалзан Монгол Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн бүтэц, зохицуулах асуудлуудын цар хүрээг тодорхойлж, эдийн засаг болон гадаад, дотоод худалдаа, хүн ам зүйн тархалт, аж ахуй эрхлэгчдийн төвлөрөлт, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой холбоодын үйл ажиллагааны үр дүнтэй байдал, аж ахуй эрхлэгчдэд дутмаг байгаа санхүүжилтийн төдийгүй техник, боловсон хүчний нөхцөл байдал зэрэгт тулгуурлан хуулийн төслийг боловсруулаад байна.

Мөн зарим орны туршлагад үндэслэн Үндэсний танхимын гишүүнчлэлийг холимог хэлбэртэй байхаар тусгасан бөгөөд Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, ашгийн төлөө хуулийн этгээд нь Үндэсний танхимд заавал гишүүнчлэлтэй, харин төрийн өмчит хуулийн этгээд, гадаад улсын хуулийн этгээд болон Монгол Улсын хуулиар үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигч, эсхүл тухайн хуулийн этгээд нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд, эсхүл мэргэжлийн холбооны заавал гишүүнчлэлтэй байхаар заасан хуулийн этгээдийг сайн дурын үндсэн дээр гишүүн болохоор хуулийн төсөлд тусгажээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн та бүхнийг Худалдаа, аж үйлдвэрийн тухай хуулийн төсөлд саналаа өгөхийг уриалж байна.

Сэтгэгдэл бичнэ үү...

Нэрээ оруулна уу...

ИЛГЭЭХ

АРГА ХЭМЖЭЭ



Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг боллоо

2021/11/10 0

f share

tweet



МУХАҮТ-аас Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг орон нутгийн салбар танхимын удирдлагуудад танилцуулж, санал солилцлоо.

МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин болон БЭЗ партнерс хуулийн фирмийн захирал Загдаа нар хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлага, хууль батлагдсанаар гарах үр дагавар, ач холбогдлын талаар мэдээлэл өгч, асуултуудад хариулав.

Одоогийн хэрэгжиж буй хууль 1995 онд батлагдсан бөгөөд олон улсын жишигтэй харьцуулвал товч бөгөөд маш цөөн асуудлыг хамарсан байгаа учраас танхимын эрх, хэмжээ хязгаарлагдмал байдалтай байна. Шинэчилсэн хуулийн төсөл нь 6 бүлэгтэй, хуулийн үйлчлэх хүрээ, үйл ажиллагаанд баримтлах зарчим, дагнасан танхимын чиг үүрэг зохион байгуулалт, танхимын үзүүлэх үйлчилгээ, хараат бус байдал зэрэг нарийн зохицуулалтыг нэмж тусгасан.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтэц, зохион байгуулалт, түүний бүрэн эрх тодорхой болсноор аж ахуй эрхлэгчид эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах, хамтын удирдлагын байгууллагаар дамжуулан дуу хоолойгоо төр болон олон нийтэд хүргэх боломж бололцоо нэмэгдэх юм.

Орон нутгийн салбар танхимын удирдлагуудаас хуулийн төсөлд салбар танхимтай холбоотой ямар зохицуулалтууд орсон талаар асуултууд асууж, зарим нэр томъёотой холбоотой саналуудыг хэлж байв.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй <https://lawforum.parliament.mn/draft/70/> холбоосоор орж танилцан, санал илгээх боломжтой.



БИДНИЙ ТУХАЙ

Ерөнхийлөгчийн мандчилгээ

Эрхэм зорилго

Стратегийн зорилтууд

Он цагийн хэлхээс

Байгууллагын бүтэц

Танхимын хууль

Танхимын дүрэм

Жилийн бодлого, зорилгууд

2022 оны үйл ажиллагааны тайлан

Танхимын шагнал

Шалгаруулалт

Фото галерей

ГЭРЧИЛГЭЭ

REX бүртгэгдсэн экспортлогч

Давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ



Фото: Танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зарим ТББ, Мэргэжлийн холбоодод танилцууллаа

2021/11/11 0

f [share](#)t [tweet](#)

МУХАҮТ-аас Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн хэрэгцээ шаардлага, хүлээгдэж буй үр дүн, шинэчилсэн найруулгын төслийг танилцуулах уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл ирж

оролцов.

Тухайлбал, Монголын банкны холбоо, Монголын барилгын үндэсний ассоциаци, Монголын махны холбоо, Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо, Олон улсын эмэгтэйчүүдийн ХАҮХ-ны Монгол дахь салбар, Монголын сав баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо, Эм зүйн мэргэжилтнүүдийн нэгдсэн "Эм" холбоо, Монголын даатгагчдын холбоо зэрэг төрийн бус байгууллага, холбоодын захирал, менежерүүд оролцож, хуулийн төсөлтэй холбоотой байр сууриа илэрхийлэв.



МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин ХАҮТ-ын олон улсын тогтолцоо, Монгол Улс дахь ХАҮТ-ын өнөөгийн бүтэц тогтолцоо, ХАҮТ-ын хуулийг шинэчлэх шаардлага, хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан зарчмын гол өөрчлөлтүүд, хуулийн шинэчлэлийн хүлээгдэж буй үр дүнгийн талаар танилцууллаа. МҮХАҮТ нь бизнесийн орчны ганц хуультай ТББ-ын хувьд өмгөөлөх, нөлөөлөх, холбох, эдийн засгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг тасралтгүй явуулсаар ирсэн. Хууль шинэчлэгдсэнээр бодлогын өмгөөллийн үр нөлөө нэмэгдэж, Танхим нэрийн хамгаалалт бий болохын дээр бодлогын судалгааг хараат бусаар явуулах, хамтын удирдлагын зөвлөл, хороо, комисс зэрэг төр хувийн хэвшлийн хамтын удирдлагын байгууллагын бүрэлдэхүүнд төлөөллийг оролцуулах боломж бүрдэнэ гэж тооцоолж байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан

- Монголын сав баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбооны тэргүүн Б.Болдбаатар: Хуулийн шинэчлэл нь цаг үеэ олсон асуудал. Аль болох хурдан хугацаанд хуулиа батлуулах нь бидний зорилго байх ёстой. Дагнасан танхимыг Салбар танхим, 21 аймагт үйл ажиллагаа явуулах танхимыг орон нутагт дахь танхим гэсэн томъёоллоор оруулах,
- Монголын барилгын үндэсний ассоциацийн зөвлөх Г.Лосол: ХАҮТ-ын тухай хууль, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн уялдааг хангах хэрэгтэйг онцлоод МҮХАҮТ нь ковидын үед нөхцөл байдлын судалгаануудыг хийж, бизнес эрхлэгчдийн дуу хоолойг төрийн байгууллага, албан тушаалтнуудад хүргэж ажилласан. Цаашид энэ нөлөөллийн арга хэмжээг хуулиараа бататгах, эдийн засаг бизнестэй холбоотой асуудалд танхимын байр суурийг илэрхийлдэг байх, төлөөллөө оролцуулах,
- Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбооны менежер Б.Нацагдорж: Дагнасан танхимууд үүсгэн байгуулагдвал салбарын аж ахуйн нэгжүүдийн уялдаа холбоо сайжирна
- Эм зүйн мэргэжилтнүүдийн нэгдсэн “Эм” холбооны менежер Б.Буянчимэг: Цар тахлын нөхцөл байдлаас үүдэж манай салбар олны анхааралд өртсөн. Манай улсад төрийн эмийн байгууллага байхгүй, бүгд хувийн хэвшлийн бизнесийн байгууллага учраас нэгдмэл байдалтай байна гэдэг маш чухал. Бид ойртож, нэгдэж чадахгүй байгаагаас асуудлаа шийдэж чадахгүй байна. Дагнасан, мэргэжлийн танхим бий болвол нөлөөлөл нь их байхаас гадна мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд дэвшил гарна гэж харж байна.
- Монголын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирал Ж.Батжаргал: Нэг салбарт олон ТББ, мэргэжлийн холбоо байгааг нэгтгэж, цэгцлэх нь зүйтэй зэргээр байр сууриа илэрхийлж, хуулийн төсөлтэй холбоотой асуултууддаа хариулт авлаа.

Ашгийн төлөөх хуулийн этгээдүүдийн эрх ашгийн хамгаалах ашгийн төлөө бус, дагнасан Танхимууд байгуулагдана. Эдийн засгийн салбаруудад байгуулагдсан эдгээр дагнасан танхимууд нь нийлж Үндэсний танхимаа бүрдүүлж, нийтлэг эрх ашгийг хамгаалж ажиллах агуулгыг багтаасан Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотой саналуудаа мөн МҮХАҮТ-д бичгээр ирүүлэх боломжтой юм.



УЗ-ЫН ХУРЛААР ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБООТОЙГООР ГАРГАСАН САНАЛ:

МҮХАҮТ-ын дарга Т.Дүүрэн: Хуулийн төсөл 2022 оны Улсын Их Хурлын намрын чуулганаар удахгүй хэлэлцэгдэхээр болсонтой холбогдуулан хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар гарах үр дагавар, ач холбогдлын талаар олон нийтэд таниулах шаардлагатай байгаа. Энэ хууль улс төржилтийн золиос болохвий гэх болгоомжлол байгаа учраас энэ бол зайлшгүй гарах ёстой зардал юм. Энэ жилийн нийт баталсан төсвөөс хэтрүүлэхгүйгээр маркетингийн зарцуулалтын зориулалтыг шилжүүлэх, хагас жилийн үр дүнгээс хамаарсан байдлаар шийдэж үлдсэн зардлыг компаниудын хандив, дэмжлэгээс бүрдүүлэх саналтай байгаа. Энэ хүрээнд бид Улсын Их Хурлын Тамгын Газрын Пи Ар багаас дэмжлэг авч хамтран ажиллана. Манай маркетингийн газарт энэ жил 180.000.000 сая төгрөгөөр батлагдсан байснаас 80.000.000 нь зарцуулагдаж, 100.000.000 орчим төгрөгийн үлдэгдэлтэй үйл ажиллагаа явуулж байна. Хагас жилээр манай байгууллагын санхүүгийн тайлан, орлого, зарлагын тэнцэл, үйл ажиллагааны үр дүн эерэг гарсан. Доторх төсвийн шилжилтийг зөв хийж, зөв хувиарласнаар хууль сурталчлах ажлын хүрээнд гарах маркетингийн зардлыг эерэгээр шийдвэрлэх боломжтой байна. Ирэх онд ч мөн гаргасан зардлаа нөхөн, үр дүнтэй ажиллана гэдэгтээ итгэлтэй байна.

МҮХАҮТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшин: Хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг боловсруулахад мэргэшсэн хуульчдаас бүрдсэн хуулийн баг энэ төсөл дээр ажилласан. Судалгаанд бусад улс орнуудын Худалдааны танхимуудын тухай хууль, тогтоомжийн харьцуулсан судалгаа болон ижил эрх зүйн системтэй улс орнуудын танхимуудын хөгжлийн чиг хандлага зэрэг агуулга багтсан. Энэхүү судалгаатай холбоотой зардал мөн орсныг хэлэх нь зүйтэй. Т.Дүүрэн даргад баярлалаа. Ийм хэмжээний төсөвтэй ажлыг нэгдсэн байдлаар лоббидож ажиллана. Маш олон уулзалтуудыг гол яамдуудтай хийнэ. Удирдах зөвлөлийн гишүүдийн оролцоо үүнд маш их хэрэгтэй. Хууль батлагдтал гэж хэлээд байгаагийн цаана хуулийн төсөл унах эсвэл буруугаар ойлгогдож батлагдахгүйдээ тулвал цаашаа хуулиа батлуултал маш их ажлууд хийх шаардлагатай. Энэ хууль батлагдахгүй байсан ч хуучин хуулийг заавал шинэчлэн батлуулах нийгмийн хэрэгцээ шаардлага байгааг олон нийт зөвөөр ойлгох ёстой. Бид нийтийн эрх ашгийн төлөө, бизнес эрхлэх таатай эрх зүйн орчин бүрдүүлэхийн төлөө энэ хуулийг батлуулах гэж байгаа. Ийм ч учраас Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэдэг байгууллага бусад улсуудад бий болсон жишгээр зөв системтэй, бизнес эрхлэгчдийн түшиж болох маш том шүхэр байгууллага болох ёстой юм. Хууль батлагдах эсэх талаарх асуудал маш олон талын оролцоотойгоор, ойлголцлоор батлагдах хууль болохыг та бүхэн анхаарч үзнэ үү. Төсвийг харж байхад бизнесийг дэмжихтэй холбоотойгоор маш их хөрөнгө төсөвлөгддөг. Энэ хөрөнгө байндаа тусдаг эсэхийг анхаарах шаардлагатай.

Дорноговь аймаг дахь салбар танхимын дарга Д.Отгонбаяр: Хуультай танилцсан, хэд хэдэн удаа уншсан. Дэмжиж байгаа.

“Урбанек” ХХК-ийн ерөнхий захирал Б.Лхагважав: 1996 оны Танхимын тухай хуулийг гардан хийж байсан Гөлөгөө гуайтай уулзах нь зүйтэй. Тухайн үед

Б.Чимэд хуульчтай хамт Турк улсад очиж туршлага судлаад хуулийг гардан хийсэн гэж ярьж байсан. Мөн Дэмбэрэл дарга болон өмнөх удирдлагуудтай уулзах хэрэгтэй. Дэмбэрэл дарга ажиллаж байсан 16 жилийн хугацаанд Танхим институтын хэлбэрт очсон. Ажил олгогч эздийн холбоо болон Үйлдвэрчний эвлэл зэрэг байгууллага тусгайлсан институтын хэмжээнд очоогүй л байна. Би буруу санаагүй бол 2023 оны 3 дугаар сард Танхимын их хурал болох ёстой. Ирэх онд тарчиг эдийн засагтай болох үед энэ хуулийг Засгийн газар хүлээн авах уу гэдэг талаас нь бодолцох хэрэгтэй.

Архангай аймаг дахь салбар танхимын дарга Ч.Мөнхбат: Хуулиа яаралтай батлуулах нь зөв гэж үзэж байна. Маш олон удаа саналуудаа өгсөн.

**УЛААНБААТАР ХОТЫН ХУДАЛДААНЫ ТАНХИМТАЙ ХАҮТ-ЫН ХУУЛИЙН ТАЛААР
ХИЙСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГИЙН ҮЕЭР ЯРИГДСАН ГОЛ САНАЛУУД**

2022.10.12

Улаанбаатар хотын танхимын ерөнхийлөгч А.Ганхуяг: Татварын орчны хувьд Танхимын ямар нэгж хаана, хэр хэмжээгээр татвар төлөх ёстой болж байна вэ? Тухайлсан Focus area нь өөр өөрсдийн асуудлыг шийдвэрлэх, улсын төсөв ярихын тулд салбарын мэргэшсэн танхимтай заавал ярьж байж батлах шаардлагатай. Ингэхдээ Улаанбаатар танхимын саналыг авсны үндсэн дээр төсөв батална гэдэг агуулгыг мөн хуульд оруулах хэрэгтэй гэж үзэж байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй бүх ресторанууд нийслэлийн татвар төлж явж байгаа. Ноос ноолуурын бизнес эрхлэгч Улаанбаатар хотод үйлдвэртэй тул хүсвэл Улаанбаатар хотын танхимын гишүүн байж болно. Яагаад гэвэл газар дээр нь үйл ажиллагаа явуулж байгаа гэдгээрээ Улаанбаатар хоттой харилцах харилцаа үүснэ. Ганцхан бүтээгдэхүүн экспортод гаргаж байгаа гэдгээрээ биш. Эрх ашгаа хамгаалуулахын тулд Улаанбаатар хотын танхимын гишүүн болох ёстой гэдгийг бизнес эрхлэгчид ойлгох ёстой. Танхимын менежмент тэр тал дээр тулж ажиллах ёстой болчихоод байна. Логикийн хувьд бүгд гишүүн байх нь утгагүй. Эрхээ хамгаалуулах шаардлага тулсан үед хамгаалуулах хэрэгцээ гарах байх гэж харж байна.

МҮХАҮТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшин: Нийтлэгээрээ хот тохижилттой холбоотойгоор ч юм уу Улаанбаатарын худалдан авалтанд оролцдог маш олон компаниуд байна. Барилга байгууламж, сургууль цэцэрлэгийн засвар үйлчилгээ, ресторан, клубууд Нийслэлийн танхим дээрээ очиж асуудлаа ярих нь оновчтой. Төсөв дээр 1 хуудас цаас аваад дэмжсэн гээд явдаг биш, 2024 онд Нийслэлийн танхим өөрөө Нийслэлийн иргэдийн хуралд оролцож эрх ашгаа тусгуулаад явдаг байх ёстой. Ядаж татвараа үр ашигтай зарцуулаач гэдэг шаардлагаа тавиад явах боломжтой болох гээд байгаа юм.

Улаанбаатар хотын танхимын ерөнхийлөгч А.Ганхуяг: Жишээлбэл Улаанбаатар хотын төсөв хэлэлцэхэд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал дээр төсөв хэлэлцэхэд хурлын дэг жаяг, процедурын дагуу Улаанбаатар хотын танхимаас санал авна гэдгийг энэ хуулинд заасан уу?

МҮХАҮТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшин: Хуулинд нэмэлтээр орно.

Улаанбаатар хотын танхимын ерөнхийлөгч А.Ганхуяг: Тэгэхгүй бол хууль батлагдсаны дараа Улаанбаатар хотыг төлөөлж байгаа Худалдааны танхимаас санал авахгүйгээр Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал нь халтай шийдвэр гаргадаг асуудал гардаг.

МҮХАҮТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшин: Эдийн засаг, бизнестэй холбоотой хуулин дээр заавал санал авна гэж орж ирж байгаа. Аймаг ч бас адилхан. Яг төсөв хэлэлцэхэд тухайн газрын танхим нь орж санал өгдөг байх хэрэгтэйг ойлгож байгаа.

Улаанбаатар хотын танхимын ерөнхийлөгч А.Ганхуяг: Хуулийн ерөнхий зарчим нь зөв гэж үзэж байна.

Хуульч Б.Загдаа: Төлөөллийн асуудал яригдана. Энэ нь хуулийн төслийн 23 дугаар зүйл дээр байгаа. Зорилгод заасан асуудлаар Үндэсний танхим бүрэн төлөөлнө. Үйл ажиллагааны чиглэлээс хамааран төлөөлөх асуудлыг дүрмээр зохицуулна. Уян хатан орхих, хэрэгцээ шаардлагыг сонсож байж

Үндэсний танхим татварын хуулиар бол төсөвт санал өгөхдөө саналыг доод нэгжүүдээсээ нэгтгэн авч нэгдсэн санал боловсруулна.

О.Амартүвшин: Бидний дангаараа ярих, дангаараа шийдэх асуудал угаасаа биш шүү дээ.

Хуульч Б.Загдаа: Та төсөв хэлэлцэхэд тухайн газрын танхим нь орж санал өгдөг байх хэрэгтэй талаар ярьлаа. Энэ хуулийг даган өөрчлөлт орох 10 гаруй хуулийн төсөл байгаа. Тухайлбал, Тендерийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Сан, Хоршооны тухай хууль зэрэг олон нийтийн шинжтэй, төсөв зарцуулагддаг холбоотой бүх хуулиудад Үндэсний болон дагнасан танхимын төлөөллийг оролцуулна гэдэг байдлаар дагах хуулийн төслүүдэд оруулсан байгаа.

Улаанбаатар хотын танхимын гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ: Дагнасан танхим гэж эдийн засгийн салбараар 7.13

“Дэлэнт Онч Аудит” ХХК-ийн ерөнхий захирал Д.Ончинсүрэн: Энэ хуулийн 23 дугаар зүйлд “Үндэсний танхим нь худалдаа, аж үйлдвэрийн танхимын зорилгод хамаарах аливаа асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах эрхтэй байна.” Гэсэн байна. Улаанбаатар танхим Үндэсний танхимын нэг салбар биш бие даасан танхим баймаар байна. Тухайлбал Улаанбаатар хотын захирагчийн албан дээр очоод Улаанбаатар хот дахь бизнес эрхлэгчдийн асуудлыг ярина гэхээр ямар ч статусгүй болчих гээд байдаг. Аймаг, орон нутгийн танхимууд бол тусдаа өөр асуудал. Улаанбаатар хотод эдийн засгийн төвлөрөл үүссэн, өөр статустай байх ёстой байгууллага.

Улаанбаатар хотын танхимын гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ: 5.7 дахь хэсэгт “Үүсгэн байгуулагдсан аж ахуй нэгжүүд эдийн засгийн үйл ажиллагааны салбараар дагнасан танхимд заавал гишүүнчлэлтэй байна.”, “5.5 дахь хэсэгт Үндэсний танхим нь Монгол Улсын нэг ба хэд хэдэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг хамарсан салбар, төлөөлөгчийн газар байгуулж болно.” гэсэн байна. Өөрөөр хэлбэр Улаанбаатар хотын бие даасна танхим байхгүй байна гэж харагдаж байна.

МҮХАҮТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшин: Аймаг, Нийслэл гэж орж ирнэ. Энэ нь цаашдаа засагдана. Энэ тооноос харахад Улаанбаатар хотын танхим угаасаа зохион байгуулалтанд орж таарна.

2 талаас хуулийн төслийн үзэл баримтлал, үндэслэлээ нэгтгэж ярилцах ажлын хэсэг гаргамаар байна. Хуульд санал өгөхөд бүгдийнх нь зөвшөөрсөн гарын үсэг зуруулж протокол хөтлөх хэрэгтэй.

МҮХАҮТ-ын тэргүүлэгч гишүүдийн хурлын тэмдэглэлээс

2021.12.22

О.Амартүвшин: Ингээд хэлэлцэх асуудлын дарааллаар “Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай” хуулийн шинэчлэлийн хэрэгцээ шаардлага, хүлээгдэж буй үр дүн, танилцуулгыг та бүхэнд танилцуулъя.

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчлэлийн хэрэгцээ шаардлага, хүлээгдэж буй үр дүн, танилцуулгыг хийв.

Ц.Эрдэнэбилэг: Танхимын тухай хууль батлагдсанаар Улаанбаатар худалдааны танхимын үйл ажиллагаа хэрхэх вэ? Танхимын тухай хууль маань хэзээ батлагдахаар байгаа вэ?

О.Амартүвшин: Засгийн газар Танхимын хууль батлагдах ёстой гэдгийг 100 хувь дэмжсэн байгаа. Мөн УИХ-ын дарга болоод, ардын намын бүлэг, ардчилсан намын бүлэг хуулийн төслийг бүрэн дэмжсэн байгаа. Тиймээс энэ намрын чуулганаар хууль орохоор байгаа ба ажлын хэсэг байгуулагдаад, дэмжигдээд явах байх. Шинэ сэргэлтийн хуулийн тухайд одоогоор илүү хэрэгцээтэй хууль учраас бидний хувьд энэ хууль дээр ач холбогдол өгч ажиллаж байгаа.

Үндэсний танхимын үйл ажиллагааны цар хүрээ илүү Засгийн газар, яам, агентлагийн түвшинд явдаг. Харин Улаанбаатар хоттой ажиллах механизм байхгүй байсан учир Улаанбаатар хотын худалдааны танхимыг тухайн үед бид байгуулж байсан. Үйл ажиллагаа нь нээлттэй маш зөв механизм бүрдэж байсан. Гэвч удирдлага нь солигдож үйл ажиллагаа нь суларсан. Үндэсний танхимын хувьд ч Улаанбаатар танхим байгаа учраас хоттой шууд харьцахгүй хамтарч ажиллахыг эрмэлздэг. Ковидын нөхцөл байдлын улмаас сүүлийн үед хоттой шууд харьцах шаардлага үүссэн бөгөөд үүний улмаас бидний дунд үл ойлголцол үүссэн.

Бид цаашид Улаанбаатар хотын захиргаатай хамтарч ажиллах зайлшгүй шаардлага хэрэгцээ байгаа. Үүнийг ч танхимын тухай хуульдаа тусгаж өгсөн. Энэ нь өөрөө хотын танхимын чиг үүрэг болох талаар бид бүхий л түвшиндээ ойлголцож явсан боловч дотоод зөрчлөөс болгон үр дүнд хүрээгүй байна. Саяхан Улаанбаатар танхимын шинэхэн удирдлагатай бид уулзалт хийж мэдээллээ илүү тодорхой өгөх талаар тохирсон.

Хуулийн төслийн хүрээнд тэдний яриад байгаа шиг үл ойлголцол байхгүй юм. Улаанбаатар хотын танхимын ажиллах орон зай хэвээр үлдэнэ гэдгийг тэдний зүгээс дутуу ойлгосон юм шиг санагдсан. Үүнээс бид хуулийн төслөө илүү сайн ойлгож тайлбарлах хэрэгцээ шаардлага байгаа гэдгийг ойлгосон.

М.Даваасүрэн: Танхимын тухай хууль нь бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах томоохон бүтэц бий болно гэж ойлгож байгаа. Харин мэргэжлийн холбоодыг хажуудаа нэгтгэх нь гэсэн болгоомжлолоор хүмүүс над дээр их орж ирсэн. Барилгын

яам дээр гэхэд 3 мэргэжлийн холбоод байгаа. Гэвч эдгээр холбоод нь тал талд өөр зүйл яриад явдаг. Холбоод нэрээр мөнгө хураах ашиг сонирхолтой, хүнд сурталтай болчихсон. Олон талд олон асуудлыг хариуцдаг, олон толгойтой болсон. Бас танхимыг олон задлахгүй байх тал дээр анхаараарай. Танхимыг хэт олон задлах тусам олон толгойтой болох эрсдэл байгаа шүү. Яагаад байгуулж байгаа үндэслэлээ маш тодорхой болгож хүмүүст та өөрөө манлайлж ойлгуулах нь маш чухал.

О.Амартүвшин: Тантай санал нэг байна. Танхимын тухай хууль нь эдгээр олон холбоодын эрх ашгийн тухай биш бөгөөд зөвхөн бизнес эрхлэгчдийн эрх ашгийн төлөө байгууллага гэдгийг хэлэх ёстой.

М.Даваасүрэн: Би энд нэг жишээ хэлмээр байна. Бид саяхан Таван толгой-Зүүн баян чиглэлийн төмөр замыг барьсан. Төмөр замын бүхий л бетоныг бид нийлүүлсэн. Мөн эрчим хүчний бүхий л тулгууруудыг үйлдвэрлэсэн. 2 холбоо дээр би зангидаж Монголдоо хийж чадаагүй бүхнийг бид 1 жил 6 сарын дотор хийсэн. Нэгдэл гэдэг үүнийг хэлж байгаа юм. Бид бие биенийгээ дэмжиж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтад орсон тохиолдолд бид хожно. Олон толгойтой, олон даргатай байх юм бол бид хөгжихгүй.

Ч.Амарбаатар: Бид хуулиа нэгэнт өөрчилж байгаа учир ганц худалдаа гэдэг үг дээрээ төвлөрөх ёсгүй. Бид сэтгэлгээгээ эхлээд өөрчлөх ёстой. Коммерци гэдэг орос үгийг зөв орчуулж буулгах, үгүй бол энэ чигээр нь аваад явах хэрэгтэй байх. Тэгэхгүй бүх зүйл өөр чиглэлд төвлөрч байна. Виртуал орчин хүртэл өөрчлөгдөн, хувьсаж байна. Тиймээс энэ ойлголтыг цэгцлэх шаардлага байна. Тэгж байж бид бусадтайгаа хөл нийлүүлэн алхана.

О.Амартүвшин: Саяхан Дубайд дэлхийн 1200 орчим танхимууд цугласан. Эдгээр танхимуудын нэршил 2 төрөл байсан. Нэг нь chamber of commerce, нөгөөх нь chamber of commerce and industry. Бид танхимын хуулийг Оросоос авсан чигээр нь trade гэсэн үгийг орчуулсан байгаа. Эдийн засгийн ойлголтоор commerce, trade 2 өөр ойлголт. Trade бол бараа бүтээгдэхүүнийг валютаар солилцох хэлбэр, commerce нь илүү өргөн ойлголт. Гэвч бид анхнаасаа Оросоос авсан энэ ойлголтоороо явж хэвшсэн. Гэтэл бидний үйл ажиллагааны цар хүрээ маш өргөн байдаг. Бид үүнийг хөндөх нь зөв. Гэвч Монголчилж буулгахад арилжаа гэж буулгах уу? Юу гэж буулгах уу? гэдгийг бодох ёстой юм билээ.

Ш.Нэргүй: Төрийн бус байгууллагууд яагаад ийм олноороо бий болж байна вэ? гэдгийг бид судалж үзсэн. Гол асуудал нь ардчилал байдаггүй, засаглал байдаггүй, төрийн бус байгууллага нь дарга болсон хүнийхээ хувийн өмч болчихдог. Оролцогч аж ахуйн нэгжүүдийнхээ саналыг сонсдоггүй. Бас төр засагтай харьцахдаа нэг хүний үзэмжээр харьцдаг. Эдгээрийг хуульд хэрхэн тусгах вэ? гэдгийг бодолцож үзэх хэрэгтэй. Тухайлбал нэг асуудал төрийн байгууллага руу оруулахад гишүүдийн тодорхой хувийн саналаар дэмжиж авч хэлэлцдэг, хурлын тэмдэглэл, шийдвэр дээр үндэслэдэг байх хэрэгтэй.

Удирдах зөвлөлийн хувьд хэрхэн дэвших, сонгогдох тодорхой механизмуудыг тодорхой оруулж өгөх, засаглалыг тодорхой болгож оруулах шаардлагатай.

О.Амартүвшин: Таны хэлж байгаа асуудал бол яалтч үгүй засаглалын зөв механизм юм. Жишээ нь: Аялал жуулчлалын салбарын 280-иад холбоо байгаа юм. Эдгээрээс хэн нь засагтай илүү ойр байна. Тэр нь илүү давуу байдаг. Тиймээс бид асуудлыг нийлж ярьдаг, сайн засаглалтай болох чухал юм. Хуулийн төсөлд үндэсний танхим болон дагнасан танхимын засаглалын асуудал хөндөгдөж байгаа. Дүрэм дээр энэ талаар илүү нарийвчилж тусгахаар байгаа.

Таны хэлснээр улс төрөөс ангид байх, ротаци хийдэг байх, удирдлага солигддог байх нь чухал. Удирдлага нь хийх ёстой юмаа хийгээд дараагийн хүмүүс нь орж ирдэг эрүүл засаглалтай байх нь олон нийтийн байгууллага цаашид зөв хөгжих суурь нь болох юм билээ.

Бид Германы танхимтай онлайн уулзалт хийж байхад танхим нь өөрөө нийтлэг асуудлыг хөнддөг учраас эрүүл тогтолцоотой байдаг. Хэрэв цөөн төлөөлөл байх юм бол зөвхөн өөрсдийн асуудлыг хөндөөд эхэлдэг. Тиймээс энэ уялдаа холбоог хангах үүднээс зохион байгуулалт хийх нь зөв гэдгийг ОУ-ын туршлагууд харуулж байна.

Э.Лхагва: Манай компанийн хувьд Улаанбаатар худалдааны танхимд мөн адил давхар гишүүнчлэлтэй. Удирдлага солигдсон гээд нээх муудсан зүйл байхгүй байх гэж бодож байна. Саяхан Улаанбаатар танхим хурлаа хийж бизнесийн томоохон төлөөлөл болох Премиум группийн захирал Ганхуяг удирдлагаар нь сонгогдсон байгаа. Тиймээс 2 танхим маань ойлголцож, танхимын хууль маань цаашаа яваасай гэж хүсэх байна. Бидний зүгээс хуулийн төслийг дэмжиж байгаа.

Өмнө нь манай компанийн зүгээс Үндэсний танхимын үйл ажиллагаанд яагаад идэвхитэй оролцож байгаагүй талаар ярьж байхад жижиг бизнесүүдийн дуу хоолой том бизнесүүдийн дуу хоолойноос илүүтэй чанга гарч ирдэг талаар ярьж байсан.

Мөн Засгийн газар 100 хувь хуулийн төслийг дэмжиж байна гэдэг нь миний хувьд маш том асуултын тэмдэг гарч ирж байна. Улс орноо үнэхээр хөгжүүлэх гээд байна уу? Эсхүл өөрсдөдөө танхимыг ойрхон байлгах гээд байна уу? Яагаад гэвэл өнгөрсөн жилийн хугацаанд Улаанбаатар худалдааны танхим Хөдөлмөрийн тухай хууль дээр Оюу толгой ХХК-д илүү бодлогын өмгөөлөл хийж өгсөн. Хөдөлмөрийн тухай хууль 1 сарын 1-нээс эхлэн хэрэгжиж эхэлснээр маш хэцүү нөхцөл байдал үүснэ. Ажилчдын ажлын цаг багасна энэ хирээр цалин багасна. Он гараад ажилчид эхнээсээ суулт хийх талаар ярьж эхэлж байна. Үүн дээр бодлогын өмгөөлөл хийгдээгүй, бизнесийхэнд өөрсдөд нь зохицуулах боломж олгоогүйгээс иргэний хэргийн шүүх ачааллаа дийлэхээ болино гэж харж байна. Тиймээс миний асуух гээд байгаа зүйл бол танхимын тухай хууль дээр бодлогын өмгөөллийн үйл ажиллагаа нь яаж нэмэгдэх вэ?

О.Амартүвшин: Танхимын тухай хуулийг Засгийн газар дэмжиж байгаа гэдэг агуулга нь аливаа хэлэлцэгдэж байгаа хууль тогтоомжууд Засгийн газраар дэмжигдэж байж УИХ-д өргөн баригддаг. Энэ утгаар хувийн хэвшлүүд зөв зохион байгуулалтад орсноор улс орны эдийн засагт ач холбогдолтой талаар танилцуулгуудыг хийсний үндсэн дээр оруулж ирж байгаа. Хууль батлагдсанаар танхимыг хувийн хэвшлийн маш том нэгдэл болох учраас улс төрчдийн зүгээс ч болгоомжилж байгаа.

Улаанбаатар хотын худалдааны танхимын сайн мууг би хэлж мэдэхгүй. Үндэсний танхим нь өөрсдийн чиг үүргийн дагуу ажлаа хийж, бусдын ажилд орохгүй байхыг хичээдэг. Харин бусад байгууллагуудын уялдаа холбоог аль болох хангахыг хичээж байгаа. Бидний зүгээс Улаанбаатар худалдааны танхимтай ямар нэг зөрчил байхгүй.

Хөдөлмөрийн тухай хуулийг хөндөж байна. Хууль батлагдан гарах хүртэл маш олон асуудал үүссэн. Танхим дээр 5 удаагийн хэлэлцүүлэг болсон ба ажлын хэсэг маш олон удаа хуралдсан. Өөрчлөлт оруулсан 91 заалт байснаас 4-5 заалт дээр зөрчилдөөн үүссэн. Гэвч эцсийн дүндээ хуулийг бид яаж ч тайлбарлаад байнгын хороо болон УИХ-ын гишүүд шийдэж баталдаг. Танхимын зүгээс уртын ээлжээр ажиллуулах асуудлыг бусад улс орны адил нээлттэй үлдээх талаар саналаа дэвшүүлсэн боловч уурхайчдын гэр бүлийн асуудал хүнд байна гэдгээр хуулиа батлуулсан.

Б.Жаргалсайхан: Танхимыг статусыг тодорхой болгох шаардлагатай байх. Хэрэв төрийн бус байгууллага байгуулах бол мэргэжлийн холбоодтой ижил түвшинд очно. Тэгээд ч төрийн бус байгууллага нь өөрөө хүч муутай, төр тэдний дуу хоолойг сонсох албагүй. Тиймээс танхим маань ашгийн бус бизнесийн төв байгууллага гэсэн статустай байвал зохимжтой байх гэж бодож байна. Хуулиар ийм ангилал байдаггүй бол бий болгож байгуулах хэрэгтэй байх гэж бодож байна.

Эдийн засгийн салбараар ангилагдсан танхим байна гэдгийг бүрэн дэмжиж байна. Үүний хажуугаар орон нутгуудад танхимууд байна байх. Эдгээрийн нийлбэр нь Үндэсний танхим гэж явах нь зөв байх. Хэрвээ энэ бүтцээр явах бол Улаанбаатар хотын танхим нь илүүц байх гэж бодож байна. Учир нь Улаанбаатар танхим нь бусад танхимтай ижил түвшинд орж ирэх юм бол төв танхимтайгаа зөрчилдөх, үл ойлголцох нөхцөл байдал үүсч болохоор санагдаж байна.

О.Амартүвшин: Германы ХАҮТ-тэй ярьж байхад 2022 оны 1 сараас статус нь таны хэлсэнчлэн өөр болж байгаа юм билээ. Тус танхим нь Герман даяар нийтийн эрх ашгийн төлөө үйлчилдэг гэсэн агуулгаар өөрчлөгдсөн байсан. Бид мөн Х.Нямбаатар сайдтай ярьж байхад энэ агуулгыг мөн адил хөндсөн. Монголд ийм агуулгатай байгууллага байдаггүй. Энэ агуулгатай анхны хуулийн байгууллага нь танхим болох ёстой талаар хэлж байсан.

Улаанбаатар худалдааны танхимын тухайд бид Улаанбаатар хоттой ажиллах лобби бүлэглэл байх ёстой гэдгээр байгуулж байсан. Тиймээс хуульд зөвхөн Улаанбаатар хоттой ажилладаг бүтэц байхад л хангалттай гэж харсан. Одоогийн Үндэсний танхимыг харахад Улаанбаатар хотын асуудалд үндсэндээ орхигдоод явчихдаг.

С.Мэндхүү: Надад санал байна. Миний хувьд өмнөх их хурлын үед ХАҮТ-ын тухай дүрмийн ажлын хэсэгт О.Амартүвшин ерөнхийлөгчтэй орж ажиллаж байсан. О.Амартүвшин ерөнхийлөгчийн хувьд ажлын хэсэгт ажиллаж байхдаа Германы ХАҮТ-ын тухай хуулийг ярьж танхимын хуулийг шинэ шатанд гаргах хэрэгтэй талаар тайлбарлаж ярьж байсан. Тухайн үед 100 хувь дэмжиж байсан. Одоо энэ үйл ажиллагаагаа бодит ажил болгох гэж маш олон судалгаа хийж, үндэслэлийг нь маш сайн гаргаж ирсэн байна. Миний хувьд салбарыг хариуцаж олон жил ажиллаж байгаагийн хувьд танхимын тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ шаардлага маш их байгаа. Удирдах зөвлөлийн хурал дээр салбар танхимуудад дэмжлэг хэрэгтэй байгаа талаар удаа дараа ярьдаг байсан ч яг ямар дэмжлэг хэрэгтэй байгаа талаар тэр

болгон ярьдаггүй байсан. 21 аймгийн салбар танхим өнөөдөр нэгдсэн зөв системээр ажиллахыг хүсч байгаа. Иймд энэ хууль маань хурдан батлагдаж дагнасан танхимууд байгуулагдсанаар аймаг болгон нь танхимтай болох нөхцөл бүрдэж байгаа. Учир нь аймаг орон нутгийн барилгын танхимууд нь дагнасан танхимдаа гишүүнээр элсэж, жижиг дунд бизнесүүд нь аймгийн танхимдаа харъяалагдаад орхигдохгүй явах боломжтой гэж харж байгаа.

Үндэсний танхимын зүгээс ч танхимын тухай хуулийн талаар салбар танхимуудад танилцуулж, саналыг нь авсан. Иймд бидний зүгээс хуулийн төслийг маш сайн ойлгож хүлээж авч байгаа.

О.Амартүвшин: Одоогийн хуулиар 21 аймгийн салбар танхимууд нь орон нутагт байгуулагдаж, эдгээр нь нийлж Үндэсний танхимаа бүрдүүлдэг. Гэтэл дүрмээрээр 21 аймаг маань манай Удирдах зөвлөлийн гишүүд ч үндэсний танхимаас хамааралтай ажилладаг. Ийм зүйл байж болохгүй юм. Салбар танхимууд нь бие ээ даах ёстой. Танхимуудын нэгдэл нь Үндэсний танхим. Салбар танхимууд нь орон нутгийн гишүүдээ нэгтгээд, бие даасан байдлаар ажиллаж чадах юм бол орон нутгийн хөгжил маш цэгцтэй болно.

Үндэсний танхим нь одоо 21 салбар танхимдаа төсвийн хувьд тодорхой дэмжлэг үзүүлдэг. Удирдах зөвлөлийн хурал дээр салбар танхимыхан маань бидний төсвийг баталдаг ийм тогтолцоог бид халах ёстой.

С.Мэндхүү: Одоо салбар танхимын Ерөнхийлөгч нь тухайн аймгийн Засаг дарга байдаг. Гэтэл ширээний 2 талд төртэй бизнесийхэн хэлэлцэнэ гээд суухад бидний удирдлага Засаг дарга учраас шүүмжилмээр байгаа асуудал дээрээ дуугүй өнгөрөх тохиолдлууд их байдаг. Энэ нь маш буруу тогтолцоо юм.

О.Амартүвшин: Би нэг жишээ хэлье. Төрийн бус байгууллага, төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага өөрөө тусдаа ойлголтууд. Гэтэл саяхан Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар буюу төрийн байгууллагын доор төрийн бус байгууллагуудын нэгдсэн холбоо байгуулагдсан. Тусдаа байх ёстой байтал доор оо нэгтгэнэ гэдэг утгагүй. Үүнтэй адил аймгуудын худалдаа аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч нь Засаг дарга байна гэдэг нь бүүр утгагүй юм.

Танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр энэ бүхнийг засах юм. Бидний суурь төлөөлөл нь компаниуд гэдгийг бид маш сайн ойлгох хэрэгтэй. Үүнийг л бид зөв ойлгох ёстой. Цаашид хуулийн төслийн талаар олон хэлэлцүүлэг зохион байгуулж, саналуудыг нэгтгэж зөв томъёолох нь чухал юм.

Ч.Ганцэцэг: Би ноос ноолуурын холбооны Удирдах зөвлөлд байдаг. Танхимын хууль батлагдах сургаар холбоод намайг танхимын удирдах зөвлөлийн хуралдаа очихгүй байж эсэргүүцлээ илэрхийлэх ёстой гэх мэтээр холбоод маш ихээр хуваагдаж эхэлж байна. Энэ нь аж ахуйн нэгжүүдэд маш хүндрэлтэй байна.

Маш олон төрийн бус байгууллага, холбоод байгуулагддаг нь аж ахуйн нэгжүүдийг маш их хуваадаг. Төр засагт үгээ хүргэхдээ тухайн холбоог хариуцаж байгаа даргын өөрийнх нь компанийн эрх ашгийн зүгээс ярьдаг нь бусад жижиг дунд үйлдвэрүүд болон аж ахуйн нэгжүүдэд маш хортой байдаг. Мөн нэг УИХ-ын гишүүнтэй очиж

уулзахад бүгд өөр зүйл ярьж, урагшлахгүй байна. Тиймээс танхимын тухай хууль яаралтай батлагдах хэрэгтэй байгаа юм. Танхимын тухай хууль батлагдсанаар танхимын доор бүхий л холбоод зангидагдаж Германы ХАҮТ-ын жишгээр явах нь маш зохимжтой санагдсан. Бид нэгдсэн дуу хоолойгоо төр засагт хүргэснээр бодлого хэрэгжиж явахад үр өгөөжтэй байна гэж бодож байна.

О.Амартүвшин: Манай Удирдах зөвлөлийн гишүүд ихэвчлэн томоохон компаниудын төлөөллүүд байдаг. Та бүхэн маш олон холбоодод гишүүнчлэлтэй байж, олон талд татвар төлдөг. Танхимын хууль батлагдсанаар энэ бүхэн эцэс болох юм. Салбарын нэгдсэн бодлогоо дагнасан танхим дээр ярьж, том эрх ашгаа үндэсний танхим дээрээ ярьж явна. Энд хэн нэгэн нь танхимын даргаар томилогдох, удирдах нь сонин биш бөгөөд зөвхөн хийх ёстой ажлаа сонгогдсон хугацаандаа хийнэ чадахгүй бол дараагийн хүнийг нь дундаасаа сонгох ил тод засаглалтай байх нь их чухал.

Одоогийн дүрмээр бид үйл ажиллагаагаа ямар нэг зовлонгүйгээр явуулж болох боловч одоо л бид эдгээр шинэчлэлтийг хийхгүй бол хувийн хэвшил нэгдэж чадахгүй байна. Төр бол өөрөө босоо тогтолцоотой учраас нэгдмэл байдаг. Гэтэл бид нэг талд нэгдэж чадаагүйгээсээ болоод хичнээн их хэмжээний татвар төлж байгаа гэж дуугарсан ч авч хэлэлцэхгүй байна. Харин бид нэгдэж чадах юм бол илүү хүчтэй дуугарч чадах юм. Жишээлбэл: Германы ХАҮТ төр засгаар нь орж байгаа ямар нэг бодлогод дэмжсэн санал өгч байж цаашаа явдаг жишиг бий. Татвар төлж байгаа бизнес эрхлэгчид бидний төлж байгаа татвар зөв зүйлд зарцуулагдаж байгаа эсэх талаар хяналт тавьж болохгүй бол асуудлыг дахин авч хэлэлцдэг, болсон гэж үзвэл цааш нь шийдэгдэж явдаг.

Ц.Эрдэнэбилэг: Нэгэнт энэ хууль цаашид батлагдаж явбал нэг анхаарах зүйл нь салбарын яамдуудтай мэргэжлийн танхимууд маш нарийн холбоотой байхыг хуулиар зохицуулж өгөх шаардлагатай. Нэгэнт танхимууд нь томоохон институт болж байгаагийн хувьд яамдууд нь салбарын бодлогоо тодорхойлохдоо шийдвэрийг нь авч үздэг байхаар хуульчилж оруулж өгөхгүй бол яамдууд дээр туршлагатай, боловсролтой боловсон хүчин тун цөөхөн болсон. Тэгэхээр бид энэ сэдвээр ярих асуудал их байна. Гэвч цаг бага байгаа учир дараагийн хэлэлцэх асуудалдаа ороод явбал ямар вэ?

О.Амартүвшин: Зөвшөөрлийн хуультай холбоотой хэлэлцүүлэг их удаан өрнөж байгаа. Танхим үүн дээр маш идэвхитэй оролцож явж байгаа. Зарим төрлийн зөвшөөрлийг энэ хуулиар мэргэжлийн танхимд шилжүүлэх талаар зааж өгч байгаа. Энэ хууль хэрэгжих юм бол танхимуудын үүрэг оролцоо, төрд нөлөөлөх нөлөөлөл маш тодорхой болох юм. Зөв буруу гэж ярьбал маш олон зүйлийг ярина. Гэхдээ нийтлэгээрээ хуулийг дэмжиж байгаа гэж ойлгож байна. Тиймээс дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. МҮХАҮТ-аас гаргасан “Их сэргэлт” санаачлагын явцын талаар товч мэдээллийг Т.Дүүрэн танилцуулна.

Хавсралт 7

**МОУА-ЫН АРБИТРЧДЫН ЗӨВЛӨЛ, МҮХАҮТ-ЫН ХУУЛИЙН БОДЛОГЫН
ЗӨВЛӨЛИЙН ХАМТАРСАН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ТАНХИМЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛД ГАРГАСАН САНАЛ**

2022.09.30

МҮХАҮТ-ын хуулийн бодлогын зөвлөлийн дарга, “Скайтел” ХХК-ийн хууль, хүний нөөцийн албаны захирал Ө.Жамбалсүрэн – Хуулийн төслийг сайжруулах талаар санал хэлье. Энэ хуулийн төслийн 3.1 дэх хэсэгт заасан зарчим маш сул тусгагдсан байна. Танхимын үйл ажиллагааны зорилго зарчимтайгаа уялдах ёстой. Мөн 4.1-4 дэ хэсэгт өрсөлдөөний асуудал гэхээр тодорхой аж ахуй нэгж холбоодын хооронд яригдах гээд байдаг. Ямар агуулгаар шударга өрсөлдөөныг хязгаарлах зарчим оруулсныг тодруулмаар байна. Японы танхим шиг байгууллагын статусыг хүчирхэгжүүлэх хуулийн шинэчлэлт хэрэгтэй. Мөн 23 дугаар зүйлд заасан төртэй харилцах харилцааг тодорхойлсон эрх зүйн зохицуулалт сул байна. Төрийн байгууллага олон нийт, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана гэх ойлголтгүй учраас маш тодорхой шууд хэрэгжиж болохуйц заалтыг оруулах шаардлагатай. Тухайлбал Харилцаа холбооны салбарын дагнасан танхим байгуулахаар боллоо гэж үзвэл манай салбар ердөө 6 том байгууллагатай. Дагнасан салбар танхим байгуулахаар заасан тоо хэмжээ буюу 50 аж ахуй нэгжийн тоонд хүрэхгүй. Энэ мэт асуудлыг яана гэсэн үг вэ? Суурь үзэл баримтлал, зарчмуудтай бол санал нэг байна. Бүх аж ахуй нэгжүүд тодорхой төрийн байгууллагуудтай харилцдаг. Бизнесүүд нийтлэг асуудлаар шаардлагаа гаргаж тавих арга зам нь танхим байдаг.

“Мобиком корпораци” ХХК-ийн хуулийн албаны ахлах хуульч – 5.9 дүгээр хэсэгт заавал гишүүнчлэлтэй байхаар заасан гишүүн гэдэгт хэнийг оруулах вэ? Мэргэжлийн холбоодын тухай хууль болон төрийн бус байгууллагын тухай хууль асуудалтай. Сангийн зохицуулалт, хувийн тэтгэвэрийн асуудлыг ямар байдлаар зохицуулах талаар компаниуд хүлээлттэй байгаа. Мөн Танхимын нэр явцуу утгаар ойлгогдохоор байдаг. Нэрийг нь солих талаар хэлэлцэх ёстой. Эдийн засгийн суурь харилцааг өөрчлөх гэж байгаа талаарх ойлголтыг зөвхөн хуульч нар биш нийгмээрээ бүгд ойлгох ёстой. Холбоо сангийн тухай хуулиар сайн зохицуулалтууд орох ёстой гэж үзэж байгаа.

“Туушин” ХХК-ийн эрсдэлийн удирдлагын албаны захирал дэд Н.Энхриймаа – Албан журмын гишүүнчлэлийн талаар асууя. 50000 аж ахуй нэгжүүдэд ямар босго тавьж байж гишүүнчлэл олгох вэ? Тусгай зөвшөөрлөөр жил бүр гэрчилгээ олгохдоо хамрагдах механизмыг тодорхойлох юм байна. Гэтэл тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжүүдийг яаж хамруулах вэ? Албан журмаар хамруулахдаа ямар механизм хэрэглэх вэ?

МҮХАҮТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшин: Ганц жишээ авахад л бизнес эрхлэгч бизнесээ эхлүүлэх гээд Улсын бүртгэл дээрээс хуулийн этгээд гэрчилгээ авсан цагаасаа яахаа мэддэггүй. Яах нь тодорхойгүй байдаг. Энэ хууль батлагдсанаар зохион байгуулалттай нэгжид шууд хандах, туслалцаа авах зэрэг бизнесийн орчны асуудлууд тодорхой болно. Одоо ийм чиг үүрэгтэй бүтэцүүд сайн

дураар ажилладаг тул хүсвэл хийдэг, хүсвэл хийдэггүй ч юм уу эсвэл нэг мөр ойлголт байдаггүй зэрэг замбараагүй асуудлууд тодорхой болно. Салбар сайжирвал бүгдэд өгөөжтэй. Төрийн ашиг сонирхолийн эсрэг бидний хийх зүйл ч тодорхой болоод ирнэ гэж хардаг.

МОУА-ын арбитрч Т.Алтангэрэл – Хуулийн үзэл баримтлалыг харахад энэ салбарт үнэхээр том шинэчлэл хийх гэж байгаа гэж харагдаж байна. Бизнесийн орчинд нөлөөлөх маш том хуулийн төсөл явж байгаа гэж харж байна. Монгол улсад бизнесийн үйл ажиллагаа явуулж буй бүх нэгжүүд МҮХАҮТ-д заавал гишүүнчлэлтэй байна гэвэл Улаанбаатар хотын танхим яана гэсэн үг вэ? Мөн төрийн зарим чиг үүрэг гэдэгт мэргэжлийн хяналтын чиг үүргийг дагнасан танхимууд руу шилжүүлнэ гэсэн үг үү? Нийгэмд цаашид маш их хэрэгтэй байгууллага болох юм байна. Цаашлаад Казакстаны жишгийг зоригтой нэвтрүүлэх боломжтой гэж харж байна. Чөлөөт бүс байснаар заавал Монголын хуулийг хэрэглэхгүй, гадаад улсуудын хуулийг арбитр хэрэглэнэ гэдэг нь таалагдаж байна. Хөрөнгө оруулагч нарыг үүгээрээ татдаг зүйл ч байж болно. Өмчийн эзэн нийтийн эрх ашгийн төлөө үүрэг хүлээнэ. Үүнийг Үндсэн хуулинд заасан байдаг. Гэхдээ хуулийн зүйл заалтыг явцуу хүрээнд хардаг зүйл байж болохгүй.

МҮХАҮТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшин: Мэргэжлийн хяналтын чиг үүргийг мэргэжлийн танхимууд хэрэгжүүлнэ. Харилцан эрүүл харилцаа бий болж бизнесийн орчин илүү сайжрах нөхцөд бүрдэнэ. Хуулийн шинэчлэлттэй холбоотойгоор магадгүй олон төрийн бус байгууллагуудын эсэргүүцэлтэй тулгарах байх. Иймд хуулийн үзэл баримтлалыг зөв ойлгуулах талаар арга хэмжээ авах талаар олон ажил гүйцэлдүүлэх шаардлага гарах байх.

Монголын Олон Улсын Арбитрын дарга С.Энхцэцэг – Аж ахуй нэгж байгууллагуудыг Танхимд гишүүнчлэлтэй болгохын тулд дан ганц Улсын бүртгэлд бүртгэх асуудлаар тогтохгүй өөр олон хууль зүйн үр дагавар гарч ирэх тул нарийвчилсан зохицуулалтууд шаардлагатай. Энэ хуулийг дагаж гарах хуулиудыг маш их бодож боловсруулах ёстой.

Цахимаар “Богд банк” ХХК-ийн гүйцэтгэх захирал, арбитрч С.Оргодол, МУИС-ийн хууль зүйн сургуулийн хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, дэд профессор, МОУА-ын арбитрч Т.Мэндсайхан нар оролцсон. Ямар нэг санал гаргаагүй.

АЖЛЫН ХЭСЭГ

/Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл/

1. Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр
2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Эрдэнэбулган-91119992
3. Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга З.Энхболд
4. Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дэд захирал Г.Өлзийсайхан-88113145
5. Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү-
6. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Ерөнхийлөгч Д.Энхтүвшин- 88119988
7. Улаанбаатар хотын Худалдааны танхимын Ерөнхийлөгч Д.Ончинсүрэн-99090450
8. Улаанбаатар хотын Худалдааны танхимын гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ- 99030694
9. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Хуулийн бодлогын зөвлөлийн дарга Ө.Жамбалсүрэн- 90990909
10. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын дарга С.Энхцэцэг- 99049966
11. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын Ерөнхий нарийн бичгийн дарга М.Шинэбаяр- 88115425
12. Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын ахлах шинжээч Д.Мөнхжаргал-261540
13. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын асуудал хариуцсан шинжээч Э.Сугарбаяр-260709
14. Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Пүрэвсүрэн- 88004418
15. Өмгөөллийн "Хэруга Партнерс" ХХН-ийн гүйцэтгэх захирал, өмгөөлөгч- Л.Загдаа- 99994739
16. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Бодлого стратегийн газрын хуульч Б.Эрхбаяр- 88150363